

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ: “НИЙСЛЭЛИЙН 2024-2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ”

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Та сонсголын тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС
2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/ ЗОХИОН
БАЙГУУЛСАН “НИЙСЛЭЛИЙН 2024-2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ
ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ” СЭДЭВТ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН
СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 47 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал даргалав.

Ерөнхий хяналтын сонсгол явуулсан сэдэв:

“Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал”

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ерөнхий хяналтын сонсголд оролцогч Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Удтал хүлээлгэсэнд Та бүхнээс дахин хүлцэл өчье.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны ирц бүрдсэн тул сонсголыг эхлүүлэхэд бэлэн боллоо. Ирц танилцуулъя. Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Тилеуханы Аубакир, Жамбын Батсуурь, Пүрэвжавын Ганзориг, Нанзадын Наранбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Ринчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Чинбатын Номин, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр Төсвийн байнгын хорооны ирц 53,3 хувиар бүрдсэн байна.

2026 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдэвт ерөнхий хяналтын 2 дахь өдрийн сонсгол нээснийг мэдэгдье. Өнөөдрийн сонсголд ажиглагч 1, төрийн байгууллагын төлөөлөл 61, ТББ болон иргэдийн төлөөлөл 40 хүн оролцож байна.

Сонсголын үйл ажиллагааг парламентын шууд дамжуулах суваг болон хуульд заасны дагуу сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор МҮОНРТ-ээр дохионы хэлмэрчтэй шууд дамжуулж байна. Хяналтын сонсгол нь зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмаар явагдана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-д заасны дагуу “Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй”. Өөрөөр хэлбэл, оролцогчоор бүртгүүлсэн иргэд үг хэлж, мэдээлэл хуваалцаж болно гэсэн үг. 124 дүгээр зүйлийн 124.1-д заасны дагуу сонсголд оролцогч “энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх,” энд төрийн байгууллагыг онцолж байх шиг байна. “сонсголын тэмдэглэл гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;”, “сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах.” эрхтэй. 124 дүгээр зүйлийн 124.2-т заасны дагуу сонсголд оролцогч “сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар хүрэлцэн ирэх;”, “сонсголын дэг сахих;”, “сонсгол зохион

байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;”, “сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;”, “холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.24-т “...Улсын Их Хурлын хяналтын сонсгол болон хяналт шалгалтын түр хорооны сонсголд оролцож байгаа этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ.”, 21.26-д “...холбогдох албан тушаалтан худал мэдээлэл өгсөн, танилцуулсан гэж үзвэл гишүүн хуралдаан даргалагчид санал гаргаснаар Тамгын газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн мэдээллийн үнэн зөв, бодит эсэхийг ажлын 5 өдрийн дотор хянаж, дүгнэлт гаргана”, 21.28-д “...худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг нуун дарагдуулсан улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлыг нам, эвслийн бүлэг, эсхүл 20-оос доошгүй гишүүн гарын үсэг зурсан бол энэ хуулийн 30.1.11-д зааснаар холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.”, 21.30-д “...Улсын Их Хурлын хяналтын сонсголд ... худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан нийтийн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 32.8-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.”, 21.31-д “...хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан байна.

Оролцогчдоос нийслэлийн өмнөх удирдлагууд, албан тушаалтнууд яагаад ирэхгүй байгаа талаар асуусны дагуу Тамгын газраас тодруулсан. Ерөнхий хяналтын сонсголд үүрэг хүлээж байгаа албан тушаалтан оролцож тайлбар, мэдээлэл өгөх хуультай гэдгийг энэ дашрамд хэлье. Тэгэхээр албан тушаалаа өгчихсөн бол иргэн гэсэн үг.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 57.1-д “Энэ хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг тасалдуулсан бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.25-д заасан парламентыг үл хүндэтгэх үйлдэл гэж үзэн Төрийн албаны тухай хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 57.6-д “Шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.” 57.7-д “...шинжээч, сонсголд оролцогч, ажиглагч бусад хүн сонсголын дэг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 57.9-д “Холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, эсхүл холбогдох тайлбар, мэдээлэл өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэж заасан.

Одоо сонсгол даргалагчийн эрх, үүргийг Та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлд заасны дагуу сонсгол даргалагч нь сонсголын явцад асуулт асуух, хариулт өгөх дарааллыг тогтоох бөгөөд тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох, сонсголын дэг зөрчсөн, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй

шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах, сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх, сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авах эрхтэй байна.

Та бүхэнд өнөөдрийн сонсголын хөтөлбөрийг танилцуулна.

Төрийн байгууллага, оролцогчдын эрх, үүргийг танилцууллаа. Та бүхнийг удаан хүлээлгэсэндээ дахин уучлал хүсье. Иргэдийн мэдэх эрхийг хангаж, хүмүүс сонсохыг хүсэж байгаа учраас Улсын Их Хурлын ерөнхий хяналтын сонсголыг хуулийн дагуу зохион байгуулж байна. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч гэж Үндсэн хуульд заасан байдаг. Иргэд бол сонсох эрхтэй. Бид энд төрийн албаныхныг дуудаж ирээд хоёр талцаад маргалдаад байгаа зүйл байхгүй. Өгөх ёстой мэдээллийг нь өгөхийн тулд үүнийг зохион байгуулж байгаа. Сонсгол даргалагчийн хувиар хариуцлага тооцуулах талаар санал, мэдээлэл ирж байна. Би 2 зүйлийг сонсгол эхлэхээс өмнө та бүхэндээ хэлье.

1 дүгээрт, сонсголын бэлтгэл ажлын хүрээнд албан бичгийн хариу ирээгүй нэлээн удсан асуудал байгаа. 6 дугаар сарын 10-ны өдрийн УИХ-03/6719 тоот албан бичгээр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчид шийдвэр гаргалтад оролцохдоо ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг илэрхийлж орсон эсэх талаарх хуралдааны тэмдэглэл ирүүлэхийг хүссэн. Энэ хариу ирээгүй, зөвхөн хуулийн дагуу оролцдог эсэхээр тайлбар ирсэн. Өчигдөр холбогдох албан тушаалтнаас хурал/сонсгол дээр мэдээлэл авсан. Энэ бичгийн хариуг ирүүлэх шаардлагыг хүргүүлсэн. Тэгэхээр мэдээллийг хугацаа алдаж ирүүлсэн талаар хариуцлага тооцох үндэслэлийг Тамгын газрын Хяналт шалгалтын газраас шалгаж дүгнэхийг чиглэл болгож байна.

2 дугаарт, өчигдрийн сонсголын үеэр нэгэн мэдээлэл дээр магадлах санал ирсний дагуу нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент компанийн талаар өчигдөр мэдээлэл авсан. Говь-Алтай аймгийн сэргээгдэх эрчим хүчний төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа юм байна. Зөвлөх үйлчилгээний төлбөр 250,0 сая төгрөг дээр нэмэлт гэрээний нөхцөл ямар орлого олох вэ? гэдэг зүйл асуусан. Гэрээнд зааснаар “зөвлөх нь хөрөнгө оруулалтын шимтгэлийг татан төвлөрүүлсэн санхүүжилтийн дүнгийн 1.5 хувьтай тэнцэх шимтгэлийг гэрээний дагуу хүлээж авна. Энэ нь бусад хамтрагч байгууллагын хөлс төлбөрийг төлөх зорилготой байна” гэж заасан юм байна. Өчигдөр компанийн захирал тайлбарлахдаа “нэмэлт төлбөр хөрөнгө оруулалтыг хийсний дараа саксес фи (success fee) гэж байгаа. Түүнийг олон улсын хөрөнгө оруулагчийн талаас Говь-Алтай аймгийн Засаг даргаас олон улсын хөрөнгө оруулагчид шилжүүлнэ, манайхаар дамжихгүй” гэж тайлбарласан байсан. Тэгэхээр энэ нь гэрээний заалттай нийцэхгүй байна гэсэн санал байна. Үүнийг бас Тамгын газар шаардлагатай байгууллагаар магадлуулаад санал, дүгнэлт ирүүлэхийг хүсье.

Ингээд бас 2, 3 коммент байна. Тэгэхээр ажил хариуцаж байгаа хүмүүс бид нэг нэгнийгээ аргалсан мэдээлэл байж болохгүй шүү. Энэ сонсголын утга учир бол олон мянган хүмүүсийн хүсэл, санаа зовнил, шаардлагын хариулт учраас тэдэнд хандсан асуулт, хариултыг бид энэ сонсголоор авч санал, дүгнэлтээ гаргах ёстой гэж хэлмээр байна.

Өнөөдрийн сонсголын хөтөлбөр танилцуулъя. Цаг зөрсөн учраас шууд уншъя.

Эхний танилцуулга “Туулын хурдны замын төсөлд хийсэн аудитын талаар”

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, “Зам, тээврийн яамны бодлого ба Нийслэлийн зам тээврийн мега төслүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо” Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, “Туулын хурдны замын төслийн хэрэгжилтийн явцад гарсан зөрчлүүд, авсан арга хэмжээ” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, “Туул хурдны замын төслийн хүрээнд хийсэн худалдан авах ажиллагаанд хийсэн дүгнэлт” ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, “Туулын хурдны замын төслийн төсвийн зарцуулалт, холбогдох баримт бичигт хийсэн дүгнэлт” шинжээч С.Бат-Эрдэнэ, Э.Батболд, Д.Энхбаяр, “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Нийслэлийн бүтээн байгуулалтын бодлогын уялдаа холбоо, төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах санал, дүгнэлт” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД М.Баяраа, “Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, зураг төсөл батлагдсан үйл явцын талаарх танилцуулга” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД М.Баяраа, “Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, Сэлбэ 20 минутын хот төслийн төсвийн гүйцэтгэл, холбогдох баримт бичигт хийсэн дүгнэлт” шинжээч З.Туяа, Э.Батболд, Д.Энхбаяр нар танилцуулна.

Дараа нь сонсголд оролцогчдоос санал, тайлбар, үг хэлэх хугацааг нийт 2 цаг 10 минут төлөвлөсөн. Үдийн хоолны завсарлага. Мөн оролцогч иргэдээс урьдчилж бичгээр ирүүлсэн санал хүсэлт, мэдээллийг уншиж танилцуулна. Улсын Их Хурлын гишүүд асуулт асуух, хариулт авах хугацаа нийт 2 цаг 20 минут, төгсгөлд нь Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, сонсгол 17 цаг 30 минутад өндөрлөхөөр төлөвлөсөн байна.

Цайны завсарлага байхгүй, нийт оролцогчид заалны гадна байх цай, кофегоор үйлчлүүлээрэй гэж хүсье.

Одоо “Туулын хурдны замын төсөлд хийсэн аудитын талаар” Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулна. Мэдээллийг дэлгэц дээр гаргаж өгөөрэй.

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Сонсголд оролцогч нийт хүмүүст энэ өдрийн мэнд хүргэе. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасны дагуу Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолоор баталсан сэдвийн хүрээнд “Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал” сэдэвт аудитыг гүйцэтгэж, тайлагнах шатанд ажил үргэлжилж байна. Аудитыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эхэлж, 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, холбогдох төрийн байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна. Аудитыг хэрэгжүүлэх явцад төслийн талаар, тэр дундаа ТЭЗҮ, зураг төсөл, худалдан авах ажиллагаа, гэрээ хэлцэл, төсөвт өртөг, санхүүжилт, байгаль орчин, урьдчилгаа төлбөрийн баталгаа, ил тод байдалтай холбоотой иргэд, олон нийт, мэргэжлийн ТББ-аас дэвшүүлсэн асуудлыг анхаарч ажиллаж байгаа бөгөөд Үндэсний аудитын газраас ЗГХЭГ, хууль хяналтын байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг болон энэхүү ерөнхий хяналтын сонсголын ажлын хэсэгт аудитын байгууллагын төлөөллийг оролцуулж, шаардлагатай мэдээллээр ханган хамтран ажиллаж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 33, 37 дугаар зүйлд заасныг үндэслэн аудитын явцад гүйцэтгэсэн дүн мэдээллээс урьдчилсан байдлаар дараах асуудлыг танилцуулж байна.

Нэг. Бодлого, хууль тогтоомжийн талаар

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, мөн нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд уг төслийг хэрэгжүүлэх талаар тусгасан байна. “Туулын хурдны зам” мега төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Гудамж төсөл”-ийн хүрээнд анх төлөвлөгдсөн бол Засгийн газрын 2022 оны “Улаанбаатар хотын Шинэ тойрог замыг барьж байгуулах тухай” 476 дугаар тогтоолоор Туулын хурдны зам гүүрэн байгууламж барьж байгуулахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгаснаар уг төсөл хэрэгжиж эхлэхээр болсон. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 253 дугаар тогтоолоор “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг “Туулын авто зам төсөл”-ийг концессоор хэрэгжүүлэх жагсаалтад оруулан баталжээ. Улмаар Засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар уг төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд олон улсын нээлттэй тендерээр сонгон шалгаруулж хэрэгжүүлэх чиглэл баримтлахаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

НИТХ-ын “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” 2024 оны 24/33 тогтоолоор нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалтад Туулын хурдны замын төсөвт өртөг 916,3 тэрбум төгрөг, тухайн онд 538,6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Харин нийслэлийн ИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/01 дүгээр тогтоолоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад “Туулын хурдны зам” мега төслийг оруулж, улмаар Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Нийслэлд хэрэгжүүлэх томоохон төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор тендер шалгаруулалт, хөрөнгө оруулалтын гэрээнд Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны (FIDIC) гэрээний нөхцөлийг хэрэглэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид” даалган шийдвэрлэжээ.

Хоёр. ТЭЗҮ, зураг төслийн талаар

Засгийн газрын 2013 оны “Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай” 307 дугаар тогтоолоор Туулын хурдны замын чигийг анх тогтоосон бөгөөд энэ тогтоол одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүний дагуу 2014 онд нийслэлийн Засаг даргын Зам тээвэр, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч, Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын дарга, Эдийн засаг, хөгжлийн яам, “Гудамж төсөл”-ийн захирал нар хамтран баталсан Ажлын даалгаврын дагуу “Эм Си Пи Си Жи Ар” ХХК нь төслийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, төсвийг хэсэгчлэн боловсруулсныг Барилгын хөгжлийн төвөөс анх магадлал хийж баталгаажуулсан байна. Зам, тээврийн хөгжлийн төвөөс 2016 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн магадлалын ерөнхий дүгнэлтээр төслийн нэгдсэн төсөвт өртгийн тооцоог 594,8 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байна. Улмаар 2024 оны Зам, тээврийн хөгжлийн төвөөс нэгдсэн төсөвт өртгийн тооцоог 916,3 тэрбум төгрөгөөр магадлал хийж тодотгон баталгаажуулжээ.

Зам, тээврийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2025 оны хамтарсан шийдвэрээр төслийн төсөвт өртгийг 1,9 их наяд төгрөг байхаар тооцож тендерийн баримт бичигт тусгасан байна. Энэ төсөвт өртөг нь магадлалаар баталгаажаагүй бөгөөд энэ асуудлаар холбогдогч 2 байгууллагаас аудитын явцад тайлбар одоогоор ирүүлээгүй байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай” 27 дугаар тушаалаар 14 экспертийг томилсон бөгөөд холбогдох хуульд нийцүүлэн “Туулын хурдны авто зам төслийн ТЭЗҮ, зураг төсөл”-ийг хянаж, баталгаажуулах ажлыг Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулж, төслийн Хөрөнгө оруулалтын урьдчилсан төсвийг 2,3 их наяд төгрөг, газар чөлөөлөлтөд 170 тэрбум төгрөг байхаар тооцон 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 316/2025 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтийг баталгаажуулан гаргасан байна.

Гурав. Төслийн сонгон шалгаруулалтын талаар

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан бөгөөд эхний сонгон шалгаруулалт 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зарлагдаж, үнэлгээний дүгнэлтээр тендер шалгаруулалт амжилтгүй болсон бөгөөд тендерийн нийт төсөвт өртөг 1,9 их наяд төгрөг байсан ба эрх бүхий байгууллагын магадлалаар баталгаажаагүй байна.

Хоёр дахь сонгон шалгаруулалт 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр зарлагдаж БНХАУ-ын “Хао Юань групп” ХХК болон “Тяньжин ӨүБайВэй” ХХК-иудын түншлэлтэй оролцогч нь “хамгийн сайн” үнэлэгдэн шалгарсан байна. Хоёр дахь сонгон шалгаруулалтын үеийн төсөвт өртөг болох 2,3 их наяд төгрөгийн дүнд магадлал хийгдсэн байна.

Дээрх төсөвт өртгийн магадлал болон үнийн зөрүү, тендерийн баримт бичгийг хууль тогтоомж, заавар аргачлалтайгаа нийцэж байгаа эсэх эцсийн үр дүнг аудитын тайланг хүргүүлэхэд бүрэн танилцуулах болно.

Дөрөв. Төсөв, төслийн санхүүжилтийн талаар

Нийслэлийн ИТХ-ын “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” 2024 оны 24/33 тогтоолоор төслийн төсөвт өртгийг 916,3 тэрбум төгрөг, санхүүжих дүнг 538,6 тэрбум төгрөг, мөн “2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 25/106 дугаар тогтоолоор төсөвт өртгийг 2,3 их наяд төгрөг, санхүүжих дүнг 500,0 тэрбум төгрөг болгон өөрчлөлт оруулан баталсан. Улмаар “Нийслэлийн 2026 оны төсөв батлах тухай” 2025 оны 25/133 дугаар тогтоолоор төслийн төсөвт өртөг 2,3 их наяд төгрөг, тухайн жилд санхүүжих дүнг 800,0 тэрбум төгрөгөөр баталсан байна.

“Туулын хурдны зам” төсөлд нийслэлийн хөрөнгө оруулалтын төсвөөс 2025 онд 500,0 тэрбум төгрөг, 2026 онд 800,0 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэгч байгууллагаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн 2025 онд 401,0 тэрбум төгрөг, 2026 онд баталгааны үлдэгдэл 99,0 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Төслийг хэрэгжүүлэхэд төслийн төсөвт өртгөөс гадна дараах 7,8 тэрбум төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна. Үүнд:

- “Туулын хурдны зам”-ын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнд 100,0 сая төгрөг;
- “Туулын хурдны зам”-ын зураг, төсвийг шинэчлэх ажил 2,9 тэрбум төгрөг;
- Газар чөлөөлөх нөхөн төлбөр 2025 онд 800,0 сая төгрөг, 2026 онд 3,9 тэрбум төгрөг;
- “Туулын хурдны зам” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардалд 50,0 сая төгрөг;
- “Туулын хурдны зам” барих барилгын ажлын зураг, төсөл боловсруулах, худалдан авах барилгын ажил гүйцэтгэх гэрээ хэлэлцээ хийх зөвлөх үйлчилгээний зардалд 25,0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Тав. Урьдчилгаа төлбөрийн баталгааны талаар

“Туулын хурдны зам” төслийн гүйцэтгэгч БНХАУ-д бүртгэлтэй “Чайна Хайвэй Групп Лимитэд” компани нь урьдчилгаа төлбөрийн баталгаанд баталгаа гаргагч гадаад улсад бүртгэлтэй “Жианбанг Инженеринг Перформанс Гаранти (Шаньдунг) компани, тус компанийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад бүртгэлтэй “Мөнх даатгал” ХХК-ийг сонгосон байна.

Төслийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, урьдчилгаа төлбөртэй холбоотой асуудлыг АТГ, Тагнуулын ерөнхий газар, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсэг болон ЗГХЭГ-т байгуулсан ажлын хэсгийн хүрээнд нягтлан шалгаж байгаа тул Төрийн аудитын тухай хууль болон Аудитын стандартын дагуу асуудлыг тодорхой хүрээгээр хязгаарлан авч үзэж, нотлох баримтын хүрээнд шаардлагатай мэдээллийг ажлын хэсгүүдэд өгч хамтарч ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчны нөлөөллийн талаар

Төслийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон журмын хүрээнд дараах дүгнэлт, тайланг боловсруулж, батлуулдаг. Үүнд төслийн ТЭЗҮ-ийн хүрээнд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг Барилгын хөгжлийн төвөөс 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан. Харин Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий үнэлгээний дүгнэлтийг 2025 оны 6 дугаар сарын 09-ний өдөр, Байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээний тайланг 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр тус тус Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хүлээн авч, хянан баталгаажуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд усны сав газар, түүнд учрах сөрөг нөлөөллийг Усны тухай хуулиар нарийвчлан зохицуулсан бөгөөд Усны тухай хуулийн 16¹.4.10-д заасан усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ус ашиглалт дүгнэлт гаргах асуудал хийгдээгүй орхигдсон байна.

Долоо. Тусгай зөвшөөрлийн талаар

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн байгууллагаас авах 15 тусгай зөвшөөрлөөс дараах 4 зөвшөөрлийг аваагүй байна. Үүнд:

- Газар эзэмшүүлэх зөвшөөрөл;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын зөвшөөрөл;

- Хаягдал ус зайлуулах зөвшөөрөл;
- Усны сан бүхий газрын ашиглалтын төслийн дүгнэлт гэсэн ийм зүйлүүд авагдаагүй байна.

Мөн төсөл эхлүүлэхэд шаардлагатай хуульд заасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй, археологи, палеонтологи, түүх угсаатан зүйн хайгуулын тандалт, судалгааны ажил хийгдэж, дүгнэлт, тайлан гаргаагүй байхад ажил эхлүүлсэн байна.

Найм. Замын трассын давхцал, газар чөлөөлөлт

“Туулын хурдны зам” төслийн замын трассын давхцал, газар чөлөөлөлттэй холбоотой 112 нэгж талбараас нийт 56 нэгж талбарыг чөлөөлж, үүнээс 23 нэгж талбар нь дүйцүүлэх буюу талбай шилжүүлэх байдлаар, 33 нэгж талбар нь нөхөн олговор олгох байдлаар шийдвэрлэгджээ. Засгийн газрын 2013 оны “Хурдны зам баригдах талбайн солбицол батлах тухай 307 дугаар тогтоолоор баталсан трасст давхцаж байгаа 30 нэгж талбараас 3 иргэнд 1,05 тэрбум төгрөг олгож, 4 иргэнд 1,4 тэрбум төгрөг олгохоор төлөвлөсөн байна. Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 69 дүгээр тогтоолоор “Туул голын онцгой болон энгийн хамгаалалтын бүстэй Туулын хурдны замын трассын давхцал, мөн Засгийн газрын 2013 оны 307 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрчлийн асуудлаар аудитын тулган баталгаажуулах горим, сорил хийж тайланд эцэслэн тусгаж, танилцуулахаар бэлтгэж байна.

Танилцуулгад дурдагдсан аудитад хамрагдаж буй асуудлаар төслийг хэрэгжүүлэх, захиалагчийн зүгээс ил тод, үнэн зөв мэдээлэл хангалттай өгөх, иргэдийн мэдээлэл авах, мэдэх эрхийг хангаагүйн улмаас иргэд, олон нийтийн дунд ойлголтын зөрүү үүсэж буйг анхаарч төр, иргэдийн хүсэн хүлээж буй асуудалд голлон төвлөрч, хуулиар зохицуулсан хараат бус, бие даасан чиг үүргийг хэрэгжүүлэн аудитын дүгнэлтийг гаргахаар ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар аудитын урьдчилсан дүн, дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хуралд танилцуулах 2, үйл ажиллагаа, асуудалд чиглэсэн 7, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд чиглэсэн 5, нийт 12 зөвлөмж, илэрсэн зөрчил, хариуцлагын асуудлаар 4 албан шаардлага, хууль хяналтын байгууллагыг мэдээллээр хангаж, хамтран ажиллах 4 асуудлыг төлөвлөж байгаа бөгөөд аудитын тайлангийн төслийг шалгадагч болон хамрагдагч байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн тайлбартай танилцаж аудитын дүн, дүгнэлтийг эцэслэн баталгаажуулах үе шатны ажил хийгдэж байна. Аудитын тайланг баталгаажуулан 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Төсвийн байнгын хороо болон холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд иргэд олон нийт аудитын цахим сайтаар дамжуулан тайлантай танилцах боломжоор бүрэн хангахаар төлөвлөж байна.

Энэхүү сонсголд уг асуудлаар ажиллаж буй аудитын багийн төлөөлөл холбогдох асуултад хариулахаар бэлэн оролцож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За баярлалаа. Илтгэгчид 10 минутад багтааж мэдээлэл хийх шаардлагатай учраас Та бүхэн цагаа барихыг хүсье.

Зам, тээврийн яамны бодлого ба нийслэлийн зам тээврийн мега төслүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо (Туулын хурдны зам, Метро, Дүүжин тээвэр, Тойрог 1, 2-р зам, Трам, Тусгай замын автобус зэрэг) Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан. Мэдээлэл хийх хүн байна уу? Нэр, албан тушаалаа танилцуулаад танилцуулгаа эхлээрэй. Түрүүчийн танилцуулга дээр Зам, тээврийн сайд, нийслэлийн Засаг даргын хамтарсан шийдвэрээр төсөвт өртгийг 1,9 их наяд төгрөг байхаар тооцоод тендерийн баримт бичигт тусгасан. Энэ асуудлаар холбогдох 2 байгууллагаас аудитын явцад тайлбар ирүүлээгүй байна гэсэн мэдээлэл өгсөн. Үүнийг танилцуулга хийхдээ анхаараарай гэж хүсье.

Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа: Зам, тээврийн яамны бодлого, нийслэлийн зам тээврийн мега төслүүдийн уялдаа холбоо гэсэн сэдвээр танилцуулга хийе. Зам, тээврийн яамны хувьд холбогдох салбарын болон яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн зөвлөмж гарган ажиллаж байна. Зөвлөмжтэй холбоотой асуудлуудыг мега төслийнхөн болон мега төслийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байгаа газрууд нарийвчилсан зураг төсөлдөө тусган ажиллаж байгаа. Жишээлбэл, Туулын хурдны зам дээр Авто замын салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөс зөвлөмж гаргаж хүргүүлсэн.

ТЭЗҮ-ийг Хот төлөвлөлт, судалгааны институтээс боловсруулан хэлэлцүүлсэн. Үүнд зөвлөмжийг хүргүүлсэн. Тухайн санал болгож байгаа трасс нь нийслэлийн авто замд хамаарч байгаа тул Эй Эйч (АН)-3 замаар дайран өнгөрөх эсэхийг тодруулах, 2 дугаарт геодези, байр зүйн судалгааны ажлыг сайжруулан нэмэлтээр оруулах, 3 дугаарт зам, барилгын материалын орд газрын байршил, эзэмшлийн талаарх мэдээллийг тайлбарын хамт оруулж, гидрологийн судалгааг нарийвчлан тайланд тусгах, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Усны газар, Эрчим хүчний яамнаас санал зөвлөмж авч тайланд тусгах, Туул голын ай сав газрын зөвшөөрлийг авах, авто замын трассын дагуу шаардлагатай хэсгүүдэд хайс, гэрэл гялбаа сарниулагч, дуу чимээ тусгаарлагч, хяналтын камер зэрэг тоноглолуудыг нэмж, тооцоо судалгааг нарийвчлан оруулах, Трассын чиглэлд зам барилгын ажил хэрэгжих үед түр зам гаргах талаар урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлын тоо хэмжээг гаргах, Төсөвт нэмэлтээр тусгах эсэхийг шийдвэрлэх, Зайсангийн гүүрнээс баруун тийш шаардлагатай зурвас газрыг хэвээр үлдээх эсэхийг шийдвэрлэх, нийслэлийн авто замын түгжрэлийн судалгаа, тооцооллыг нарийвчлан хийж, өгөгдлийг зөв болгох, Улаанбаатар хотын төвөөр дайран өнгөрч буй төмөр замыг шилжүүлэх трассын хувилбарыг судлан сонгогдсон трасстай харьцуулах, орц, гарц төлөвлөгдсөн газруудад шилжилтийн зурвас нэмэх тооцооллыг хийх, Туулын ай савыг хамгаалах талаар санал шийдлийг тусгах эсэхийг шийдвэрлэх, гүүрний тоо хэмжээ, төлөвлөлтийг нарийвчлан судалж, тооцооллыг тусгах, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацааг бодитоор тооцоолох, Авто замын байгууламжийн ажилд шинэ техник технологийг ашиглах, норм, стандартыг боловсруулах, гүүр, гүүрэн байгууламжийн ачааллын тооцооллыг нарийвчлан тооцоолж норм дүрэм, шаардлагад нийцүүлэх, гүүрний геологийн судалгааг өрөмдлөг хийсэн эсэхийг тодруулах, тулгуур суурийн тооцооллыг дахин нарийвчлан гүйцэтгэх, ТЭЗҮ боловсруулах судалгааг хариуцан гүйцэтгэж буй авто замын зургийн инженер, гүүрний инженерийг тодорхой болгож ажлыг хариуцуулан үүрэгжүүлсэн

Танилцуулгад дурдсан 2014 онд боловсруулсан ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж байгаа тул Эм Си Пи Си компани 2014 онд боловсруулсан ТЭЗҮ нь зохиогчийн эрх авсан байх магадлалтай. Тухайн үед Эм Си Пи Си компанийн зураг болон ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл Зам, тээврийн сайдын тушаалаар

хүчингүй болсон байгааг магадлах, хучилтын хийцлэлийг дахин тооцоолох, явган зорчигчдын зам хөндлөн гарах зорчилтын судалгааг гүйцэтгэх, замын трассыг томоохон хотхонуудаас шаардлага хангахуйц зайтайгаар төлөвлөх, трасст өртөх нэгж талбаруудын газруудыг боломжит хамгийн бага хэмжээгээр төлөвлөх зэрэг асуудлуудаар зөвлөмж гаргаж өгсөн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг нийслэлийн Замын хөгжлийн газраас албан бичгээр тодруулга авахад нарийвчилсан зураг төсөлд тусгаж байна гэсэн хариуг ирүүлсэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Энэ танилцуулга нь “Зам, тээврийн салбарын бодлого ба нийслэлийн тээврийн мега төслүүдийн уялдаа холбоо” гэсэн сэдэвтэй байсан. Танилцуулгад 1, 2 дугаар тойрог замын төслийн үндэслэл, эрх зүйн баримт бичгүүдийг дэс дарааллаар нь дурдлаа. Таны нэр, албан тушаал хэн билээ, би зүгээр сонсчихъё. Хөтөлбөрт Б.Дэлгэрсайхан сайд байсан, Тамгын газраас надад ямар нэгэн мэдээлэл өгөөгүй болохоор түрүүн би байгаагаар нь уншсан. Урьдчилж мэдээлээгүй юм уу? Хөтөлбөр дээр Зам, тээврийн яамнаас сайд Б.Дэлгэрсайхан мэдээлэл хийх ёстой байсан. Урьдчилж мэдээлсэн зүйл надад ирээгүй. Тамгын газрынхан анхаарч ажиллахыг хүсье.

2 дугаарт, хүмүүст мэдээлэл өгөх гэж сонсгол хийж байгаа. Түүнээс аргалж, цаг өнгөрөөх гэсэн юм байхгүй. Парламентыг үл хүндэтгэх тухай заалтыг би уншиж өгсөн. Парламент хүндэтгүүлэх гээд байгаа зүйлгүй, иргэд, ард түмний төлөөлсөн хурлын байгууллага, “парламентын гишүүн ард түмний элч” гэсэн заалттай. Энэ мэдээлэл хүмүүст хүрч байгаа, хүмүүс сонсохыг хүсэж байгаа гэдгийг дараа дараагийн танилцуулга хийх төрийн албан хаагчид Та бүхэн анхаараарай.

Дараагийн танилцуулга “Туулын хурдны замын төслийн хэрэгжилтийн явцад гарсан зөрчлүүд, авсан арга хэмжээ” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир танилцуулна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир: Ерөнхий хяналтын сонсгол даргалагч болон гишүүд, сонсголд оролцож байгаа оролцогч нартаа өдрийн мэнд хүргэе.

Туулын хурдны замын төсөлтэй холбогдуулаад манай яамнаас танилцуулах төслийн хэрэгжилтийн явцад гарсан зөрчил, авсан арга хэмжээний талаар мэдээлэлтэй холбогдуулан дараах 4 агуулгын хүрээнд мэдээлэл бэлдсэн.

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний талаар;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний талаар;
- Усан орчны экологийн асуудлын талаар;
- Ой модны экологийн асуудлын талаар.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний талаар

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг тус төсөл дээр Мон газар экологи ХХК 2025 онд хийж гүйцэтгэсэн. Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 7.3-д заасны дагуу ерөнхий үнэлгээний 2025 оны А/325 дугаартай “Байгаль орчны ерөнхий үнэлгээ”-ээр нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байдаг. Ингээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 28, 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар Байгаль орчны

нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцэж нэмэлт, өөрчлөлт, засвар хийж, 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн баталж, албажуулсан байдаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний талаар

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам батлаагүй байхад “Хао Юань женерал констракшн” ХХК гадаадын хөрөнгө оруулалттай компани төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн нь Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.1-д заасан “тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ” гэсэн заалтыг зөрчсөн тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хурлаар “Туулын хурдны зам”-ын төслийн үйл ажиллагааг түр зогсоож, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулахыг төсөл хэрэгжүүлэгчид үүрэг болгож шийдвэрлэсэн.

Хао юань женерал констракшн ХХК гадаадын хөрөнгө оруулалттай компани нь “Туулын хурдны зам”-ын төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлага биелүүлээгүй, Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй, усыг зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр ашигласан гэх зөрчилд нийслэлийн Прокурорын газар 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн БО01/2618 дугаартай гомдол мэдээлэл, 2026 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн БО01/2627, БО01/2628 дугаартай гомдол мэдээллүүдийг тус тус бүртгэсний дагуу тус яамны Байгаль орчны улсын хяналтын газраас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн нийслэлийн Прокурорын газрын дугаартай зөрчлийн хэрэг нээн хуульд заасны дагуу шийтгэлийн арга хэмжээг авсан. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий ААН болох “Сайхан ариун дэлхий” ХХК нь “Туулын хурдны зам” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, ерөнхий шинжээчийн шийдвэрээр 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан болно.

Усан орчны экологийн асуудлын талаар

Усан орчны экологийн асуудлын чиглэлээр усан орчны судалгааг төсөл захиалагчийн батлуулсан ТЭЗҮ болон зураг төсөл, инженерийн судалгаа, ус зүйн судалгаа зэрэг тооцооны тайлангуудыг үндэслэж усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг мэргэжлийн байгууллага тодорхойлсон.

Замын төсөл хэрэгжих ажлын явцад технологийн усны хэрэглээг 47000521,8м³ ундны усны хэрэглээг 1000390,2м³ шаардагдахаар тооцоолсон байна. Замын ажлын бүтээн байгуулалтын үед гүний 4-6 худаг гаргаж унд, ахуйн ус хэрэглэхээр төлөвлөсөн бөгөөд технологийн усыг Туул голоос авахаар ТЭЗҮ-д тусгаж батлуулсан байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн

А/37, А/31 дүгээр тушаалаар баталсан “Хүрээлэн байгаа орчны хохирол тооцох аргачлал”-аас гадна Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ”, 2 дугаар хавсралтаар “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”, БОАЖ-ын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дүгээр тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”, 7 дугаар хавсралтад заасан “Авто замын салбарын усны норм”-ыг үндэслэн нийт экологи, эдийн засгийн үнэлгээ нь 775,4 сая төгрөгөөр тооцоолсон байна. Гол дотор баригдах гүүрний суурь 8 байршилд нийт 18 ширхэг гүүрний суурь суурилагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан болно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар 29 зөвлөмж өгч, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгуулсан байна. “Туулын хурдны зам” төслийг хэрэгжүүлэгч Хао Юань Женерал констракшн ХХК гадаадын хөрөнгө оруулалттай компани нь хайгуул судалгааны ажлын гэрээг Жун Юань компанитай байгуулсан байх бөгөөд хайгуулын үед ашигласан усыг зохих гэрээ, зөвшөөрөлгүй ашигласан зөрчилд нийслэлийн Прокурорын газар 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн БО01/28 гомдол мэдээллээр 4 дүгээр сарын 21-ний өдрийн дугаартай зөрчлийн хэрэг үүсгэсний дагуу тус яамны Байгаль орчны улсын хяналтын газраас Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаар 5 мянган нэгж торгууль оногдуулснаар 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хэргийг хааж, зөрчлийн үр дагаврыг арилгуулах эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэн зөрчлийн хэргийг хянуулахаар прокурорын байгууллагын хяналтад хүргүүлсэн байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед “Туул хурдны зам”-ын төслийн геологи хайгуулын судалгааны явцад өрмийн үйл ажиллагаанд ашигласан химийн бодисын асуудлаар ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албанд 10/2261 дугаартай албан бичиг хүргүүлж, 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 13-5/2026 дугаартай албан бичгээр уг асуудлыг гомдол мэдээлэлд оруулан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн болно.

Ой модны экологийн асуудлын талаар

Ой модны экологийн асуудлаар авто замын трасст өртөх модны талбай болон тоо хэмжээг тооцохын тулд хээрийн судалгааг 2025 оны 10 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн байх бөгөөд Туул голын дагуух гол төлөв хайлаас, улиас болон бургасан ойн бүрэлдэхүүнийг тооцохдоо ойг бүрдүүлж буй мод төрөл тус бүрийн эзлэхүүнийг тооцож, ойн нөөцөөр эзлэх хувийг тогтоосон байна. Түр зам байгуулахад өртөх ойн 50 хувийг улиас, 50 хувийг бургас зонхилсон ой эзэлж байх бөгөөд улиасан ойн дундаж нас 50 жил, дундаж өндөр 12,4 метр, дундаж диаметр 21,5 см байгааг тогтоосон. Харин бургасан ой нь дундаж нас 38 жил, дундаж өндөр 3,9 метр, салаалалтын дундаж тоо 16 байсан нь судалгаагаар батлагдсан. Нийт авто замын трассын дагуух мод, сөөг нийтдээ 14 байршилд 43,2 га талбайг хамарч байна. Жишээлбэл, Зайсангийн гүүр орчимд хамгийн их буюу 6,6 га талбайг хамарч байна.

Замын трасст өртөх бургас, улиасан ойн экологи, эдийн засгийн үнэлгээг БОАЖ-ын сайдын 2020 оны А/176 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасан “Ойгоор бүрхэгдсэн 1 га талбайн экологи-эдийн засгийн үнэлгээ”-ний шууд болон шууд бус нөлөөллийг тооцсон нийт үнэлгээний төлбөрийн 1 дүгээр мужаар тооцоолоход улиасан ой 10,6 га талбай, бургасан ой 32,531 га талбай өртөж байгаа тул экологи-эдийн засгийн үнэлгээгээр нийтдээ 805,0 сая төгрөгөөр үнэлж тодорхойлсон байна. Үнэлгээний тайланд мод, сөөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг

бууруулах, арилгах 19 зөвлөмжийг өгч, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгуулсан байна. Хао юань Женерал констракшн ХХК нь мод тайрах, зөөвөрлөн тээвэрлэх, туслан гүйцэтгэх гэрээг Дорно Улзын Мандал ХХК-тай байгуулсан боловч Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу өсвөр залуу модыг шилжүүлэн суулгахгүйгээр тайрч огтолсноос нийт 7,2 га талбайн дунд насны улиас, бургасан ойг сүйтгэсэн байна. Туслан гүйцэтгэгч Дорно Улзын Мандал ХХК-ийн гаргасан зөрчилд нийслэлийн Прокурорын газар 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн БО01/26/27 дугаар зөрчлийн гомдол мэдээлэл бүртгэсний дагуу тус яамны Байгаль орчны улсын хяналтын газраас 4 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар зөрчлийн хэрэг үүсгэж, Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь заалтад зааснаар 500 нэгж торгууль, хохирол нөхөн төлбөрт 352,000,233.1 мянган төгрөгийн шийтгэлийг оногдуулсан байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ц.Сандаг-Очир сайдад баярлалаа. Сайдын танилцуулгын дэлгэрэнгүй саяын текст ирэх байх тийм ээ?

Туул хурдны замын төслийн хүрээнд хийсэн худалдан авах ажиллагаанд хийсэн дүгнэлтийн талаар Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Б.Энхбаяр танилцуулна.

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Б.Энхбаяр: Та бүхний өдрийн амгаланг айлтгаж мэндчилье. Төрийн худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлэх Засгийн газрын хяналт нь Засгийн газрын тухай хуульд зааснаар Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байдаг бөгөөд “Туул хурдны замын худалдан авах ажиллагаанд хийсэн шалгалтын дүн”-г Сангийн сайдаас Монгол Улсын Ерөнхий сайдын нэр дээр 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01/5434 тоот албан бичгээр ирүүлснийг та бүхэнд товчилж танилцуулъя.

Худалдан авах ажиллагаанд хийсэн шалгалт үндсэндээ 6 чиглэлээр хийгдсэн.

1. Гэрээ байгуулах эрх олгосон түншлэл тендер шалгаруулалтын шаардлага, шалгуурт нийцсэн эсэх;
2. Түншлэлийг төлөөлж гэрээний хэрэгжилтийг хангах нэг гишүүнийг томилсон эсэх;
3. Тендерт эрх олгосон түншлэлийн тусгай зөвшөөрөл хуулийн шаардлагад нийцсэн эсэх;
4. Тендер шалгаруулалтын шаардлага болох татвар, нийгмийн даатгалын өр төлбөрийн лавлагаа;
5. Тендерт оролцогч хуулийн этгээдийн санхүүгийн баталгаа, чадамж;
6. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага, ур чадвар гэсэн хүрээнд танилцуулгыг бэлтгэж та бүхэнд танилцуулъя.

1.Гэрээ байгуулах эрх олгосон түншлэл тендер шалгаруулалтын шаардлага, шалгуурт нийцсэн эсэх

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан “Туулын хурдны зам”-ын ажил гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад 4 компани оролцсон. Захиалагчаас Чайна Хуавэй групп Лимитед (China Huway Group Limited) болон Тяньжин Оү Бай Вэй (Tianjin Oubaiwei) компанийн түншлэлд 2025 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 03/2052 тоот шийдвэрээр гэрээ байгуулах эрх олгосон байна.

Чайна Хуавэй групп болон Тяньжин Оү Бай Вэй ХХК-ийн түншлэл нь

тендерийн цахим системээр компанийн худалдааны менежер Д.Золбоо 2025 оны 6 дугаар сарын 27-ны 01 цаг 19 минут 33 секундэд цахим тоон гарын үсгээр баталгаажуулж илгээсэн байна. Д.Золбоо нь тус компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болохыг нотолсон, захирал Лю Дай Вэн (Liu Daiwen)-ээс олгосон итгэмжлэлийг ирүүлээгүй байгаа нь холбогдох хуулийн шаардлагад нийцэхгүй байна гэдэг дүгнэлтийг хийсэн.

2.Түншлэлийг төлөөлж гэрээний хэрэгжилтийг хангах нэг гишүүнийг томилсон эсэх

Чайна Хуавэй групп болон Тяньжин Оү Бай Вэй компани 2025 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн HYWAY-2025-005 дугаартай “Консерциумын гэрээ”-ний дагуу түншлэлээр оролцсон боловч уг гэрээнд түншлэлийг төлөөлөн оролцох, гэрээний хэрэгжилтийг захиалагч, хуулийн этгээдийн өмнө хариуцах нэг гишүүнийг томилоогүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.2.3 дахь заалтыг зөрчсөн байна.

3.Тендерт эрх олгосон түншлэлийн тусгай зөвшөөрөл хуулийн шаардлагад нийцсэн эсэх

Тендерт эрх олгосон түншлэлийн тусгай зөвшөөрөл хуулийн шаардлагад нийцсэн эсэхийг шалгаж үзэхэд Чайна Хуавэй групп (China Hyway Group) нь Бүгд Найрамдах Ангол Улсын тусгай зөвшөөрөл ирүүлсэн. Тяньжин Оү Бай Вэй (Tianjin Oubaiwei) компани Бүгд Найрамдах Серб Улсын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн тусгай зөвшөөрөл ирүүлсэн. Серб Улсын тусгай зөвшөөрлийн орчуулгад “ОүБайВэй” ХХК, “Белград-Шингэ Белград” гэсэн нь “OBW Grandja Doo Beograd-Novi Beograd” гэсэн эх хувиас зөрүүтэй байна.

Тусгай зөвшөөрлийн өөрчлөлтийн хувьд Тяньжин Оү Бай Вэй (Tianjin Oubaiwei) компани Серб Улсад үүсгэн байгуулсан Белград “OBW барилгын ХХК”-д өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд өөрчлөлтийн агуулга нь Серб дэх “Белград Барилгын” компанийг “OBW барилгын ХХК” болгон өөрчилж, хөрөнгө нэмэхээр болсон. Ийм өөрчлөлтийг ирүүлсэн Тяньжин Оү Бай Вэй (Tianjin Oubaiwei) компани өөрийн тусгай зөвшөөрлийг ирүүлээгүй, оронд нь Серб Улсад үүсгэн байгуулж, хөрөнгө оруулсан “OBW барилгын ХХК”-ийн тусгай зөвшөөрлийг ирүүлсэн байна.

4.Тендер шалгаруулалтын шаардлага болох татвар, нийгмийн даатгалын өр төлбөрийн лавлагаа

Татвар нийгмийн даатгалын өр төлбөрийн лавлагааны тухайд түншлэл нь тендер зарласнаас хойших байдлаар эрх бүхий байгууллагаас татварын өргүй болохыг нотлох баримт бичиг ирүүлээгүй. Чайна Хуавэй групп (China Hyway Group) хугацаа хэтэрсэн өргүй тухай тодорхойлолтыг өөрөө гаргаж ирүүлсэн байна.

Ситибанк Эн Эй Хонконг (Citibank N.A HongKong) банкны и-мэйл ирүүлсэн боловч зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолттой адилтгах баримт бичгийг ирүүлээгүй байна.

5.Тендерт оролцогч хуулийн этгээдийн санхүүгийн баталгаа, чадамж

Тендерт оролцогчийн санхүүгийн баталгаа чадамжийн тухайд Гуандун

мужийн “Дэн Ги Да инженеринг батлан даалт” ХХК-аас олгосон зээлжих чадварын батламжийг тус тус ирүүлсэн. Харилцагч банкны дансны үлдэгдэл, арилжааны банкнаас зээл авах боломжтой тухай тодорхойлолтыг ирүүлээгүй байна.

6.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага, ур чадвар

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын хувьд Чайна Хуавэй групп (China Huway Group) нь 2008-2017 онд Мозамбик Улсын төмөр замын их засвар, барилгын ажлыг гүйцэтгэсэн. 2014-2019 онд Сербийн E763 хурдны замын төсөл, 2015-2024 онд Би Эй Ай Эй (BAIA) өртөө - Лунадагийн нисэх буудлын төмөр замын хажуу шугамын ажил, Тяньжин Оү Бай Вэй (Tianjin Oubaiwei) компани нь Мозамбекийн төмөр замын засвар, Сербийн хурдны замын төсөл болон Лунадагийн нисэх буудлын төмөр замын хажуу шугамын төсөл гэсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн гэдэг мэдээллийг ирүүлсэн боловч сая дурдсан 2 түншлэлийн компанийн ирүүлсэн 5 ажлаас 4 нь тухайн ажлыг хийж гүйцэтгэсэн гэх комиссын акт, дүгнэлт байхгүй, материал дутуу, шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт хийснийг та бүхэнд танилцууллаа. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Дараагийн танилцуулга “Туулын хурдны зам”-ын төслийн төсвийн зарцуулалт, холбогдох баримт бичигт хийсэн дүгнэлтийг шинжээч С.Бат-Эрдэнэ, Э.Батболд, Д.Энхбаяр танилцуулна.

Шинжээч С.Бат-Эрдэнэ: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. “Туулын хурдны зам” төслийн техникийн цэгийн зураг төслийг 2013-2016 оны хооронд Барилгын хөгжлийн төв болон Зам, тээврийн хөгжлийн төвөөс зураг төсвийг магадалж 594,9 тэрбум төгрөгөөр хянасан байна. Нийслэлийн ЗДТГ-аас дээрх 2016 оны төсвийг шинэчлүүлж 2 урсгалтай 4 эгнээ бүхий 33 км авто замыг 916,3 тэрбум төгрөгөөр магадлан ерөнхий дүгнэлтийг гаргуулж, төсөвт суулгасан байна. Үүний дараа Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу 2 урсгалтай 6 эгнээтэй болгон төлөвлөж, зураг төслийг шинэчлэн боловсруулах ажил эхэлсэн байна. Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн төвийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06/25 дугаартай магадлалаар ТЭЗҮ, урьдчилан зураг төслийг магадалж, мөн Барилгын хөгжлийн төвийн 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 316/2025 магадлалын дүгнэлтээр ТЭЗҮ, урьдчилан зураг төсөвт өртгийг баталж, төсөвт өртгийг 2,3 их наяд төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Гэвч зураг төсөл, төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар батлуулаагүй байхад нийслэлийн Засаг даргын 2025 оны А77 дугаар захирамжаар “Туулын хурдны зам”-ын хөрөнгө оруулалтыг 1,9 их наяд төгрөгөөр нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлсэн байна. Техникийн шийдлийг анхнаасаа тогтоогоогүй төсөвт тусгасан нь төсвийн төлөлтийг алдаатай төлөвлөсөн байдлыг бий болгосон гэж үзэж байна. Мөн тендер шалгаруулалтын явцад гэрээний загварыг Засгийн газрын 2025 оны 78 дугаар тогтоолоор фидик (FIDIC) гэрээгээр нийлүүлж шилжүүлсэн нь сонгон шалгаруулалтын процедурыг удаашруулж, хугацааг хойшлуулах нөхцөлийг бий болгосон байна.

Сонгон шалгаруулалтад тусгасан шалгуур үзүүлэлт нь дотоодын ААН-үүдийг оролцох боломжийг хязгаарласан тендерийн баримт бичгийг тусгаж оруулсан байна. Тухайлбал, санхүүгийн чадавхыг сүүлийн 3 жилийн аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувь буюу 982,4 тэрбум төгрөг байгаа нь хэт өндөр, техникийн чадавх нь сүүлийн 5 жилд 300 сая ам.долларын үнийн дүнтэй 5 ажил, цельсийн -20 градусаас хүйтэн уур амьсгалтай бүсэд нэг ажил заавал гүйцэтгэх зэрэг хэт өндөр шалгуур

үзүүлэлтүүдийг тогтоож өгсөн байна. Мөн ажлын нарийвчилсан зураг төслийг батлуулалгүйгээр зөвхөн урьдчилсан төсвөөр гүйцэтгэгчийн материалыг үнэлсэн нь төсөвт өртгийг харьцуулах боломжгүй шийдвэр гаргах эрсдэлтэйг харуулж байна. Худалдан авах ажиллагаагаар сонгон шалгаруулсан ХаоЮОань групп болон Тяньжин ӨүБайВэй нарын түншлэлийн гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгаа дээр Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан мэдээллээс үзэхэд даатгагчийн баталгааны гэрээ гэж үзэхээргүй байгааг бас анхаарах шаардлагатай байна. Дээрх урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслээд 500 тэрбум төгрөгийг 13 гүйлгээгээр шилжүүлсэн байна.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн ямаар төсвийн ТЭЗҮ боловсруулах худалдан авах ажиллагааны дараа батлуулсан байгаа нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуультай нийцэхгүй байна.

Төслийн авто замын трассын өөрчлөлтөд нийт 112 нэгж талбар өртсөнөөс 58 нэгж талбарын газар эзэмшигч, ашиглагчтай зөвшилцөж, 54 нэгж талбарын иргэн, хуулийн этгээдтэй зөвшилцөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.2 дахь заалттай нийцээгүй гэж үзэж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд төлөвлөлтийн үе шат, “Туулын хурдны зам”, авто зам, гүүрэн байгууламжийн инженерийн үндсэн шийдэл байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон төсөвт өртгийн магадлалын дүгнэлт эцэслэн баталгаажуулжээс төслийн хэрэгжилтийн явц, техникийн шийдэл удаа дараа өөрчлөгдөж төсөвт өртгийг 160 хувиар нэмэгдүүлсэн байна. Гүйцэтгэгч компаниас ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгаа нь холбогдох хууль, журамд заасан баталгааны хэлбэрээр ирүүлсэн байх боловч баталгаа гаргагч этгээдийн эрх зүйн байдал, санхүүгийн чадавх, баталгааны хүчин төгөлдөр байдал болон баталгааны үүргийг хэрэгжүүлэх боломжийг нотлох баримтын хүрээнд үнэлэх боломжгүй байна.

Төслийн шинэчилсэн зураг төслийн дагуу замын дараалсан нөлөөлөлд өртсөн нийт нэгж талбайн 48,2 хувийн эзэмшигчидтэй газар чөлөөлөх асуудлаар зөвшилцөлд хүрээгүй байгаа нь төслийн бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй, иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдөх, шүүхийн маргаан үүсэх, төслийн хугацаа сунжрах, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэй гэж үзэж байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хуульд заасан хугацаанд боловсруулж, мэргэжлийн эрх бүхий байгууллагуудаар батлуулаагүй нь төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргах, санхүүжилтийг төлөвлөх болон худалдан авах ажиллагааг эхлүүлэхээс өмнө байгаль орчны үнэлгээг баталгаажуулах шаардлага хангагдаагүй гэж үзэж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Их чухал дүгнэлт хэлээд байна. Гэхдээ их аяархан яриад сайн сонсогдсонгүй болчих шиг боллоо. Гишүүдийн хувьд асуулт, хариултын цаг байгаа. Оролцогчид дэгээрээ асуулт асуух боломжгүй. Тиймээс оролцогчдоос дахиж тодруулж мэдээлэл авах уу? Та бүхэн юу гэж бодож байна? “Туулын хурдны зам” төслийн төсвийн зарцуулалт холбогдох баримтад хийсэн дүгнэлтийн талаар Шинжээч Э.Батболд, Д.Энхбаяр нараас дэлгэрүүлж, тодотгож өгөх мэдээлэл байна уу? Д.Энхбаяр шинжээчээс нэмэлт дэлгэрүүлж өгөх мэдээлэл байна уу? Байхгүй бол асуулт, хариулт дээр Та бүхэнд асуух зүйл байвал бичгээр өгөөрэй.

Одоо Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Нийслэлийн

бүтээн байгуулалтын бодлогын уялдаа холбоо, төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах санал, дүгнэлтийн талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд ирэх боломжгүйг урьдчилж мэдэгдсэн учраас ТНБД М.Баяраа танилцуулна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-аас авсан мэдээлэлд үндэслэж 2026 оны 5 дугаар сард гарсан 16 мега төслийн хэрэгжилтийн мэдээллээр Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болох “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтуудын хүрээнд нийслэлийн нийтийн тээврийн 4 төсөл, авто зам, замын байгууламжийн 3 төсөл, орон сууцжуулалтын 3 төсөл, Эрчим хүч, дэд бүтцийн 4 төсөл, усны менежмент, үерийн эрсдэлийг бууруулах 2 төсөл, нийт 16 томоохон төсөл, арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн бүрдэл”-ийг баталсан. Одоогоор 2020 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссантай холбогдуулан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г 2017 оноос боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, одоогоор Байнгын хороод дээр хэлэлцүүлэгдэж байна. За энэ баримт бичгийг батлагдсаны дараа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Засгийн газрын тогтоолоор батлах ёстой. Өөрөөр хэлбэл нийслэлийн 16 төсөл уг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаж, улсын хэмжээнд нэгдсэн байдлаар хэрэгжих учиртай. Мөн Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйл буюу аймаг, нийслэлийн ИТХ-ын бүрэн эрхийн 8.1.6-д “нийслэл, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах,” гэж заасан заалтыг цаашид анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, нэгдсэн бодлогоор Хот байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах шаардлагатай гэж үзэж байна. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Нэмэлт мэдээллийг асуулт, хариулт дээр авч болох байх. Одоо Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, зураг төсөл батлагдсан үйл явцын талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД М.Баяраа мэдээлэл өгнө.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа: Сэлбэ дэд төвийн орон сууцжуулалтын ТЭЗҮ, зураг төслийн талаар танилцуулъя.

Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг

хандлага"-д нийслэлийг нэг төвт бүтэцтэй хотоос олон төвт хот болгон хөгжүүлэхээр тусгагдсан. Энэ хүрээнд Толгойт, Баянхошуу, Сэлбэ, Дэнжийн мянга, Шар хад, Дамбадаржаа зэрэг 6 дэд төвүүдийг хөгжүүлэхээр төлөвлөсөн. Мөн "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төсөлд нийслэлийг 20 минутын олон төвт хот болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Сэлбэ дэд төвийн 158 га талбайд гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулахаар баталсан. Өнөөдрийн сонсголтой холбогдуулан төслийг хэрэгжүүлэгч "Сэлбэ 20 минутын хот" корпорацаас манайд ирүүлсэн ТЭЗҮ, зураг төсөлтэй танилцахад дараах нөхцөл байдалтай байна.

Нийслэлийн ИТХ-ын 2023 оны 61 дүгээр тогтоолоор Сэлбэ дэд төвийн 58 га талбайн хил заагийг баталсан. Үүний дагуу нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогчийн 2023 оны 2023/11 дугаартай ТЭЗҮ, барилгажилтын төсөл, зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг баталж, сонгон шалгаруулалтыг зарлан гүйцэтгэгчээр Би Би Эс Мо компани шалгарсан. Би Би Эс Мо компанийн хийсэн төслийн ТЭЗҮ-г Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15/2025 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр, барилгажилтын төслийг нийслэлийн Ерөнхий архитекторын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр тус тус батлуулсан. Төслийн хүрээнд 8575 айлын нийтийн зориулалттай орон сууц, 3457 айлын амины болон үйлчилгээтэй орон сууц, 3780 хүүхдийн хүчин чадалтай 3 сургууль, 1200 хүүхдийн хүчин чадалтай 5 цэцэрлэг байгуулахаар төлөвлөжээ. Төслийн хэрэгжилтийн хүрээнд 2206 айлын хашаа, байшин чөлөөлөгдөж, үүнд нийслэлийн төсвөөс 405,0 тэрбум төгрөг зарцуулсан. Нэг өрхийн газрыг дунджаар 183,6 сая төгрөгөөр чөлөөлсөн байна.

Үүнтэй холбоотойгоор нийслэл болон хөдөө орон нутаг, салбарын яам дээр хэрэгжүүлж байгаа төслийн жишээг бас дурдъя.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 оны 88 дугаар тушаалаар "Ногоон нуур 1008 айл" төсөлд иргэдийг хамруулах зорилгоор нийслэлийн төвийн 6 дүүргийн Засаг дарга, холбогдох мэргэжлийн байгууллагаас бүрдсэн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 18.3-д заасан эрэмбийн дагуу газрыг орон сууцаар солих хэлбэрээр хэрэгжүүлсэн бол иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулахад илүү үр дүнтэй, бодитоор яндан дахин үүсэхгүй байх боломжийг эрэлхийлж энэ төслийг хэрэгжүүлж байна. Цаашид орон сууцжуулах ийм төслийг хэрэгжүүлэхдээ төрөөс газар, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хөгжүүлэх, бэлдсэн газар дээр хувийн хэвшилтэй хамтран хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж, төрөөс илүү баталгаа, батлан даалт хийх замаар зохион байгуулалтыг хариуцаж ажиллах, төсөвт учруулах дарамтыг бууруулах чиглэлийг баримталж ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд Орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг 6 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан ба энэхүү хуульд эдгээр зохицуулалтуудыг хамруулан тусгасан болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: М.Баяраа даргад баярлалаа.

Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, Сэлбэ хорин минутын хот төслийн төсвийн гүйцэтгэл, холбогдох баримт бичигт хийсэн дүгнэлтийн талаар шинжээч З.Туяа, Э.Батболд, Д.Энхбаяр нар танилцуулна.

Шинжээч 3.Туяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраагийн танилцуулга дээр нэмэхэд энэ төсөл бол Азийн Хөгжлийн банкны төслийн хүрээнд 2011 оноос хойш ТЭЗҮ нь бэлтгэгдээд, түүнд зориулан Улсын Их Хурлаас 2013 онд батлагдаад, ИТХ-аар газар, байршил, ерөнхий төлөвлөгөө нь баталгаажиж, цааш төсөл хэрэгжүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, төсөл нь 2013 онд Улсын Их Хурлаар батлагдаж, 2014 оноос эхэлсэн.

“Сэлбэ 20 минут хот” гэсэн нэртэй болоод, энэ төслийн ачааллыг нэмэгдүүлсэн байгааг та бүхэн харж байна. Ер нь 5 давхраар нягтруулж гэр хорооллыг хөгжүүлэх, амины орон сууцтай иргэдтэйгээ хамтарч хөгжүүлнэ гэсэн энэ төсөл хэдийд өөрчлөгдөв гэдгийг хөөгөөд үзсэн боловч яг нарийн шийдвэр гараагүй, хаана баталгаажсан нь мэдэгдээгүй. Гэхдээ Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль 2023 онд гарснаас эхэлжээ гэж ойлгож байгаа юм. Энэ хуулийг хэрэгжүүлэх хүрээнд. Энэ хууль 2023 оны 12 сараас хойш ердөө 2024 оны 11 сард бонд гаргах хүртэл маш богино хугацаанд ажилласан байгаа. Тэгэхээр энэ шийдвэр гаргалтын процессоос харвал Засгийн газар орон нутгийн захиргаатай ойлголцвол маш хурдан шийдвэр гарч, зохион байгуулж болдог юм байна гэсэн сайн жишээг нэг талдаа харуулж байна. Нөгөө талдаа харвал өөрөө бэлтгэлгүй байвал ямар хэмжээнд хүргэдэг вэ гэдгийг одоо харуулах болно. Энэ төсөл бол түрүүн хэлсэн 2015 онд ИТХ-аар батлагдсан 23500 хүн амтай болох ийм хороолол, үүнд зориулсан дэд бүтцийг Азийн Хөгжлийн банкны төслөөр зээл авч байгуулаад 2021 онд дуусгасан.

2024 ТЭЗҮ-ийг дахин шинэчлээд ойролцоогоор 48,200 хүнтэй болгохоор ачааллыг нэмэгдүүлсэн. Энэ нь Азийн Хөгжлийн банкнаас авсан дэд бүтэц дээр дахиад ачааллууд нэмэгдлээ гэсэн үг юм. Энэ ажиллагаа явагдсан. Дээрээс нь 2015 онд батлагдсан ерөнхий төлөвлөгөө дээр халиа дош үүсэж байсан байгаль орчны төлөв байдлын хувьд нэлээн эмзэг хэсэг газар дээр барилга барихгүй, нэлээдгүй нээлттэй орон зайтай төлөвлөж байсан. Энэ тодотголоор битүү орон сууц бариад эхэлсэн. Нөгөө талдаа болохоор гэр хорооллын дунд яндан байгуулсан. Энэ байгуулсан яндангийн доор амины сууцын зориулалтаар ашиглах байсан. Анхны ерөнхий төлөвлөгөөгөөр бол үйлдвэрийн зориулалттай ашиглагдах байсан. Өөрөөр хэлбэл утааны хаялга доор, салхины доор байгаа учраас үйлдвэрлэлийн зориулалттай байсан. Гэхдээ саяны тодотголоор дахин өөрчлөгдөж орон сууц болсон. Өөрөөр хэлбэл яндангийн өндөр 86 метр, барьж байгаа байшин маань бараг тавиад метрийн өндөртэй. Энэ бол яндантай бараг зэрэгцэхүйц байдалтай орон сууц баригдаад эхэлж байгаа учраас орчны, орон сууцын өөрийнх нь чанарт нөлөөлнө гэсэн үг. Халиа дош үүсэж байгаа газар дээр орон сууц баригдаад эхэлсэн.

Хамгийн гол чухал асуудал нь түрүүн хэлсэн бүх объектууд нэмэгдэж байгаа. Авто зам, шугам сүлжээ, дэд бүтцийн эх үүсвэр, усны эх үүсвэр, цахилгааны эх үүсвэр гээд бүхий л үйл ажиллагаанууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон энэ төслийн хүрээнд өртгийг нэмэгдүүлж байгаа. Нийт төсөвт өртгийг, төслийн урьдчилсан томсгосон тооцоог авахыг хүссэн боловч 2,3 их наядаар бид нарт төслийн нэгж өгсөн. Гэхдээ ТЭЗҮ болон одоо байгуулагдсан гэрээ, дээрээс нь борлуулалтын тооцоонд орж байсан, нэмэгдэж хийгдэх ажлууд болон энэ бүгдийг аваад, нэмээд хувийн хэвшилд зориулж олгож байгаа нийт метр квадратад нь үндэслээд, магадлалаар хийсэн магадлалын үнэлгээг нэмээд нийт төсөвт өртгийг урьдчилсан байдлаар тооцож гаргахад 5,5 их наяд төгрөгийн төсөл болж хувирч байгаа. Эндээс эх үүсвэрээр харагдах юм бол ерөнхийдөө нийслэлийн бонд нь

өөрөө 35%-ийг, улсын төсөвт 45%-ийг, хувийн хэвшил ердөө 19%-ийн хөрөнгө оруулалттай Азийн хөгжлийн болон Европын хөрөнгө оруулалтын банкны хувь оролцоо нь ийм бага байгаа.

Эндээс харахад бид улсын хөрөнгө оруулалт давамгайлсан ийм төсөл болж хувирч байгаа гэдгийг нь та бүхэн харж байна.

Гүйцэтгэлийн хувьд, одоогоор газар нүүлгэн шилжүүлэх дээрээс нь талбайн бэлтгэл ажил, ТЭЗҮ, зураг төслийн боловсруулах үйл ажиллагаа, дэд бүтэц болон барилга байгууламж, орон сууц гээд төрлүүдэд нь ангилаад үзэхээр одоогоор гэрээ байгуулсан энэ дунд талын, энэ улааныг битгий хараарай, яагаад гэвэл энд санхүүжилтийн дүн дээр харж байна. Хар өнгөтэйнүүд нь бодогдоод ирэхээр бид ойролцоогоор 1 их наядын ойролцоогоор 978 тэрбум төгрөг гаргасан байна. Нийт дүндээ аваад үзвэл ойролцоогоор 50-аад хувьд нь гэрээ байгуулсан, гэхдээ гүйцэтгэлийн хувь 18%-тай нийт төслөөс нь бодох юм бол, хэрэгжүүлэлт санхүүжилтээ бодох юм бол 20 хувьтай явж байгаа, ашиглаж байгаа. Өөрөөр хэлбэл бид нар босгочихсон бондынхоо ашиглалтын 20%-аар яваад байгаа гэсэн үг.

Тэгээд барилга байгууламж нь 113 барилга цэвэр орон сууцын блокуудыг байгуулж эхлээд анхны гэрээ байгуулагдсан. Гэхдээ газар шорооны нөхцөл байдал үүссэн учраас өөрөөр хэлбэл геологийн бүтэц нь өөрчлөгдөөд 2 компанийн ажлын гүйцэтгэл нэлээн удаашралтай явж байгаа. Үүний цаана цахилгаан холбоо болон репэ эрчим хүчний бэлтгэл ажлын 2 дугаар багц нь зарлагдсан ажлын гүйцэтгэл тодорхой мэдээлэл бол ирээгүй. Гэхдээ санхүүжилтийн гүйцэтгэл 20 хувьтайгаар олгогдсон, 2026 онд гүйцэтгэл явагдаагүй гэж харагдаж байгаа. Ингээд харахаар нүүлгэн шилжүүлэлтийн асуудал онцгой анхаарал татаж байгаа.

Төслийн хүрээнд бүтэн нөлөөлөлд өртсөн, хагас өртсөн, түрээслэгч хүмүүсийн бүх нөхцөл байдал харгалзуулж АХБ-ны нийгмийн нөлөөлөлд нь өртөж энэ газар чөлөөлөлт явагдсан байдаг. Дээрээс нь хамгийн гол нь 10 жилийн хугацаанд энэ хүмүүст газар ашиглалтын чиглэлийг, газрыг дэмжиж хөрөнгө оруулж байгаа. Улсын хөрөнгө оруулалтаар та бүхэн ашиг хүртэнэ гэдэг мессежийг 10 жилийн туршид явуулсан байгаа. Гэхдээ энэ тамгатай тэмдэгтэй төрийн бусууд нь байгуулагдсан, газрын эздийн бүлгүүд байгуулагдсан.

Бизнес эрхлэгчид шинээр ирэх гэж байгаа бизнестэйгээ та нар хэрхэн өрсөлдөх юм бэ гэдэг бэлтгэл ажил хангагдсаар байтал энэ нүүлгэн шилжүүлэлт явагдсан. Энэ нүүлгэн шилжүүлэлт нь өөрөө ямар нэгэн эрх зүйн нөхцөл байдлыг өөрчилсөн үү, зөрчсөн үү, зөрчсөн байх магадлал нь дараа яригдана. За энэ процесс дотор одоогоор 87 эдэлбэр газар үлдсэн, дандаа бизнесийнх үлдсэн байгаа. Тэгэхээр бид нар ямар хэмжээнд, 70, 80%-ийн зөвшөөрөлтэй байх юм бол энэ үйл ажиллагааг явуулж болно гэдэг процесс чинь яг бизнесийнхээ хүмүүсийг ашиг орлого олж байгаа өнөөдөр орлого нь өөрийнх нь амьдрал нь орлогоос нь хамаарчихсан бизнес эрхлэхэд нөлөөлөөд байгаа байдал энд яг гарч ирж байгаа. Энэ асуудал бүр дахин төлөвлөлтийн төсөл болгон дээр гарч ирж байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй.

Тэгээд хамгийн гол нь энэ тендерком гэдэг ном гаргасан. Энэ болохоор Газрын тухай хуулиар заагдаагүй нөхцөлөөр бид нар төсөл сонгон шалгаруулалтаар худалдан авагчийг сонгох гээд байгаа. Энэ үйл ажиллагааг компани нь одоо явуулж байгаа. Энийг хуульд ийм төслийн хөрөнгө оруулалтыг хийхэд ийм асуудал хэрэгцээ байгаа бол хууль эрх зүйн нөхцөл нь бүрдээгүй үед энэ арга хэмжээг авах гээд байна

гэдгээр харагдаж байгаа.

Дараагийн нэг асуудал нь дулааны асуудал. Сэлбийн 28 МБТ-ын дулаан станцаас 21-ийг өгнө, Дамбадаржаагийн 63-аас 23-ыг өгнө. Ингээд зөрүүд нь 48мвт-ын дулааны эх үүсвэрийг хайгаад явж байгаа. Энэ асуудлыг бүрэн шийдээгүйгээр энэ асуудлыг эхлүүлсэн. Одоо Дамбын 63 МБТ-ыг бид нар дэд бүтэц нь баригдаагүй шугам сүлжээ тодорхойгүй байгаа. Шугам сүлжээ нь 73%-ийн гүйцэтгэлтэй явж байхад энэ айлуудтай дараагийн нөхцөл нь яригдаагүй байгаа учраас энийг одоо авна гэсэн ийм яриа хэлцэл явагдаж байгаа юм байна. Гэхдээ шийдвэр, шийд гараагүй байгаа. 35/10-ын дэд станцын зураг хийгдээгүй байгаа, авто замын зураг төслийг энэ төсөвт өртөгт ерөөсөө оролцоогүй байгаа. Энийг яаж шийдэх вэ гэдэг нь шийдэгдээгүй байгаа гэсэн үг.

Одоогийн баригдсан байгаа барилга байгууламжаас өөрсдийн өгсөн зураг дээр 77 блок нь дулаанаа авах бололцоотой, авна. Магадлалтай нь 20 блок. Ингээд дараагийн үлдсэн барилгуудын асуудал гарч ирнэ. Тэгэхээр хугацаандаа яг дуусах уу, зээлийнхээ хөрөнгийг бүрэн ашиглаж бид чадах уу гэдэг нь эрсдэл. Яагаад гэвэл 14 сарын дараа маш богино 2,8 жилийн хугацаатай энэ зээлийг бид буцаагаад төлнө. Энэ зорилгодоо хүрэх үү, 15600 яндан, 12 мянган нүхэн жорлон буулгана гэж ярьсан, гэхдээ энийг бид нар баталгаажуулах боломжгүй байгаа.

Энэ хүмүүс авсан мөнгөө инфляц буураад, орлого буурсан, мөнгө хомсодсон үед энэ нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг бэлэн мөнгөөр ярьсан учраас энэ хүмүүс бүгдээрээ нүүсэн. За тэгээд хаашаа нүүснийг нь бид нар одоохондоо мэдээгүй байгаа. Мөшгөх судалгаа явагдаагүй байгаа.

Дээрээс нь худалдан авалтын борлуулалт нь гэр хорооллын иргэдэд зориулж байгаа гэдэг мессеж нь байхгүй. Одоогийн байгаа метр квадрат нь гэр хорооллын иргэдийн худалдан авах чадварт нийцэж байгаагүй юу гэдэг нь өөрөө асуудал.

За тэгээд дээрээс нь 6%-ийн ипотекийн зээлд гэр хорооллын 6-хан хувь нь ногдсон гэж байдаг. Эндээс хасвал бид нар яригдана. За тэгээд дээрээс нь НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын “Газар ба хүний эрх: стандарт ба хэрэглээ” гэдэг удирдамжид алтернацийн хувирал байхгүй тохиолдолд хамгийн сүүлд авах эрх хэмжээ нь энэ нүүлгэн шилжүүлэлт байна шүү гэж заасан байдаг. Тэгэхээр бид нарын хувьд хэрвээ газрын эзэд өөрсдийнхөө үнийг үнэхээр 408 тэрбум төгрөгөөр үзэж байгаа бол энэ нийт төсвийн өртгийн 7 хувьд нь байгаа. Тэгэхээр энэ 7 хувийн ашгаас нь ч болтугай энийг өөрсдөө зохион байгуулж оролцуулаад, энд нь суралцуулаад 10 жилийн хугацаанд ямар байдлаар газрыг хөгжүүлж болох вэ гэдэг суралцаад ингээд явбал энэ 7%-ийн ашгийг нь газар дээр нь бид нар нэмж өгөх төслийн өөрчлөлтийг хүртэх бололцоо байсан байна гэж харагдаж байгаа. Тэгэхээр хувилбар бидэнд байсан байна. Яагаад гэвэл ийм аргаар иргэдийн оролцоотой маш олон төсөл хэрэгжиж байгаа. Дээрээс нь Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн дахин төлөвлөх хэлбэрээр л хөгжүүлнэ. Дахин төлөвлөлтийн тухай хуульд бол дахин зохион байгуулах арга хэмжээ байдаг. Дахин төлөвлөх дотроо хуулийн 4.1.4-д нь “гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч” гэж гэр хорооллыг орон сууцжуулах нийслэлийн өмчид хуулийн этгээдийг зааж өгсөн. Ингээд Засгийн газар нь энэ байгууллагадаа бонд босгож өгсөн. Гэтэл яг энэ төрлийн төслийг хэрэгжүүлээд 2012 оноос хойш гацаж байгаа төслүүд байгаа. Яг энэ төслийг хэрэгжүүлэх гэж гэр хорооллын иргэд нь нөхөрлөл байгуулан ажиллаж байгаа энэ хүмүүст маш том өрсөлдөгчтэй одоо тулчхаад байна гэж харагдаж байна. Өөрөөр

хэлбэл нийслэл өөрөө өрсөлдөгч нь болчихжээ. АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжүүлсэн төсөл түрүүн хэлсэн иргэд нь яаж энэ төсөлтэй оролц...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт цаг өгье.

Шинжээч 3.Туяа: За тэгээд энэ ажлыг үнэгүйдүүлсэн. Төр хэдийд ч бодлогоо өөрчилж чадна гэдгийг харуулсан. Энэ шийдвэр нь өөрөө хотыг байгуулах үйл ажиллагаа нь төр иргэдийн оролцоонд харилцан хамааралтай нөхцөлийг эффектээ үзүүлээд эхэлчихсэн байгаа. Яагаад гэвэл ийм их бэлэн мөнгөөр чөлөөлж байгаа учраас нийслэлийг л хүлээнэ. Өөрөөр хэлбэл цаашдаа энэ үйл ажиллагаа явуулахад итгэлцэл буурна. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль батлагдсанаараа иргэдийг орон сууцжуулна гэсэн нэр томьёо хэрэглэж эхэлсэн. 2023 оноос хойш анх удаа энэ орон сууцжуулна гэдэг нэртэй болоод эхэлсэнтэй холбогдоод орон сууцны талаар төрөөс баримтлах бодлого болон хот байгуулалтын бодлого тодорхойлогдоогүй бодлогоосоо зэрэгцээ 2 бодлого гарч ирчхээд байна гэж харагдаж байгаа. Хувийн хэвшлээ дэмжих гээд байна уу, нэг бол төр өөрөө орон сууцаар хангах гээд байна уу гэдэг. Гэр хорооллыг дахин хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд бэлтгэгдсэн төслийн ачааллыг нэмэгдүүлээд, эндээс гарах нэмэлт эх үүсвэрүүдийг хаанаас шийдэх гэж байгаа нь тодорхойгүй орсон. Бэлтгэл нь өөрөө дутуу байгаа учраас өнөөдөр энэ төслийн хугацаа сунгаад төслийн зардал нэмэгдэх эрсдэл үүсчихсэн байна гэж харагдаж байгаа. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд улсын төсвөөр хийх нөхцөлүүдэд мега төсөл гэдэг ангилал орж ирж байгаа юм бол бусад төслүүдийг ямар хэлбэрээр бэлдэж байх ёстой юм бэ гэдэг энэ зарчим чинь гарч ирээгүй байгаа учраас өнөөдөр төрийн болон орон нутгийн хоорондын ярилцах систем бүрдээгүй байна гэж харж байна. Тэгэхээр энэ нь цаашдаа маш хурдан, богино хугацаанд босгосон хөрөнгөнөөсөө болоод энэ ажлын төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх ёстой. Энэ төрийн байгууллагуудын хүмүүсийг ямар нэгэн аргаар энэ ажлыг урагшлуулах ёстой гэдгээсээ болоод үйл ажиллагааны процессыг урагшлуулах, ингээд зөрчил гарч ирэх ийм асуудлууд гарч ирчхээд байна. Тэгэхээр энийг өнөөдөр ажил хийгээд ажлаа урагшлуулж байгаа хүмүүстэй одоо ярихгүй гэдэг дээр бол би санал нийлж байна.

Тэгэхээр хууль боловсруулж байгаа нөлөөллийнхөө эффектийг, дээрээс нь боловсруулж байгаа ТЭЗҮ-д нийтээр ач холбогдол өгөхгүй бол өнөөдөр ТЭЗҮ-ийг ажлын зурагтай хамт баталж байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл ТЭЗҮ-ээр үүсэх гээд байгаа нөхцөл байдлыг хэрхэн илаарьшуулах вэ, үүсэх гээд байгаа эрсдэлийг нь яаж хаах вэ гэдэг нь төсөвт өртөгт нь орж ирээгүй, бэлтгэл ажил бүрэн хангагдаагүйгээсээ болоод бид нар процессын алдаа гаргаад байна гэж харагдаж байгаа.

Дараагийн асуудал нь энэ төсөл бол Улаанбаатар хотын хүчин төгөлдөр байгаа ерөнхий төлөвлөгөөний ачааллыг нэмэгдүүлсэн. Өөрөөр хэлбэл, газар ашиглалтын дүрмийг зөрчсөн, хуулиа зөрчсөн. Энэ хууль ерөнхий төлөвлөгөө УИХ-аар батлагддаг. Тэгээд энэ батлагдаад байгаа процесс нь маш урт хугацааны процесс болохоор хотод тогтмол болоод байгаа энэ газрын ашиглалтыг өөрчлөх хэрэгцээ шаардлага гараад байгаа энэ нөхцөл, хэмнэлтэй ерөөсөө таарахгүй байгаа. Тэгэхээр газрыг зохион байгуулах оновчтой шийдлийг 2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд батлах ёстой гэж заасан боловч 2014 оноос хойш ямар ч арга хэмжээ аваагүй. Энэ нь өнөөдөр Улаанбаатар хот даяараа дүрмээ зөрчсөн ийм нөхцөл байдлыг үүсгэчихсэн. Тийм болохоор энэ ерөнхий төлөвлөгөөг батлах, газар зохион байгуулалтын энэ үүргийг нь иргэдийн хурал руу буулгах арга хэмжээ авахгүй бол бид Улаанбаатар хотын үйл ажиллагааг дэмжих боломжгүй болчихоод байна гэж

харагдаж байгаа.

Төсвийн зардлаар бэлтгэж байгаа төслүүдийн арга хэмжээ, санхүүгийн зохицуулалтыг хуримтлуулж ерөөсөө бүртгэдэггүй юм байна. Мэдээлэл нь ингээд тасарчихдаг юм байна. Урт хугацааны төсөл хөрөнгө нь олдохгүй. Тэгэхдээ ТЭЗҮ нь боловсруулагдчихсан, мартагддаг юм байна. Тийм болохоор төслийн арга хэмжээний хөрөнгийг бүртгэх хэрэгтэй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Цаг дууслаа, баярлалаа. Хөтөлбөрийн дагуу албаны хүмүүс болоод шинжээч нар танилцуулга хийж дууслаа. Одоо сонсголд оролцож байгаа оролцогчид санал хүсэлт, мэдээлэл танилцуулна. Танхимд хүрэлцэн ирсэн оролцогчдоос 24 хүн үг хэлнэ гэж хүсэлт ирүүлсэн байна. Эдгээрээс 4 хүн дэлгэцээр мэдээлэл хуваалцахаар хүсэлт ирүүлсэн байгаа. Дэгээрээ нэг оролцогч 10 хүртэл минут мэдээлэл хийх боломжтой. Гэхдээ цагийнхаа баримжаа, хуулийн заалтаа хараад нэг оролцогч 3 минут, дэлгэцээр мэдээлэл хуваалцах хүмүүс 5 минутаар гэдэг дэг барьж явъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан оролцогчийн хувиар мэдээлэл танилцуулна. 3 номерын микрофон.

Оролцогч Ж.Дэлгэрсайхан (Төсвийн тогтвортой байдлын зөвлөл): Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл сая хуралдаан даргалагчийн хэлсний дагуу оролцогчоор саналаа илэрхийлж байгаа. Монгол Улсын төсөв ер нь яаж яваад байгаа, нийслэл болон орон нутаг дээр гарч байгаа энэ тодорхой асуудлууд Монгол Улсын төсвийн нэгдсэн байдал, бодлогод хэрхэн нөлөөлөх вэ гэдэг талаар бид та бүхэнд өөрсдийн хийж байгаа чиг үүргийнхээ хүрээнд мэдээлэл өгье.

Монгол Улсын төсвийн тогтвортой байдал төсөв гэдэг зүйл бол Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулагдаж байдаг. Тэгэхээр нэгдсэн төсвийн тогтвортой байдал гэдэг бол бодлогын тогтвортой байдал, төсвийн зарлагын оновчтой байдал, өрийн болон бусад эрсдэлийг хамгаалсан ийм нөхцөл байдалтай гэж бид ойлгох хэрэгтэй. Энийгээ бид төсвийн тусгай шаардлагууд болон бусад зохицуулалтаар хэрэгжүүлээд явж байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын үндсэн зорилтуудыг бид харахдаа нэгдсэн төсвийн тогтвортой байдал гэдэг зүйлийг ирээдүйд Монгол Улсын төсөв эрсдэлгүй ямар нэгэн асуудалгүй байх ёстой, төсвийн хариуцлага, сахилга баттай байх ёстой бөгөөд эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх буюу төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд эдийн засгийн хөгжлийг дэмжсэн ийм байдалтай байна гэж үзэж байгаа.

Та бүхний өмнө төсвийн тоо баримтууд байгаа. Монгол Улсын төсөв өнөөдөр 32,9 их наядаар батлагдчихаад явж байгаа. Энэ тоог дурдаж байгаа шалтгаан бол Монгол Улсын нэгдсэн төсвийн энэ тоон дотор улсын болон орон нутгийн бүх төсвүүд багтаж явах ёстой. Энэ тоо бол Монгол Улсын 2026 оны бүх төрлийн төсвүүдийн нийт дээд хязгаар юм. Бидний зүгээс барьж байгаа бодлого бол энэ төсвийн тогтвортой байдал гэдэг бол ДНБ-д эзлэх зарлагын хувь хэмжээг бууруулах буюу төрийн оролцоог бууруулах чиглэлд ажиллаж байгаа гэж үзэж байгаа.

Сүүлийн 2 жил төсвийн зарлагын хязгаарлалтыг Засгийн газраас сайн хийсэн байдаг. Гэтэл энэ дээр үүсээд байгаа асуудал нь юу вэ гэдэг нь их чухал. Монгол

Улсын төсвийн урсгал зардал тэлээд байгаа. Манай зөвлөлийн өгч байгаа дүгнэлтүүд дээр бол ерөөсөө төсвийн урсгал зардлын тэлэлт нь хөрөнгө оруулалтын зардлын орон зайгаа шахаад гаргачих. Гэтэл хөрөнгө оруулалтын зардлын орон зайг шахсаны улмаас дөнгөж саяхан бид нар Эрдэнэбүрэн болон Алтанширээт дэх нефтийн үйлдвэрийн төслийг төсвөөс гаргаж байж энэхүү стратегийн ач холбогдолтой төслүүдийг хөдөлгөх болж байгаа. Энд байгаа 8 их наяд гээд байгаа тоон дотор улсын төсвийн орон зай үнэхээр багасчихсан.

Улсын төсөв дээр өнөөдөр бид нар хоёр гурван их наядын л асуудал ярьдаг. 2027 он дээр бол бид бүр 2,2 их наяд төгрөг улсын төсөв дээр ярьж байгаа. Тэгэхээр энэ нэгдмэл бодлогын дагуу энд хязгаарлагдаж шийдэгдэх ёстой гэдэг асуудал бол сүүлийн үед Улаанбаатар хотын төсөв болон түүнийг дагаад бусад аймаг орон нутаг руу халдварлах шинжтэй болж эхэлж байгаа.

Томоохон төслүүдийг нэгдсэн бодлогоос гарчихсан орон нутгийн бие даасан байдал гэдэг рүү оруулснаас болоод зарим нь бол УИХ-ын зөвшөөрөлгүйгээр Засгийн газраас эрхийг нь олгоод бонд гаргаад явж байгаа ийм төслүүд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар анхаарах ёстой. Монгол Улс бол нэгдмэл улс. Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс харж байгаа зүйл бол бүх зүйл орон нутгийн бие даасан байдал байж болох боловч Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцсэн, төсвийн хязгаарт баригдсан тэр төсвийн бодлогыг л бид цаашдаа барих ёстой. Сүүлийн үед энэ систем өөрөө алдагдах эрсдэлтэй байна.

Бид уул уурхайн баялгаас орж ирж байгаа аж ахуйн нэгжүүдийн орлогуудыг сүүлийн 10 гаруй жил орон нутаг руу нэлээд хүчтэй шилжүүлсэн. Энэ нь бол орон нутгийн ялангуяа сүүлийн үед Улаанбаатар хот дээр гарч байгаа асуудлууд бол энэ татваруудыг шилжүүлсэнтэй холбоотой. Мөн Улаанбаатар хот бие дааж цалинтай холбоотой, татвартай холбоотой бие дааж шийдвэрүүдийг гаргасан нь төсвийн бодлогоос гадна нэгдмэл улсын макро эдийн засгийн бодлогын хувьд тодорхой хэмжээний гажуудлуудыг үүсгэх гээд байна уу гэж харж байгаа юм. Дараа нь нэг асуудал байгаа нь урд оны үлдэгдлийг бид нар Төсвийн тухай хуулийн 57.3-аар ашигладаг болчихсон. Урд оны үлдэгдлийг ашиглаж байгаа энэ байдал бол бид нарт их асуудалтай байгаа юм.

Дараа нь гарч байгаа нэг асуудал нь ерөөсөө энэ хууль гэдэг зүйлийг аль ч түвшинд баримтлахгүй байгаа нь бидний зүгээс хардаг хамгийн эмзэглэдэг асуудал. Төсвийн тухай хуулийн 57.2 дээр яах аргагүй орон нутгийн төсвийг алдагдалгүйгээр баталж хэрэгжүүлнэ гээд байж байдаг. Хязгаарт байх ёстой гээд бас байж байдаг. Тэгэхээр төсвийн хууль эрх зүйн орчин үнэхээр сайн боловч энийг бид баримтлахгүй бол төсвийн сахилга бат алдагдана. Энэ нь эргээд нийгмийн сайн сайханд сөргөөр нөлөөлөх юм гэсэн ийм зүйлийг харж байгаа юм. За та бүхэн энд харж байна. Монгол Улсын нэгдсэн төсөв бол улсын төсөв, үндэсний баялгийн сангийн төсөв, нийгмийн даатгал.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За гүйцээгээд сонсчихъё.

Оролцогч Ж.Дэлгэрсайхан (Төсвийн тогтвортой байдлын зөвлөл): Төсвөөс бүрдэнэ гэсэн энэ дотор багтаж байгаа гэдгийг дахин сануулъя. Монгол Улс нэгдмэл улс гэдгийг мөн сануулахыг хүсэж байна. Учир нь өнөөдөр бидний энэ гаргаад байгаа олон их наядын төсвийн хөрөнгө оруулалтын зарлагууд, үүний үр ашигтай байдал нь баталгаажаагүй байгаа байдал энэ сонсголоос харагдаж байна.

Хэрэгжилт хангалтгүй байгаа байдал харагдаж байна. Энэ эргээд Монгол Улсын нэгдсэн төсөв дээр Монгол Улсын төсвийн алдагдалд нөлөөлөөд байгаа юм. Үнэт цаасыг ч гэсэн бид УИХ-ын түвшинд хянагдаагүй үнэт цааснууд явж байна гэж харж байгаа юм. Үнэт цаасны ашиглалтын түвшин дээр энд олон мэдээлэл өгсөн учраас бид энийг бол дурдах хэрэггүй. Гол нь энэ бол эргээд Монгол Улсын төсвийн нэгдмэл бодлого, Монгол Улсын үр ашигтай байдал, төсөв нийтийн эрх ашгийн төлөө зарцуулагдах ёстой гэдэг энэ асуудал дээр сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байгаа юм. За тэгээд төсвийн нэгдмэл байдлыг бид алдагдуулснаараа төсвийн алдагдлыг өсгөх, төсвийн тусгай шаардлагууд баримт.

За цаг бага байгаа учраас товчилъё. Төсвийн тухай хууль дээр орон нутгийн төсвийг алдагдалгүй баталж хэрэгжүүлнэ гэдэг энэ зүйл бол үнэхээр алдагдсан. Нэгдсэн төсвийн тусгай шаардлагууд Монгол Улсын төсвийн бодлогыг хүчтэй зөрчиж байна, алдагдуулж байна. Дараа нь зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээс хэтрэхгүй байна гээд 57.3 дээр өмнөх жилийн үлдэгдлээс ашиглаж болох энэ орон зайг бид эргэж харах ёстой гэж үзэж байгаа юм. Төсвийн сахилга батын хувьд нэлээд том хийдэл энэ 57.2, 57.3-тай холбоотой гэж үзэж байна. Үүнтэй холбоотой гол сөрөг үр дагаврууд нь энэ нөхцөл байдалд цаашдаа халдана. Бэлтгэлгүй реформ хийх гэж оролдсон нь ирээдүйн эрсдэлийг бий болгоно, дунд хугацааны тэнцвэрийг алдагдуулж байна гэсэн олон эрсдэлүүдийг энэ орон нутгийн төсөвтэй холбоотой, өнөөдрийн сонсголтой холбоотой асуудлууд хөндөж байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр бидний зүгээс зарим саналуудыг хэлж байгаа. Энэ хуулийн хийдлийг арилгах.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Цаг дууслаа. Дараагийн оролцогч Л.Ану-Үжин танилцуулга хийнэ. 3 номер дээр сууна уу.

Оролцогч Л.Ану-Үжин: Өдрийн мэнд. Би өнөөдөр Улаанбаатар хотын 7 зам тээврийн төслүүдийг хооронд нь хянаж, харьцуулсан дүгнэлтээ танилцуулах юм. Намайг Лхагвасүрэн овогтой Ану-Үжин гэдэг. Барилгын мэргэшсэн зэрэгтэй инженер, барилгын төсөвчин мөн хотын удирдлагаар магистрын зэрэгтэй. Ерөнхийдөө хот төлөвлөлт болон хот төлөвлөлтийн онол талаасаа төлөвлөлтийн асуудлуудыг яг аваад үзэхэд энэ 7 зам тээвэртэй холбоотой төслүүд нь нийлээд 26,8 их наяд төгрөгийн өртөгтэй болж байгаа. Энэ нь манай ДНБ-ий 32%-тай тэнцэж байна гэсэн үг. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд хамгийн түрүүнд үндэслэл буюу энэ төслүүдийг хэрэгжүүлэх шаардлага байгаа юу гэдэг асуулт тавигддаг. Тэгэхээр энэ асуултад огт хариулаагүй ийм төслүүд байна гэж ерөнхийдөө дүгнэж байгаа. Яаж дүгнэж, яаж үнэлсэн талаараа танилцуулъя. Ерөнхийдөө Метроны төсөл, Тусгай замын автобус буюу Би Ар Ти, Эл Ар Ти буюу Трам, Дүүжин тээвэр, 1 дүгээр тойрог зам, 2 дугаар тойрог зам, Туулын хурдны зам. Бүгдээрээ 2024 оноос эхлээд судалгаа болон ТЭЗҮ-ийн шатанд эхэлчихсэн. Ихэнх зардлууд нь бас гараад эхэлчихсэн. Ийм 7 төслийг авч үзсэн. Энэ 7 төслийг 10 асуултаар үнэлсэн. Үндэслэл нь бодитой эсэх, өнөөгийн өгөгдлөөр түгжрэлийн асуудлаа шийдэж байгаа эсэх, нэн шаардлагатай эсэх, хэмжээ дамжаа болон хувилбараар тохирох эсэх, өөр альтернатив хямд хувилбарыг сонгож үзсэн эсэхийг нь бас харьцуулсан. Эрэлтийн тооцоо бодитой эсэх, эдийн засгийн хувьд үндэслэлтэй эсэх, санхүүгийн хувьд тогтвортой эсэх, өрийн эргэн төлөгдөх чадвар байгаа эсэх, засаглал худалдан авалт, хэрэгжилтийн эрсдэл, алдагдсан боломжийн өртөг зэргийг нь мөн тооцоолсон эсэхийг нь хянаж үзсэн байна.

Тэгээд эдгээр үнэлгээний зорилго нь бол ерөөсөө энэ 7 төсөл маань өөрсдөө

Улаанбаатар хотод ТЭЗҮ-ээрээ хэрэгцээ шаардлагатай, хэрэгжих боломжтой эсэхүүдийг нэгдсэн байдлаар үнэлэх зорилготой. Хамгийн гол асуудал нь юу гэж харагдсан гэвэл эдгээр 7 төслүүд нь бүгд тус тусдаа ТЭЗҮ-тэй, тус тусдаа судалгаатай, тус тусдаа зорчилтын буюу эрэлтийн тооцоолол, судалгаануудыг хийгдчихсэн. Тэгэхдээ нэг хотод хийх гэж байгаа 1,5 сая хүнд зориулсан 7 төсөл хоорондоо нэгдсэн төлөвлөлт байхгүй, нэгдсэн судалгаа байхгүй, нэгдсэн тооцоолол байхгүй ийм асуудалтай байна. Хамгийн том эрсдэл нь юу гэж үзэж байгаа вэ гэвэл нэгэн зэрэг эхлэх ийм төлөвлөлттэй байгаад байгаа.

2024 оноос авхуулаад эхэлж байгаа. Нэгэн зэрэг 26,8 их наядын төслийг зам тээврийн салбарт эхлүүлэх, зөвхөн тэрийгээ Улаанбаатар хотод, зөвхөн 1,5 сая хүнд энэ хэмжээний ДНБ болон улсын төсөв нийслэлийн төсвийг ингээд зарцуулах нь өөрөө ямар том асуудалтай вэ гэдгийг харж болно. Буцаагаад энийг нь 70%-ийг нь зээл тусламжаар олж авахаар байгаа. Нэг ёсондоо эдгээр санхүүжилт нь олдоогүй. Тэгэхээр 1,4-1,8 их наядын эргэн төлөлт жил болгон гарахаар ийм тооцоо гарч байна.

Би гэхдээ яг санхүү эдийн засгийн хүн биш учраас та бүхэн өөрсдөө бас нэмж макро эдийн засаг талаас нь тооцоолж болох юм. Тээврийн салбар дээр 5,3 тэрбумын өр болж очно гэсэн үг. Жил бүр 5,3 тэрбумаас 400-500 сая шаардагдах нь. 1,2-1,5 тэрбумын төсөвт ирэх ийм дарамт болж байгаа гэсэн үг. Нэг төслийн бус нийтээрээ энэ 7 төсөл нь. Тэгэхээр хамгийн гол асуудал нь бид нар энэ 7 төслийг нэг зэрэг хэрэгжүүлэх, нэг зэрэг санхүүжүүлэх чадвар, хэрэгцээ байгаа юу гэдэг асуултад хариулахыг зорьсон.

Энэ дээр хөрөнгө оруулалтынх нь хуваарилалтыг хийж харсан байгаа. Хамгийн их хувь буюу 71% нь гадаадын зээл, төр хувийн хэвшлийн түншлэл, урт хугацааны төлбөрийн үүрэг дарамт үүсгэж байгаа. Эдгээр нь нэг ёсондоо огт олдоогүй, батлагдаагүй, байхгүй мөнгө гэсэн үг. Тэгээд энүүгээр бол дан өр тавина. 17% нь нийслэлийн төсөв энийгээ торгууль хураамж гэж тооцоолсон байсан, 12% нь улсын болон орон нутгийн бонд гаргана, үнэт цааснаас гаргана гэж тооцсон байна. За дараагийнх нь болохоор энд хөрөнгө оруулалт нь яаж орж ирэх гээд байгаа вэ гэхээр хэрвээ бид яг энэхүү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минутаар 2 удаа байгаа. Микрофоноо нээчихье.

Оролцогч Л.Ану-Үжин: Авч үзэх юм бол 71%-ийн зээл тусламж авлаа гэхэд энэ нь эргээд Улаанбаатар хотод боловсролын салбар, эрүүл мэндийн салбар, бусад инженерийн дэд бүтэц, гэр хорооллын шинэчлэл, нийгмийн үйлчилгээ гэсэн гол үйл ажиллагаануудын маань аж ахуйн зардлууд танагдаад, бүгд зөвхөн замын үйл ажиллагаанд явагдаад, замын зээлд ороод эргээд бид маш их хэмжээний бас алдагдсан боломж өртгийн ийм асуудал гарч ирж байгаа. Хамгийн том тооцоолол дээр бүх 7 төсөл дээр хийсэн судалгаа тус бүр бүгдээрээ нэг өвлийн матриц ашигласан байсан. Хүн амын урсгал тоог маш өндрөөр тооцоолсон байсан. Өвлийн матриц нь 2007 болон 2017 оны 2 том судалгаа гэж байгаа боловч бүгдээрээ одоогийн байдлаар маш хоцрогдолтой, 2007 он, 2017 оноос хойшоо ч гэсэн Улаанбаатар хотын хүн амын дэд бүтэц суурьшлын бүтцийн төлөвлөлтүүд тэр чигтээ өөрчлөгдсөн байгаа. Энэ асуудлуудыг огт тооцож үзээгүй, буруу өвлийн матриц дээр тооцоолсон байна гэж харсан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Дахиад нэг минут нэмж

өгье.

Оролцогч Л.Ану-Үжин: Давхардсан үр ашигтай маш том асуудалтай байгаа. 7 төслийн үнэлгээ бол ерөөсөө хамгийн боломжтой нь Би Ар Ти буюу тусгай замын автобус, хамгийн асуудалтай нь 2 дугаар тойрог зам болон Туулын хурдны зам гэсэн 2 том төслийн хяналтыг хийж үзэхэд маш их асуудалтай гарсан. Мөн метроны төслийн ТЭЗҮ дээр нь эдийн засгийн үр ашиггүй буюу эрсдэл өндөртэй гээд биччихсэн байна. Дүгнэлт дээр нь гарчихсан байна. Метроны 2024 оны судалгаа нь 2013 оны ЖАЙКА-гийн судалгааг тэр чигт нь хуулбарлаад тоо хэмжээг нь өөрчилсөн байдлаар хийсэн. Тэгэхдээ учир дутагдалтай тоонуудаа бүрэн гүйцэд сольж чадаагүй байна. 2 дугаар тойрог зам дээр бол санхүүгийн хувьд маш өндөр алдагдалтай буюу 2,4 хасах заачихсан байгаа. Үндэслэл нь өөрөө эдийн засгийнхаа хувьд хэт өсгөсөн тооцоололтой, алдагдсан боломж оруулж тооцсон байсан. Туулын хурдны зам бол санхүүгийн сөрөг өгөөжтэй, үндэслэл хангалтгүй...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Дараагийн оролцогч Г.Уянгаа. Дэлгэцээр мэдээлэл танилцуулна. 3 номерын микрофон дээр сууна уу.

Оролцогч Г.Уянгаа: Сайн байцгаана уу. Намайг Уянгаа гэдэг. Өнөөдөр би иргэн хүнийхээ хувиар танилцуулга хийхээр орж ирсэн байгаа. Нийслэлийнхэн Туулын хурдны замыг барина гэж өнгөрсөн оноос хойш л ярьж байсан Байгаль орчноо хамгаалах бол иргэн бүрийн журамт үүрэг байдаг, үүнийг Үндсэн хуульдаа заачихсан байдаг. Энэ иргэнийхээ үүргийнхээ хүрээнд би Хатан Туулаа хамгаална гэдэг иргэдийн хөдөлгөөнд оролцсон байгаа. Өнөөдөр илтгэл тавьж байгаа шалтгаан нь аливаа үзэгдлийн иргэд бол аягүй том оролцогч тал байдаг. Нийгэмд болж байгаа өрнөлийн. Энэ хүрээнд оролцогч талынхаа хүрээнд би хэрхэн энэ төрийн эрх мэдэлтэй тулаад, юу туулсан талаараа товч маш хураангуйгаар тайлбарлая гэж бодсон.

2026 оны 3 сарын 19-нд бид нарт Туулын бургасыг хядаж байна гэдэг мэдээлэл ирсэн. 20-ны өдөр би хүүхдүүдээ авахаасаа өмнө цаг гаргаад очсон чинь ийм экскай, ховотой гаднын иргэд Туулын модыг хяргаж байсан. Тэгээд Туулын хурдны зам төсөл гүйцэтгэгч нь Хао Юань Женерал Констракшн гэдэг нэрийг хамгийн анх энэ дээрээс олж мэдсэн байдаг. Иргэд бид 3 сарын 21-нээс Маршалын гүүрэн дээр энэ Туулын хурдны замыг эсэргүүцээд жагсаж эхэлсэн. Энэ жагсах байгаагаа бид тухайн үедээ Хан-Уул дүүргийн цагдаа болон ХЭҮК-т мэдэгдэж хяналтдаа байлгахыг хүссэн байгаа. Үүнтэй зэрэгцээд манай нийслэлийн Замын хөгжлийн газар болон Нийслэлийн инженер Ш.Баранчулуун, нийслэлийн 1 дүгээр орлогч Т.Даваадалай гэх хүмүүс энэ хурдны зам бол ямар нэгэн эрсдэлгүй, экологид ямар нэгэн алдагдал учруулахгүй, бургаснууд бол ингээд өмхийрчихсэн бараг л үхэх гэж байгаа гэж бид нарт, иргэдэд ухуулж байсан. Бүр нэмээд Туул голыг тойрсон гүний худаг байхгүй гэж. Нэмэлтээр бид нарыг жүжигчид гэх мэтээр маш ихээр доромжилж байсан. Доромжийн агуулгыг бол сүүлдээ бид нар бүүр тоолж барахгүй болсон. Зөвхөн доромж нь ингээд үгийн хэлбэр комментоор биш бүр хэвлэл мэдээллээр бид нарыг доромжлох хэмжээнд хүрсэн.

Бид нарын эсрэг кино хийж янз янзаар доромжлох хэмжээнд хүрсэн. Иргэн хүн өөрийнхөө журамт үүргээ жишээлбэл нийгэмд эрхээ хамгаалах, улсдаа байх эрхээ хамгаалах гэхээр ийм байдлаар доромжлуулдаг гэдгийг өөрийн биеэр мэдэрсэн. Тухайн үед Хао Юань Женералын үйл ажиллагаа огт зогсохгүй байсан. Манай жагсаал дээр ирж, талбай дээр өдөр болгон ирж байсан. Дээрээс нь

өрөмдлөгийн ажлууд нэмэлтээр эхэлсэн. Үүнтэй холбогдуулан нэг амьтан үхсэн дуудлага ирэхэд огт хариу өгөхгүй байсан. Нийслэлийн Байгаль орчны газраас ирж нөгөө амьтныг чинь өдөрт нь устгалд оруулсан байдаг. За 3 сарын 30-ны өдөр энэ Төрийн ордны яг энэ өрөөнд нийслэлийн төлөөлөгчид болон Байгаль орчны яамны төлөөлөгчид, Хао Юань Женерал компанийн талаар мэдээлэл өгсөн. Маш олон гоё ажил хийсэн гэж бид нарт тайлагнасан байдаг. Тийм болохоор Туулын хурдны замыг Хао Юань Женерал гэдэг компани барихаар болсон гэж танилцуулсан боловч иргэд бид энийг нь шалгахад ялангуяа Сербийн ЗТЯ-с бүх мэдээллийг нь тулгаж үзэхэд эдгээр төслүүдийг Хао Юань Женерал огт хийгээгүй, өөр компаниуд хийсэн байгаа нь нотлогддог. Энэ өдөр мөн Нийслэлийн Засаг дарга болон Хан-Уул дүүргийн Засаг дарга, НИТХ-ын төлөөлөгч нар болон СХД-ийн хорооны дарга нар иргэдийн эсрэг жагссан байдаг. Энэ жагсаалаараа иргэд бид нарыг нэмэлтээр дахин доромжилж террористууд гэх мэтээр тэгээд Монголоос яваа гэж доромжилсон байдаг. За 4 сарын 10-нд менежментийн төлөвлөгөө батлагдтал түр зогсоосон. Гэтэл 4 сарын 14-нд иргэд бид ахиад өөрсдийнхөө журамт үүргээ гүйцэтгээд явж байтал Хао Юань Женералын 4 дүгээр кемпийг нь олоод очтол Хао Юань Женералын ажил нь огт зогсоогүй байсан. Бид нар цагдаад дуудлага өгсөн..(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт цагийг нь өгье.

Оролцогч Г.Уянгаа: Би өөрийн хувийн журмаараа жишээлбэл цагдаад нийтдээ 39 дуудлага өгсөн байдаг. Үүний дараа Т.Даваадалай гэдэг хүний талаар нийгэмд нээлттэй мэдээллийг мөшгөөд “Анка Урбан Инженерингийн Дизайн” гэдэг компанийн нэрийг өөрчлөөд 1 дүгээр тойрог зам болон Метро төсөлд Т.Даваадалайн өөрийн хувийн компани оролцож байгаа мэдээллийг нийгэмд түгээсэн. Үүний хүрээнд Т.Даваадалай одоогоор цагдан хоригдсон байгаа юм. За тэгээд дээрээс нь Усны газар болон Туулын сав газраас мэдээллүүдээ иргэнийхээ журмаар бүгдийг нь цуглуулж авахад энэ зам нь өөрөө ингээд хууль бус байгаа нь нотлогдсон. Гэвч нөгөө сүрдүүлгүүд шинэ хэлбэрт ороод миний хүүхдүүд рүү чиглэж эхэлсэн. Тэгээд ХЭҮК-оос хүүхдүүдийг эрсдэлтэй байдалд байна гэдэг дүгнэлт гараад Цагдаагийн ерөнхий газар...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минут.

Оролцогч Г.Уянгаа: Ингээд хүүхдүүдийн маань чиглэсэн сүрдүүлэг орж ирж байгаа юм. Тэгэхээр эхний сүрдүүлэг бол над руу болон ар гэр лүү маань ингээд хөгжөөд яваад байгаа байхгүй юу. Энэ өрөөнд сууж байгаа нэг хүн над руу утасдаж сүрдүүлсэн байдаг. Тэр хүн ямар учиртай байсан гэхээр би зүгээр ХОМ-ийг нь авах гэж яам руу нь хандсаны төлөө над руу уурлаж энэ дугаараас залгасан байгаа. Дээрээс нь хотын захирагч Х.Нямбаатар намайг нийтдээ шүүхэд 3 удаа өгсөн байдаг. Тэгэхдээ энэ шүүхэд нэхэмжлэл гаргах хугацаандаа дандаа хотын даргын ажлаа хийж байсан. Тэгээд иргэн хүнийхээ хувьд жишээлбэл энэ ажлуудыг ингээд мөрдлөгийн ажлуудыг би өөрөө хийх ёстой юу эсвэл ЦЕГ хийх ёстой юу, АТГ нь хийх ёстой юу би ерөөсөө ойлгоогүй. Эцэст нь ийм олон дарамт шахалтад орсон байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 3 номерын хугацаа дууслаа. Баярлалаа. Одоо Т.Амарзаяа 3 дугаар микрофон дээр мэдээллээ хийнэ. Дэгээрээ 10 хүртэл минут боловч та бүхнийг 5 минутад яриарай гэж хүсэж байна.

Оролцогч Т.Амарзаяа: За баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. “Монголын залуучуудын эвсэл” төрийн бус байгууллагын төлөөлөл Т.Амарзаяа. Манайх 2023 оноос хойш төсвийн ил тод байдлын чиглэлээр ажиллаж байгаа,

ялангуяа нийслэл, 9 дүүргийн төсөв дээр ажиллаад явж байгаа. Та бүхэнд нийслэлийн 2024, 2025 оны хэвлэл мэдээллийн зардалд хийсэн дүн шинжилгээг товч хуваалцъя гэж бодлоо. Нийслэлийн 2024-2025 онд нийтдээ 3,144,709,000 мянган төгрөгийн 306 гэрээ байна гэсэн ийм дүр зураг харагдаж байгаа. Үүнээс 9 дүүрэг болон НЗДТГ-ын төсвийг харахаар НЗДТГ дангаараа 40 орчим хувийг нь эзлэхүйц ийм өндөр дүнтэй гэрээнүүдийг хийсэн харагдаж байна. Дүүргүүдийг эрэмбэлээд нийт хувиар нь харвал НЗДТГ 45%-тай, Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүрэг гээд хийсэн гэрээнүүдийн дүн, эзлэх хувиуд энд харагдаж байна. Хамгийн өндөр дүнтэй 10 гэрээг харах бол дээд тал нь 30 сая төгрөг, 29 сая төгрөг, 25 сая 900 мянган төгрөг гээд ингээд хэвлэл мэдээллийн байгууллагууд нь харагдаж байна. Дэнс медиа, МОНЦАМЭ, Энх арслан, Лого гэх мэтчилэн Товч репорт, Хангарди бат гээд өндөр дүнтэй 10 гэрээг эндээс харж болохоор байна. Бага дүнтэй гэрээнүүд мөн адил 1 сая 900 мянган төгрөгөөс 4 сая 500 мянган төгрөгийн хооронд буюу Шилэн дансны хууль зөрчихгүйгээр хийгдсэн гэрээнүүд гэж харагдаж болохоор байна. Сонирхолтой гэвэл 3 гэрээг хувь хүмүүстэй хийсэн байсан. Хувь 3 хүнд 8 сая 400 мянгаас 15 сая төгрөгийн гэрээ хийсэн байна.

Аж ахуйн нэгжийнх нь хэлбэрийг харвал бол нийт 93 хувьцаат компани, 30 төрийн бус байгууллага, телевиз, хувь хүн сонин гээд ийм тоогоор харж болохоор харагдаж байна. Гэрээ байгуулсан хуулийн этгээдийг хувиар нь харах бол мэдээж хувьцаат компани нь өндөр байна. Төрийн бус байгууллагуудыг харах бол нэг иймэрхүү төрийн бус байгууллагуудтай гэрээ хийжээ. Нийтдээ 324 сая 980 мянган төгрөгийн гэрээг энэ хугацаанд төрийн бус байгууллагуудтай хийсэн байна. “Ардчилсан сайтуудын холбоо” гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага, “Монголын арилжааны телевизүүдийн дуун холбоо”, “Алс эрхэс” төрийн бус байгууллага гэх мэт ийм төрийн бус байгууллагууд, Сэтгүүл зүйн хөгжил гэх мэт ашгийн бус байгууллагууд харагдаж байгааг харж болно.

Гэрээний үнийн дүнг дундажлаад харвал бол хамгийн их хувьтай нь мэдээж 5 сая төгрөгт багтах үнийн дүнтэй гэрээнүүд, дараа нь 10 сая үнийн дүнтэй, 15 сая, 20 сая гээд хамгийн өндөр нь 30 сая төгрөгийн гэрээ харагдаж байна. Нийт төсвийн задаргаа нь дүүргүүд болон НЗДТГ-аар харагдаж байна. Нэгдсэн удирдлагын газрын төсөв гээд хүснэгтэлсэн мэдээллүүдийг харуулж байгаа зорилго нь ерөнхийдөө ямар утга агуулгатай гэрээнүүд явж байгаа гэдгийг харуулахыг хүссэн юм. Жишээлбэл, хотын аж ахуйн чиглэлийн ажлыг иргэд олон нийтэд сурталчлах, видео зураг, рийл постерын тоо гэх мэтчилэн нэг иймэрхүү байдалтай гэрээний агуулгууд харагдаж байна.

НИТХ-ын хэвлэл мэдээллийн зардлыг товч харуулахыг хүслээ. 2026 онд одоогоор 477 сая орчим төгрөгийн гэрээ явж байгаа бол 2024 онд 690, 2025 онд 720 орчим сая төгрөгийн гэрээ хийгдсэн байна. Мөн 2024 оны хувьд хамгийн өндөр дүнтэй 10 гэрээ энд харагдаж байна. 2025 оных нь бас ийм хэвлэл мэдээллийн байгууллагууд харагдаж байна. Эндээс харахаар дийлэнх нь бараг 30 орчим хувь нь төрийн бус байгууллагууд байгааг харж болно. Цаг богино байгаа учраас шууд дүгнэлт зөвлөмжөө хэлье. Ерөнхийдөө хэвлэл мэдээллийн зардал дээр харахаар жижиг дүнтэй олон гэрээ хийх замаар хэвлэл мэдээллийн хараат бус байдалд нөлөөлж байна гэж харахаар байна. Яагаад ингэж байна гэвэл манайх төсвөөр ажилладаг учраас нийслэлийг шүүмжилсэн төсвийн ил тод байдлаа ил болгохыг шаардсан хэвлэлийн бага хурал болон мэдээллүүд хийхээр хэвлэлийнхэн огт ирдэггүй. Тэгэхээр их бага хэмжээгээр нийтдээ 306 гэрээ гэдэг бол бага тоо биш. Бага дүнтэй ч бай, их дүнтэй ч бай гэрээнүүд хийх байдлаар хэвлэл мэдээллийн хараат бус байдалд нөлөөлөх буюу нийслэлийг шүүмжлэхгүй байх ийм

өнцгүүдийг...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт нэг минутыг нь өгье.

Оролцогч Т.Амарзаяа: Ингэж харж байна. За нийслэлийн ТӨК-уудын хэвлэл мэдээллийн зардал, нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хэвлэл мэдээллийн зардал ил тод биш байна, мега төслүүд, төр хувийн хэвшлийн түншлэлийн замаар хийсэн төслүүд гэх мэтчилэн гэрээнүүд ил тод биш. Энэ зөвхөн НЗДТГ, иргэдийн хурлын албан ёсны хийсэн гэрээнүүд байгаа учраас үүнийг миний зүгээс, бидний зүгээс зөвхөн мөсөн уулын орой харагдаж байна. 3,1 тэрбум гэдэг бол маш жижиг тоо байна гэж харж байгаа. Тендерийн хуулийн цоорхойг ашиглаад шилэн дансанд бүртгэлгүй гэрээнүүдийг үй олноор нь хийсэн байна. Үүнд нийслэлийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны зардал нэрээр шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж байхгүй гэрээнүүд маш олон байгаа учраас Нийслэлийн аудитын газраас хэвлэл мэдээллийн зардалд хяналт шалгалт хийж, түрүүний гүйлгээний утгын дагуу үйл ажиллагаануудаа хийсэн эсэхэд шалгалт хийх хэрэгтэй. Гэрээнүүдийн ард нууцлал гэсэн хэсэг байгаа. Тэр дээр талууд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Т.Амарзаяа мэдээлэл хийлээ. Одоо 3 номер дээр оролцогч н.Чинбат. Бид нарт нэг нүүр дүүрэн жагсаалт байгаа. Тийм болохоор дэлгэц дээр мэдээлэл гаргая гэж хүсэлт ирүүлсэн оролцогч нарт 5 минут, бусад оролцогч нар 3 минутаар хуваарилж байгаа. Та бүхэн 3 минутад багтааж хэлж өгөөрэй гэж хүсье. Сонсголын зохион байгуулалт, цагийн баримжаанд ийм шаардлага зайлшгүй гараад байгаа. Чинбат байна уу? Байхгүй байна. Дараагийн оролцогч Ц.Эрдэнэбилэг 3 номер дээр мэдээллээ хийнэ үү. 3 минут.

Оролцогч Ц.Эрдэнэбилэг: Сайн байцгаана уу. Миний нэрийг Цэдэвийн Эрдэнэбилэг гэдэг. Нано Грийн Энержи Монголиагийн үүсгэн байгуулагч мөн гүйцэтгэх захирлаар одоо ажиллаж байна. Манайх 2018 оноос Монголын бараг анхны л хогноос эрчим хүч үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлж ирсэн. Нийслэл болон Байгаль орчны яам, ЭХЯ-с манай төслийг мэдэхгүй газар гэж байхгүй. 2022 онд нийслэлийн менежер байсан Ганболдтой бид Хамтын ажиллагааны гэрээ байгуулаад, 2024 онд Номинчимэг гишүүнтэй бид Санамж бичиг зурсан. Ер нь бол 2024 ондоо хамгийн сүүлийн манай салбарын явцын шалгуур бол энэ худалдах худалдан авалтын гэрээ хийгээд хэрэгжүүлэх түвшиндээ ирчихсэн байхад нийслэлийн талаас “Улаанбаатар түншлэл” гэж өөрийн гэсэн ТЭЗҮ-тэй шинэ компани гаргаж ирээд хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд эхэлсэн. Тэгээд сонгон шалгаруулалт гэж нэг бараг жүжгийн юм болоод тэрийг нь би шүүхэд нягтлуулъя гэхэд шүүхийн явцад НЗД-ын 6 сарын 26-гийн А/907 тогтоолоор сонгон шалгаруулалтгүй энэ төслийг явуулна гэсэн баримт ил гарсан. Тэгэхээрээ энэ сонгон шалгаруулалт нийслэлийн түвшинд явсан юм бүгд жүжиг болж таараад, “Асем вилла” дээр асар их зардал гаргаж нээлтийн гарын үсэг зуруулчхаж байгаа. Гадаад түнштэй гарын үсэг зурсан бүгд жүжиг болж таарсан. Ийм байдлаар энэ төслийг авч явсан. Дээрээс нь энэ сонгон шалгаруулалтгүй төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийг явуулахад маш өндөр шалгууртай юм байна. Нэгдүгээрт, үндэсний түвшинд гамшиг байх ёстой юм байна лээ. Тэгээд 2026, 2025 онд тэр 3 дугаар цахилгаан станцын дэлбэрэлттэй холбогдолтой Засгийн газрын хуралд болсон юм байна. Энэ хурлын тогтоол, протокол нь маш нууцад байдаг юм байна. Энийг би ярих боломжгүй байна. Нэг үг хэлбэл бид бүр бүгдээрээ ачигдах юм байна лээ. Тэгэхээр энийг үндэслэл болгож энэ төслийг сонгон шалгаруулалтгүй зохицуулсан юм байна. Хоёрдугаарт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар гэрээ хийх

хувийн хэвшлийн компани нь Монголд бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай компани байх ёстой юм байна. Тэгэнгүүт Иргэдийн хурлын 25/126-гаар А.Баяр гэж Нийслэлийн иргэдийн хурлын даргын гарын үсэгтэй энэ гадаадын компанитай гэрээ хийх ийм зөвшөөрлийг өгөөд хууль зөрчсөн байгаа юм. Бид энийг яаж баталж байна гэхээр Улсын бүртгэлийн газраас энэ компанийг лавласан, ийм компани Монгол Улсад байхгүй байна. Энэ сонгон шалгаруулалт нь бас 2-3 өдрийн дотор л явагдсан. Бид энийг хууль зөрчсөн байна...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг удаа нэг минут.

Оролцогч Ц.Эрдэнэбилэг: Сая миний өмнө иргэн Т.Амарзаяа, Г.Уянгаа нар ярьж байна. Энэ нийслэлийн хэвлэл мэдээллийн алба гэж нэг аймаар том мангас байна. 2 өдрийн дараа бид сонгон шалгаруулсан, хууль бусаар хасагдсаны үндсэн дээр 19 сайтаар манай байгууллагын нэрийг харлуулсан. Энэ ерөөсөө биднийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр харлуулсан. Ингэхээр энэ татвар төлөгчдийн хувийн хэвшлийн мөнгөөр өрсөлдөх компани үүсгээд, өрсөлдөх ТЭЗҮ-г нь үүсгээд хар пи ар-аар санхүүжүүлээд тэгээд шүүхдэхээр энэ шүүхийн зардал, өмгөөлөгчийнх нь зардлыг нь татвар төлөгчдийн, хувийн хэвшлийн мөнгөөр л явж байна шүү дээ. Ийм л жишиг тогтчихоод байна. Бид 24 мега төсөл иргэдийн санаачилга гэхийг үгүйсгэхгүй. Тэгээд 24 нийслэлийн өмчит компани байгуулаад л ингээд төр нь.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Дараагийн оролцогч Г.Хажидмаа 3 дугаарын микрофон дээр үг хэлнэ. Дараа нь Б.Нямаасүрэн бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Хажидмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ард түмний дунд сонсгол зарлачхаад хуралдаа ирдэггүй Улсын Их Хурлын гишүүдийг хүлээсээр байгаад 2 цаг мөн ч их чиллээ шүү. Би бол Гантөмөр овогтой Хажидмаа. “Баялагтаа эзэн Монгол” ТББ-ын тэргүүн, иргэдийн эрүүл мэндийн боловсрол төрийн захиргааны магистр ийм хүн байгаа юм. Монгол Улс өнөөдрийн ганц энэ сонсголоор 30 жилийн хулгайн талаар ярьж байна. Тэгээд 30 жил энэ замбараагүй газар олголтоос үүдэлтэйгээр Монголын ард түмний эрүүл мэнд Улаанбаатар хотын хэмжээнд асар өндөр хохирол амссан, хохирсон. Хөрсний бохирдол гэж нэг асар аймаар юм байгаа. Утаа л яриад байдаг боловч хөрс нь өөрөө маш аймшигтай. Улаанбаатар хотод Сэлбэ төсөл шиг ингээд 30 жилийн хугацаанд энэ олон барилгуудыг ийм хурдан хугацаанд босгочхож болох байсан юм байна гэж би одоо харж байгаа юм. Иргэдийн эрүүл мэндийн боловсролын холбоотойгоор. Маш олон том хулгай байгаа. Тэгээд сөрөг хүчний хийсэн 30 жилийн хүүхэлдэйнүүд олигтой байсан бол өнөөдөр Ардын нам нь 2 хуваагдаад бас ингээд яриад суух уу, үгүй юу гэдгийг Монголын ард түмэн бодох л асуудал болсон гэж би харж байгаа юм. Хувь хүний дүгнэлтдээ. Миний ярих гэж байгаа зүйл бол маш жижиг хулгай. Монгол Улсын Ерөнхий сайд ард түмнийхээ карман руу ордог ийм хулгайг хийдэг болчихсон байна. Энэ чинь арай дэндэж байгаа юм биш үү? Том төсөл хулгайлдаг байсан, одоо карман руу ордог болсон байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг 10 жил ярьж яваа тэмцэгч хүн, СХД-т өнгөрсөн сонгуулиар 28 мянган хүний санал авсан. Яагаад гэвэл иргэдийн төлөө, ахмадуудын төлөө явдаг учраас энэ ахмадууд маань, иргэд маань надад бас хайртай байдаг юм. За би маш жижиг хулгай ярья. Энэ хүлэмжийн зураг байгаа. 2012 оноос хойш 100 га газрыг СХД-т Улаанбаатар хотын 9 дүүргийн ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааг дэмжих төслийн хүрээнд ажиллуулж эхэлсэн. Энэ хүлэмж өнөөдөр тоногдсон, сүүлдээ үлдсэн хэдэн хүлэмжийг нь Хөдөлмөрийн

хэлтэс буух нэрийдлээр 50 хүлэмжийг хуу хамаад аваад явсан. Өнөөдөр гадаа ахмадууд тэтгэврээ нэмүүлье гээд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт цаг өгье.

Оролцогч Г.Хажидмаа: Жил дамнан зогсож байна. Гэтэл ахмадуудынхаа карман руу орчихсон байгаа байхгүй юу. Ерөнхий сайдын яриад байсан ард түмний карман руу орлоо гэдэг хулгай чинь яг бодит байдалд энд хэрэгжээд байгаа юм. Энэ төсөл хүлэмжийн араас 5 жил явлаа, олддоггүй. Холбогдох байгууллагуудаас нь та нар яаж актлаад, яагаад аваад явчихсан гэхээр чамд ямар хамаатай юм гэдэг байдлаар ханддаг. Тэгэхээр би энийг яагаад одоо яриад байгаа вэ гэвэл сөрөг хүчин гэж хүүхэлдэйнүүд байгаа. Шинэ томилогдсон хотын дарга үүнийг анхааралдаа аваад ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, амьжиргааг дэмжих дээр түлхүү анхаараад ажиллаад өгөөч. Шинэ гарч ирж байгаа багийнханд энийг захиж хэлэхээр ирээд энэ үгийг хэлж байна. Нөгөө талдаа гомдолтой байгаа иргэдийг хотын шинэ удирдлагууд нэг өдөр цуглуулж уулзаж, энэ асуудлыг нь шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэхийг хүсэж байна. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Үг сонслоо. Дараагийн оролцогч Б.Нямаасүрэн. Түүний дараа Ж.Баярмаа бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Нямаасүрэн: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэнд хүргэе. Би Бямбажав овогтой Нямаасүрэн. Сэлбэ дахин төлөвлөлтийн нөлөөнд өртсөн иргэдийн нэг байгаа юм. Ингэж гомдол мэдүүлж санал яагаад хэлээд байгаа вэ гэхээр иргэдийнхээ өмчил 347 м.кв газрыг төр нь шууд дээрэмдэж аваад түүн дээрээ бүтээн байгуулалт явуулчихдаг. Гомдол мэдүүлээд шат шатны байгууллагад нь гомдол мэдүүлээд явахаар Хүний эрхийн комисс, Эмнисти олон улсын байгууллагын хэлэлцүүлэгт ороод газрын асуудал дээрэмдэж ингээд байр цутгаад барьчихсан байна гэж ярихад нь 1950, 1960 оны Солонгосын бүтээн байгуулалтыг яриад, та нарыг зодохгүй, дарамтлахгүй байгаа шүү гэж манай Т.Даваадалай дарга хэлж байсан. Тухайн үед тэгж хэлэхэд нь би бол юу ч хэлж чадаагүй л дээ. Тэнд оролцож байсан 50 гаруй хүнээс нэг л эмэгтэй босож ирээд Т.Даваадалай даргыг таныг ийм үг хэлсэнд харамсаж байна гэж хэлж байсан. Бусад 50 хүн нэг нь юу ч хэлж чадаагүй. Би ч гэсэн одоо ямар дэглэм бий болчихсон юм бэ гэж бодсон. Өөр надад юу ч бодогдоогүй. Нийслэлийнхээс нэг санал тавьсан. Би 347 м.кв нэг үл хөдлөхтэй байсан.

Үл хөдлөхөө дахин төлөвлөлтөд орно гээд өөрөө буулгачихсан байсан. 347 м.кв дээрээ би 2 давхар байр барьчаад, 2 давхарт нь амьдраад, нэг давхарт нь 8 нэрийн дэлгүүр ажиллуулъя гэж бодож байсан юм. Түүнээс нь илүү юм хүсээгүй байсан. Тэгээд Нийслэлийн Газрын алба, Нийслэлийн Орон сууцны корпорацын н.Говьсайхан дарга эд нартай тухайн үед гурван удаа уулзсан. Эхний 2 уулзалт дээр Цайз 16, яармаг, ханын материалд байр авч болно гэсэн. Би 104 метр квадрат авъя гэж хэлсэн. Би 40 метр квадратад нь амьдраад, 64 метр квадратад нь 8 нэрийн дэлгүүр ажиллуулъя гэж бодоод байгаа гэж хэлсэн. Тэгээд 104 метр авъя гэж л хэлсэн. Тэгэхэд намайг үнэлгээний 92 сая төгрөгөө өгчих тэгээд үлдсэн мөнгийг нь 5 жилийн хугацаатай зээлээр төл гэдэг санал тавьж байгаа юм. Үнэнийг хэлэхэд би өөрөө 2 банкны зээлтэй.

Нийслэлийн орон сууцн корпорацын санал тавьж байгаа зээлийг би төлж чадахгүй, хэмжээгээ угаасаа мэдэж байгаа. Угаасаа тийм илүү төлөөд явах чадвар надад байхгүй болохоор энэ асуудлыг шат шатны хүмүүст бүгдэд нь хандсан.

Ерөнхий сайд Н.Учрал боллоо гээд иргэнийхээ төлөө явж байна, иргэнийхээ хувийн хэвшлийг дэмжиж байна гэж сошиалаар явахад хүмүүс попорч байна энэ тэр гэхээр нь ямар ч байсан өргөдлөө өгөөд үзье гэж бодоод өгсөн. Бас нэлээн олон гишүүдэд өргөдлөө хамтад нь тухайн үед нь бичиж өгч байсан. Тэгсэн харин Ерөнхий сайдаас ирсэн өргөдлийн хариу нь нийслэлээс НЗД-ыг...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минут нэмж өгье.

Оролцогч Б.Нямаасүрэн: Иргэдтэйгээ тохиролцож энэ асуудлыг шийдэх гэж хариу ирсэнд би баярлаж байгаа юм. Хүчээр шийддэг, дарангуйлагдсан тогтолцоо арай ч тогтоогүй юм байна гэж би бодсон. Цаашдаа нийслэлийн удирдлагуудаас хүсэхэд миний тэр алдагдсан газрыг 104 м.кв үл хөдлөх болгож өгөөч гэж хүсэж. Ийм санал гаргаж байна. За баярлалаа

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Төрийн ажил хийж байгаа хүмүүс анхаарах байх аа. Ж.Баярмаа, 3 номер.

Оролцогч Ж.Баярмаа: Сайн байцгаана уу. Намайг Ж.Баярмаа гэдэг. Би “Ар Чиргил” компанийн захирал, Хүннү Ротари клубийн гишүүн. Миний хувьд Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд зааснаар Засгийн газрын үйл ажиллагаанд иргэд хяналт тавих эрхтэй. Байгалийн баялаг, газар дээрх болон газар доорх байгалийн баялаг бол Монгол Улсын бүх хүний өмч байх ёстой гэдэг үүднээс би өөрөө энд оролцож байна. Үнэхээр Туулын хурдны замын ТЭЗҮ болон бусад бүх бичиг баримтууд бүгдээрээ хуурамч худлаа гэдгийг нь өнөөдөр бүгдээрээ хараад сууж байна. Миний хувьд 2025 оны 12 сараас эхлээд Туулын хурдны замыг тавих гэж байгаа гэдгийг нь мэдээгүй ч гэсэн Туул гол дээр ямар нэгэн байдлаар газар ухаад эхэлж байгааг анх удаа мэдээлж байсан. Тэгээд 3 сарын 12-нд Байгаль орчны яаманд мэдэгдэж байсан. Байгаль орчны яам нь өөрөө бараг мэдэхгүй сууж байсан. Яг ингээд биеэрээ ирж үзээд Туул голын эргээр модыг бүр хядаад тавьчихсан байхыг нүдээрээ үзээд өөрсдөө маш их гайхсан. Өнөөдөр ингээд Туулын хурдны замын бүх юм нь худал хуурмаг, тэр үйл хэрэг нь хүртэл худлаа байгааг харж байгаа мөртөө ямар ч хариуцлага хүлээхгүй байна. Дэлхий дээр байхгүй өндөр үнээр ТЭЗҮ-ийн үнийг тогтоож байгаад бүр үнэхээр гайхаж байна. Миний харилцагч Солонгос банкны ажилтан танай Монгол Улсад дэлхий дээр байхгүй ТЭЗҮ-ийн үнээр ТЭЗҮ гаргаж байгаад үнэхээр их гайхаж байна, 100 саяас 2,2 тэрбум төгрөгөөр гаргана гэдэг чинь жижигхэн Монгол Улсад байж боломжгүй өндөр үнэтэй ТЭЗҮ байна. Энэ ТЭЗҮ болон 3,5-аас 600 тэрбум төгрөгийг ямар хүн зөвшөөрөл өгөөд байгааг гайхаж байна. Би бас үнэхээр энэ Төрийн сан болон Сангийн яамыг гайхаж байна. Ямар хүн ингээд зөвшөөрөл гаргаад энэ их мөнгийг ингээд шилжүүлчихдэг юм бэ? Монголын аж ахуйн нэгжүүд өнөөдөр хаалга үүдээ бариад сууж байна. Бид нарын аж ахуйн нэгжүүд татвар төлөх чадваргүй болж байна. Цаашдаа энэ улс чинь татвар төлөгчгүйгээр яаж хөгжиж дэвших юм бэ? Энийг үнэхээр ойлгохгүй байна. Одоо бид нартай зэрэгцээд хууль зөрчөөд сууж байгаа энэ Б.Одбаяраас авхуулаад, Ш.Баранчулуун гуай гээд ийм хүмүүс ингээд сууж байгаад бүр гайхаж байна. Яагаад энэ хүмүүст хуулийн хариуцлага оногдуулахгүй байгаа юм бэ? Яагаад эд нар бид нартай ингээд зэрэгцээд суугаад байгаа юм? Монгол Улсад хууль үйлчилдэг юм уу? Хууль хүн бүрд тэгш үйлчлэх ёстой биз дээ. Татвар төлөгчид үнэхээр өнөөдөр аргацаасан байдалтай амьдарч байна. Зарим хаалга үүдээ хаагаад, гадаад улсад хар ажил хийх гээд явж байна. Би өөрөө Солонгос Улсад сурч байсан. 35 жилийн туршид Монгол Улс гадаад руу дүрвэж...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт нэг минут өгье.

Оролцогч Ж.Баярмаа: Өнөөдөр монголын залуучууд эх орондоо итгэх итгэл алга. Бүгдээрээ гадаад улс явж ажиллаж, амьдарч мөнгө олохын төлөө явж байна. Гэтэл бид 500, 600 тэрбумаа цаасан дээрх компанид шилжүүлчхээд ангайгаад сууж байгаад би үнэхээр гайхаж байна. Тэр Сангийн яамны ямар хүний гарын үсгээр энэ мөнгө шилжүүлсэн юм бэ? Төрийн сан, хэн энэ зөвшөөрлийг олгож энэ мөнгийг шилжүүлсэн юм бэ? Би тэрийг одоо хүртэл мэдэж авч чадахгүй байна. Тэрийг ил болгохыг хүсэж байна. Энд хатуу хариуцлага тооцож, энэ мөнгийг эргүүлж Монгол Улсын төрийн санд төвлөрүүлмээр байна. Бид нар Монгол Улсыг хөгжихийг хүлээсээр байтал эхнээсээ цаг бусаар одсоор байна. Энэ яагаад ийм хариуцлагагүй үйлдлийг ингээд өөгшүүлээд дарга цэрэг болгоод, албан тушаалд томилуулаад зэрэгцээд бид нартай ингээд ангайгаад суугаад байгааг ерөөсөө ойлгохгүй байна. Тийм учраас хуулийг хүн бүрд тэгш үйлчлүүлэх үүднээс бид нар хариуцлага гэж ярьсаар 35 жил боллоо...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Таны яриад байгаа мэдээллийг сонсох гэж энэ сонсгол явагдаж байгаа. Нэмэлт юм хэрэгтэй бол бичгээр хандаж болно шүү. Би оролцогчдоо хандаад нэг зүйл хэлэх нь зөв байх. Хууль зөрчсөн гэдэг зүйлийг хэлэхдээ бид нэлээн бодож тунгааж байж хэлэхгүй бол энэ чинь өөрийн гэсэн дүрэмтэй хуультай. Хэн үнэхээр зөрчсөн юм, үгүй гэдгийг нь тусгай байгууллагууд шалгаж тогтоож байж, түүний дараа шийддэг асуудал гэж хэлмээр байна. Хуулийн үл нийцэл, эрх зүйн зөрчилтэй, ажил явахгүй байгаа талаар сонсгол дээр чөлөөтэй ярьж байгаа. Дараагийн оролцогч Г.Намуунтуяа. Дараа нь Д.Цэрэнжав, түүний дараа Ц.Эрдэмбилэг бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Намуунтуяа: Өдрийн мэнд. Хан-Уул дүүргийн нөлөөллийн бүсийн иргэн Наташа. Миний энэ орос нэрээр хүмүүс мэдэх байх гэж бодож байна. Туулын хурдны замтай холбоотой Хан-Уул дүүргийн иргэдээс нэг асуумж аваагүй. Ер нь 2025 оны 9 сард үерийн далан дээр 2 км шахуу зам барина гэснээр бид нар Туулын хурдны замыг анх мэдэж байсан. Яагаад бид нар эсэргүүцээд байгаа вэ гэвэл өөрсдөө бид нар энэ эргийн хамгаалалтын онцгой бүсэд амьдардаг, тийм учраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5-д заасан хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалтай салшгүй холбоотой хууль болох Усны тухай хуулийн 12.1.4-т заасан үүргүүд биелэгдэхгүй байна. Харин ч нийслэл, дүүргийн Засаг дарга нар өөрсдөө Туул голын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг зөрчигчид болж хувирсны улмаас экологич зөвлөх авч, зөвлөхөөр ажиллуулсан. Мөн хамтраад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Туул голын ай сав газрынхан, Өв соёлын үндэсний төвийн хүмүүс маань цаг алдалгүй шаардлагатай бичгүүдийг бид нарт өгснөөр бид цагдаагийн албан хаагч нартай 2 сарын хугацаанд энэ хууль бус Туулын хурдны замын ундны усны нөөцийн худгууд дээрх кемпүүд дээрх энэ Хятад кемпийг барьж дуусахаас нь өмнө бид нар 2 сарын хугацаанд сахин хамгаалж зогсоож байсан. Ийм учраас Байгаль орчны яам, Усны газар, Туул голын ай сав газар, цагдаагийн албан хаагчдадаа баярлаж байна. За тэгээд энэ 57 хоногийн хугацаанд зөвлөх экологичийн хамтаар 47 хууль зөрчсөн баримтыг Ерөнхий сайдад 2026 оны 5 сарын 14-ний өдөр хүлээлгэн өгсөн. Одоо иргэн хүний зүгээс миний хүсэж байгаа зүйл бол Хао Юань Женерал Констракшн гаднын хөрөнгө оруулалттай ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй байхад Туул голын усны ундарга тэжээн тэтгэгч усны судлыг гэмтээж өрөм тавьсан болон бургас зөвшөөрөлгүй хядсан, Усны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.10-тай холбоотой хууль дүрмийг биелүүлээгүй, Усны газрын дүгнэлт байхгүй, тусгай зөвшөөрөлгүй, химийн хортой бодис Туул голын ай сав газар буюу ундны усан дээр ашигласан, соёлын өвтэй холбоотой палеонтологи археологийн судалгаа малтлага судалгааны

тайлан огт хийгээгүй буюу байхгүй гэх мэт маш олон хууль зөрчсөн. Үүнээс гадна Монгол Улсын онц чухал объект буюу ундны усны гүний худгууд дээр 10 метр зайтай орж ирсэн болон транзит тээвэр буюу химийн аюултай ачаа нь хот дотор явах хориотой байдаг. Ундны усан дээгүүр болон ундны усны худгууд дээгүүр явах нь өөрөө...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт минут өгье.

Оролцогч Г.Намуунтуяа: Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд халдаж байна гэж үзэж байгаа. Иймээс яаралтай тэрэг техникүүдийг улсын орлого болгон хураан авч, тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгож, Монгол Улсад учруулсан хохирлыг барагдуулж, экологийн эсрэг гэмт хэргийнх нь хохиролд хариуцлага тооцох шаардлагатай байна. Эдгээр хууль бус үйлдэлтэй нь холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй этгээдүүдэд хариуцлага тооцож, толгой Хятад компанийг ажилчдын хамтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс албадан хөөж гаргана уу гэсэн ийм хүсэлтэй байгаа юм. Яагаад гэвэл Туулын хурдны зам төслийг 2 сарын хугацаанд, 3 сарын 19-нөөс хойш Туул голдоо хайртай залуустайгаа болон мэргэжлийн зөвлөх экологичийг зөвлөхөөр авч ажиллуулсан. Харьяа яамд мөн цагдаагийн байгууллагууд бид нартай хамтарч иргэддээ тусалж ажилласнаараа бид нар өнөөдөр хууль бус, угаасаа хориотой энэ химийн аюултай бодис, транзит зам хот дотор явах нь угаасаа хориотой байдаг, энийг бол би маш олон удаа хэлж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Таны үгийг сонслоо. Дараагийн оролцогч Д.Цэрэнжав, түүний дараа Ц.Эрдэмбилэг бэлдэж байгаарай. 3 номерын микрофон.

Оролцогч Д.Цэрэнжав: Улаанбаатар хот өөрийнхөө тулгамдсан асуудлыг ингэж нээлттэй, оролцоотой ярьдаггүй учраас тэр бугласан бүх асуудлууд нь Туулын голоор сэдрээд, өнөөдөр бид нар энд суугаад ийм яриа өрнүүлж байна гэж бодож байна. Тэгээд би шуудхан хэлье. Улаанбаатар хотод өнөөдөр хот төлөвлөлт, газар олголт, барилгажилтын онц байдал тогтоох түвшинд хүрсэн. Асуудал ингэж даамжирсан гэж би үзэж байна. Энэ бүхэн хяналтаас гарсан. Үүнийг нотлоод би хэдэн санаа хэлье. Улаанбаатар хот бол ХХ зуунд төлөвлөөд бүтээн байгуулчихсан дэд бүтэцтэй, тэр нь 30 жил хүрэлцэхүйц эрчим хүчний эх үүсвэртэй, өргөн цэлгэр гудамж талбайтай, барилга байшинтай ийм хот байсан. Бидний өнөөдрийн яриад байгаа тэр 20 минутын хот гэдэг бол юу ч биш. Тэнд 5 минутын хот, 10 минутын хот гэдэг маань тэр 1 дүгээр хороолол, 3, 4 дүгээр хороолол, Сансар хороолол байсан. Тэгээд өнгөрсөн 20, 30 жилийн хугацаанд бид нар энэ бүх орон зайг паразитласаар байгаад өдий хүрсэн байна. Тэгээд бүх газар, бүх сул орон зайг иргэдээс, олон нийтээс, оршин суугчдаас, хүүхдүүдээс, сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагаас булааж авсаар байгаад өнөөдөр чигжсэн ийм хот болсон. Хамгийн харамсалтай нь энэ үргэлжилсээр байгаа учраас би Улаанбаатар хотод хот төлөвлөлтөд онц байдал тогтоох хэрэгтэй гэдэг ийм санааг дэвшүүлж хэлж байгаа юм. Тийм хуулийн гаргалгаа байхгүй ч гэсэн би санаагаа ойлгуулах үүднээс хэлж байна. Тэгээд энэ бүхэн бол зогсохгүй байна. Сэлбэ гол дээр бүхэл бүтэн орон сууцын хороолол барьж байна, Туул голд халдаж байна, Богд уулын амнуудаа харья. Нийслэл Улаанбаатар хот хамаагүй гэж хэлэх байх л даа. Гэхдээ тэд чинь барилгын зөвшөөрөл олгодог юм шиг байгаа юм. Хамгийн сүүлд Улаанбаатар хотын ХХ зуунд бүтээн байгуулчихсан түүхэн төв болсон Бага тойрууг өнөөдөр өдөр бүр дэс дараатай дахин төлөвлөлт нэртэйгээр системтэйгээр устгаж байна. Та бидний өмнө маш эмгэнэлтэй үйл явдал болж байна.

Тэгэхээр Улаанбаатар хот бол засаглал, хот төлөвлөлтийн хувьд мухардалд орсон. Юу болж байна гэвэл нэг гараараа Улаанбаатар хотоос түгжрэлийг бууруулах нэрээр хэдэн 10, хэдэн 100, хэдэн тэрбум, их наядын хэмжээтэй хөрөнгө мөнгийг мега төсөлд зарцуулж байгаа хэр нь нөгөө гараараа яг хотынхоо төвд 16, 20, 24 одоо бүр 50 давхар барилгын зөвшөөрөл олгоод байна. Эцсийн дүндээ энэ бүх асуудал шийдэгдэхгүй байна гэдгийг би хэлмээр байна.

Энэ бүгдийг хэлэхлээр Улаанбаатар хотын удирдлагууд энэ хотын түгжрэлийг бууруулж, утааг багасгах ч гэдэг юм уу, энэ тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд бид энэ бүгдийг хийж байна гэж ялархсан байдал гаргаад байгаа юм. Өчигдөр ч гэсэн ийм байдал ажиглагдаж байна лээ. Тэгэхээр би асуумаар байна л даа. Ер нь Улаанбаатар хотын энэ бүх асуудлыг шийдэж, хөгжүүлэхийн тулд Улаанбаатар хотын мега гэдэг 24 төслийг хэрэгжүүлэх ёстой юм уу?, үгүй юм уу? Энэ бүхэн чинь тэгээд хэрэгжүүлэх нь зөв юм уу?, үгүй юм уу? Хэн нэгэн хүний бизнесийн шахаа болсон, хүслийн жагсаалт энэ тэр чинь одоо зөв юм уу?, үгүй юм уу?

УИХ нь сандраад Улаанбаатар хот болохоо байлаа гэхэд УИХ-аас батлаад өгчихсөн энэ бүх төслүүд чинь зөв юм уу? Биш гэж би бодож байна. Тэгэхээр энэ бүх зүйлийг дахин өөрөөр харах ёстой. Ер нь энэ барилгажилт бол арай дэндэж байна. Барилга бариад орон сууцжуулах нь зөв байх. Гэхдээ энэ бүгдийг хуйгаар нь хотоо ингэж өөрчилж болохгүй байх.

Олон хүмүүсийг орон сууцад орууллаа гэхэд тэд нарын дараагийн хэрэгцээ нь юу болох вэ гэвэл зуслангийн газартай болох ёстой. Одоо зуслангийн газар нь тэр чигээрээ гэр хороолол болчихсон байж байна. Яагаад би энэ бүгдийг хэлж байна вэ гэвэл, үүнийг заавал мега төслөөр биш зөв зохион байгуулалтаар, сайн бодлогоор, сахилга хариуцлагаар, оновчтой шийдлээр шийдэх ёстой байсан. Гэтэл энэ боломжийг огт ашиглахгүй байна.

Би хамгийн сүүлд нь Улаанбаатар хотод хамгийн хэрэгтэй байгаа мега төслийг зарлая. Улаанбаатарт сайн засаглалыг бий болгох нь хамгийн том мега төсөл шүү. (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Одоо оролцогч Ц.Эрдэмбилэг үг хэлнэ. Дараа нь З.Гэрэлт-Од бэлдэж байгаарай.

Оролцогч Ц.Эрдэмбилэг: Та бүхэнд Их Монгол Улс байгуулагдсаны 820 жилийн ойн баярын мэнд хүргэе. Яг одоогоос 820 жилийн өмнө Эзэн Чингис хааныгаа хүрээлээд бүх монголчууд нэгдэж байсан юм шүү. Тэгэхээр бид бүгдээрээ одоо эв нэгдлийг илүү их чухалчилж үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Монголчууд бид одоо сэрж байна.

Бүгдээрээ улс орноо яаж хөгжүүлэх вэ гэсэн тийм үзэл бодол бол байна. Ер нь бол дэлхий нийтээрээ Монголчуудыг дөрвөндөө эрхшээснийг мэддэг учраас энэ монголчуудаас дэлхийг удирдах ухаан ч гэж гаргана гэж үздэг. Тийм болохоор 3,5 сая монголчууд, хүн болгон мянган хүн захирах, мянган хүний аж байдлыг сайжруулах тийм хүчин чадалтай шүү гэдгийг Та бүхэнд хэлье.

Би бол энэ залуучуудыг их дэмждэг хүн байгаа юм. Энэ залуучууд зоригтой үйл ажиллагааг явуулж байсныг мэдэж байгаа. Мэдээж хэрэг нийслэлийн төсөв гэдэг бол улсын төсөвт заавал ч үгүй захирагдах ёстой.

Тийм болохоор энэ Туул голын хурдны замын төсөл бол зогсох нь зайлшгүй. Ер нь бол хууль хяналтын байгууллагуудын тэд нарын хийх ажил. За тэгээд миний хэлэх гэсэн эхний санаа бол нэгдүгээрт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудал байна. Энд ашигтай, боломжтой нь ч байж байгаа, боломжгүй нь ч байж байгаа.

Нийт гэр хорооллын дахин төлөвлөлт болон орон сууцын залилангаар 70 мянган хүн хохирсон юм. Тэдгээр хүмүүсийн нэг нь би өөрөө байгаа юм. Тийм учраас Гэр хорооллын дахин төлөвлөлтийг сайн явуулах ёстой. Үүний нэг жишээ нь энэ Сэлбэ дэд төв байна. Энэ маань нэлээн сайн явж байхад нэг ёсондоо Туулын хурдны замыг зогсоохын төлөө нөгөө нэг төслийг нь бас давхар зогсоодог нь яаж байгаа юм бэ? Уг нь УИХ-аар нефтийн үйлдвэр, Эрдэнэбүрэний УЦС, Сэлбэ дэд бүтэц 3 орж байснаа яагаад Сэлбэ дэд бүтэц нь алга болчихов оо? Энэ төмөр замаас урагшаагаа Баянмонгол хороолол гэж анх баригдсан. Одоо тэрнээс хойш цементэн ширэнгэн ой болчихлоо. Түүнтэй адилхан Сэлбэ дэд бүтцийн сонгосон газар дээр бас тийм ширэнгэн ой болох гээд байгаа юм уу? Уг нь нэгдсэн байдлаар Сэлбэ дэд бүтцийг явуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Миний дараагийн нэг санаа бол Сонгинохайрханы дүүргийн ХҮЙ-7 худаг гээд бид нарыг наадмаар очиход нэг халзан хоосон уул байдаг. Үүнийг цэцэрлэгт хүрээлэн болгоё гээд “Баялагтаа эзэн Монгол” ТББ-ын Г.Хажидмаа хөөцөлдөөд явж байгаа. Бид хамтдаа нэгдэж байгаа учраас үүнийг бас дэмжиж өгөөч гэдэг хүсэлтийг энэ хотын захиргааны шинэ залуучуудад хандаж хэлэх байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За нэг минут нэмж өгье.

Оролцогч Ц.Эрдэмбилэг: Миний хоёр дахь хэлэх гэсэн санаа бол энэ агаарын бохирдлын асуудал байгаа юм. Агаарын бохирдол ямар их гамшиг тарьсныг та бүхэн харж байна. Сүүлийн 5 жилд 125,247 эх зулбасан байна. Ийм өндөр тоо, баримтуудыг чинь ҮСХ-ноос гарсан тоо шүү. Энийг зүгээр судалж үзээд л гаргаад ирчих боломжтой байгаа байхгүй юу. Энэ агаарын бохирдлын асуудал чинь Улаанбаатар хотын л асуудал шүү дээ.

Агаарын бохирдлын асуудал ярихаар эхнийх нь сайжруулсан түлш гэж байгаа. Энэ маань ерөөсөө л хүхэр гаргаж байгаа шүү дээ. Судалгаагаар хүхрээр хүмүүс хордож байсан гэдгийг ерөөсөө зарлахгүй байна. Түүнтэй адилхан дараагийнх нь коксожсон нүүрс байгаа. Та бүхэн өглөө босоод л машинаа асаахад чинь тэр чигээрээ машины чинь гадна тал... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Таны үгийг сонслоо. Баярлалаа. Дараагийн оролцогч З.Гэрэлт-Од 3 дугаар микрофон дээр хүрэлцэн ирнэ үү? Дараа нь Түүний дараа Б.Болор-Эрдэнэ, Ц.Пүрэвдорж гэсэн дараалал байна.

Оролцогч З.Гэрэлт-Од: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би иргэн З.Гэрэлт-Од байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч асан Х.Нямбаатар, НИТХ-ын дарга А.Баяр нарын бий болгосон автомашины татвар, авто замын татвар мөн Улаанбаатар хотын татваруудын заримыг нь 4 дахин, заримыг нь 1 дахин нэмсэн тухай захирамж, тушаал, шийдвэрүүдийг хүчингүй болгож өгөөч.

Улаанбаатар хотын ард иргэдийг нийслэлийн Иргэдийн хурлын төлөөлөгч нар болоод нийслэлийн удирдлагууд бэлэн мөнгөний автомат машин шиг харах юм.

Улаанбаатар хотын ард иргэд бол энэ нийслэлийн 45 төлөөлөгчдөд нэг ч төгрөгийн өргүй байхгүй юу. Улаанбаатар хотод энэ иргэд чинь өөрсдөө ажил хөдөлмөрөө эрхлээд, өнөөдөр амьдрах гэж ядаж байгаа юм. Тэгэхлээр энэ захирамж, тогтоол, шийдвэрийг нэн даруй хүчингүй болгож өгөөч. Бид нар Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж, энэ Улаанбаатар хотод чинь амьдармаар байна. Бид Вьетнам гэдэг юм уу?, Хятад эсхүл ОХУ-аас ирж энд амьдраагүй. Бид Улаанбаатар хотын ард иргэд учраас энэ эрхээ шаардаж байгаа юм. Энэ талаар холбогдох байгууллагадаа уламжилж өгнө үү!

Хоёрдугаарт, энд Н.Алтаншагай, П.Сайнзориг гээд 2 гишүүн байна. Өчигдрийн сонсгол дээр орж ирээд баахан улс төржүүлж, худлаа ярьж байгаад гарсан. Энэ 2 хүнээс асуумаар байна. У.Хүрэлсүх даргын Ерөнхий сайд байхдаа улсын төсвөөс 500 тэрбум төгрөг зарцуулж байгаад гаргаж ирсэн түлшний үйлдвэр яасан бэ? Өнөөдөр Улаанбаатар хот БНХАУ-аас түлшээ аваад авах хэмжээний ийм л байдалтай болоод байж байна. Тэгэхлээр энэ түлшнийхээ асуудлуудыг өөрсдөө, монгол инженерүүдтэйгээ хамтраад дотооддоо шийдвэрлэх хийх талаар та бүхэн тодорхой арга хэмжээ авч өгөөч. Алийн болгон төсвийн мөнгийг Улаанбаатар хотын ард иргэдийн төлсөн татвараар та нар баруун солгойгүй цацах юм бэ гэдэг дээр шаардлага тавимаар байна.

Нийслэлийн 45 төлөөлөгчөөс 43 нь өнөөдөр давхар дээлтэй сууж байна. Энэ хүмүүс чинь яасан ханаж цаддаггүй нөхдүүд вэ? Энэ нөхдүүдийг бүрэн эрхийг нь эргүүлэн татаад хууль, цагдаа, шүүх, прокурор, АТГ нэн даруй шалгаад ард түмэндээ тайлангаа нь тавимаар байна. Бид нар энэ 43 төлөөлөгчид төлөх өр байхгүй. Энэ нөхдүүдийг буулгаад, шалгаад одоо нийслэл Улаанбаатар хотод тулгамдсан байгаа засаглалын хямралыг арилгах хэрэгтэй байна. Ард түмнийхээ төлөө ажил хийж чадна гэсэн ийм залуучуудаар та нар нийслэлийнхээ төлөөлөгчдийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За нэг минут нэмж өгье.

Оролцогч 3.Гэрэлт-Од: Баахан улс төржсөн, худлаа ярьсан нөхдүүд орж ирээд сууна. Одоо зарим нь ичихгүй хараад сууж л байна.

Тэгээд хурал даргалагч танд нэг горимын санал байна. Х.Нямбаатар гэдэг юм уу? Эсхүл А.Баяр мөн энэ нийслэлийн 43 төлөөлөгч нарт хариуцлага яг яаж тооцох юм бэ гэдгээ тодорхой хэлэх хэрэгтэй байна. Та олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 5 хоногийн хугацаанд ард иргэдийг үл ойшоож, энэ арга хэмжээнд хүрэлцэн ирээгүйд нь ямар шалтгаан байсан талаар бичгээр болон амаар нь албан ёсны тайлбар хийлгэх хэрэгтэй байна гэдгийг хэлмээр байна.

Төгсгөлд нь зүгээр нэг “жок” болгоод хэлэхэд энэ шинээр сонгогдсон Засаг дарга чинь ер нь ажил хийж чадна биз дээ? 3-4 сар байж байгаад бас нэг галзуу солиотой болоод явчих вий дээ гэж айх юм байна шүү. За Та бүхэнд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хуулийнхаа зохицуулалтаар ерөнхий хяналтын сонсгол дээр одоо албан тушаал хашиж байгаа албан тушаалтнууд ирж асуултад хариулж, мэдээлэл өгөх үүрэгтэй. Харин өмнө нь албан тушаалаа өгчихсөн хүн бол заавал ирэх үүрэг хүлээдэггүй юм байна. Харин тусгай хяналтын түр хороон дээр бол гэрчийн мэдүүлэг өгөхөөр дуудсан хүн болгон ирж тайлбар, мэдээлэл өгөх үүрэгтэй байдаг. Тийм учраас дуудсан хүн бүр ирээгүй гэдгийг танд хэлье. Сонсгол даргалагчийн хувьд 5 хоногийн дотор сонсголын

тайлан, тэмдэглэлүүд гарна. Дараагийн оролцогч Б.Болор-Эрдэнэ, түүний дараа Ц.Пүрэвдорж, А.Оюунчимэг нар үг хэлэхээр бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Болор-Эрдэнэ: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Намайг Б.Болор-Эрдэнэ гэдэг. Иргэн бас хохирогч гэж хэлье. Ер нь Монголчуудаа, улс төрчид өө, УИХ-ын гишүүд ээ! Бид өнөөдөр яагаад ийм сонсгол хийгээд сууж байгаа билээ гэж асуух гэж ирлээ. Юун Ли Бай, юун О Ви болчихсон бэ? Сүүлд олон улсын стандартаар авсан шалгалтаар Монголд 3 хүүхэд тутмын 2 нь уншсанаа ойлгохгүй байна. Тэгээд өнөөдөр яригдаж байгаа хэдэн их наядын төсөв, бүүр 10-11 их наядын төсөв чинь 2023 оноос яригдаж байгаа. 2023 онд 1 дүгээр ангид орсон хүүхдүүдэд 4 жил энэ мөнгийг зарцуулсан бол өнөөдөр бүгдээрээ уншдаг болчихсон байхаар мөнгө шүү дээ. Тэгээд энэ мөнгө яагаад Ли Бай, О Ви овогт гээд энэ хаана нь мэдэгдэхгүй компаниуд руу гараад явчихсан юм бэ? Х.Нямбаатарт хэн ийм боломжийг өгсөн бэ? 2024 оноос байгуулагдсан УИХ өөрөө шүү дээ гэж хэлэх гэсэн чинь энд УИХ-ын гишүүд алга. Иргэдийн өөдөөс хараад суух нүүр байхгүй бололтой. Харуулах нүүртэй ганц 2 нь энд сууж байна.

Гадаа чинь 2024 оноос гэсэн самбар байгаа биз дээ. Тэгэхээр би 2024 оноос бүрдсэн энэ УИХ-ын гишүүдээс асуумаар байна. 2025 оны 1 дүгээр сард Туулын хурдны замын төсвийг 2 их наяд төгрөг болгож нэмж байхад юу хийж байсан хүмүүс вэ? 2025 оны 1 дүгээр сард УИХ-аар нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040 хүртэл гээд бүр 70 тэрбум ам.долларын төсөвтэй 24 мега төсөл орж ирэхэд батлаад явуулсан шүү дээ. Энэ УИХ дахиад 2025 оны 3 дугаар сард нийслэлийн төсвийг 5,8 их наяд болгож нэмэгдүүлж байхад юу хийж байсан хүмүүс вэ? 4 дүгээр сард нь 6,771 метр урттай байсан гүүрийг 9,878 болгоод дахиад 2,3 их наяд болгож төсөв нэмж байхад юу харж байсан хүмүүс вэ?

Тэгэхээр энэ бүхнийг энэ зэргийн хулгай, дээрэм гарна гэдэг нь бол ойлгомжтой байсан. Би энэ гишүүдийг батлаад яваад байсан байгаа юм чинь ойлгохгүй байсан гэж бодохгүй байгаа. Яагаад ойлгомжтой асуудалд хөдөлж өгөхгүй байсан бэ? Хөдлөхгүй болохоор чинь энэ иргэд бүтэн жил гудамжинд амьдарлаа шүү дээ. Хулгай, дээрэм хийгээд байгаа энэ мөнгөөр гараа угаагаад байгаа даргаасаа салах гэж, энэ бүхнийг зогсоох гэж. Тэр тулдаа өнөөдөр энд сууж байна.

Энэ чинь ойлгомжгүй юм биш. Маш ойлгомжтой. Төсвийн хяналтаараа нэгдсэн төсвөөрөө... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За нэг минут нэмж өгье.

Оролцогч Б.Болор-Эрдэнэ: Яагаад 2024 оноос хойш энэ УИХ-ын батлаад явуулчихсан, бүр нийслэлийн эрх хэмжээг нэмсэн 10 хэдэн хуульд эрх хэмжээ өгчихсөн. Яах гээд явуулаад байсан ойлгомжтой шүү дээ. Өөрсдөө тэр 24 мега төсөлд макро ч юм уу, микро ч юм уу тендер аваад орчих гээд, компаниа оруулчих гээд, ах дүүгээ идүүлчих гээд л байж байсан хүмүүс байгаа шүү дээ.

Тэгээд хийдэг юм нь тэрнийхээ төлөө гаргаж байгаа 2 шийдвэр болгоны нэг нь дарга юм уу, сайд томилох, нэг бол татах. Ингээд энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиараа, Төсвийн хүрээний мэдэгдлээрээ, Өрсөлдөөний хуулиараа, Өрийн удирдлагын хуулиараа зогсоож болох байсан асуудал дээр санаатайгаар хүрсэн учраас УИХ-ын энэ чуулган бол ерөөсөө хам хэрэгтнүүд. Ингээд хам хэрэгтнүүд хууль нэг ширхэг мөр хууль бичихгүй хэр нь одоо Авлигатай тэмцэх газрыг буруутгаад байгаа юм. Бүгдээрээ шоронд орох зорилготой улс төр юм уу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Маш чухал пойнт хөндөж байна шүү. Нийслэлийн үйл ажиллагаа нь УИХ-аас баталсан хууль тогтоомжийнхоо хүрээнд явж байгаа, тэрийгээ засахгүй яасан юм бэ УИХ-ын эрхэм гишүүд ээ гэсэн зүйл ярилаа. Энэ мэдээллийг бол сонсож байгаа. Одоо завсарлагааны цаг болчихсон, хүн цөөн байгаа ч гэсэндээ бүгд л сонсож байгаа. Дараагийн оролцогч Ц.Пүрэвдорж, түүний дараа А.Оюунчимэг бэлдэж байгаарай.

Оролцогч Ц.Пүрэвдорж: “Шар шувуу үүрэндээ гардийн дүртэй” гэж ярьдаг юм байна лээ. Энэ нийслэлийн хэдэн нөхдүүд, мега төслийг үхтлээ цээжээрээ хамгаалсан хэдэн гишүүд Төрийн ордонд даналзаад л сууж байна.

Хятадыг тэд дуурайдаг юм гэнэ лээ. Энэ бүх мега төслүүд нь хятад төсөл гэсэн. Хятад орчуулгатай, зарим нь орчуулж амжаагүй Хятадаар ч явж байна гэсэн. Хятадыг та нар их дуурайдаг юм гэнэ лээ. Манай хуулийн байгууллага яг одоо Төрийн ордонд орж ирээд та нарыг баривчлаад аваад явдаг болоосой. Даан ч тэгж чадахгүй юм байна л даа.

Энд өглөөнөөс хойш авлига, эдийн засаг, Засгийн газар гээд биччихсэн цаас байгаа ч даана ч энэний ард хэн ч ирсэнгүй. Би иргэн хүнийхээ хувьд хуулийн байгууллага, АТГ-т итгэл алдраад байгаа. Нийслэл гэж нэг ийм картель, мафи байгуулчихсан юм шиг хэдэн нөхдүүд байна. Та нар одоо бүгдээрээ сонслоо. Хэвлэл мэдээллээ худалдаад авчихдаг, тролл арми худалдаад авчихдаг, иргэдийнхээ эсрэг дайрч давшилдаг, иргэдээ ялладаг, хулгай хийдэг. Хэвлэлийнхэнтэй 300 хэд гэнэ үү удаа гэрээ хийсэн байна гэж байна шүү дээ. За энэ ч яах вэ!

Одоо энэ мега төслүүдийн чинь өр төлбөрийг хэзээ төлж дуусах юм бэ? Байгаль орчны сайд нь маш олон хууль зөрччихсөн байна гэж мэдэгдэл хийлээ. Үндэсний аудитын газрын дарга нь ирээд өчнөөн зөрчил гаргачихсан байна гэж мэдэгдэл хийлээ. Энэ шинжээч нар чинь үндэслэлгүйгээр 1 их наяд төгрөг нэмчихсэн байна гэж яриад байна шүү дээ. Тэгээд юу ч хийгээгүй юм шиг, хулгай хийгээгүй юм шиг ингээд даналзаад суугаад байх юм. Шар шувуунууд гардийн дүртэй сууцгаагаад байх юм.

Нүүрсний сонсгол гэж хэдэн жилийн өмнө болсон. Нүүрсний хулгайн хэргээр нэг ч хүн ял аваагүй. Одоо та нар түүн шиг эрдээд энэ том төслүүд дээрээ хулгайлсан мөнгөн дээрээ ял авахгүй гэж бодож байх шиг байна. Ард түмэнд ой санамж байгаа шүү. Нүүрсний их наядын хулгай, 40 их наядын хулгай гэж ярьж байгаад араар нь Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар тэргүүтэй хүмүүс хэдэн их наядын хулгай хийсэн байна лээ. Харбины гэрээгээ хар. Зарим гишүүд чинь 10 тэрбум ам.долларын алдагдалтай гэрээ хийчихлээ, баахан концесс гэрээгээр 16-27 жилийн хугацаанд нүүрсээрээ бартерлаж, төлөх нүүрсээ 30-70 ам.доллароор үнэлсэн байна гээд яриад байна. Ойрын 20 жил нүүрснээс ашиг олохгүй нь.

Та нарын энэ яриад байгаа, энэ том бүтээн байгуулалт гээд байгаа, энэ хулгай луйврын чинь мөнгийг төлж дийлэхгүй. Монгол Улс юугаараа төлөх юм. Үнэхээр харамсалтай байна. УИХ-ын гишүүд нь ч гэсэн сонсголд оо ирдэггүй, 2 цаг хүлээлгэдэг, өлсөж үхэх гэж байгаа гэдэг нь мэдэгдэж байна шүү дээ. Та нар хоолны цаг боллоо гээд бүгдээрээ хаяад гараад явчхаж байна. Энэ зааланд хэн ч алга байна. Эцэст нь хэлэхэд ямартай ч ... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За нэг минут нэмж өгье.

Оролцогч Ц.Пүрэвдорж: Энэ сонсгол гэж зохион байгуулж “энэ мега төсөл хулгай болж байна” гэж хэдэн гишүүд нэлээн сайхан орилж, ярьж байж энэ сонсгол хийж байгаад зарим гишүүддээ баярлалаа. Зарим нь энэнээс болж маргалдаж, хүзүүдэж унагааж байгаа харагдаж байсан. Үнэхээр хүзүүдэх байтугай л байна шүү дээ.

Бид нар яриад л байдаг, хэлээд л байдаг үр дүн гарах юм уу, үгүй юм уу би мэдэхгүй байна. Цаашдаа тэгээд хуулийн байгууллага нь анхаарна биз гэж бодож байна. Та нар ер нь даналздагаа одоо боль л доо. Мафи биш дээ ямар? Та нар маш олон хууль зөрччихсөн байна шүү дээ. Хууль болгоныг зөрчсөн байна шүү дээ. Ичээч та нар. Энэ шинэ хотын дарга гээд нэг нөхөр байна. Мега төслүүдийг эрэмбэлнэ гэнэ үү! Бас өмнөх шиг бүтэхгүй 5 юмыг авчраад тавьчихсан юм байна лээ. “Мордохын арзгай” гэдэг шиг дөнгөж ажлаа авсан хүнийг шүүгээд яах вэ! Гэхдээ ингэж мордохын хазгайгаар эхэлж байгаа бол дараагийн хулгайч нь дахиад явна. За өөр хэлэх үг алга. Баярлалаа

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За дараагийн оролцогч А.Оюунчимэг, түүний дараа Г.Болдбаатар бэлдэж байгаарай. А.Оюунчимэг байхгүй байна. Оролцогч Г.Болдбаатар байна уу? 3 дугаар микрофон дээр урья

Оролцогч Г.Болдбаатар: Гишүүд өглөө хоцорч ирдгээ болимоор байна. Өчигдөр бас ийм зүйл болсон. Энд чинь өчнөөн хүн цаг гаргаад ирж байгаа шүү дээ. Одоо тэгээд хойшлуулаад цайны цаг таараад, гадаа хүмүүс идэж уугаад яриаг нь сонсож байгаа ч амьтан байхгүй байна. Зориуд ийм зохион байгуулалтын алдаа гаргаад байгаа юм шиг харагдаад байна шүү. Дараа дараачийнх дээр анхаараарай. Олон хүмүүс ярьчихсан учраас хэдхэн юм л хэлчихье.

1 дүгээрт энэ төсвийн тэлэлт дээр 2026 онд 7,8 их наяд, зөвхөн хот дээр 2,5 их наядын алдагдалтай гэж гарсан. Одоо шинэчлэх байх тийм ээ. Төсвийн тодотгол хийх байх. Гэхдээ улстай харьцуулахад одоо энэ чинь бараг 230-240 буюу 2,4 дахин их алдагдалтай төсөв тодотгоод, батлаад явчихсан байхгүй юу. Энийг бүгд хараад хүлээн зөвшөөрөөд явсан шүү дээ. Сая ингээд огцруулаагүй бол энэ чинь үргэлжлээд явах байсан байхгүй юу. Одоо бас бүрэн алдагдлыг нөхөж чадахгүй гэж харагдаж байна.

Орлогыг харахаар 2020 оноос 734 тэрбумаар батлагдаж байсан хотын төсөв 3 их наяд, одоо 5,4 их наяд болохыг бид нар сүүлийн 6 жил зүгээр л нүдэн дээрээ хараад суучихсан байхгүй юу. Энд байгаа бүх хүмүүс харж суусан. Тэгээд зардал нь байнга алдагдалтай болж эхэлсэн. 2020 оноос эхлээд ер нь бол 2022 онд 1,4 их наяд 2025 онд 4,5 их наяд, 2026 онд нийт 7,8 их наядын зардал алдагдалтайгаар батлагдсан. Улсын төсөв ч 1 их наядын алдагдалтай батлагдахад ямар том асуудал үүсдэг билээ. Энэ яагаад ингээд вакумжаад, хаалттайгаар ийм муухай мафижсан, балиар систем хот дээр үүссэн бэ гэдэг нь хамгийн гол асуудал байхгүй юу даа.

Үүнийг бүгд хараад хүлээн зөвшөөрөөд явсан шүү дээ. Энэ хотын дарга нар менежерүүд энд байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Ихэнх нь сая гараад явчихлаа. Эргэж орж ирэх юм уу, үгүй юү мэдэхгүй. Хуучин дарга, цэргүүд нь тэр тусмаа энд байх ёстой байхгүй юу! Одоо хүртэл ажиллаж байгаа шүү дээ. Хуучин баг нь шинэ даргатайгаа ажиллаад сууж байгаа. Тийм ээ. Одоо бөөн зөрчилтэй байгаа.

Төсвийн тогтвортой байдлын хууль байгаа ч гэсэн тодотголоор жил болгон 4-

5 дахин төсвөө нэмж, алдагдалд оруулсаар ирсэн. Зөвхөн хот дээр ярьж байгаа шүү. Сүүлийн 2-3 жил энэ бонд, алдагдалтай төсөв, зээлүүд бүгд өр шүү дээ. Тийм ээ. Өр бол төсвийн тэлэлт, мөнгө хэвлэлт болох эрсдэлтэй байхгүй юу. Төсөвт тэлж байгаа нь өөрөө ААН-ийн орлогын татвар дотор Хувь хүний орлогын л албан татвараас хувиас шууд хамааралтай. Энэ 2 татвараас хотын төсөвт 70% бүрдэж байгаа. Тийм учраас татвараа буулгахгүй гээд зүтгээд байгаа юм. Зүтгэсэн одоо ч гэсэн шууд холбоо нь ... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За нэг минут нэмж өгье.

Оролцогч Г.Болдбаатар: Тэгээд энэ хотын татвар хавсарч олон дахин нэмэгдсэн. ААН-үүд угаасаа арчигдаж байгаа. Эдийн засгийн ашиглалт хөрөнгө оруулалт зогссон. Татвар өснө. Угаасаа туйлдуулж байгаа. Мега төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор 1,5 их наядыг 2026 онд гаргах байснаас 600-900 тэрбум нь одоо мэдэгдэж байгаагаар гараад явчихсан байна. Үүнийг буцааж авч чадахгүй юм чинь Туулын замаа бол угаасаа болих ёстой. Оронд нь юу хийх юм бэ? Энийгээ маш тодорхой яаралтай болгооч ээ!

За хугацаа байхгүй учраас шууд сүүлийн хэсэг рүү орчихъё доо. Энэ төсвийн алдагдалгүй байдал, төсөв болон мега төслийн ил тод байдал нэг номерт шүү. Жинхэнэ тогтолцооны өөрчлөлтийг одоо хиймээр байна. Иргэдэд дата байхгүй байна, хянаж чадахгүй байна тийм ээ. Энэ дээр ямар нэгэн бодитой үйлдэл хийж чадахгүй байна. Одоогийн байгаа шилэн данс гэдэг хошин шогоо болиоч ээ. Одоо юу гэдэг юм Дулмаагаас эхлээд, хорооны ажилтнаас эхлээд бүх төсвийг нэг нэгэнгүй онлайнаар нэгдсэн датагаар оруулдаг, хянадаг, нээлттэй систем бий болгооч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нийтийн ажил хийж байгаа хүмүүс нийт төсвөө ил байлгая гэдэг ийм саналыг хэллээ. За одоо Э.Тэмүүжин, дараа нь Г.Гүррагчаа. Та хэн билээ? За А.Оюунчимэг 3 дугаар микрофон нээж өгье

Оролцогч А.Оюунчимэг: Юуны өмнө Монгол Улсын Их Хурал дээр Төсвийн тухай хууль, хурдны замын талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийж байгаад баяртай байна. Би өглөө 8 хагаст таксидаад ирсэн. Бараг 2 цагийн дараа эхэллээ. Тэгээд энд үгээ хэлэх гэж ирсэн. Би “Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан”-ийн тэргүүн А.Оюунчимэг байна. Өөрөө би багш, физикч мэргэжилтэй, 25 жил улсад ажиллаад сүүлийн 20 жил нь Улаанбаатар хотын хог хаягдал, гол горхи, карьеруудын асуудлаар хяналт шалгалтын асуудлыг хийж захиргааны хэргийн шүүхэд хүртэл хандаж ирсэн.

Өнөөдөр би энд хүнийг шүүх, ямар нэгэн байдлаар зэмлэх асуудлаар хэлмээргүй байна. Юу гэж бодож байна вэ гэвэл тэртээ тэргүй хөндлөнгийн шинжээчид асуудлыг гаргаад ирчихсэн болохоор, хууль хяналтын байгууллага асуудлаа шийдэх байх гэж харж байна. Би өөрөө олон жил худалдан авах тухай хуульд ажиллаж байдгийн хувьд сая Туулын хурдны зам бол ерөөсөө үндсэн үнэлгээ дээр уначихсан юмыг тэнцүүлчихсэн. Худалдан авах тухай хуулийг энэ тендерийн хороо зөрчсөн байна гэдгийг хэлчихье.

За нөгөө талаас бид “жоомоо алах гээд гэрээ шатаах” вий. Одоо 2 талд чинь дайн дажинтай, экологи, гео экологийн хувьд бид хэцүү үед амьдарч байгаа байхгүй юу. Тэгээд дэлхийн эдийн засаг унаж байгаа энэ үед хоорондоо муудалцаад, хийх гэж байгаа ажлаа унагаагаад, улсаа хойш нь татчих вий. “Азийн цагаан дагина”

хүртлээ энэ улс хөгжиж ирж байсан. 1966 оны үерийг биеэрээ үзсэн хүн бол би байна. Одоо 70 настай.

Нөгөө талаас яах вэ гэхээр хот, төр энэ гол усаараа битгий их оролдооч. Бид тийм хэмжээний мэргэжилтэнтэй, тийм хэмжээний чадварт хүрээгүй. Баранчулуун гуайг сая яагаад энд сууж байгаа юм гэж байна. Манай усны салбарт аравхан тооны, гарт багтах докторууд байдаг. Тэр докторуудын хийсэн судалгаа, хөдөлмөрийг зүгээр нэг үг хэлж байгаа залуучууд устгаж болохгүй. Энэ хүний чинь насаараа хийсэн хөдөлмөр гэдгийг анхааруулж би хэлье.

Бид хууль тогтоомжийн хүрээнд хийж байгаа асуудалтайгаа холбогдолтой юмыг л ярих ёстой байх гэж ойлгож байна. АХБ-ны гэр хорооллын дахин төлөвлөлтийн тендерүүдэд би сууж байсан. Энэ 2010 хэдэн оноос эхлээд явж байгаа. Тэгэхдээ зарим компаниуд өнөөдөр ч гэсэн орон сууцыг нь бариагүй иргэд 6-7 жилээр орон гэргүй тэнүүчлээд явж байгаа ийм асуудлууд байгаа. Ардчилсан улс мөн юм бол хүний эрхийг хүндэтгэх хэрэгтэй. Хүний эрхийн 1-д амьд явах, 2-т нь орон байраар хангах, 3-т нь баталгаатай хүнстэй, эрүүл аюулгүй орчинд амьдарна гээд заачихсан байгаа. Үүнийг бүх төрийн албан хаагч, салбарынхан ойлгоосой. 2012 онд Дэлхийн банкаас 1 сая ам.доллар аваад нийслэл хот төлөвлөлт гэдгийг хийсэн... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минут нэмж өгье.

Оролцогч А.Оюунчимэг: Тэгээд юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл салбар дундын уялдаа холбоо, төрийн ажил муугаас өнөөдөр энэ маргаан, дураараа юм шийддэг асуудал гарч байгаа шүү. Ялангуяа, салбар хоорондын уялдаа байдаг. Төр тогтвортой, тууштай, хэтийн бодлого төлөвлөлттэй байдаг бол хэзээ ч ийм маргаан гарахгүй. Улаанбаатар хотод 1,5 сая хүн байна. Нийт хүн ам чинь 3,5 сая байгаа. Захын том улсын тосгон шиг улсад эв зүйгээрээ, зүй зүйтэй, сайн сайхан хөгжөөсэй гэж хүсье. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Дараагийн оролцогч Э.Тэмүүжин. Түүний дараа Г.Гүррагчаа, Г.Гэрэлмаа нар бэлдэж байгаарай.

Оролцогч Э.Тэмүүжин: Сайн байна уу? Намайг Э.Тэмүүжин гэдэг. Миний хувьд зам тээврийн судалгаа, төлөвлөлт хийдэг ийм байгууллагатай. Авто тээврийн салбарт 18 дахь жилдээ ажиллаж байна. Энэ хүрээндээ Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийг сайжруулах гэдэг юм уу олон төслүүдийг санаачилж, үе үеийн хотын дарга нарт ажил хэрэг болгохоор санал, шийдлээ хүргүүлдэг боловч ерөөсөө хүлээж авч уулздаггүй.

Ийм учраас 2020 оноос нийгэмдээ үгээ хэлж эхэлсэн. Одоогоос 6 жилийн өмнө гэсэн үг. Олон хэвлэлийн бага хурал хийж, олон эсэргүүцэл хийж, тухай бүрд нь хийж байсан ажлуудаа ил тод нээлттэй хүргэдэг.

Одоо ингээд 5 дахь хотын даргадаа бас түгжрэлийн талаарх шийдлийг одоо хүргэе. Удахгүй энэ ажлын албаны хүмүүст бичгээр хүргүүлье гэдгээ бас энд хэлье.

Би Туулын хурдны зам бол түгжрэлийг бууруулахгүй гэж анх эсэргүүцэж үгээ хэлж гарч эхэлсэн хүн байгаа. Туулын хурдны замын асуудал яах вэ? маш олон хүмүүс зөндөө олон ярьчихсан байгаа болохоор би нэг шинэ юм хэлье.

Мэргэжлийн хүмүүсийн баг бүрэлдэхүүнтэйгээ нийлээд “Хатантуул” гээд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөлтийг хийж байгаа. Монголын хамгийн том цэцэрлэгт хүрээлэн бол өнөөдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэж байгаа. Энэ өөрөө Улиастайн гүүрнээс Маршалын гүүр хүртэлх БЗД-ийн нутаг дэвсгэрт 973 га газрыг хамарч байгаа. Бид нарын төлөвлөж байгаа бол Баянзүрхийн гүүрнээс Маршалын гүүр, Зайсангийн гүүр, Сонсголлонгийн Яармагийн гүүр энэ хотын 4 дүүргийг хамарсан Туул голын ай сав газрыг орчмыг хамарч байгаа. Нийтдээ 2 мянга орчим га газар. Энд нь үерийн усны далан байгууламж байгуулах, нүүдлийн шувуудад зориулсан хиймэл нуур цөөрөм бий болгох, иргэдэд ая тухтай, цагаа зөв боловсон өнгөрүүлэх дугуйн зам, гүйлтийн замын бүтээн байгуулалтын төслийг эхэлсэн. Энэ Монголын хамгийн том цэцэрлэгт хүрээлэн. Хатантуул цэцэрлэгт хүрээлэн гээд нэрлэсэн. Бид КОП-17-д оролцохоор байгаа. Энэ КОП-17-д яах вэ? Санхүүжилт илүү нөгөө юм авах шаттай байх юм бол тухайн нэг хотын захиргаа нь өөрөө дэмжчихсэн байдаг юм байна лээ. Тэгээд үүнийг Та бүгдэд удахгүй бичгээр хүргүүлнэ гэж хэлье.

2 дахь асуудал нь би түгжрэлийн тухай товчхон хэлчихье. Өнөөдөр бидний яригдаж байгаа сэдэв бол 16 мега төслийг ярьж байна. 29 их наяд төгрөг ярьж байгаа. Энэ 20 их наяд төгрөг бол ерөөсөө дан түгжрэлийн шийдлийг ярьж байгаа.

Би эндээс шууд нэг минутаа аваад тодруулъя. Мега төсөл гэдэг бол их бүтээн байгуулалт, их хөрөнгө мөнгөөр зарсан ажил бол мега төсөл биш шүү дээ. Их үр дүнтэй ажил мега төсөл шүү гэж хэлмээр байна. Би энд нь түгжрэлийн ганцхан шийдлийг хэлээдэхье. Түгжрэл дээр замын хөдөлгөөний ачааллын 30% нь хүүхэд, залуучуудын сургуулийн хүртээмжийн асуудал байгаа. Энэ нь юу гэж байна гэвэл тэгш бус боловсролоос үүдэж байгаа хотын төвөөсөө зах руугаа явах тусам боловсролын чанар, хүртээмж муудаж байгаа, төр өөрөө энэ ялгаатай байдлыг бий болгож байгаа, улсын сургуулиудыг тэргүүний лаборатори, гүнзгийрүүлсэн, төрөлжсөн гэх мэтээр боловсролыг ялгаатай байдлыг үүсгэж байна.

Үүнээс болж хүмүүс аль болох хотын төв рүүгээ хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэх энэ асуудлаас үүдэж замын хөдөлгөөний ачаалал үүсэж байгаа. Тэгэхээр ижил, тэгш боловсролыг олгох ёстой гэдэг шийдлийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Оролцогч Э.Тэмүүжиний үгийг сонслоо. Одоо Г.Гүррагчаа дараа нь Г.Гэрэлмаа, Б.Мөнхсайхан байгаа. 3 дугаар микрофон нээж өгнө үү?

Оролцогч Г.Гүррагчаа: Энэ өдрийн мэндийг хүргэх нь зөв байх гэж одоо бодож байна.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгч гээд 45 гишүүний тухай гадаа байгаа самбар дээрээс дөнгөж сая харж, танилцлаа. Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн дарга, гишүүнээр ажиллаж байгаа нийт 104 суудал гэх мэтчилэн нэг ийм утгагүй зүйлүүдийн талаар харж байгаа юм.

Ийм хэлэлцүүлэг явтлаа ужгирсан зүйлийн талаар түрүүнд Б.Энхбаяр сайд хууль зөрчсөн тухай мэдэгдээд л гарсан. Ц.Сандаг-Очир сайд сүйрүүлж байна гээд хэлсэн. Би зүгээр нийслэлийн иргэний хувиар бодлоо хэлж байгаа юм.

Одоо энэ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийг тараах цаг болсон юм биш үү. Эд нар чинь иргэдийнхээ өмнө үнэн амлалттай шударга ёсны тангарагтай байх

ёстой. Гэтэл одоо ингээд баахан хулгай луйвар яриад, баахан баримт дэлгэж ярьж байна. Тэгээд мега төсөл гэдэг зүйл бол хэрхэн Сега төсөл болохыг одоо бид нар харж байна. Үндсэндээ олон улсын дунджийг хараад үзэх юм бол Монгол Улс, Улаанбаатар хот бол тийм усан дээгүүрээ, гол дээгүүрээ зам тавих хэмжээний тийм газар нутаггүй улс биш гээд байгаа шүү дээ. Тэгээд ийм мэдрэл юм шиг ийм хэцүү шийдвэр гаргаад тэгээд ард иргэдийгээ бухимдуулаад, дээр нь татвар, хяналтын нэрийдлээр торгуулийн системээ хэзээ болих юм бэ?

Би уг нь одоогийн шинэ даргын залуу хүн гээд аягүй дэмжээд байгаа. Энэ маань одоо хэр итгэл даах юм. Мэдэхгүй. 1990 оны залуу юмыг арай өөрөөр харах юм болов уу гээд бодож байна. Өөрөөр хэлэх юм бол энэ төслүүд автомашинд биш хүнд зориулсан бодлого байх ёстой гэж хэлэх гээд байгаа юм.

Та нарын 35 жил нийлж хулгай хийдэг энэ системийг чинь ард түмэн чинь таньчаад байна шүү дээ. Түрүүнд нэг эмэгтэй бас ярьж байна. Үндсэн хуулийн дагуу үед үзэл бодлоо хуваалцаад, иргэний журамт үүргээ биелүүлээд, гол усаа хамгаалаад явж байхад, үзлээ бодлоо хэлж байхад гэр бүлийг нь, үр хүүхдийг нь дарамтлах ийм технологитой болчихлоо шүү энэ манай төрийн зарим хэсэг нөхдүүд. Одоо ойлгомжтой биз дээ. Хэлсэн ярьсан болгоныг нь ингээд хорьдог, чагнадаг... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минут нэмж өгье.

Оролцогч Г.Гүррагчаа: Жаахан шударга байя. Дандаа залуу хүмүүс харагдаж байна. Би тэгээд юу хэлэх гэж байна вэ гэвэл, хулгай хийж байгаа хүнийг хараад тэр хулгайг таслан зогсоогүй, нуун дарагдуулсан бол тэр хүн адилхан хулгайч л байдаг. Би зарчмын юм ярьж байгаа юм. Тэгэхээр нийслэл дээр байгаа 45 гишүүн гэдэг юм уу энэ хүмүүс бодох хэрэгтэй.

Одоо нээлттэй сонсгол зарлах хэмжээний ужгирсан байдалд хүргэсэн явдал бол өөрөөр хэлбэл, тэд нар энэ гэмт хэргийг нуун дарагдуулсан байна гэж одоо үзэж болох талаар Ц.Сандаг-Очир сайдын дүгнэлтээс харж байгаа юм. Тэгээд энэ хариуцлага маш ил тод бүр тултал нь хийх хэрэгтэй байна шүү дээ. Дараачийн дарга нар хэзээ ч хулгай хийхгүй болтол нь тулгах хэрэгтэй байна. Хулгайч бол ялаа авах хэрэгтэй, шударга ёс энэ ардчилсан эрх чөлөө энэ за. (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Үг сонслоо. За дараагийн оролцогч Г.Гэрэлмаа 3 дугаар микрофон дээр хүрэлцэн ирнэ үү? Түүний дараа Б.Мөнхсайхан, Б.Өлзийбат, Р.Насанбат гээд дараалал байна.

Оролцогч Г.Гэрэлмаа: Өдрийн мэндээ. Иргэдийн төлөөлөл болж оролцож байгаа иргэн Г.Гэрэлмаа байна. Энд Туулын хурдны замын асуудал гэхээсээ илүү иргэдийн төлөөллийн үгийг дамжуулъя гэж бодлоо.

Ард иргэд энэ сонсголд Х.Нямбаатар яагаад байхгүй байна вэ гэж маш их асууж харж байгаа. Би өөрөө ч гэсэн иргэдийн төлөөллийн хувьд асууж байна. Түрүүн З.Гэрэлт-Одод ажлаа өгчихсөн болохоор заавал байх ёсгүй гэсэн хариулт өгсөн л дөө. Гэхдээ Х.Нямбаатарын хийсэн энэ баасан дээр ямар ч хамааралгүй шахуу шинжээч гэх хүмүүс нь ингээд яриад байх ёстой юм уу? Х.Нямбаатар нь өөрөө яагаад хариуцлага хүлээхгүй, өнөөдөр энд байхгүй гадаадад явдаг юм бэ? Ард иргэд чинь Х.Нямбаатар энэ сонсголд байна уу гэдэг дээр маш их анхаарлаа төвлөрүүлж байгаа.

Ийм хариуцлагагүй байхад энэ төрд гарсан хулгайч нар ямар нэгэн байдлаар хулгайгаа хийчхээд яваад өгөх нь байна шүү дээ. Төрийн тогтолцоонд хариуцлага гэж яагаад байхгүй байгаа юм бэ? Бордюрын хулгай, Сэлбийн хулгай, дүүжин тээвэр, метро түлшний будилаан гээд Х.Нямбаатарын хийсэн юм их байгаа шүү дээ.

Өнөөдөр ганц ярьж байгаа нь Туулын хурдны замын талаар болохоос биш ер нь бол Туулын хурдны зам гэхээсээ илүү ард иргэдээ ажилтай, орлоготой болгох юм бол бүгдээрээ энэ зам дээрээ түгжрээд байхгүй шүү дээ.

Ажилгүй болохоороо 400,000–500,000-уулаа бүгдээрээ энэ зам дээр чинь түгжрээд байна. Өнөөдөр ажилтай бол бүгдээрээ үйлдвэр лүүгээ ороод хийх ёстой юмаа хийгээд, зөвхөн өглөө оройдоо л түгжрэл үүсэж болно. Ямар ч шийдэл байхгүй ингээд хэлэлцүүлэг л хийгээд байх юм. Бүх зүйл дээр л хэлэлцүүлэг хийх юм. Эцсийн үр дүн ард түмэнд юу мэдэгдэж байгаа юм бэ? Ард түмэн яг өнөөдөр маш их бухимдалтай, та нар луу дайрахад бэлэн байна. Учраа олохгүй байгаад байна. Ард иргэдийн амьдрал бүүр уул цаашаа газрын гав руу орчхоод байна.

Өнөөдөр тэрэн дээр яагаад анхаарлаа хандуулахгүй зөвхөн нэг бичиг цаас боловсруулсан, барьсан нэг л нүсэр хүнд аппарат юу хийгээд байгаа юм бэ? Ганцаараа би бухимдаагүй, монголын ард түмэн бүгд бухимдаж байна. Хаана ажил орлого байгаа юм. Ажил орлогогүй болохоороо зам дээр чинь түгжрээд багтахгүй, энэ дээр нь дөрөөлөөд нэг хурдны зам ч гэх шиг 2,3 их наядын төсөвтэй хулгай хийх гээд байж байдаг.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Нэг минут нэмж өгье.

Оролцогч Г.Гэрэлмаа: Миний яриад байгаа зүйл бол Х.Нямбаатар гэж хүн энэ баасаа яагаад өөрөө цэвэрлэхгүй, энэ дотор байхгүй байна вэ гэдэг дээр л ард иргэд бухимдаад байна. Шинжээчид гэсэн хүмүүс л байгаль орчны үнэлгээ, эдийн засгийн талаас нь, хууль эрх зүйн талаас нь бүгдээрээ ярьж байна. Тэр хүнд хариуцлага тооцмоор байна. Яагаад? Хариуцлага байхгүй тохиолдолд яаж энэ төр чинь зөв зарчимтай горимтой явах юм? Хулгай хийгээд л гадаад дотоод руугаа явцгаачихна шүү дээ. Ойлгомжтой шүү дээ. Төрд гараагүй ч гэсэн энгийн хүмүүс бүгд энийг чинь мэдэж байна. Төрд хариуцлага хэрэгтэй байна. Өнөөдөр ямар нэгэн мэдлэг боловсрол гэхээсээ илүү хариуцлага хэрэгтэй байна, боловсрол гэхээсээ илүү хүмүүжил, ёс суртахуун хэрэгтэй байна. Ард түмний үгийг би дамжуулж байна.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Түрүүнд Ж.Золжаргал гишүүн хуулиараа яг тухайн албан тушаалыг энэ сонсголын үеэр эрхэлж буй хүмүүс л ирэх үүрэгтэй байдаг. Харамсалтай нь хуулиараа ийм юм байна. Бид нарын өнөөдрийн хийж байгаа ерөнхий сонсголыг түр хороо байгуулаад мөрдөн шалгах ажиллагааны элементүүд орох юм бол өмнө нь алба хашиж байсан хүмүүсийг дуудаж ирүүлж болдог юм байна. Хуулийнх нь зохицуулалт ийм юм байна.

Тэгэхээр бид арга байхгүй. Яг өнөөдөр тэр өмнөх хүмүүс албан тушаал чөлөөлөгдөөд ингээд явчихсан учраас дуудаж ирүүлэх ямар ч хууль зүйн үндэслэл байхгүй юм байна. Энийг ойлгоорой. Дараагийн оролцогч Б.Мөнхсайхан таныг микрофон дээр урья.

Оролцогч Б.Мөнхсайхан: Ямар ч байсан Монгол хүн байна мэнд мэдчихье. Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн сонсгол гэдэг бол сонсгож байгаад гол гаргана л гэсэн үг шүү дээ. Ер нь та нар сонс, бид сайхан хуслаа гэдэг

нэг л хаданд хашхирсан цуурай мэт л болоод байна.

Энд байгаа албан тушаалтнууд тэр дундаа УИХ-ын гишүүд энэ сонсголыг сонсож байгаа Монголын ард түмнийг хүндэтгэхгүй байна. Орж ирчхээд нэг мэдээллээс гараад явчихна. Өглөө 2 цаг гаран хүлээлгэсэн. Монгол төрийн ажил ингэж явдаг юм уу? Ийм хариуцлагагүй баймааргүй байна. Ер нь бол би энэ шинэ Б.Пүрэвдагва гэж даргад уг нь хэлье гэж бодсон. Бас гараад явчихсан байна. Гэхдээ дараа нь нөхөж үздэг байлгүй.

Туулын хурдны замыг энэ голын голдирол дагуулах биш трассыг нь өөрчлөөд барих нь зүйтэй болов уу гэж иргэн хүний хувьд бодож байгаа юм. Зам бол хэрэгтэй, бүтээн байгуулалт хэрэгтэй. Гэхдээ мод ургамлыг тастаж, ус рашаанаа бохирдуулж хиймээргүй байгаа юм. Түрүүнд Байгаль орчны сайд хэлж байна. Байгальд хохирол үзүүлсэн гэж бусад юмыг нь бас ярьж байна. Би өөрөө байгаль экологи, ус, ургамлын тал дээр анхаардаг учраас маш сайн анхаарч сонслоо.

Нийслэлийн байгаль орчны газраас хүн байна уу? Би энэ байгууллагад хүсэлт өгөөд нийслэлийн ерөнхий төлөвлөгөөгөө батлуулаад БЗД-ийн ЗДТГ-тай хамтраад БЗД-ийн 11 дүгээр хороонд байдаг “Сахарын рашаан” гэж нэрлэдэг энэ сайхан рашааныг тохижуулах гээд төслийг нь гаргаад төсвийг нь тавиулах гэсэн чинь мөнгө байхгүй гэдэг. Нэг сайхан рашааныг тохижуулаад янзалчихъя гэхээр мөнгө байхгүй гэдэг мөртөө өөрсдөө хулгай хийж, луйвардах болохоороо хэдэн их наядаар нь дансандаа хуваагаад хийчихсэн гэдэг зүйлүүдийг яриад байна шүү дээ.

Одоо та нар мэдэж байгаа “Play time” плэй тайм гээд фестиваль болдог. Залуучуудад зориулсан ийм үйл ажиллагаа болох нь зөв ч гэсэн үндэсний соёлыг сурталчлан таниулсан арга хэмжээ маш дутмаг байна. Бид нар чинь дэлхийд өв соёлоороо гайхагдаж явах ард түмэн. Маш дутмаг байгаа дараагийн асуудал бол газар олголт. Иргэдэд газар өмчлөх, эзэмшүүлэх, ашиглуулах энэ ажил аягүй хэцүү явж байна. (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: За нэг минутыг нь өгье.

Оролцогч Б.Мөнхсайхан: За баярлалаа. Нийслэл болон дүүргийн газрын албадад ажилладаг газар зохион байгуулагч нар компьютерын ард тетрис тоглоод сууж байдаг, иргэдийн газрыг хулгайлж луйвардаж авдаг хэдэн юмнууд байгаад байна. Энэ дээрээ арга хэмжээ аваач. Иргэд газраа авъя гээд кадастрын зургийг нь хийгээд бариад очихоор энэ газрыг олгох боломжгүй, таны хүсэлтийг авахгүй гэдэг. Надад тийм тохиолдол байсан. Хүсэлтийг нь аваагүйгээс болж таны бүртгэл ороогүй гээд газрын маргаан таслах зөвлөлөөр таны баримт бүрдсэнгүй гээд миний дараа өөр компанид олгочихсон.

Тэгсэн хэр нь эргээд би газрын маргаан таслах зөвлөлд хандахаар энэ газрыг чинь олгох боломжгүй, нийтийн эзэмшил болгох гэж байгаа юм гэх мэтчилэн иймэрхүү зохимжгүй үйлдлийг таслан зогсоох хэрэгтэй байна. Арай дэндэж байна.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Оролцогч Б.Мөнхсайханд баярлалаа. Дараагийн оролцогч Б.Өлзийбат та микрофонд ирж санал бодлоо хэлнэ үү. Эхлүүлчихье тэгэх үү? За баярлалаа.

Оролцогч Б.Өлзийбат: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын Барилгачдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Б.Өлзийбат байна. Сонсгол бол

сайн зүйл. Сонсгол бол олон нийтэд иргэн, ААН-үүдийн дуу хоолой, мэргэжлийн байгууллагын дуу хоолойг шийдвэр гаргахын өмнө эсвэл шийдвэр гаргасны дараа явдаг процесс юм. Үүнээс шалтгаалж парламент, Засгийн газар тухайн нийслэл холбогдох газруудад нь асуудлыг ярьдаг. Өчигдрийн сонсголын талаар УИХ-ын гишүүдэд би одоо хууль ярилтай биш. Гэхдээ нэг зүйлээ хэлье.

Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн бөгөөд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т Монгол Улс улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна, Гуравдугаар зүйлийн 1-д Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Ард түмэн энэхүү эрхээ шууд болон өөрийн сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаа эдэлнэ гэж зааж өгсөн. Өнөөдөр ард түмэн Баянхонгор ч, нийслэл дээр ч, парламент дээр ч асуудлаа ярьж болно.

Энэ нь өөрөө Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон, нөгөө талаасаа УИХ-ын гишүүн бол нийт иргэн улсын эрх, ашиг сонирхлын төлөө ажилладаг. Өнөөдөр нийслэлийн хэдэн эрх ашиг нь барьцаалагдсан төлөөлөгчдийн БЭТ болчихсон юм шиг УИХ-ын зарим гишүүд болих хэрэгтэй.

Тийм учраас гол хэлэх гэсэн зүйл юу хэлэх вэ гэвэл, өнөөдөр Монгол Улсын байгаа байдал энэ өрөнд орчихсон маш олон ААН-үүд байна. Өнөөдөр нийслэл тэр чигээрээ ААН-ийн боломжийг хаах маш олон ажил хийсэн. Гүйцэтгэлд нь хяналт тавьж өгдөггүй. Сэлбэ 20 минутын хот дээр яг өнгөрсөн жил Монголын барилгачдын нэгдсэн холбооноос нийт барилгачдынхаа эрх ашгийн төлөө 2025 оны 4 дүгээр сарын 25-наас эхэлж 6 дугаар сарын 02-ны өдөр талбайн баруун хаалган дээр суусан.

Яг жилийн өмнө 2025 оны 6 дугаар сарын 17-нд Эдийн засгийн байнгын хороон дээр барилгачдын эрх ашгийг хамгаалж, Сэлбэ дэд төвийг гаднынханд өгөх гээд тохирчихсон байсан тэр төслийг нь Монгол ААН-үүдэд оролцох боломжийг өгч Эдийн засгийн байнгын хороон дээр 2 багц нэг нь 400 тэрбум төгрөг нөгөөдөх нь 600 тэрбум төгрөгөөр хоёрхон ААН-үүдэд өгөх гэж байсан байсныг ААН-үүдтэйгээ тэмцэж 54 хоног 600 гаруй ААН-ийн төлөөлөл 100 гаран компаниуд 300 гаруй албан бичгийг Үндэсний аюулгүй байдал УИХ-ын дарга, УИХ-ын гишүүдэд хандаж боломжийг авчирсан.

Өнөөдөр Сэлбэ дээр монголчууд бүтээн байгуулалтыг хийж байна. Гол хэлэх гээд байгаа зүйл юу вэ гэвэл өнөөдөр Сэлбэ дээр Монгол ААН-үүд 700 гаруй тэрбум төгрөг дээр 4 ААН 150 ажилтан, туслан гүйцэтгэгчтэй байна. 2 мянга гаруй ажилчдын 70% нь Монголчууд байна.

Монголын төр нийслэл Монгол барилгачдаа, Монгол хүндээ, Монгол мэргэжилтэндээ итгэдэг байх хэрэгтэй. Шууд гадагшаа гүйдэг байж болохгүй. Бид нар барилга барьж чаддаг. Ноднингийн жагсаал дээр Сэлбэ корпорацийн захирал У.Баатар, нөгөө Даваадалай нь бол дөргүй бух юм байна лээ шүү дээ.

Боломжгүй агуу юм яриад л үнэхээр бодитой үр дүн гаргаж Х.Нямбаатарыгаа ятгасан. Х.Нямбаатарын нэг сайн хийсэн зүйл нь Сэлбэ дээр Монгол компаниудыг оруулсан. Муу хийсэн зүйл нь “өөрийгөө төр мөнгө” гэж бодсон. Тэгээд дахиад нэг зүйл нь Сэлбэ 20 минутын хот бол улс төржиж болохгүй. Сэлбэ 20 минут хотын ерөнхий инженер Ганзориг УИХ дээр зээлийн тухай хууль явж байхад УИХ дээр унасан.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: За нэг минутыг нь өгье.

Оролцогч Б.Өлзийбат: УИХ дээр зээллэгийн хууль унахад Ганзориг гэдэг хүн юу гэсэн бэ гэвэл, УИХ Сэлбийг унагаалаа, Сэлбэ зогслоо гэдэг маш хариуцлагагүй мэдэгдэл хийсэн.

Энэ ерөнхий инженер гэдэг хүн маш олон ААН-үүд эрх ашгийн төлөө ажиллаж байгаа. Үүнээс нь болж маш олон ААН-үүд Сэлбэ зогсох юм байна гэдэг эргэлзээнд орж ирсэн. Маш олон туслан гүйцэтгэгч, маш олон хүмүүс гайхаж, маш олон туслан гүйцэтгэгч хэцүү байдалд орсон. Үүнээс болж АТГ-аас маш олон байгууллагуудад шалгалт явж эхэлсэн. Өнөөдөр дансыг нь зарцаачихсан, маш олон ААН-үүд банкнаас өндөр хүүтэй зээл авчихсан өрөндөө нэхэж байна.

Тэгэхлээр АТГ-ынхан шалгах зүйл нь байгаа бол шалга. Санхүүжилт хийж явж байгаа, гүйцэтгэлийг нь 20 минут корпорацын төслийн нэгжийнхэн та бүхэн татвар төлөгчдийн мөнгөөр ажиллаж байгаа улс төржиж болохгүй, аль нэг талд нь орж болохгүй гэдгийг анхаараарай. Сонсголд Монгол Улсын иргэд оролцоотой байгаа гэдгийг дахин хэлж байна.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: За баярлалаа. Хуулийнхаа хүрээнд бид нар, УИХ-ын гишүүд, иргэд ч боломжоо ашиглаж байгаагийн нэг хэлбэр бол энэ ерөнхий хяналтын сонсгол байгаа юм. Бид нар чинь сонсож ч чадахгүй, иргэддээ мэдээлэл ч өгч чадахгүй, мэдээлэл ч үгүй яваад байгаа юм л даа. Аргаа бараад сонсгол хийж бүгдээрээ мэдэж авцгааж байгаа юм. За баярлалаа. Дараагийн оролцогч Р.Насанбат таныг микрофон дээр урья.

Оролцогч Р.Насанбат: Сайн байцгаана уу? Өдрийн мэнд хүргэе! Хан-Уул дүүргийн иргэн Р.Насанбат байна. Нийт 16 мега төсөл байхад яагаад зөвхөн энэ 2 төслийг авч үзээд бусад төслүүдийн талаар мэдээллийг өгөхгүй байгаа юм бэ?

Зөвхөн энэ 2 төсөл дээр өнөөдрийн хэлэлцүүлгийг хийж байна. Төсөл эхлэхэд хамгийн гол нь яагаад энэ төслийг хийх гэж байгаа талаар ард иргэд, олон нийтэд мэдээллийг маш сайн өгч ажилламаар байна. Үүнийг зөвхөн нэг менежментийн асуудал гэж хараад байгаа боловч явцын дундаа харвал энэ Улаанбаатар хотын нийт иргэдэд яг энэ төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх шаардлагатай байгаа юм. Одоо энэ цахим мэдээллийн эх үүсвэрүүд маш их хөгжихөөд байхад яагаад үүнийгээ нуун дарагдуулаад байдаг юм бэ?

Одоо зөвхөн энэ хоёрхон төсөл ярьж байна. Үүнээс цаашаа ярих юм бол метро төсөл, Улаанбаатар трам, дүүжин тээвэр, Тойрон зам 1, 2, Туул усан цогцолбор, Дулааны 5 дугаар цахилгаан станц, хөрсний ус, үерийн хамгаалалт, ханын материал, орон сууцжуулах төсөл, Баянхошуу орон сууцжуулах төсөл, Лаг шаврын үйлдвэр, Хог лаг шатаах, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр, олон түвшний уулзвар, Туулын хурдны зам, Хүннү хотын дэд бүтэц, Эмээлт Эко гээд олон төслүүд байгаа. Яг үүн шигээ энэ үлдсэн төслүүд дээрээ мэдээллийг эхнээсээ дэлгэрэнгүй өгөөд явчих юм бол өнөөдрийн энэ сонсголын түвшинд хүрэхгүй байх.

Хоёрдугаарт, Нийслэлийн иргэдийн хурлын 45 төлөөлөгчид маань энэ төслүүдийг эхлээд явж байхад яагаад ямар нэгэн мэдээллийг ард иргэдэд, олон нийтэд өгдөггүй юм бэ? Яагаад эцсийн шатдаа хүртэл яваад байдаг юм бэ? Энэ дээр дэлгэрэнгүй мэдээлэл шаардаж байна.

Энэ төслүүдээс харах юм бол ТЭЗҮ нь дууссан 12 төсөл байна. Эхэлсэн 8 төсөл байна. Гүйцэтгэл нь одоогоор нийт 10%-тай гэсэн ийм дүгнэлттэй яваад байна. Тэгэхээр энэ төслүүдэд яагаад ийм гүйцэтгэл муутай байна вэ? 2026 оны эхний хагас маань өнгөрчхөөд байхад төслүүдийн гүйцэтгэл 10%-тай байна гэдэг маань өөрөө маш эмгэнэлтэй харагдаж байна. Тэгэхээр бусад төслүүдийн талаар хэзээ ярих вэ гэдэг дээр дэлгэрэнгүй мэдээллийг өгөөч. За баярлалаа.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Оролцогч Р.Насанбатдаа баярлалаа. Анх энэ асуудал Туулын хурдны замаас эхэлсэн байгаа. Олон нийтийн хүсэл сонирхол, шаардлагын дагуу ерөнхийдөө нийслэлд юу болж байгааг сонсьё гэдэг гол төлөв санхүү, төсөв, хөрөнгө оруулалт нь юу болж байна гэсэн анхны сэдлээр л хийж байгаа сонсгол гэж ойлгож байгаа.

Дахиад энэ сонсгол хийхээр бол сэдвийг нь өөрчлөөд эсвэл өргөжүүлээд, дутуу ярьсан зүйлээ нэмээд цаашид хийхэд болохгүй зүйл байхгүй гэж бодож байна. Одоохондоо ямар ч байсан хамгийн их анхаарал татаж байгаа энэ 2 том төслийг нь илүү ач холбогдол өгч хийж байна гэж ойлгож байна аа. За баярлалаа.

Дараагийн оролцогч О.Бямбадорж таныг микрофонд урья.

Оролцогч О.Бямбадорж: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе! ЧД-ийн иргэн О.Бямбадорж байна. Өнөөдөр хэлэлцэж байгаа 2 сэдвийн дүгнэлт, тайлбаруудыг сонслоо. Эхний Туулын хурдны зам дээр бол үнэхээр хулгай байж. Тендер гэдэг зүйл бол ер цэг таслал бүрээр нь үнэлгээний хороо шалгаж үздэг шүү дээ. Үг үсгийн алдааг нь ч бараг хянаж байдаг. Тэгтэл ийм ноцтой зөрчил, ийм өндөр дүнтэй явж байгаа бол зайлшгүй хууль зөрчсөн, Эрүүгийн хууль зөрчсөн үйлдэл байна гэж харагдаж байна.

Сэлбэ дэд төслийн хувьд бол бас л төсөв нь бүрэн батлагдаагүй байна. Дулаан нь хангах эсэх нь тодорхойгүй байна. Маш олон ААН-үүдийг оруулаад, сонгон шалгаруулалтыг хүч түрж яваад олон иргэн, ААН хохирох байдалд өнөөдрийн байдлаар орчхоод байна. Тэнд хамтран ажиллаж байгаа төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниуд, иргэд, ААН бол санхүүжилтгүй, гүйцэтгэлгүй, цалин мөнгөгүй ийм байдалд орж байгаа байхгүй юу.

Энэ төслийг зарлаж байгаа, шалгаруулж байгаа, дутуу дулимаг, ТЭЗҮ-гүй, дутуу дулимаг мэдээлэлтэй, тэрийгээ хянаагүй төслийг сонгон шалгаруулж эхлүүлснээс үүдэж байгаа юм. Тэгэхээр энэ бол төрийн буруутай үйл ажиллагаа явагдаж байгаа гэсэн үг байхгүй юу.

Өнөөдрийн сонсгол бол зайлшгүй ач холбогдолтой зүйл болж байна. Тэгээд өмнөх сонсголууд үзэж байсан. Өнөөдрийн энэ сонсголын эцсийн дүгнэлт нь холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцсон, төслийг ингэж зогсоно, энэ төслийг ингэж явуулна гэдэг үр дүнтэй байхгүй л бол түрүүний нэг хүний хэлсэн шиг “сонсгоод гол гаргалаа” гэдэг шиг зүйл битгий болоосой. Ямарваа нэг үр дүн гараасай гэж хэлье гэж бодсон юм аа. За баярлалаа.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: За баярлалаа. УИХ дээр хяналтын сонсгол хийсний үр дүн нь юу болох вэ эрх зүйн өөрчлөлт, ялангуяа бид нар өчигдрөөс хойш маш их ярьсан. Нийслэл маань бараг засаглалын хямралд орчихсон шахуу юм байна. Энэ нь цаанаа юутай вэ гэвэл хуультай холбоотой байна. Тийм учраас энэ хуулийг нэн яаралтай өөрчлөх хэрэгтэй гэдэг эхний дүгнэлтийг хийчихсэн байгаа.

Тийм учраас УИХ-ын гишүүд бол энэ дээр маш яаралтай хуулийн төслийг нь өргөн барьж, нийслэлд явагдаад байгаа энэ засаглалын хямралыг засах ёстой байх гэж бодож байгаа юм.

За дараагийн оролцогч Ц.Цэндхүүг урья. Нийслэлийн одоо ажиллаж байгаа дарга, удирдлагууд уг нь энд сууж байх ёстой. Манай залуу дарга Б.Пүрэвдагва байна уу? орлогч А.Амартүвшин, тэгээд нийслэлийн удирдлагууд уг нь байх ёстой л доо. Оролцогч нар маань удирдлагуудад нь хандаж ер нь яриад байгаа шүү дээ. Ялангуяа шинжээчдийн дүгнэлтийг сонсоод, нөхцөл байдлыг ажиглаад энэ иргэд чинь үгээ хэлээд байна шүү дээ.

Энэ цаашдынх нь үйл ажиллагаанд уг нь тус дэм болох ёстой гэдэг агуулгаараа заавал байх ёстой. Тамгын газрын хариуцаж байгаа хүмүүс нь холбогдох өндөр албан тушаалтнуудыг дуудах нь зүйтэй байх. Тэгэхгүй бол “хаданд хашхирснаас өөрцгүй болно” гээд түрүүн нэг оролцогч хэлсэн. Нийслэлийн удирдлагуудыг дуудъя. Тэд нарыг одоо хүлээгээд сууж байлтай нь биш. Энэ олон хүмүүс өглөөнөөс хойш хүлээж байгаа, цаг заваа зарцуулсан учраас ямар ч байсан Ц.Цэндхүүг микрофондоо уриад яриаг нь сонсьё.

Оролцогч Ц.Цэндхүү: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын төрийн бодлогын алдаатай асуудлууд дээр сонсгол хийж байгаад баяртай байна. Би Сэлбэ 20 минут хотын нэг блок барилгын туслан гүйцэтгэгчийн гэрээгээр хийж гүйцэтгэж байгаа компанийн төлөөлөл байна. Бүгдээрээ нэг сайхан тайван бас эерэг юм бодоод миний үгийг сонсоосой гэж бодож байна.

Яагаад гэвэл, манай Монголд ялангуяа хот төлөвлөлтийн бодлого алдагдсанаас үүдэж Сэлбэ 20 минутын хотыг ТЭЗҮ-г боловсруулж, олон мянган инженерүүдийн оролцоотойгоор энэ төсөл хэрэгжиж байгаад баяртай байдаг. Юу гэвэл, түгжрэлээс яаж гарах вэ гэж арга замыг хайж, сэдэж, агаарын бохирдол, хөрсний бохирдлыг шийдэхийн тулд энэ том төслийг хэрэгжүүлж эхэлсэн гэж боддог.

Өнөөдрийн байдлаар бид бодлого төлөвлөлтөд оролцдоггүй, хэрэгжилт дээр барилгаа гэрээнийхээ үүргийн дагуу чанартай, сайн гүйцэтгээд төрдөө хүлээлгэж өгөх ийм субъектүүд байгаа юм.

Гэтэл бид нарт асуудал гараад байна. Санхүүжилтээ хугацаандаа авч чадахгүй байна. Жишээлбэл нэг давхрын санхүүжилтээ аваад одоо манай барилга 7 давхар дээр явж байна. Үлдсэн 6 давхрын санхүүжилт аваагүй компани яаж байна гэвэл бусад итгэлцэл дээр хамтарч бид нарт бетон, арматур бусад барилгын материалыг нийлүүлж байгаа энэ бизнесүүдээ эрсдэлд оруулах гээд байна. Тийм учраас аливаа улс төрийн янз бүрийн тогтворгүй байдлууд шууд бизнесүүдэд нөлөөлөөд байгаа учраас хамтран ажиллаж байгаа бизнесүүдээ татан унагаах, эрсдэлд оруулах найдваргүй, итгэлгүй гэдэг нэрийг зүүгээд байна.

Энэ хорооллын барилгуудыг харж байгаа хүмүүс бол их л сэтгэл ханамжтай явдаг юм. Хажуугаар явж байхдаа үнэхээр гоё болж байгаа юм байна, манай хотын зүүн тал танигдахын аргагүй сайхан бүтээн байгуулалтууд явж байгаа юм байна гэдэг. Одоо дулааны улирал эхэлсэнтэй холбоотой маш олон хүмүүс ийм сайхан сэтгэгдлийг хэлээд л барилга барьж байгаа хүмүүсийн хажуугаар өнгөрдөг.

Гэтэл 2012 онд мөн л АН нь байж байгаад л МАН, МАН нь байж байгаад АН гарч ирэнгүүт бас барилгуудыг тодорхойгүй хугацаагаар зогсоож байсан юм. Энэ бол

үнэхээр байж боломжгүй зүйл. Энэ тодорхой хугацаагүйгээр санхүүжилт өгөхгүй зогсоох чинь бизнесүүдийг шууд уналтад аваачиж байдаг. Тэр их банкны зээлийн хүү, тэр их итгэлцлээр материалаа нийлүүлчихсэн компаниудыг чинь тодорхойгүй байдалд очиж байна. Дээр нь манай монгол барилгачид яаж барьж чаддагийг харуулж байна шүү дээ.

Долоо хоногт нэг давхрын цутгалтыг хийж байна. Энэ сайхан эрч хүчтэй ажиллаж байгаа бригад хувь энэ хүмүүсийг ... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Нэг минут нэмж өгье.

Оролцогч Ц.Цэндхүү: Одоо ажилдаа урамгүй болж байна. Ахуй амьдралдаа мөнгө төгрөгөө аваачихгүй болохоор тэр гэр бүлийн санхүүжилт хүнд байдалд орж байна. Тийм учраас УИХ-ын Эдийн засгийн байнгын хороон дээр би бас оролцож байсан.

Гадаадаас оруулж ирж байгаа бондыг бага хүүгээр авч ирээд арилжааны 5 банкан дээр байршуулчихсан байгаа гэхээр хүүгийн эрсдэлд ороогүй болов уу гэж бодож байна. Одоо 8-9 давхраа цутгачихсан компаниуд яах юм бэ? Энэ төслийг маш яаралтай санхүүжилтийг нь олгоод эхэлчихсэн барилгуудыг дуусгаж, үр өгөөжийг нь авах, өнөөдөр шийдэл ярих болохоос биш энэ ёстой буруу юм болжээ буцаад нүүе гэдэг асуудал байх ёсгүй байх аа?

Тийм учраас одоо энэ алдаанаас хэтэрхий айгаад байвал ер нь эрс шинэчлэлтийг хийж чадахгүй. Яагаад гэвэл, манай Монголд бодлогын алдаа их байгаа, энийг шинэчлэхийн тулд эр зоригтой хэдэн залуучууд гарч ирээд энэ төлөвлөлтийг хийчихлээ гэж баяртай байдаг. За баярлалаа.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Ц.Цэндхүү гуайд баярлалаа. Танхимд хүрэлцэн ирсэн оролцогчдоос урьдчилж авсан нэрсийн жагсаалтын дагуу нийт 27 оролцогч үг хэлж, санал бодлоо илэрхийллээ. Та бүхэндээ маш их баярлалаа. Протоколд оруулах зүйлсийг уншиж танилцуулъя. Байхгүй юм байна. За уучлаарай энд нэр нь байгаа Ц.Батболд таныг микрофонд урья. Ирээгүй юм шиг байна гээд байсан ирсэн байсан байна.

Оролцогч Ц.Батболд: Хуульч Цогбадрахын Батболд байна. Өнөөдрийн нөхцөл байдлаа үнэлээд цаашид авах арга хэмжээний талаараа ярилцаж, иргэдийнхээ мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хангаж ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулж, удирдан явуулж байгаа гишүүддээ талархаж байна.

Миний хувьд Туул хурдны замын мега төслийг эсэргүүцэж анхнаасаа энэ хөдөлгөөнд хуульч, өмгөөлөгчийн байр сууриас оролцож байгаа хүн. Захиргааны шүүхэд хандаж нэхэмжлэл гаргасан. Туул хурдны зам мега төсөл бол анхнаасаа мега хулгай байсан. Мега төслийг хэрэгжүүлэхийг дэмжүүлсэн, хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж яваад баригдсан болон түүний хамсаатан нар энэ буруутай үйлдэлдээ хуулийн байгууллагаар шалгагдаж, хуулийн цээрлэлээ хүлээх ёстой.

Эдгээр буруутай этгээдийн цаана би нэг байгууллагыг нэгжээр нь нэрлэх гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, хотын дарга энэ хулгайн мега төслөө хэрэгжүүлэхийн тулд НИТХ-аар зөвшөөрүүлдэг. Энэ хурал 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 25-д ороод 123 дугаартай ИТХ-ын тогтоол байгаа юм. Хурдны 1 дүгээр тойрог, Туулын

хурдны зам төслийн хэрэгжилтийг зөвшөөрсүгэй гэсэн энэ тогтоол. Яагаад ийм хулгайн мега төслийг эд нар хэлэлцэхгүй, хурлаараа шууд зөвшөөрчхөв. Ажиглалат бүгд нөгөө НЗД-ынхаа карманд орчихсон, албан тушаалын авлига авчихсан ийм хүмүүс байгаа юм. Ийм учраас зөвшөөрөхгүй байдаг юм.

Иргэдийн төлөөлөгч гэдэг бол зөвхөн тухайн тойрог, нутаг орон нутагтай болж байгаа асуудал. Иргэдэд тулгамдаад байгаа асуудлыг олж илрүүлж, давхцал байгаа шийдвэрүүдийг гаргаж орон нутгийн төсөвтөө багтаан энэ асуудлаа шийдэх ёстой ийм л байгууллага. Оны эцэст төсвийг нь баталж өгнө.

Засаг дарга юу хийв гэдгийг хурлаараа авч хэлэлцэх ёстой. Ерөөсөө ийм үндсэн чиг үүрэг бүхий байгууллага байх ёстой шүү дээ. Гэтэл НЗД-ынхаа аж ахуйн ажил руу нөгөө өөрөө төсвийг нь баталдаг ажил руугаа хутгалдаад орчихсон, тэнд төрийн болон орон нутгийн өмчийн ХК-ийн захирал, төсөл хөтөлбөрүүдийн зохицуулагч, удирдагч гэсэн нэртэй өөрөө төсвөө баталсан ажил руугаа яваад орчихсон байгаа асуудал бол засаглалын хямрал.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэг Монгол Улсын нутаг дэвсгэр орон нутгийн удирдлага гэсэн байгаа. Үүний 59.1-д Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага бол нутгийн өөрөө удирдах ёсыг... (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Нэг минут нэмж өгье.

Оролцогч Ц.Батболд: Төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлнэ гэсэн ийм заалт байдаг. Энэ нь ИТХ, Засаг дарга нарыг хоорондоо цус ойртоод “хонины найр шиг” дундаа орчих гэсэн үг биш. Хослон гэдэг нь энэ 2 зэрэгцэж удирдлага явуулах боломжтой ийм 2 байгууллага юм гэдгийг зааж өгсөн болохоос биш хоорондоо эвцэлдээд ингээд төсөв дээрээ найраад байх асуудал биш. МАН сүүлийн 30 жил засаг барихдаа энэ 4 дүгээр бүлгийг булшилсан, хэрэгжүүлээгүй. Өөрөөр хэлбэл, энэ бүлэг булшлагдчихсан, цаашдаа УИХ-ын гишүүд анхааралдаа авч, ямар хуулийн өөрчлөлтөөр засаж сайжруулах ёстой вэ?

Энэ засаглалыг зөв хэлбэрт нь оруулах ёстой вэ гэдэг дээр шийдвэр гаргах хэрэгтэй. Зүй нь төрийн шийдвэр тэр болгон орон нутгуудад хүртээмжгүй хүрдэггүй боломжгүй. Угаасаа ИТХ төр засгийн энэ шийдвэр иргэдэд хүрэх боломжгүй учраас... (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: 5 хүртэлх минут гэж дэг дээр байгаа юм байна. 1 минут нэмж өгье.

Оролцогч Ц.Батболд: Тэгэхээр энэ төр засгийн шийдвэр хүрэхгүй байгаа энэ тохиолдолд Та бүхэн өөрсдөө дотроо энэ төлөөлөгчөөрөө дамжуулаад тулгамдаад байгаа асуудлаа шийдчихээч ээ гэсэн л байгууллага байхгүй юу. Шийдэх ёстой гэсэн гэтэл төсөв рүү орчихсон, аж ахуйн ажил руу орчихсон явж байгаа нь буруу. Хуулийн гажуудал байна. Энэ Туулын хурдны хулгайн мега төсөл батлагдахад энэ засаглалын буруу хэлбэр их нөлөөлсөн. Дээр нь УИХ-ын гишүүд байгаа учраас та бүхэнд энэ өнгөрсөн онд 2025 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Усны тухай хуульд нэг муухай өөрчлөлт оруулсан юм. 22.1 дээр Х.Нямбаатар өөрөө оруулсан. За онцгой хамгаалалтын бүс буюу усан сан бүхий газраас 50 метрт хэнбугай ч юу ч хийж болохгүй ийм хуулийн заалт байсныг төр, хувийн хэвшил байвал усан дээр гол голдирол дээрээ дураараа дүүргэж дунд чөмгөөрөө наргина гэсэн хуулийн заалтыг

та нар хийчихсэн. Энэ заалтаа хүчингүй болгоорой. Энэ заалтыг хүчингүй болгох саналыг Б.Мөнхсоёл гишүүн гаргасан байна лээ. Танд бас талархъя.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Ц.Батболд оролцогчид баярлалаа. Тэгээд ташрамд бас энэ Туулын хурдны зам дээр маш их идэвх санаачилгатай ажилласан иргэний нийгмийнхэндээ маш их баярлаж байна. Та бүгдийн гаргаж ирж илрүүлж ажилласан энэ бүх зүйлүүд эхнээсээ хууль хяналтын байгууллагад шалгагдаад зарим нэгэн газраас, яам, тамгын газраас дүгнэлт нь ирээд ерөнхийдөө мөргөх тал руу орж байна гэж дүгнэж байна. Тэгэхээр ямар ч байсан Монгол Улсад ардчилал бол юу юугүй сөнөчхөөгүй. Иргэний нийгэм ажиллаж байна гэдэг чинь ардчилал ажиллаж байна гэсэн үг. Тэгэхээр та бүхэнд нийслэлийнхээ иргэдийн өмнөөс энэ индрийг ашиглаад талархал илэрхийлье

Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр буюу 2 дахь өдрийн сонсгол үргэлжилж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.5-д гишүүн оролцогчоос асуулт асуух хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж хариулт авч болно. Мөн 126.2-т энэ хуулийн 126.1.5, 126.1.6-д заасан үйл ажиллагаанд олонх цөөнхийн төлөөлөл ээлжлэн асуулт асуух үг хэлэх боломж олгоно гэж заасан байдаг. Одоо төрийн байгууллага, шинжээч, сонсголд оролцогчоос хийсэн мэдээлэл, дүгнэлт, саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна. Гишүүдийн асуулт асууж, хариулт авах хугацааг нийт 12 минутаар тогтоож байна. 3 минут асуулт, 3 минут хариулт гэх маягаар энэ 12 минутаар багтааж асуулт хариулт явах нь. Ингээд асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Ц.Баатархүү гишүүнээр тасалъя. Д.Үүрийнтуяа гишүүн асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа: Үндэсний аудитын газраас асуух гээд байгаа юм. Ерөнхий аудиторын танилцуулгатай холбоотой. Ерөнхий аудитор эзгүй байх юм асуугаад явах уу? 2, 3 асуулт байна 1 дүгээрт би энэ Туулын хурдны замтай холбоотой асууж байгаа шүү зам тээврийн сайд, Нийслэлийн засаг дарга нар 2025 оны хамтарсан шийдвэрээр Туулын хурдны замын төслийн төсөвт өртгийг 1,9 их наядаар тусгаж тендерийн баримт бичигт тусган хамтран баталсан байна гээд хамтарсан шийдвэр гаргасан байгаа юм. Энэ хамтарсан шийдвэр гэж яг ямар шийдвэр хэлээд байгаа юм бол? Үндэсний аудитын газрын зүгээс Зам тээврийн сайд нийслэлийн одоо хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг өөрчлөхөд хамтран батлах эрх бүхий субъект мөн үү, биш үү гэдэг дээр ямар дүгнэлт хийж байгаа юм. 3 дугаарт нь Үндэсний Аудитын газар 2025 оны санхүүгийн тайлангийн аудит, бодвол одоо нийслэл дээр хийсэн байх л даа. Тэгэхээр энэ санхүүгийн тайлангийн аудитаар яагаад энэ төсөвт өртгийг ямар нэгэн магадлалгүйгээр, дүгнэлтгүйгээр 900 тэрбум төгрөгөөс 1,9 болгоод нэмчихсэн дээр ямар нэгэн дүгнэлт гарсангүй вэ? Нийслэлийн аудит болон гүйцэтгэлийн аудит 2025 онд нийслэлд орсон уу. Мөн энэ төсвийг магадлал хийгээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ Туулын хурдны замын төсөл дээр магадлал хийсэн дүгнэлтүүдийг он цагийн дарааллаар харахаар шинжээчдийн танилцуулга дээр байна лээ. 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Барилга хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв магадлал хийчихсэн. Энэ магадлалаар 916 тэрбум гээд гарчихсан. Гэтэл 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр болохоор Барилга хөгжлийн төв 2,3 их наяд гээд гаргачихсан.

Тэгэхээр энэ яг хэн магадлал хийх ёстой байсан төсөв юм бэ? Энэ хоёулаа

хийгээд байдаг нь зөв юм уу? За Барилга хөгжлийн төвөөс Зам тээврийн хөгжлийн төвөөс хүмүүс байгаа болов уу? Мөн ялгаагүй саяын асуултад би эдгээр хүмүүсээс асуумаар байна. Энд хүмүүс ирсэн болов уу үгүй болов уу. 3 дахь асуулт худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт гарсан байна. Энэ Сангийн яамнаас хийсэн юм байна гэж харлаа 6 зөрчил байна тэ? Тэгэхээр Худалдан авах ажиллагааны Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газраас асуухад энэ 4 оролцогч компаниас алианаас нь ч гомдол гараагүй юу? Энэ тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой аль нэг компаниас нь ер нь гомдол гарсан уу үгүй юу? Энэ дээр тендер зохион байгуулсан төрийн албан хаагчид байгаа юм болов уу? Нийслэл өөрөө энэ дээр ямар тайлбар өгөх бол? Одоо энэ худалдан авах ажиллагаанаас гаргаж байгаа энэ 6 зөрчилтэй дүгнэлтэд ямар тайлбар өгөх юм бол?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Үндэсний аудитын газраас хариулт өгье. 14 дугаарын микрофоныг нээе.

Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын менежер Б.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын менежер Б.Батчимэг байна. Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээр асуулт буюу хамтарсан шийдвэрийн тухайд 2025 онд Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, хянасан Нийслэлийн Замын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Одбаяр боловсруулсан. Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч гээд А.Амартүвшин нарын хамтарсан нийслэл Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд хэвтээ тэнхлэгийн Туулын хурдны замын барилга угсралтын ажлын урьдчилсан ТЭЗҮ батлах тухай гэдэг тамга тэмдэг бүхий шийдвэр байгаа.

Энийг бид нар одоогийн байдлаар бол шийдвэр гэдгээр нь тайлангийн төсөлдөө тусгаад явж байгаа. Энэ дээр одоо яг дэлгэрэнгүй тайлбар болон одоо нотлох зүйлийг бол ирүүлэхийг хүссэн боловч яг үндэслэл бүхий тайлбар нэгдүгээрт ирээгүй байгаа. Хоёрдугаарт нь Зам тээврийн яаман дээр энэ талаар архивд нь бас баримтын үзлэг хийхээр энэ ажил дутуу явж байгаа гэсэн үг. Хоёрдугаарт нь Нийслэлийн аудит, санхүүгийн аудиттай холбоотой асуулт асууж байна. Нийслэлийн санхүүгийн аудитыг яг одоо би энэ Туулын хурдны замын аудитад орсон учраас яг тэр асуудлыг бол энд одоо хариулж мэдэхгүй байна. Тэгэхээр энийг Нийслэлийн аудитын газар хариулах байх гэж бодож байна. Гурав дахь асуулт нь Магадлалын ерөнхий дүгнэлтийг асуусан. Энэ Туулын хурдны зам маань анх бол Зам тээвэр дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч, Улаанбаатар хотын ерөнхий архитектур болон нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын дарга, Эдийн засаг, хөгжлийн яам, Гудамж төсөл гэдэг нэршлийн доор энэ төслийн хүрээнд 2014 онд анх хэсэгчилсэн байдлаар магадлал хийж баталгаажуулсан байдаг. 2014 онд 7 удаагийн магадлал хийгдсэн. 2016 онд Зам тээврийн хөгжлийн төв 594 тэрбум төгрөгөөр бас магадалсан байдаг. 2024 онд Зам тээврийн хөгжлийн төв Туулын хурдны замын барилгын ажлын шинэчилсэн төсөв гэж магадалсан. Энэ нь 916 тэрбум төгрөгөөр магадлал хийж баталгаажуулсан байдаг. Хамгийн сүүлд нь Барилгын хөгжлийн төв буюу 2025 оны 3 дугаар сарын 18-нд магадлал хийж баталгаажуулсан. Ингэж магадлал хийхдээ Засгийн газар буюу Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу магадлал хийж баталгаажуулсан. Тэгэхээр аудитын явцад Зам тээврийн хөгжлийн төв үү, үгүй бол Барилгын хөгжлийн төв аль нь магадлал хийх ёстой вэ гэдэг талыг бол нийцлийн талаас нь судалж үзээд аудитын тайлангийн төсөл дээр тусгасан байгаа. Яг өнөөдрийн байдлаар аудитын эцсийн үр дүнг энд танилцуулах боломжгүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээе.

УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа: Та хэн билээ, Үндэсний аудитын газрын ямар албан тушаалтай билээ. Үндэсний Аудитын газрыг төлөөлж хариулж чадахгүй байна. Аудитын асуудал ярихаар тодорхой хариулт өгөхгүй байгаад байна л даа. Би тэгэхээр асуултдаа тодорхой хариулт авмаар байх юм. Яг Үндэсний аудитын газар 2025 онд санхүүгийн тайлангийн аудитаар яагаад энэ асуудал гарч ирээгүй юм бэ? Төлөвлөлт дээр гүйцэтгэлийн нийцлийн аудит хийгдсэн юм уу хийгдээгүй юм уу? Барилга хөгжлийн төв магадлах ёстой юм уу, Зам тээврийн хөгжлийн төв магадлах ёстой юм уу? Яагаад хоёулаа оруулаад ийм зөрөөтэй юм яриад байгаа юм? Тэгэхээр би минутдаа тодорхой хариулт авмаар байна. Миний минут ингээд ийм үр дүнгүй хариултаар дуусчих гээд байх юм. Барилга хөгжлийн төв Зам тээврийн хөгжлийн төвийнхөн байгаа бол энд хариулмаар байна. Зам тээврийн яам мөн энд хариулаач. Зам тээврийн сайд энд оролцох эрх бүхий субъект мөн юм уу биш юм уу? Би яг тодорхой асуугаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хариултаа би тодорхой авмаар байх юм. Нөгөө минут маань дуусчих гээд байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Яг тодорхой хариулъя аа. 14 дугаарын микрофоныг өгье.

Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын менежер Б.Батчимэг: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад тодорхой хариулж байна гэж бодсон. Уучлаарай яг санхүүгийн аудитын тайлангийн тухайд Нийслэлийн аудитын газар маань санхүүгийн тайлангийн аудит хийгээд дүгнэлтээ гаргаад хүргүүлсэн байгаа. Нийслэлийн төсөв учраас Нийслэлийн аудитын газар хариулах ёстой. Би болохоор энэ аудитын баг буюу Туулын хурдны замын аудитад орж ажилласан учраас яг Туулын хурдныхаа замын асуудлыг гүйцэтгэлийн талаас нь харж хариулж байгаа. Зам тээврийн сайдын тухайд тэр гаргасан шийдвэр нь өөрөө хууль зүйн хувьд хүчингүй учраас энэ шийдвэрийн талаар дэлгэрэнгүй тайлбарыг Зам тээврийн яамнаас өгнө гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Зам тээврийн яамнаас байр суурь сонсьё. 13 дугаарын микрофоныг нээе.

Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Сайдын болон Нийслэлийн засаг даргын хамтран баталгаажуулсан баримт бичгийн талаар Үндэсний аудитын газраас манай яамнаас албан бичгээр авсан. Яг албан ёсны мэдээлэл байхгүй байна гэсэн хариуг манайх өгсөн байгаа. Тэгээд Үндэсний аудитын газраас сая хэлж байна. Ер нь баримтын үзлэг хийнэ, архивд үзлэг хийнэ гэсэн асуудлыг ярьж байна. Хууль, эрх зүй талаас Монгол Улсын Засгийн газрын 476 дугаар тогтоол байгаа. 2022 оны 12 дугаар сарын 21-ний 7-д нь бол шинэ хориг зам төслийн техник эдийн засгийн үндэслэл барилгын ажлын нарийвчилсан зураг төслийг баталгаажуулахад шаардлагатай техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн засаг даргын хувьд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар холбогдох байгууллагын удирдлагад үүрэг болгосугай гэсний дагуу оролцоод явж байгаа. Магадлалтай холбоотой асуудлаар Зам тээврийн хөгжлийн төвийн захирал болон Магадлал хариуцсан хэлтсийн дарга ирсэн байгаа. Энэ дээр

хариултуудыг өгчих байх.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Зам тээврийн хөгжлийн төвөөс хариулт өгье. Нэгдүгээр микрофон нээж өгнө үү?

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: За сайн байцгаана уу, Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. 2016 онд Зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийн хүрээнд авто зам эйрдромын зураг төсөл магадлалын үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2016 онд Туулын хурдны зам буюу 33 км 4 эгнээтэй 3,2 км гүүрэн байгууламжтай зураг төслийг 594 тэрбум төгрөгөөр магадалсан байдаг. Мөн 2024 онд мөн тухайн төслийн төсвийг нь шинэчилж дахиж магадалсан байдаг. Тэр нь 2024 оны 11 сард тухайн үеийн зураг төсөл зохиогчоор бол Эм Си Пи Си Жи Ар ХХК бол зураг төслийг зохиож манай байгууллага дээр зураг болон төсвийг магадлуулсан байдаг. 2025 онд тухайн төслийн зураг зохиогч нь өөрчлөгдсөнтэй холбогдуулан тухайн зураг төсвийг дахиж зөвхөн зургийг нь магадалсан байдаг. Энэ нь өөрөө 2025 оны Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн гуравдугаар зүйлд заасан зураг төслийг магадлал гэж зөвлөмж болгосны дагуу зөвхөн зургийг нь магадалсан байдаг. Тэр нь ТЭЗҮ буюу урьдчилсан зураг төсөв буюу техникийн зураг төсвийг магадалсан байдаг. Төсвийг бол магадлаагүй байгаа.

УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа: Зам тээврийн яамны үндсэн танилцуулга мэдээлэл бол сэдвийнхээ хүрээнд хийгдэж чадаагүй л дээ. Яг зам тээврийн бодлого энэ нийслэлийн авто замтай холбоотой төслүүдийн уялдаа холбоо ямар байгаа юм гэдэг агуулга бол үндсэндээ таны танилцуулгаас гарч ирээгүй. Дээр нь Зам тээврийн хөгжлийн төв, Барилга хөгжлийн төвийн энэ магадлаад байгаа дүнгүүдийн зөрөөтэй асуудлууд Үндэсний аудитын тайлан дээр ч ялгагдаж харагдахгүй байна. Шинжээчдийн дүгнэлт дээр ч ялгагдаж харагдахгүй байгаа, таны тайлбараар ч ялгагдахгүй одоо бүүр холилдоод явчихлаа. Шинжээчийн дүгнэлтийг харахаар 2024 оны 11 дүгээр сарын 19-ний магадлалыг Зам тээврийн хөгжлийн төв хийсэн. 2025 оны 3 дугаар сарын магадлалыг Барилга хөгжлийн төв хийсэн гэсэн дүгнэлт шинжээчийн дүгнэлт дээр байгаа шүү дээ. Тэгэхээр 2025 онд Зам тээврийн яам дахиад төсөв биш зургийг нь магадалсан гээд байдаг яг энэ олон төсвүүдийн чинь учир ерөөсөө олдохоо болилоо. Нийслэлийн Иргэдийн хурал энэ төсвийг баталж өгсөн байгаа юм. Тэгээд 1,9-өөр тендер зарлаад гүйцэтгэгч шалгаруулахдаа 1,9-өөр одоо тендерийн баримт бичиг гэдэг юм батлаад 2 талаас гарын үсэг зураад ийм нэг урьдчилсан үнэлгээ шиг юм гаргаад явчихсан мөртлөө Нийслэлийн иргэдийн хурлын баталсан төсөвт 2,3 их наяд төгрөг гээд ер нь ямар учиртай нэмэгдлүүд тоонууд орж ирээд байна гэдэг чинь бүүр ойлгогдохоо байлаа шүү дээ. Тэгээд зам тээврийн хөгжлийн төв юугаа магадлаад байгаа юм. Барилга хөгжлийн төв нь юугаа магадлаад байгаа юм.

Энэ 2 ялгаатай төсвийг чинь алийг нь барих ёстой юм тэгээд. Аль нь бариад явчихсан нь зөв болж таарах юм. Тэгээд энэ төрийн байгууллагууд өөрсдөө энэ юмаа тодорхой гаргаж өгмөөр байна. Үндэсний аудитын газар, Ерөнхий аудитор танилцуулга хийсэн, Ерөнхий аудитор өөрөө оролцмоор байна. Зөвхөн Туулын ордны зам дээр аудит хийсэн гээд нэг аудитор орж ирчхээд асуудлаа мэдэхгүй нийслэл мэднэ гээд байдаг. Аудитын байгууллагыг төлөөлж сууж байгаа юм бол өнөөдөр аудитын дүгнэлтээ аудитынхаа үр дүнг системийнхээ хэмжээнд хамгаалаад яриад сууж байх ёстой шүү дээ. Зөвхөн Туулын хурдны замын аудитыг иргэдийн хурал хийе гэхээр хийдэг биш их хурал хийе гэхээр хийдэг биш хуулиараа

өөрөө хийж байгаа аудитын үр дүнгүүдээрээ яагаад энэ дүн чинь гарч ирээгүй юм бэ гэдгийг л би тодруулаад байгаа байхгүй юу.

Санхүүгийн тайлангийн аудит дээр асуудал үүссэн нь хэрвээ тодорхой байсан бол урьдчилаад энэ асуудлуудыг чинь тэр дахиад тодотгол хийхээс өмнө ярих боломж нь байсан юм биш үү? Аудит яагаад анхааруулж дүгнэлтээрээ гаргаж ирээгүй юм? Би ийм л зүйлүүдийг асуугаад байна л даа. Тодорхой хариулт авч чадахгүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хариулт өгөх хүн байна уу, 2 номер дээр хариулт өгье.

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер 3.Энх-Оргил: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Барилгын хөгжлийн төв Барилгын тухай хуулийн 25, мөн Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хүрээнд барилга хангамжийн зураг төсөлд магадлал хийх энэ ажлыг зохион байгуулдаг. Барилгын хөгжлийн төв Туулын хурдны замтай холбоотой 2025 оны 3 дугаар сарын 18-нд ө д 0316/2025 гэсэн Туулын хурдны замын техник эдийн засгийн үндэслэл урьдчилсан зураг төсөвт бол магадлалын дүгнэлтийг гаргасан. Энэхүү дүгнэлтэд сайдын тушаалаар 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай сайдын 27 дугаар тушаалаар холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын хүрээнд бол техник эдийн засгийн үндэслэлд магадлал хийх ажлыг зохион байгуулсан. Туулын хурдны замын техник эдийн засгийн үндэслэл буюу урьдчилсан зураг төсөв гэсэн ийм нэршилтэй бол гарсан. Энэ дээр магадлалын дүгнэлтээр 2 их наяд 384 тэрбум 13 сая 846 мянга гэсэн ийм урьдчилсан тооцоолол байна гэсэн дүгнэлт гарсан. Энэ бол яг эцсийн төсөв биш, нийт шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ нь хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулан дараа нь ажлын зургийн шатад бол өөрчлөгдөж нарийвчлан тооцох шаардлагатайгаар тусгасан гэсэн ийм дүгнэлтэд мөн дурдсан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Би гишүүний асуулт дээр тодотгоод асуучихъя даа. Цаг нь дуусчихсан юм байна. Туулын хурдны зам төсөл чинь 916 тэрбум төгрөг гээд 2024 онд магадлангаар ороод тогтоосон. Дараагаар нь өргөсгөж том болох хэрэгтэй байна гээд чиглэл өгөгдөөд 1,9 их наяд төгрөг болсон 6 эгнээ болоод том болоод тэрийг магадлангаар баталгаажаагүй бөгөөд нөгөө 2 байгууллагаас аудитын явцад тайлбар ирүүлээч ээ гэсэн тайлбар ирүүлээгүй. Яагаад ирүүлээгүй гэдэг асуултыг тавимаар байгаа юм. Яагаад ирүүлээгүй вэ Зам тээврийн сайд, Нийслэлийн засаг дарга гээд өмнөх хүн нь явчихсан эрх нь бол хамаагүй, одоо байгаа хүмүүс нь хариулах ёстой эсвэл тэр оронд нь ирсэн хүн хариулах хэрэгтэй. Яагаад ирүүлээгүй юм? дараагаар нь та бүхэн магадлан хийчих урьдчилсан зураг төсөл дээр үндэслэж магадлан хийсэн гээд байгаа техник эдийн засгийн урьдчилсан зураг төсөв гэж юм одоо манай хууль дээр юу байдаг юм бэ? Энийг би дараа нь асуумаар байгаа юм. Техникийн зураг төсөл тэгээд инженерийн нарийвчилсан ажлын зураг төсөл гэж байгаа байх. Урьдчилсан зураг төсөв дээр магадлан хийж болдог юм уу? Барилгын хөгжлийн төв төсөв хийсэн, Зам тээврийн хөгжлийн төв болохоор тоо хэмжээ магадлан хийсэн гээд байгаа юм. Би гишүүний асуултыг үргэлжлүүлээд тодруулж асууж байгаа юм шүү.

Тэгээд Ерөнхий аудитор Их хурал дээр ажилтай байсан учраас түрүүн гараад явсан буцаж ирэх болно гэсэн. Хэрвээ асуултад хариулж чадахгүй байгаа бол

Тамгын газраас Ерөнхий аудиторыг хуралд дуудъя. Нийслэлийн засаг дарга баруун аймгуудаар малын шүлхий гарч, хөл хорионы нэлээн асуудал холбоотой хэлээд гараад явсан байгаа. Тэгээд тэр асуудал нь дуусчихвал ирэх байлгүй. Орлогч нар нь бас байгаа. Тэгэхээр ажил нь дуусах юм бол ирж гишүүдийн асуултад хариулах шаардлагатай гэдгийг бас Тамгын газраас дамжуулж хэлж өгнө үү. За саяын асуулт дээр гүйцээгээд хариулаад өгөөрэй. 2 номерын микрофоныг нээе.

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер З.Энх-Оргил: Барилгын хөгжлийн төв энэ техник эдийн засгийн үндэслэл дээр магадлал хийсэн байгаа. Яг энэ төсөв дээр биш техник эдийн засгийн төсөв холбогдох энэ батлагдсан ажлын даалгаврын дагуу боловсруулсан байна гээд дүгнэлт дээр яг тодорхой дүгнэж тусгасан байна. Энэ төсөвт өртөг бол зүгээр томсгосон үнэлгээгээр буюу хөрөнгө оруулалтын тооцоо хийх ийм урьдчилсан тооцоолол учраас яг нарийн эцсийн дүн биш ээ. Дараа нь ажлын зургийн шатад нарийвчилсан төсвийг дахиж магадлалаар оруулах шаардлагатай. Энэ бол техник эдийн засгийн үндэслэл дээр магадлал хийсэн гэж ойлгож болно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэгэхээр ТЭЗҮ, урьдчилсан магадлал дээр үндэслээд нарийвчилсан зураг төсөл байтугай наадах чинь худалдан авалт хийгээд 500 тэрбум төгрөг төлчихсөн байгаад байна шүү дээ. Гэрээ байгуулаад ажил эхэлчихсэн. 1 номер дээр нэмэх юм байгаа юу? За нэг номерын микрофон нээчих.

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: 2025 оны 1 сард захиалагчаас үндсэндээ тухайн зураг төслийг дахиж магадлалд оруулах хүсэлтийг ирүүлсний дагуу зураг төслийг урьдчилсан зураг төсөл буюу яг таны хэлдэг техникийн зураг төсөл дээр магадлал хийсэн. Зам тээврийн сайдын баталсан авто зам, замын байгууламжийн зураг төсөл магадлал хийх журам дээр 2 үе шаттайгаар магадлагдах. Техникийн зураг төсөл, нарийвчилсан зураг төсөл гэдэг тухайн захиалагч нь өөрөө өөрсдөө тавих шаардлага. Захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тухайн техникийн зураг төсөл буюу урьдчилсан зураг төсөл дээр нь магадлалын үйл ажиллагааг зохион байгуулсан байдаг. 2016 оныхоос ялгагдаж байгаа юм нь мөн яг хэлж байгаа шиг 6 эгнээ 9 км гүүрэн байгууламжтай болж өөрчлөгдсөнтэй мөн зураг төсөв зохиогч автор өөрчлөгдсөнтэй холбоотой дахиж магадлал хийсэн л гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Урьдчилсан зураг төсөв буюу техникийн зураг төсөв гэж та яриад байна шүү дээ? Тэгэхээр тэр техникийн зураг төсөл гэдэг чинь урьдчилсан зураг төсөл мөн юм уу?

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: Мөн

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тийм хуулийн тайлбар байна уу?

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: Хууль биш магадлал хийх журмаараа тэгж 2 үе шаттайгаар магадлал хийж болно гэж заасан байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Урьдчилсан техник урьдчилсан гэж байгаа юм уу?

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: Техникийн гэж байдаг юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Урьдчилсан зураг төсөл гэж үг бий юу?

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: Байхгүй..

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 14 дээр нэмж хариулъя.

Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын менежер Б.Батчимэг: 2 магадлалын талаар би дэлгэрэнгүй хэлж өгөхгүй бол 2024 оны 11 дүгээр сарын 19-ний Зам тээврийн хөгжлийн төвийн 509/2024 гэдэг магадлалаар таны асуугаад байгаа 916,3 тэрбум төгрөгийн төсвийг магадалж баталгаажуулсан. Дараагийнх нь 2025 оны 3 дугаар сарын 18-ны 316/2025 буюу Барилгын хөгжлийн төв одоо 2,3 их наяд төгрөгийн төсвийг магадлалаар баталгаажуулсан байдаг. Дунд нь буюу Зам тээврийн сайд нийслэл хотын захирагчтай хамтарсан шийдвэрийн дагуу гэдэг дээр магадлал хийгдээгүй 1,9 их наяд төгрөгийн төсвийг баталж өгсөн. Энэ төсвийнх нь дүнгээрээ тендерийн үнийн дүн болоод цаашаагаа явсан гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүдийн цагийн интервалтай учраас хариултыг тодорхой өгөөд оршилгүйгээр ярихыг хүсье ээ. Р.Батболд гишүүний микрофоныг нээж өгнө үү

УИХ-ын гишүүн Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Гол нь 2 том төсөл дээр ярьж байгаа байх. Тэгээд Туулын хурдны зам дээр бас их зүйл яримааргүй байна. Яагаад гэвэл хууль хяналтын байгууллагаар шалгагдаад явж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь төсөвт өртөг өндөр байгаад байгаа. Хоёрдугаарт бичиг баримтын бүрдэл байдаг юм уу, тендерт оролцогчийн материалтай холбоотой асуудлууд үүсээд явж байгаа. Тийм учраас нэг их олон зүйл асуулгүй орхичихъё. Сэлбэ дэд төвтэй холбоотой асуугаадахъя. Энэ 2024 оны намраас эхлээд Улсын Их Хурлын ажлын хэсэг нийслэл дээр очиж ажилласан. Тэгээд ажиллах хугацаанд энэ Сэлбэ төвийн асуудал бас яригдсан. Тухайн үедээ өртөг өндөр байна, яагаад ийм өртөг өндөр гарч байгаа юм бэ? Газрын үнэ ороогүй, дэд бүтцийн үнэ ороогүйгээр тухайн үедээ үнээ бол хэлж чадахгүй байсан ба 3600000 төгрөгөөс дээш гарчих болов уу гэсэн байдалтайгаар хэлээд байсан юм. Тэгээд бид нар бас санал болгоод явсан. Дэд төв өөрөө 119 блок гэсэн үү? тийм барилгын ажил байгаа. Энийг ер нь Монголын барилгачдадаа жижиг багцаар өгч болдоггүй юм уу, яагаад том багц зарлачхаад ингээд гаднын аж ахуйн нэгжийг дэмжих гээд байгаа юм бэ, өртөг чинь өндөр байна гэдэг талаар ярьсан.

Тэгэхээр энд ирсэн Барилга хөгжлийн төвийнхөн байдаг бол энэ төсөв дээр нь яаж хяналт юм уу, магадлан хийдэг юм бэ? Хувийн аж ахуйн нэгжүүд чинь барилга бариад явдаг, бас танайхаар зураг төсөв нь ингээд батлагдаад явдаг байх. Тэгэхээр энэнтэйгээ нийцэж байгаа юм уу, тэр улсууд чинь яаж зээлээ төлөөд гэдэг юм уу, барилга, газрынхаа үнийг төлчхөөд одоо борлуулах үнэ нь 3 сая 500 байгаад байдаг юм бэ? Тэгэхээр төсөвт өртгийг нь ер нь яаж хянадаг юм, төр гэдэг юм уу, нийслэл гэдэг юм уу энэ улсын ажлыг, ер нь төсөвт өртгүүдийг нь яаж хянаж явдаг юм гэдгийг нэг асуучихмаар байна. Хоёрдугаарт нь зарим гишүүддээ бас нэг зөв ойлголт өгөх хэрэгтэй байх. Манай барилгын салбарынхан барилга бариад сурчихсан шүү дээ. Барилга барьдаг хүмүүс зөндөө байгаа. Тэгээд өчигдөр П.Сайнзориг гишүүн

манайхан барилга барьж чадахгүй гэж байх шиг байна лээ.

Нийт улсын төсвөөр ер нь хэчнээн хэмжээний барилга байшингийн тендер зарлагдаад байгаа юм. Тэрэнд нь хэчнээн аж ахуйн нэгж оролцоод байгаа юм гэдэг тал дээр Сангийн яам юм уу, Худалдан авах ажиллагааны газар байдаг юм уу. Эд нар бас хариултаа өгчихмөөр байна. Барилгын холбооныхон байгаа бол бас хэлчихмээр байна. Яг барилгын холбоондоо бүртгэлтэй гэдэг юм уу одоо энэ барилга байшин барьчих чадвартай хэдэн аж ахуйн нэгж холбоондоо нэгдчихсэн ажиллахад бэлэн байгаад байдаг юм бэ, бид нар бол барилга барьж чадна, барилга байшингаа өөрсдөө барьдаг болчихсон шүү дээ гээд хэлээд байна лээ. Тэгэхээр энэ 2 асуудал тэр яг тодорхой хариулт өгчихмөөр байна.

Тэр төсөвт өртөг дээр Барилгын хөгжлийн төв бас хариултаа тодорхой өгчихмөөр байна. Яаж тооцсон юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Барилгын хөгжлийн төвөөс эхэлчих үү, дараа нь Сэлбийн төсөл хариуцсан хүмүүс тайлбар өгсөн нь дээр байх. 2 номер.

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер З.Энх-Оргил: Р.Батболд гишүүний асуултад хариулъя. Барилгын хөгжлийн төв бол түрүүн хэлсэн 2018 оны Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор төрийн захиргааны 10 чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Энэ дотор улсын төсвийн хөрөнгө болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хийдэг. Мөн магадлалын үйл ажиллагаа багтсан байдаг. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төсөл арга хэмжээний хувьд таны хэлсэн ажлын зураг болон зураг төсөв заавал манайхаар орж магадлуулдаг. Төсвийн магадлалыг төсөв үнэ бүрдлийн норм буюу төсөв зохиох дүрэм бүгд норм дүрэм аргачлал жишиг үнэтэй. Үүний дагуу боловсруулдаг. Хувийн хэвшлийн хувьд ажлын зургийг магадлуулж байгаа төсвийг хувийн хэвшил заавал магадлуулах тийм бодлого байхгүй хүсвэл магадлуулж болно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сэлбэ 20 минут төслийн удирдагчаас мэдээлэл өгөх үү. Төслийн захирал байна уу? Сангийн яам юм уу, Төрийн худалдан авах ажиллагааны газраас барилгын хэчнээн тендер зарлаад Монгол компаниуд хэдэн хувь дээр байна вэ гэдэг ерөнхий мэдээлэл асуусан байна. Барилгын холбооноос хүн байна уу, Төрийн худалдан авах газрын хүн байна уу хэн байна вэ, 16 номерын микрофоныг өгье.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул: Р.Батболд гишүүний асуултад хариулъя. 2026 оны Монгол Улсын төсвийн тухай хуулиар санхүүжих 179 төсөл арга хэмжээ нийтдээ 405 багц ажил дээр Төрийн худалдан авах ажиллагааны газар 122 үнэлгээний хороо байгуулж ажилласан. Нийтдээ давхардсан тоогоор 682 аж ахуйн нэгжээс 1822 тендер шалгаруулалт ирсэн байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Р.Батболд гишүүн нэмж тодруулах уу, үг хэлэх үү?

УИХ-ын гишүүн Р.Батболд: Барилга хөгжлийн төвийнхөн бас их сонин хариулна. За яах вэ хүсвэл хувийн аж ахуйн нэгжүүд өөрсдөө төсвөө хянуулаад байдаг юм байна. Хүсээд хянуулчихсан тэр барилгын ажлын төсөвт өртөг нь яг хэд байгаа юм бэ тэрийг хэлж өгөөч. Хүсээд одоо хянуулчихсан аж ахуйн нэгж байдаг

байх гэж бодож байна. Гаднын хөрөнгө оруулалт аваад юм уу барилга байшин барьж байгаа газрууд бол мэдээж төсөвт өртгөө хянуулаад тэд болох юм байна энүүгээр бид нар хөрөнгө оруулалтаа авъя тэгээд энэ төслөө явуулъя гэдэг ийм үйл ажиллагаа байдаг байх гэж бодож байгаа юм. Тийм болоод асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ нь манай энэ улсын төсвөөр хийгээд байгаа юм уу, үгүй бол энэ бондын хөрөнгөөр хийгээд байгаа энэ төсөвт өртөгтэй чинь таараад байгаа юм уу болоод байгаа юм уу яаж магадлан хийгээд яаж хянаад байдаг юм бэ л гэдэг асуудал байгаа юм. Би бас салбараас холдоод удчихаад байна. Тэр нэг стиметр гээд нэг ганц программаар л бүх төсвөө хийгээд л явдаг байсан одоо тэр хэвээрээ л байгаа байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр нэг хариулт авчхаад дахиад асууя.

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер 3.Энх-Оргил: Р.Батболд гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээн дээр хуулиараа Төсвийн тухай хууль, Барилгын тухай хуулиараа заавал магадлал хийх шаардлагатай. Ингэж байж угаасаа улсын төсөвт суудаг. Хувийн аж ахуйн нэгжүүдийн хувьд ажлын зургаа магадлуулж байгаа. Төсвөө заавал магадлуулах шаардлага үгүй гэдэг нь хөрөнгөө өөрсдөө босгож хөрөнгө оруулалтаа хийдэг учраас хүсвэл төсвөө батлуулж байгаа юм. Түүнээс биш аж ахуйн нэгж хүсэхгүй бол зүгээр ажлын зургаа л батлуулж байгаа юм. Төсвөө бол заавал магадлалаар оруулах ийм шаардлагагүй байдаг. Таны хэлсэнчлэн төсөв бол одоо эстиматораар л бодож байгаа.

УИХ-ын гишүүн Р.Батболд: Таны хариултыг ойлгоод байна л даа хүсвэл гээд байгаа юм. Тэгэхээр хүсээд хийлгэсэн газар байна уу хэчнээн төгрөгийн өртгөөр 1м²-ыг нь байдаг юм уу, та нар магадлал өгсөн юм бэ л гэж асуугаад байгаа юм. Та хариулахаараа дахиад хүсвэл гэж яриад байх юм. Тийм хүссэн газар нэг ч байгаа, байхгүй байгаа юм уу үгүй бол тэрийгээ шууд хэлчих хэрэгтэй байна.

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер 3.Энх-Оргил: Хувийн хэвшил бол мэдээж төсвөө магадлалаар оруулж байгаа аж ахуйн нэгжүүд зөндөө байгаа. Ерөнхийдөө яг тухайлсан тэр төсөл гээд хэлбэл болно л доо. Шүүгээд гаргаад ирчихье. Ерөнхийдөө бол яах вэ угсралтын метр квадратын үнэ бол 2,4-2,5 саятай магадлагдаж байгаа юм.

УИХ-ын гишүүн Р.Батболд: Яах вэ манай төрийнхний их сэтгэлгүй байна гээд хэлээд байгаа юм. Хувийн аж ахуйн нэгжүүд өөрсдөө газраа авчхаад дээрээс нь дэд бүтцээ татаад банкнаас зээлээ аваад юм уу, гаднын хөрөнгө оруулалтаа татаад нэг хотхон гэж 4, 5 блок байшингаа барьчихаад тэгээд борлуулах үнэ нь өнөөдрийн байдлаар 3 сая 500 мянган төгрөг байгаад байгаа. Яагаад энийг нягталж үздэггүй юм бэ? Улсын хөрөнгөөр ажил хийж байна гэхээр одоо ямар учиртай тэгээд аль аль нь орохгүйгээр 3 сая 800 мянган төгрөгөөр та нар тийм төсөвт өртгийг нь магадлан хийчихээд болж байна гээд сууж байдаг юм бэ? Ийм асуудал байгаад байгаа юм. Би бол төсөвт өртөгтэй нь яриад байгаа юм. Түүнээс биш энэ Сэлбэ дэд төвийн ажлыг чинь буруу гэж хэлээгүй. Бид нар утаанаасаа салах ёстой байртай байх ёстой, тэгэхдээ энэ засгийн хөрөнгөөр хийгдээд байгаа ажлууд чинь төсөвт өртөг нь замбараагүй өндөр байгаад байна. Энийгээ болиоч ээ, та нар дундаас нь хулгай хийгээд байна шүү дээ. Энийг төрийн байгууллага нь ч гэсэндээ би одоо харьцуулсан судалгаа гээд л нэг юм нэхээд байдаг юм. Хаана тийм юм байгаад байна. Хэний ямар барилгатай харьцуулчихаад тийм юм гараад байна одоо мэдээж одоо арай л алтаар бариагүй байлгүй. Энэ 2 төсөлтэйгөө холбоотой нэг зүйл хэлчихэд энэ нийслэл дээр бас нэг зүйлийг хэлчихмээр санагдаад байгаа юм. Бид нар 20 минутын хот гэдэг төсөл явуулна гээд одоо тэр нь замын түгжрэлээ багасгах

ёстой.

Бид нар дэд хотуудыг ингээд хөгжүүлэх ёстой гэж яриад байдаг, энэ хүрээндээ одоо Сэлбэ дэд төвөөс эхлүүлээд цаашаа барилга барихгүй л гэж байгаа юм. Гэхдээ энд тэнд газар чөлөөлөлтүүд хийгдээд явах ёстой байх. Ингээд явж байтал дахиад Туулын хурдны зам гээд урдуураа, гэтэл одоо энэ чинь түгжрэлтэй байна шүү дээ гэж яриад байгаа юм. Тэгэхээр энэ 2 чинь бас логикийн хувьд таараад байгаа юм уу таарахгүй байгаа юм уу? Бид нар 20 минутын хот болгочих юм бол Туулын хурдны зам барих хэрэг байгаа юм уу? Ойрхон ойрхон 20 минут дотроо ингээд блок блоктой амьдарч байгаа улсууд заавал ч үгүй Туул дээгүүр давхих гээд 10, 15 км давхих гээд байх хэрэг шаардлага байгаа юм уу гэдэг асуудал үүсээд байгаа юм. Тэгээд яах вэ? Энэ нийслэлийн чинь нэгдсэн бодлого нь яг хаашаагаа яваад байгаа юм 20 минут руугаа яваад байгаа юм уу, үгүй бол одоо энэ түгжрэлийг Туулынхаа замаар шийдчихээд энүүгээрээ байя гэж бодоод байгаа юм уу ийм асуудлууд л байгаад байгаа юм л даа. Тэгээд энд олигтой хэлэхгүй л байна л даа. Яаж ч бодоод одоо түрүү жил 3 сая байсан шүү дээ. Энэ засаг чинь өөрөө ийм бодлого явуулаад одоо Сэлбэ дэд төвийн чинь өртөг нь өөрөө 3 сая 800 бид нар зарах үнэ нь бараг 4 сая 200, 4 сая 300 болох байх гэснээс хойш үнээ нэмээд 3 сая 500 мянга болгочоод байгаа байхгүй юу. Метр квадратыг нь зарж.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүний асуултыг тэгээд тойруулж ярьсаар байгаад цаг нь дууслаа. Энэ өртөг асуугаад байна шүү дээ. Сэлбэ дэд төв маань одоо метр квадрат нь 4,8 сая төгрөг юм уу 3,7 сая төгрөг юм уу өртөг нь, зарах үнэ нь яг хэдээр болсон бэ? Би энийг нэмээд тодруулчихъя. У.Баатар төслийн гүйцэтгэх захирал одоо орж ирэх болсон. Ажлаа хиймээр байна. Хүмүүс өөрөөс нь асуугаад байдаг гишүүнтэй уулзаж байна гээд яваад байдаг гишүүнтэй уулзах ажлаа дараа нь хийгээрэй гээд мессеж бичээд өгөөрэй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл: Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр их тайван удаан ярья аа, хурдан ярьчихаар бас загналаа яалаа ийлээ гээд бас сошиалаар троллдуулаад байгаа юм уу амьд хүмүүс байгаа юм уу, юм болоод байх юм маш удаан жингүйдэж ярья. Тэгээд бодохдоо би өчигдөр уг нь өөрийгөө зөвлөгөө өгсөн гэж бодоод байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл хуучин хотын захирагч маань одоо янз бүрийн хэрэг төвөгт орооцолдоод асуудал үүслээ. Сайн засаглал биш муу засаглалыг үүсгэжээ. Цаашдаа дараагийн томилогдож байгаа Засаг дарга нь бас дахиад хэцүүдэх вий, засах сайжруулах юмаа сайн засаад сайн зөв бүтцэд ороод ажлаа сайн хийгээсэй. Энэ том боломжийг энэ сонсгол олгож байна гэдгийг хэлсэн юм. Уг нь дэмжиж, за ийм учиртай. Өчигдөр Туулын хурдны зам болон Сэлбэ дэд төвийн дэргэдэх орон сууцжуулах хөтөлбөртэй холбоотой асуултуудаа ерөнхийд нь асуучихсан. Тэгэхдээ нэг хариулт бас буруу ирсэн.

Угаасаа бүх гишүүдийн асуултуудын хариулт бүрэн бүтэн бол тодорхой сайн ирэхгүй байгааг бүгд л мэдэж байна. Одоо яалтай. Монголын өнөөгийн нөхцөл байдал нэг иймэрхүү. Тэгээд ингэж хэлсэн шүү дээ. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 1.1.3.1-д Улаанбаатар хотын Сэлбэ Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих 20 мянган айлын орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ гэж заасан байна шүү нөхөд өө. Ингэж төр хувийн хэвшлээр хэрэгжүүлнэ гэж хэлээгүй ээ гээд байгаа. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байна шүү. Өчигдөр тодорхой зарим нэг зүйлүүд асуучихсан. Өнөөдөр манай иргэд маш

идэвхтэй оролцож байна. Зөндөө асуултууд асуулаа, асуудал хөндлөө, цаашдаа анхаарах санал зөвлөмжүүд хэллээ. Манай энэ шинжээчид маань богино хугацаанд ажиллаад тодорхой тоонуудыг гаргаж ирлээ. Ухаж төнхөх шинэ сайн анализ хийх боломжууд зөндөө бий боллоо гэж харж байна. Миний товчхон ганц тодруулах зүйл юу вэ гэхээр нийгэм даяар асуултууд байна аа. Зөвхөн Улсын Их Хурлын гишүүд биш бид чинь одоо иргэдийг төлөөлж сууж байгаа олон нийтийнхээ, ард түмнийхээ төлөөлөл шүү дээ. Тэр утгаараа бас ажлаа хариуцлагатай хийж байгаа хувь хүмүүс гэсэн үг. Юу вэ гэхээр 5 алдарт 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн асуултыг л асуучихмаар байгаа юм. Ингэж одоо нөгөө Хэу Ван билүү Хао Юань ч билүү тэр Женерал констракшн гээд хятад компани нийслэлийн Замын хөгжлийн газарт ирүүлсэн бичигтэй. Бичиг нь 4 дүгээр сарын 3-нд ирсэн. 390,9 тэрбум төгрөг нь зарцуулагдчихсан, 350,9 тэрбум төгрөг нь бодит зарцуулалт хийгдчихсэн, үлдсэн 149 тэрбум төгрөг нь хүлээлтийн байдалтай ийм зарцуулалт явчихсан гэсэн ийм тайланг ирүүлчихсэн байна шүү дээ.

Энэ тоо бодит юм уу үнэхээр мөнгө нь үрэгдээд дуусчихсан уу эргэж ав олж авах боломжгүй юу захиалагч тал маань буюу манай тал хэр хяналт тавьсан бэ гэдэг ийм тов тодорхой ганцхан асуултыг л асууж байя. Бүгдээрээ бас иргэдийг хүндлээд маш тодорхой хариултыг өгчихье зөв үү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Зургаадугаар микрофон нээж өгье.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Гүйцэтгэгч талаас ирүүлсэн бичиг дээр нийт зарцуулалтын тоог зөвхөн одоо бараа захиалга байдлаар ашиглана гэж байгаа юм. Тэрнээс яг хэдэн төгрөгийн зарцуулсан байдал дээр хууль хяналтын байгууллага шалгадаад явж байгаа 500 урьдчилгаа төлбөрийн асуудалтай холбоотой юман дээр. Тэгэхээр энэ дээр яг шалгадаад явж байгаа тал дээр бол тодорхой хариулт бол өгөх бол боломжгүй байгаад байгаа юм.

УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл: Ямар ч байсан одоогийн өнөөгийн нөхцөл байдалтай холбогдуулаад Б.Одбаярыг тодорхой хэмжээний хариулт өглөө гэж үзэж байна. Цаашдаа одоо энэний араас фоллов ап хийх нь байна. Манайхан өөрөө ингээд мэдээллийн дагуу цаг тутамд нь ажиллах юм байна аа. Мэдээлэл тодорхой болонгуут ил тод гаргаж тавих юм байна гэж ойлголоо зөв үү. Энийг сайн протоколд тусгая. Тэгээд иргэд бас түрүүн хэлж байна. Маш их хүлээлт үүсчихсэн удаа удаа дараагийн сонсголоор, өчигдөр зарим нэг гишүүд маань ч хэлж байна лээ. Бие биеийгээ хардаж байна, улс төр хийж байна гэж улс төр ерөөсөө биш бүгдээрээ хамтдаа улс эх орноо, нийгмээ, Улаанбаатар хотоо хөгжүүлье л гэсэн санаа зовсон гишүүд байна. Төрийн албан хаагчид байна, иргэд байна. Тэгэхээр одоо мэдээллээ ил тод байгаад, зөв сайн шударгаар ажиллая л гэсэн уриалга тавиад сонсголын үр дүнд маш сайн ийм дүгнэлт гаргаад, зөвлөмж гаргаад, сайжруулах ёстой хууль, эрх зүйн орчноо хараад ажлын хэсэг үүсгээд ажиллах байх. Ямар ч байсан өмнөх сонсголүүд шиг сенсац үүсгээд нийгмээ талцуулаад улам тодорхойгүй бус байдалд оруулаад явмааргүй байгаа шүү, гишүүний хувьд энэ хүсэлтээ илэрхийлье.

Миний хувьд бол ажлын хэсэгт байхгүй байгаа, сонсголд идэвхтэй оролцож байгаа гишүүний нэг. Ажлын хэсэгт орьё гэсэн боловч оруулаагүй Улсын Их Хурлын Дэгийн тухай хууль гэж байдаг. Та нар маань илүү дутууг мэдээд ав. Ажлын хэсэг үүсэхэд нөгөө квот гэж байдаг юм. Монгол ардын намаас тэдэн хүн, Ардчилсан намаас тэдэн хүн, цөөнхөөс тэдэн хүн гээд, цөөнхөөс хоёрхон хүн орох юм. Нэг нь

манай сонсгол санаачлагч Ж.Золжаргал гишүүн, нөгөөх нь манай Р.Батболд гишүүн нөгөө Иргэний зориг ногоон намаасаа гэсэн үг. Тэр сошиалын болсон болоогүй бүрэн бүрэн бус элдэв мэдээлэлд хууртах хэрэггүй болсон болоогүй энэ дундын саналыг сэвдэг квот нөгөө энэ кноп дарсан юм.

За дээрээс нь энэ нэг их сүрхий ажлын хэсэгт орсон нэртэй ажилладаггүй гишүүд ч бий. Одоо шулуухан л хэлье. Бид энэ танилын нүүр халуун гээд бие биедээ шаардлага тавьж чадахгүй ингээд алдаж оносон юм зөндөө байна. Тэгээд юмыг нухацтай гүн орж харж байгаарай гэж үнэхээрийн их гуйж байна. Өнгөн мөнгөн явбал Монгол бас хэцүүдэх гээд байна шүү манайхан. За баярлалаа ингээд дуусгая даа. Хажууд 15:00 цагаас Эдийн засгийн байнгын хороо байгаа ирц бүрдээгүй байна бүрдвэл орох нь байна шүү. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Мөнхсоёл гишүүн үг хэллээ. Түрүүний тэр төлбөр тооцоотой холбоотой асуудал дээр энэ ирсэн материалууд дунд чинь Бүгд Найрамдах Хятад Ард улсын тэр гүйцэтгэгч шилжүүлсэн мөнгөнийх нь нэлээн хэсгийг нь зарцуулчихсан гэсэн мэдээлэл ирсэн байна лээ шүү дээ. Тэгээд тэрэн дээр одоо яах юм. Нягтлах төсөв батлах ажил орно гэсэн үг үү Б.Одбаяр дарга хариулах уу? Зургаадугаар микрофон.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Хэрвээ гэрээ цуцлагдвал яах вэ? Гэрээний нөхцөлийн дагуу тус төлбөрөөс гарсан зардлыг гүйцэтгэлийн тооноос олж, олгосон урьдчилгаа төлбөр суутган нэхэмжлэх боломжтой гэж байгаа. Тэгэхээр яг одоо ингээд хууль хяналтын байгууллага шалгагдаад явж байгаа учраас яг хэдэн төгрөг зарцуулсан, зарцуулаагүй гэдэг мэдээлэл манай байгууллага дээр ч бай бид нар ил тод яг хэлэх боломжгүй байгаад байна. Тэгэхээр хууль хяналтын байгууллага өөрсдөө дүгнэлтээ гаргаад ирсний дараагаар тэрийг тодорхой гаргах боломжтой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Та зүгээр зарчмыг нь тайлбарлаад өг дөө. Тэр чинь 500 тэрбумыг шилжүүлчихсэн урьдчилгаа төлбөр. Дараа нь нэг ажил хийгээд ажил хийсэн компани чинь тэдэн төгрөгийн юм бид нар хийчихсэн байна гээд нэг билл ирүүлнэ тээ. Тэгэхээр тэндээс юуг нь суутгаад хэдийг нэмж төлөх юм. Тэр томъёог нь нэг тайлбарлаад өгчих.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Урьдчилгаа төлбөр маань нийт төсөвт өртгийн 21,2% дээр өгч байгаа. Тэгэхээр нийт гүйцэтгэлээс авах юм бол хийсэн гүйцэтгэлээсээ 21,2%-ийг суутгаад гүйцэтгэл дээр өгнө гэж байгаа юм Фидикийн гэрээгээрээ. Тэгэхээр энэ дээр хийгдсэн ажлуудаа мөн ялгаа байхгүй гүйцэтгэлээр олгоно. Гүйцэтгэлээр олгохдоо 21,2%-ийг тухай бүрийн гүйцэтгэлээс суутгаж олгоно оо л гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Одоо 500 тэрбумыг төлчихсөн тэндээс чинь 300-г нь бид нар үрчихсэн юм гээд хэллээ гэе. Тэгэхээр 300-г нь үрчихсэн юм гээд хэлэхээр хэрвээ тэр нь үнэн бол батлагдвал гэсэн үг шүү дээ. Батлагдах юм бол манай тал тэр 500-аасаа суутгуулах юм уу, үгүй бол тэр 300 гэж байгаагийнх нь 20%-ийг нь 500-аасаа суутгуулаад үлдсэнийг нь дахиад 200 гэдгийг манайх төлөх үүрэгтэй болно гэсэн үг үү? 6 номерын микрофон.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Урьдчилгаа төлбөрт хэрвээ энэ дээр ямар нэгэн байдлаар бэлтгэл арга хэмжээ хийгдээд, бэлтгэл арга хэмжээн дээр хийсэн нийт ажил дээрээ бол дахин төсөв гаргана гэсэн

үг. Яг хэдэн төгрөгийн ажил ямар ажил хийсэн гэдгийг гаргаж байж энэ дээр нийтдээ хэдэн төгрөгийн 500 тэрбумаасаа яг бодит гүйцэтгэлээр нь л бид нар үнэлж гаргана гэсэн үг. Тэгэхээр бодит гүйцэтгэл яг хэдэн төгрөгийн ажил хийгдсэн бэ гэдгийг дахин магадлах шаардлагатай л гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэрний холбоотой тэр үнийн дүнгээ 500-аасаа хасаад л болоо юм уу?

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Хасаад л болоо.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Үгүй бол тэр үнийн дүн чинь тэр үнийн дүнгээс 20 хэдэн хувь гэлээ. Урьдчилгаа нь 20%-ийг нь л 500-аасаа хасаад үлдсэнийг нь Монголын тал төлөх ёстой юм уу?

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Энэ дээр яг 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа өгсөн байгаа бол урьдчилгаа бол явж байгаа. Хэрвээ гэрээний үүргээ биелүүлээгүй ч юм уу ийм байгаа тохиолдолд бол гэрээ цуцлах эрх аль нэг талаасаа хэрвээ үүссэн тохиолдолд Арбитрын шүүхээр шийдэгдэж байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Арбитрын шүүх дээр үгүй ээ, Арбитрын шүүх биш ээ тэгэхээр энэ асуулт нь байна шүү дээ. Зүгээр л тэр хэдэн төгрөг үрсэн нь хамаагүй томъёог нь асуугаад байна шүү дээ. Мөнгө урьдчилгаа гээд 500-г төлчихсөн байна. Урьдчилгаа чинь 21%, тэгээд ямар нэгэн ажил хийчихсэн гээд нөгөө компани чинь билл өглөө. Тэгэхээр манай тал тэр билл нь тэр 500 тэрбумаасаа хасагдах юм уу эсвэл ирсэн тэр тооцооны чинь 21% нь л 500-аасаа хасагдаад үлдсэнийг нь Монголын тал төлөх үү? 6 номерын микрофон.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Хэрвээ ажил хийгээд явах юм бол билл нь 500 тэрбумаасаа хасагдаад л явна гэсэн үг гүйцэтгэгч талын.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Бүтнээрээ хасагдах юм уу? Бүтнээрээ хасагдана гэсэн үг үү?

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Тийм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Наадах чинь гэрээний заалт дээр бол надад арай өөр юмаар би ойлгосон шүү. Энэ дээр шинжээч нараас энэ дээр харсан хүн байна уу? Урьдчилгаа төлбөр яаж төлж явах ёстой талаар. За энэ талаар тэгвэл дараа нь тодруулъя даа. Ингээд түрүүний асуусан асуулт дээр тодруулж асууж байгаа шүү. Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшиний микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Өнөөдөр яг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт байна. Гол асуудал Улаанбаатар нийслэл дээр явж байгаа төслүүд 2 гол асуудалд илүү төвлөрч байгаа. 16 төслийн чинь бараг ихэнх нь 2 л асуудал дээр төвлөрч байгаа. Түгжрэл бууруулах, утаа тэгээд энэтэй холбогдуулж би өмнө ч гэсэн бас асуулгууд тавьж асууж байсан. Яг нэг ийм утаа гэдгийгээ түгжрэл гэдгийгээ юу гэдгийг нь ойлгочихмоор байгаа байхгүй юу. Тэгээд нийтээрээ нэг ийм үзүүлэлттэй болоод яг тэрийгээ хардаг. Үе үеийн Засаг дарга нарын ажлын хийсэн үр дүнг нь утааг хэдэн нэгжээр утаа гэдэг тэр үзүүлэлт нь юу юм, тэр түгжрэл гэдэг үзүүлэлт нь юу юм бэ гэдгийгээ гаргаад тэрийгээ бүгдээрээ мэддэг хэмждэг арга

аргачлалаа тодорхой болгоод нийслэлийн үе үеийн удирдлагуудын энэ багийн ажлын үр дүнгүүдийг нь хардаг. Хэдэн нэгжээр яаж буулгачхав гэдэг юм гаргамаар байгаа юм. Тэгээд ингээд ярихаар өөр өөр үзүүлэлтүүд яриад байгаа юм. Түгжрэл гээд байгаа нь яг юу юм бэ гэхээр оргил цагийн үеийн нийслэл замын дундаж хурд гэж байгаа юм. Утаа гэхээр уул нь хэд хэдэн үзүүлэлтүүд байгаа юм. Агаар дахь үзүүлэлтүүдээс гадна жишээлбэл, тэрийг нь цогцоор хэмждэг агаарын чанарын үзүүлэлт гэх мэт үзүүлэлтүүд байдаг. Тэгээд яг энэ үзүүлэлтүүдээ яаж тодорхойлж байгаа юм? түгжрэл утаа гэдэг 2 үзүүлэлтийг яаж таньж мэдэж байгаа юм? Одоо тоон дээр тэр талаар мэдээлэл өгөөч? нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ нийслэлийн төслүүдийг эрэмбэлсэн гээд байгаа юм. Тэгэхээр энэ төсөл болгоноор 16 төсөл дотор яг энэ утаа, түгжрэлтэй холбоотой үзүүлэлт нь саяын утаа болон түгжрэл гэдэг үзүүлэлтийг хэдэн нэгжээр бууруулах учраас эрэмбийн хувьд дээшээ жишээлбэл, ач холбогдлоор эрэмбэлсэн гээд байна шүү дээ тэгэхээр. Өөрөөр хэлбэл ийм зорилгод чиглэсэн байх ёстой байхгүй юу. Би яагаад энийг асуугаад байна гэхээр Засгийн газрын үйл ажиллагааны 2 хөтөлбөрийг дүгнэж ярьсан. Утаа, түгжрэлийг бууруулахад зарцуулах хийх ёстой төлөвлөсөн ажлаа 30%-ийг хийчихсэн юм байна. 30%-ийн мөнгөө зарчихсан байна лээ. Гэтэл түгжрэл нь нэмэгдчихсэн, түгжрэлийн үзүүлэлт оргил цагийн ачааллын дундаж хурдыг 12 байсныг 16 болгож сайжруулна гээд ажил хийсэн чинь тэр нь 11 болоод удааширчихсан. Яг ажлын өдрийн оргил цагийн ачаалал нь болохоор 5,57 км цаг гээд бүүр удааширчихсан. Өөрөөр хэлбэл та хэд ингээд байгаа онохгүй байгаа юм биш үү. Ажил хийгээд байдаг тэгээд чуулган дээр асуухад бол камер суулгасан гээд тэгж ярьж байх шиг байна лээ. Энэ төслүүд маань ч гэсэн ингээд хийчихдэг дахиад яг энэ бид нарын зориод байгаа утаа түгжрэл гэдэг асуудалд үр дүн авчирч чадахгүй юм биш үү гэсэн эргэлзээ төрөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нэг үзүүлэлтүүдээ утаа, түгжрэл гэдгийг яг таних.

Тэгэхээр надаа нэг ийм үзүүлэлтүүд өгөөч. Утаа гэдгийг яаж хэмждэг үзүүлэлтээр яаж харж байгаа юм. Түгжрэл гэдгийг яаж харж байгаа юм тэр үзүүлэлтүүдийг яаж хэмжиж байгаа юм. Нийслэлийн энэ төслүүдийг яг хэдэн нэгжээр юуг нь яаж буулгах учраас энийг яаж эрэмбэлсэн юм. Одоо энэ 16 төсөл дээр утаа түгжрэлтэй үзүүлэлтүүдийг саяын энэ утаа түгжрэлийг бууруулна гэдэг үзүүлэлтээ ямар нэгжээр буулгасан тэрийг нь яаж эрэмбэлсэн юм тийм мэдээлэл өгөөч.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Түгжрэлийг хэрхэн хэмжих вэ гээд асуулт өргөн хүрээ рүү яваад байна л даа. Яг өнөөдөр Улаанбаатар хотын нөхцөлд бол түгжрэлийг оргил цагийн ачааллын үеэр хэмжихээс өөр аргагүй байдалд үүсэж байгаа юм. Тэгэхээр оргил цагийн ачааллын үеэр хурд нь хэр байна. Оргил цагийн хэмнэл яг хэдээс хэдэн цагийн хооронд үргэлжилж байна вэ гэдэг байдлаас илүү хамааралтай байгаа гэсэн үг. Оргил цагийн яг өнөөдөр дундаж хурд маань 10,8 км цагийн хурдтай байгаад байна. Туулын хурдны замыг хэрэгжүүлснээр энэ оргил цагийн ачааллын хурдыг 12,3 км цаг буюу нийтдээ 14%, 13,5%-аар нэмэгдүүлэх боломжтой гэдэг тооцоолол гарсан. Манай ТЭЗҮ хэрэгжиж байх үед тухай бүр яг аль аль гудамж дээр ямар ямар нөлөө гаргахыг үзүүл гэдэг эксперт, шинжээчдийн дүгнэлтүүдийг ирүүлсэн. Тэгээд бид бүхэн яг аль аль гудамж дээр хэрхэн нөлөөлөх вэ гэдэг тооцооллыг оруулсан байгаа юм. 2022 оны ЖАЙКА-гийн судалгаан дээр эрэмбийн хувьд дэд бүтцийн төслүүд дээр ирэхэд Туулын хурдны зам маань өөрөө түгжрэл дээр нөлөөлөх үзүүлэлтээрээ хамгийн нэгд эрэмбэлэгдэж байгаа. Тэгэхээр энэ мэдээллүүдийг бид бүхэн явуулсан байгаа. Та энэнээс харж болно.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Туулын хурдны зам 12,3 км цаг болно гэж байна. Тэгэхээр одоогийн байгаа түвшин чинь өөр юмнуудын нийлбэр байгаа байхгүй юу. Яг хэдэн нэгжээр тэр үзүүлэлтээ өөрчлөх гэж харахгүй болохоор бусад өөр үзүүлэлтүүд байгаа шүү дээ. Миний хэлэх гээд байгаа зүйл нь зөвхөн Туулын хурдны зам биш сая танилцуулгууд дээр гарсан энэ 16 төслийн чинь бараг ихэнх нь түгжрэлтэй холбоотой байхгүй юу. Энэ төслүүдийн хамгийн өндөр нь Туулын хурдны зам чинь одоо 2,2 км цаг орчмоор энэ үзүүлэлтийг сайжруулахаар юм шиг харагдаж байна тэ? Тэгэхээр бусад нь яг ямар үзүүлэлттэй байгаа гэдэг тийм мэдээлэл өгөөч?

Түгжрэлтэй холбоотой асуудал бэлдэж байх хооронд утаатай холбоотой яг энэнтэй адилхан аль аль төслүүд нь хэдэн нэгжээр утааг яаж хэмжиж байгаа вэ? Жишээлбэл, нийслэлийн засаг даргын тамгын газрын сайт дээр энэ 2 үзүүлэлт байнга л байж байх ёстой. Яг энэ үзүүлэлт яаж хэлбэлзэж байгаа гэдгийг өнгөрсөн жилүүдтэй нь хэн хэн удирдаж байсан бараг үетэй нь харьцуулаад харж болохоор байна. Ийм өөрчлөлтүүд гаргаж тэрний төлөө бас ингээд бууруулдаг. Хийж байгаа хөрөнгө оруулалт нь яг энэний төлөө зорьдог. Энэ нь буцаад яг иргэдийн, нийслэлийн оршин суугчдын хувьд ажил амьдралд нь нэмэртэй ийм л болгомоор байгаа байхгүй юу. Тэгэхээр төсөл хийхийн тулд биш тэгээд цаана нь ийм зорилготой хийгээд байгаа шүү гэдэг. Бүгдээрээ ийм зорилго чиглэсэн байвал илүү одоо хийж байгаа ажлууд маань үр дүнд чиглэсэн байх юм болов уу л гэж бодоод байгаа юм. Тэгэхээр утаатай холбоотой утааг яаж хэмжиж байгаа юм тэгээд нийслэлийн энэ 16 төсөл дотор орсон төслүүд утааг хэдэн нэгжээр бууруулж байгаа гэдгийг хэлж өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Эхлээд түрүүчийн түгжрэлийн талаар. Д.Энхтүвшин гишүүн нэр цохоод асуучих хүн байна уу. 8 номерын микрофоныг нээж өгнө үү?

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе ээ. Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Би яг өөрийнхөө хариуцаж байгаа төслийн хүрээнд утааг хэдэн хувиар бууруулах ганцхан агаарын бохирдол, хөрсний бохирдлын асуудлаар товчхон мэдээлэл өгье гэж бодож байна. Зөвхөн газар чөлөөлөлт хийгдсэнээр тухайн бүс нутагт 30%-ийн агаарын бохирдол буурсан гэдэг үзүүлэлттэй байгаа. Нийт төсөл маань хэрэгжсэнээр тухайн орчны агаарын бохирдлыг 47,8%-50% орчим бууруулна гэсэн ийм тооцоотой байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Д.Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Яг ямар үзүүлэлтээр хэмжээд тэр үзүүлэлтийг хэдэн хувь буулгаж байгаа гээд энэ тайлангуудыг харахаар нэг тийм л юм байгаа юм. Түгжрэлийг тэдэн хувь буулгана, утааг тэдэн хувь буулгана гэсэн яг тодорхой хариулт хүсээд байгаа юм. Түгжрэл гэдэг чинь юу юм бэ гэдгийг өөрсдөө бид мэдэж байгаа юу гэдэг асуулт асуугаад байгаа юм. Тэгэхээр яг ямар үзүүлэлтийг хэдэн хувь байхад нь хэдэн хувь буулгах юм бэ? Өөрөөр хэлбэл, тэр төсөл чинь өөрөө утаа гэдэг тэр үзүүлэлтэд чинь яаж нөлөөлж, хэдэн нэгжээр нөлөөлж бууруулж байгаа гэдэг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Төслийн Нэгдсэн удирдлагын газраас ярих юм байна уу. 5 дугаар микрофон нээж өгье.

НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Түгжрэл, утаа гэсэн 2 энэ асуудлыг шийдэхийн тулд нийслэлийн 16 мянган төслийг ерөнхийд нь ангилж байгаа. Энэ төслүүдийн хувьд орон сууцжуулах төсөл болон эрчим хүчний төсөл, бусад агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлийн төслүүд утааг бууруулах болон агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлтэй байгаа. Газар чөлөөлөлтийн асуудал Сэлбэ дэд төв дээр эрчимтэй явагдсан. Нийтдээ бид нар 158 га газрыг тухайн орчинд чөлөөлсөн. Үүний үндсэн дээр 4800 айлын янданг буулгаж чадсан байгаа. Мөн тоогоор нүхэн жорлонгийн асуудлыг цэгцэлсэн. Баянхошуу дэд төв дээр, Шархад дэд төв дээр, Ханын материал дэд төв дээр газар чөлөөлөлтийн ажил хэрэгжиж байгаа. Үүний хүрээнд нийтдээ 22 мянган айлын орон сууц барих төсөл явж байгаа. Энэ чинээгээр агаар орчны бохирдлыг бууруулж сайжруулна.

Мөн нийслэл дээр хэрэгжиж байгаа томоохон ажил бол агаар орчныг бууруулах хүрээнд хий рүү шилжих энэ ажил хийгдэж байгаа. Энэ ажлын хүрээнд ноднин 5 мянган өрхийг хийн зууханд хамруулсан байгаа. Энэ жилдээ бид нар 10 мянган айлыг нэмж хий рүү шилжүүлнэ гэсэн төлөвлөлттэй байна. Мөн сэргээгдэх эрчим хүчээр бид нар айлын дулааны асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Утааг яаж бууруулж байгааг хэмжээрэй гэсэн асуулт шүү дээ. Таны хариулт мөн үү?

НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар: Мөн энэ хүрээнд хийгдэж байгаа төсөл арга хэмжээнүүдээ бид нар танилцуулж байгаа. Тэгээд эд нар цогцоороо утааг бууруулахад бүгд чиглэж байгаа. Өнгөрсөн жил бид нар өмнөх онуудад харьцуулахад утаа нийтдээ 30% буурсан. Утааг хэмжих нэгж Пи Эйч Пи эм 2,5 пи эм 10 хүхэрлэг хий, азотын хий гэсэн ийм үзүүлэлтээр хэмжиж байгаа. Олон улсын хэмжилтийн байгууллагууд нийслэл Улаанбаатар хотод мэдрэгчүүдээ тавьсан.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Та хэдийг бас ингэж зовоогоод яах вэ. Утаа гэдгийг эхлээд хэмжих хэрэгсэл юу вэ? Жишээлбэл, ПМ2.5 энэ олон үзүүлэлт байгаа байхгүй юу? Хөхүүр азот гэдэг юм чинь тэгээд бүгдэд нь нэг процент яриад, энийг ингэж дандаа хувь яриад байхаар чинь бид нар өөрсдөө асуудлаа таньж мэдээгүй, утаа гэдгийг чинь яг тоон дээр үзэхээр ямар үзүүлэлтээр хэмжих юм гэдэг үзүүлэлт, түгжрэл гэхээр ямар үзүүлэлт байх юм гэдгийгээ тодорхой нэг ойлголттой болмоор байна. Тэгээд төслүүдээ ч гэсэн энэ тэдэн хувиар буулгаж биш яг тэр төсөл нь тэдэн нэгжээр, одоо юм хөгжөөд байгаа хэмжиж гаргаж болохоор байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ нэгдсэн үзүүлэлттэй болбол илүү үр дүнд чиглэсэн болох юм байна.

Нийслэлийн шинэ удирдлагууд цаашаа үүнийг анхаарна биз. Миний бодож, төсөөлж байгаагаар бол нийслэлийн сайтад ороход л түгжрэл, утаа 2-ын яг гол үзүүлэлтүүд нь байж байдаг. Бараг өдрөөрөө үзүүлэлтүүд нь гардаг. Хэмждэг аргачлалын цэг яг нарийн тогтоож өгөхгүй бол аль аль цэгүүдээс ямар дээж шинжилгээ авах юм, хэмжилтүүдээ яаж хийх юм гэдэг арга аргачлалуудаа гаргаад, тэгээд энийгээ хэмжээд явах шаардлагатай байх. Дээр нь нийслэл дээр байгаа төслүүдээ бүгдийг нь яг энэ зорилтдоо утаа гэдэг тэр үзүүлэлтүүдийг хэдэн нэгжээр ямар хувиар, нэгжээр буулгах юм. Түгжрэл гэдгийг хэдэн нэгжээр буулгах юм гэдэг шалгууруудыг харж байж тэгээд хөрөнгө оруулалтын өгөөж тооцох хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, нэг нэгж түгжрэлийг бууруулахад ямар өртгөөр бууруулж байна гэдэг төслүүдтэй харьцуулж байж сонголтуудаа хийдэг байвал илүү бага мөнгөөр илүү зорилт, үр дүнд чиглэсэн иймэрхүү арга ажиллагаа нь болох юм болов уу гэж бодож

байна.

Нийслэлийн удирдлагууд анхаарна биз. тэгээд явчихвал иргэдийн хувьд ч гэсэн амар байхгүй юу. Хэн ямар ажил хийсэн гэдгийг бид нар пи ар-аар биш бодит үзүүлэлтээр жишээлбэл, Х.Нямбаатар даргын хувьд ийм үзүүлэлт байхад нь ингэж өөрчилсөн, энийг ингэж буулгасан, энийг нь ингэж сайжруулсан дараа нь жишээлбэл, удирдлага ийм болсон гэдгийг бид нар нийслэлийн оршин суугч ч гэсэн хараад үзэх бололцоотой. Иймэрхүү байдлаар зохицуулбал зүгээр юм уу гэсэн санал байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүн үг хэллээ. Бид нар энд маш их цаг зарцуулж, бөөн хөдөлмөр зарцуулж, хүмүүс ирж суугаад өдөржингөө сонсоод сошиалаар, телевизээр сонсоод сууж байгаа шүү дээ. Тийм болохоор асуулт, хариултыг ингээд тойруулж аргалахгүй ээ. Сонсгол эхлэхэд заалтууд уншиж өгсөн, хуулийн заалттай, хариулт нь тодорхой байх ёстой. Нуун дарагдуулж болохгүй, худлаа ярьж болохгүй, дахиад л хэлье. Зам, тээврийн сайд танилцуулга хийхээр хөтөлбөрт орсон байсан. Оронд нь хэн орж ирэхийг ирж хэлсэнгүй. Та бүхэнд тавьсан сэдэв бол тэр том энэ тээврийн мега төслүүд чинь хоорондоо яаж уялдаж байгаа юм, 7 төсөл зэрэг хэрэгжиж чадах юм уу, нийт ямар үр дүн гарах юм, тэр чинь одоо саяын гишүүний асуугаад байгаа тэр түгжрэлтэй нь холбоотой.

Тэгэхээр энэ уялдсан талыг танилцуул гэсэн чинь Туулын хурдны 1, 2 дугаар замын үе шатыг хэлсэн. Энэ хэлэлцүүлэг дуусах болоогүй байна Тэгэхээр энэ уялдааг та бүхэн цагийн дараа танилцуулна уу, хэнээрээ танилцуулахаа мэдэхгүй. Бүхэл бүтэн яам ажиллаж байгаа. Өгсөн сэдвийн дагуу юм яриагүй, дараа нь араас нь тайлбар өгсөн. Тайлбар өгсөнгүй Улсын Их Хурлыг хүндэтгээгүй гэж би үзэж байна. Тэгээд энэ нь үндэслэлтэй байна уу үгүй юу гэдгийг Тамгын газар Хяналт шалгалтын газрыг хянаж өгөөч гэсэн хүсэлт тавья. Улсын Их Хурлын тухай хуулиар тодорхой зохицуулалттай, хариу өгөхгүй, мэдээлэл өгөхгүй, худлаа мэдээлсэн байх юм бол 5 хоног шалгана. Тэгээд хуулийн арга хэмжээ авах асуудлууд байгаа. Хоёрдугаарт нь, НИТХ-ын төлөөлөгч нар өөрийнх нь ахалж байгаа компани төсвийн байгууллагын төсвийг батлахад оролцож байна уу, хуралд сууж шийдвэр гаргаж байна уу, эрх ашгийн зөрчил байна уу гэдэг талаар мэдүүлэг хүссэн. Өнөөдөр бид нар бичиг авсан. Өнөөдөр сонсгол дуусаж байгаа 6 дугаар сарын 10-нд очсон бичиг. Тэгэхээр энэ дээр холбогдох албан тушаалтанд нь хуулийн дагуу ямар хариуцлага хүлээх ёстой вэ. Энийг бас Тамгын газраас нь нягтлаад хэрвээ үндэслэлтэй гэж үзвэл хариуцлага тооцох асуудлыг ярьж гэсэн энэ саналыг хурал даргалагчийн үүднээс гаргаж байна. Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент компани Говь-Алтай аймагт нарны цахилгаан станцын зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа. Тэрнийхээ төлбөрт хөрөнгө оруулалтын шимтгэл авах уу гэсэн манай компаниар бол дамжихгүй ээ гэж хэлсэн. Тэгээд тэр ирүүлсэн асуулт материалыг нь харахаар 1,5%-ийн шимтгэлийг зөвлөх компанид төлнө гэсэн байна. Тэгээд энэ мэдээллийг өглөө бас надад өглөө. Тэгэхээр энэ мэдээллийн зөрөө байна уу? санамсаргүй яриад байгаа юм уу, мэдээлэл дунд холиод би буруу ойлгоод байна уу, худлаа яриад байна уу? Энийг Тамгын газар бас нягталж өгөөд 5 хоногийн дотор дүгнэлт гаргаж холбогдох албан тушаалтанд хэрвээ зөрчил гаргасан бол тэр Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцох асуудлыг хурал даргалагчийн зүгээс санал болгож байна. За ингээд гишүүдийн болоод оролцогчдын ярьж байгаа санаан дээр та бүхэн тодорхой товч хариу өгөхийг хүсье. УИХ-ын гишүүн Дав.Цогтбаатар

УИХ-ын гишүүн Дав.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би энэ хөрөнгө оруулалт менежментийнх нь компанийн захирал юм уу мэдэхгүй байна. Тэнд хөрөнгө оруулалт хариуцсан эмэгтэй суугаад байсан юм тэр хүнээс асуух гэсэн юм. Ер нь бол энэ Засгийн газраар ярих юм бол Шадар сайд, Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайдыг нийлүүлчихсэн эрх мэдэлтэй юм шиг байгаа юм. Маш их баян хөрөнгө оруулалттай, хэдэн их наядаар яригддаг хөрөнгийг захиран зарцуулдаг. Тэгээд энэ чинь Монголчууд өөрсдөө барилгаа барьж чадна. Монголчууд хогноос эрчим хүчээ гаргаж чадна. Хувийн компани өөрсдөө энийгээ бид нар чадчихсан ийм ажил хиймээр байна гээд очихоор заавал Хятадын компанийг илүүд үздэг. Одоо энэ Сэлбэ дэд төв дээр барилгын тендер зарлагдахдаа хамгийн анх 5 багц болгуулаад 5 хятад компанид өгөх гэж байна л гэж яригдсаар байгаад Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч Наранбаатар гүйцэтгэх захирал Б.Өлзийбат нарын тэргүүтэй барилгын салбарынхан жагсаал цуглаан болж байсан. Ганц нэг нь монгол компаниудад очсон.

Тэгээд нийслэлийнхний харж байгаагаар бол монголчууд хийх шаардлагагүй улс ч гэж байх хэрэггүй. Нийслэлтэй холбоотой бүх асуудлыг хятадуудтай нийлж байгаад манай нийслэлийнхэн л хийчих юм шиг байгаа юм. Улаан намын цагаан байрны дээрэмчид гээд би энэ Улсын Их Хурлын гишүүд дотор бас байдаг юм бодсон чинь нийслэл дээр бол бүүр битүү шургалчихсан юм байна. Би тэр эмэгтэйдээс асуух гэсэн асуулт маань 15 туслахтай гээд байгаа юм. 3 компанийн ТУЗ-д ажилладаг. Тэр олон туслахаар юу хийлгэдэг юм бэ?

Сонсгол даргалагч аа дэг сахиулахгүй бол энэ чинь дуртай үедээ нийслэлийнхэн орж гарч бие засаж явж байгаад гардаг газар л ордон болчихоод байх шиг байгаа юм. Тэгээд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар тэр ТУЗ болон удирдлагууддаа нууц гээд өгдөггүй.

Цалингийнх нь мэдээллийг асууя гэхээр уг нь нийтийн албан тушаалд томилогдохдоо би тэдэн авгай, тэдэн хүүхэд, тэдэн төгрөгийн үхэртэй, гахайтай гэж байгаад л бүх мэдүүлгээ өгч байгаад дарга болдог. Дарга болсных нь дараа цалинг нь асуухаар хувь хүний нууц гээд өгдөггүй. Тэгэхээр жилийн дүнгээрээ ТУЗ болон удирдлагууддаа хэдэн төгрөгийн цалин урамшуулал өгдөг вэ? гэдгийг асуух гэсэн юм. 2 дугаар асуулт тэгээд ер нь хөрөнгө оруулалт хариуцаад байгаа эмэгтэй маань бонд, зээл, төсөв гээд ер нь хэдэн төгрөг захиран зарцуулдаг юм тэрийг асуух гэсэн юм. Тэгээд энэ нийслэлийн хөрөнгө оруулалт хариуцсан дарга бас сууж байна гэж сая надад мэдээлэл өгсөн. Сая энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийж байгаа мэдээллээр 6,9 их наяд буюу 7 их наяд төгрөгийн алдагдал байна. Нийслэлийн алдагдлыг улсын төсвөөр төлөхгүй. Эсвэл нийслэлийн энэ ард иргэд та нарын үйлдвэрлэсэн тансаглал...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Дав.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Дав.Цогтбаатар: Та бүгдийн энэ үйлдвэрлээд байгаа алдагдлыг нийслэлийн иргэд бол төлж чадахгүй. Сүүлийн 3 жилд үйлдвэрлэж байгаа алдагдал чинь 6,9 их наяд болсон. Улсын төсөв дээр 2025 оны төсвийг батлах гэж байхад мөчлөг сөрсөн төсвийн бодлого хийе урсгал зардлаа багасга гээд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хориг тавиад алдагдалгүй төсөв батлагдаж байсан. Иргэдийн хурлын төлөөлөгч та нар чинь нийслэлийнхээ баталж байгаа төсөв дээр хяналт тавих гэж ордог байтал өөрсдөө дотоод компаниудад нь даргаар нь ТУЗ нь орж байгаад 7,9 их наяд төгрөгийн алдагдал үйлдвэрлэчихсэн байдаг. Үүний чинь

хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Улсын төсөв хүлээх юм уу? Засгийн газар хүлээх юм уу? Нийслэл өөрөө төлж барагдуулах юм уу? Энэ дээрээ бас нэг тодорхой хариулт өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За 8 номерын микрофоныг нээж өгье.

НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах: Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах байна. 1 дүгээр асуудал бол Хөрөнгө оруулалт менежментийн корпорацийн захирал Гангамөрөн захирал бол өнөөдрийн жагсаалтад ороогүй байгаа учраас Гангамөрөн захирал ирээгүй байна. Нийслэлийн төсөвтэй холбоотой асуултад хариулъя. Нийслэлийн төсвийг аваад үзэх юм бол Төсвийн тухай хуулийн 57.3-д заагаад өгчихсөн байдаг. Орон нутгийн төсөв гээд 57.3-д юу гэж зааж өгсөн бэ гэхээр Орон нутгийн төсөв нь урд оны үлдэгдлээс санхүүжих зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжих эх үүсвэрээс хэтрэхгүй байна гээд.

Тэгэхээр Төсвийн тухай хуулийн 57.3-ын дагуу бид бүгд төсвөө төлөвлөөд явж байна. Нийслэлийн төсвийг нэг төгрөгийн ч алдагдалтай батлаагүй. Тэгэхээр бол энэний дагуу 2024 онд бол нийслэлийн төсвийн орлого 3 их наяд 91,1 төсвийн зарлага 3 их наяд 361 тэнцэл бол 271,2 тэрбум төгрөг. Тэгтэл нийслэлийн он дамжих мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бол 490,6 тэрбум төгрөг байна. 2025 оны нийслэлийн дамжих дүн маань бондынхоо дүнг оруулаад 1,5 их наядын бондын үлдэгдлийг оруулаад 2,9 их наяд. Нийслэл дүүргийн нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,9 их наяд төгрөгийг бол үлдэгдэлтэй байна. Тэгэхээр бид бүгд бол яасан юм гэхээр Төсвийн тухай хуулийн 57.3-ын дагуу бид нарт нийслэлд орон нутагт бол эрхийг нь нээгээд өгчихсөн байдаг. Тэгснээс 6 их наядын болоод холбоотой тийм бол алдагдал үүсгэчихсэн юм бол байхгүй.

2 дугаарт нь бондын асуудал байна. Нийслэл хот маань 2024 оноос эхлээд бол бонд гаргасан байгаа. 2024 онд бол 500 тэрбум төгрөг дотоод бонд 298,3 тэрбумын дотоод бонд уг бонд бол Бөөрөлжүүтийн цахилгаан станц болон 50 мегаваттын эрчим хүчний станцыг ашиглаад 600 тэрбум төгрөгийн бонд бол боссон гэсэн үг. Энэ бондыг Бөөрөлжүүтийн цахилгаан станц өөрсдөө эргэн төлж байгаа. Тэгэхээр энэ нийслэлийн төсөв дээр жил болгон Бөөрөлжүүтийн цахилгаан станц бол хүүгийн төлбөр 42 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт бол эргэн төлдөг. Улаанбаатар Энержи гээд компани бол 50мвт-ын батарей хураагуурын станц байгуулагдчихсан. Энэ бол төсвөөсөө төлж байна гэсэн үг. Харин 200 тэрбум төгрөг буюу 150 тэрбум төгрөг нь замын зам засвар ачилтад 50 тэрбум нь Туул коллекторт зарцуулсан. Эдгээр зардлыг өнгөрсөн жилийн 2025 оны 6 сарын 25-нд нийслэлийн төсвөөс 100 тэрбум төгрөгийн бондынхоо эргэн төлөлтийг бол...

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За гишүүний микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн Дав.Цогтбаатар: Би танай тайлантай танилцаагүй уучлаарай даргаа. Би саяын танилцуулгатай холбогдуулаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийсэн яг энэ танилцуулгын хүрээнд л асууж байгаа юм. Энэ танилцуулга дээр Та бүхнийг хуулийн шаардлага төсвийн тухай хуулийн 57.2, 3 дугаар заалтыг зөрчөөд алдагдал 2024 онд 2,1 их наяд, 2025 онд 2,7 их наяд, 2026 онд 2 их наяд нийтдээ 6,9 их наяд буюу 7 их наяд төгрөгийг үйлдвэрлэхчиглээ шүү

гэдгийг чинь л хэлээд байгаа юм. Нийслэл гэдэг чинь өөрөө тусдаа улс биш байхгүй юу. Монгол Улсын нийслэл улс гэж байхгүй шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын тухай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс албан ёсоор гаргаж ирүүлсэн энэ танилцуулга нь шаардлагатай мэтгэлцмээр байна гэж байгаа бол та Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнтэй учраа олох нь ээ. Туулын хурдны зам руу оръё. 2024 оны зургаараа одоо орох гарах гарцгүй байж байгаад 2025 оныхоо зургаар орох, гарах орц нь 4 байж байгаад 7 болоод байгаа юм. Тэгээд гүүр нь 5 байж байгаад 7 болоод байгаа юм. Эгнээ нь 4 байж байгаад 6 болоод байгаа юм. Нэг жилийн дотор гарч байгаа өөрчлөлт холбоос замын урт нь тэг байж байгаад 3,7 болж өсөөд байгаа юм.

Энэ яагаад 2024 оны зураг чинь 2025 он буюу нэг жил ч хүрэхгүй хугацааны дотор ингэж их өөрчлөлт ороод байгаа юм бэ? тэрийг нь батлаад байгаа юм бэ? гэдэг 1 дүгээр асуулт. Тэгээд энэ замын дарга бол миний мэдэж байгаагаар Зам,а тээврийн яамны сайдаас илүү их төсөвтэй мөнгөтэй эрх мэдэлтэй л дарга юм шиг байгаа юм. Энэ гадаад худалдааны санхүүжилт гэдэг юм уу Монголд хөрөнгө оруулах гэж байгаа хөрөнгө оруулалтуудын талаар баталгаа гаргахаараа миний мэдэж байгаагаар бол би энэ санхүүгийн салбарт 20-оод жил ажиллачихсан. Синошур гэдэг Хятадын даатгалын компани ажиллаж байж бид нар итгэдэг байсан юм. Тэгсэн чинь одоо болохоор энд танилцуулга дээр нь өөрийгөө өр төлбөргүй гээд тодорхойлчихож байх шиг байгаа юм. Монгол Улсад бүртгэлтэй Мөнх даатгал гэж нэг компани байх шиг байгаа юм. Тэрнийх нь эзэн холбогдож явж явж байгаад энэ Засгийн газарт ажилладаг нэг даргын компани болж таарч байх шиг байгаа юм. Тэгэхээр яагаад энэ Синошурын даатгал баталгааг ашиглахгүйгээр та нар шууд Ангольд барилгын тусгай зөвшөөрөл эзэмшдэг компанид энэ үнэтэй зам барих эрхийг олгоод байгаа юм бэ? гэдэг нэг асуулт байгаа юм.

2 дугаарт нь Нийслэлийн засаг даргын Тамгын газар эсвэл Нийслэлийн засаг дарга маань өөрөө хуульч л хүн байсан. Тэгээд бид нар яагаад Нийслэлийн засаг даргын Тамгын газрын хуулийн багийнхан гэдэг юм уу хуулийн газрынхны хийсэн хариуцлагагүй үйлдлээс болж гэрээн дээр чинь заачихсан алдагдлыг хүлээх ёстой юм. Яагаад олон улсын зарчмаар хийгддэг даатгал баталгааг ашиглахгүйгээр явчихсан юм бэ? Энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөөч гэж байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Одбаяр дарга 6 дугаар микрофон.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Дав.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн замын хөгжлийн газар Б.Одбаяр. Тэгэхээр 2024 онд зургийг дахин зөвхөн төсөв дээр магадлал хийлгээд цалингийн зардал болон тээвэрлэлтийн тарифын зардал өссөнтэй холбогдуулаад дахин магадлал хийлгэсэн. 2024 онд хийгдсэн зураг төсөл маань өөрөө анх 2013 оны Засгийн газрын тогтоолоор батлагдаад 2014 онд болон 2016 онд магадлал хийгдсэн. Нийтдээ яг зургийн дагуу 4 эгнээ зам байсан хурдны зам Туулын хурдны зам нь 3,2 км гүүрэн байгууламжтай.

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын тэмдэглэл дээр 2 урсгал бүхий 6 эгнээ авто замын байгууламж олгоод одоо байгаа хот төлөвлөлттэй уялдуулан төлөвлө гэдэг үүрэг даалгаврыг Р.Эрдэнэбүрэн сайд, Зам тээврийн яамны сайд болон Нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгоод үүнийх нь дагуу 2024-2025 онд эхлээд ТЭЗҮ боловсруулах ажлууд маань яваад нийт одоо байгаа тухайн трасс дээр байгаа авто замаа ямаршуу байдлаар орц гарцуудыг одоо байгаа дээр

төлөвлөлттэйгөө уялдуулаад шинээр үүсэж байгаа суурьшлын бүс бий болох газрууд дээрээ олон түвшний огтлолцол бүхий орц гарцыг нээх шаардлага үүссэн.

Мөн яг хотын төвийн хэсгээр дайрч өнгөрч байгаа буюу Маршалын гүүрнээс Яармагийн гүүр хүртэлх хэсгүүд дээр бол гүүрэн байгууламж болох шийдлүүдийг гаргаад ТЭЗҮ болон төсөв магадлал батлагдаад гарсан. Тухайн үед нийт гүүрний урт маань бол 3,2-оос 9,788 метр урт болж өссөн байгаа. Олон түвшний огтлолцол 7 байршилд гарч энэ байдлаар өөрчлөлтүүд орсон байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хариуцлагын асуудал дээр хэнээс хариулт өгөх вэ? Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: За баярлалаа. Би зүгээр энэ Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв бүтээн байгуулалттай холбоотойгоор бас иргэддээ

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За уучлаарай.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Бас мэдэх эрхийг нь хангах зорилгоор.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Уучлаарай П.Сайнзориг гишүүн ээ. Уучлаарай цаг нь дуусаагүй байсан юм байна. Тийм Дав.Цогтбаатар гишүүний микрофоныг нээж өгье.

УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар: За баярлалаа. Тэр хариулаагүй байгаа асуулт дээр хариултыг бас ирүүлбэл сайн байна. Энэ хуулийн газрынх нь байдаг юм уу яагаад зараа Засаг даргадаа зөвлөхгүйгээр ийм хариуцлагагүй гэрээг бид нар байгуулаад бид нар шууд өрөнд орох болчихсон юм бэ? гэдэг дээр. Энэ 2 дугаар асуудал дахин төлөвлөлттэй холбоотой ер нь яах вэ, барилгажилт, явах ёстой утаанаасаа салах ёстой бүгдээрээ ойлгож байгаа. Яах вэ эзэндээ үйлчилдэг нэг гишүүн байгаа юм тэр нь одоо ингээд сэлбэ зөв гээд хэлчихээр тэр нь зөв болчихдог юм шиг байгаа юм. Санхүүгийн мэдлэг бас нэг жоохон дутмаг байж магадгүй. Гэхдээ энэ дээр чинь дахиад Монгол Улс олон улсын байгууллагад хэлэх үггүй болчихсон нэг хачин төсөл үгүй хууль сая гарсан. Тэгэхээр иймэрхүү зарчимгүй байдлаар явсаар байгаад Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 6,9 их наяд гэдгийг чинь гаргаж ирээд байгаа гэдгийг л дахиж хэлэх гэсэн юм. Тэгээд саяны экспертийн танилцуулсан танилцуулга дээр барилгын тоонууд яригдсан. Одоо энэ Сэлбэ дэд төвтэй холбоотойгоор тэгэхээр яг хэдэн барилга баригдах вэ? Тэндээс яг хэд нь бодитойгоор дулаантай вэ? гэдэг дээр хариулт өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сэлбэ дэд төвөөс төслийн удирдагч 8 дугаар микрофоныг нээе.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Д.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Төслийн ТЭЗҮ-ийн хүрээнд 12 мянган айлын орон сууц баригдана гэдэг төлөвлөлттэй. Үүнээс 8,575 айлын төр өөрөө менежментээр барина. 3500 орчмыг нь хувийн хэвшлийнхнийг хөрөнгө оруулалтаар барина гэсэн төлөвлөгөөтэй. Нийт одоогийн төлөвлөгдөж байгаа орон сууцын ачаалал маань 34МВт-ын дулааны ачаалалтай. Бид нарын ажиллаж байгаа Сэлбэ дэд төв станцаас 21МВт-ыг нь авна. 10 сард орох Дамбадаржаа станц 63МВт-ын хүчин чадалтай ашиглалтад орж байгаа 45 хувийг нь Сэлбэ дэд төв рүү оруулахаар төлөвлөж байгаа. Тэгэхээр орон сууцын хувьд болон нийгмийн дэд бүтэц....(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гүйцээж хариулъя.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Орон сууц болон нийгмийн дэд бүтэц, 3 сургууль, 5 цэцэрлэг болон бусад дулааны ачаалал хангалттай хүрэхээр эхний ээлжид байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Экспертээс нь нэмээд хариулна уу. Шинжээчээс. Төслийн хүрээнд баригдаж байгаа объектуудын дулаан хангамжийн эх үүсвэр хэдийг нь хангаад хэд нь тодорхойгүй үлдэж байгаа юм бэ? гэж асуугаад байна. 3 дугаар микрофон нээж өгнө үү.

Шинжээч 3.Туяа: Сэлбэ 20 минут компанийн өгсөн мэдээллээр одоогоор 113 барилга нь энэ бондын хөрөнгөөр баригдана. Тэр дотор 77 барилга нь блок нь өөрөөр хэлбэл 113-ын 77 барилга нь дулаанаар бэлэн хангагдах боломжтой хангагдах эх үүсвэрээ авна. 20 нь боломжтой гэсэн ийм мэдээлэл байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За. Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг асуултаа асууя.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: За бас хэдэн зүйлийг тодруулаад яг тодорхой хариултууд хэлээд өгөөч гэж хүсэж байна. 2 төслийг тойроод ярьж байна. Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв буюу тэрийг түшиглэсэн энэ орон сууцуудын төслийг ярьж байна. Туулын хурдны зам уг нь түүхээсээ үзсэн бол 2013 оноос яригдаад явсан байж байгаа. Ер нь 2013 онд тэр яригдаж байсан төслийн ерөнхий зураг трасс хэр өөрчлөгдөж энэ удаагийн хэрэгжилтийг ярьж эхэлсэн юм бэ? Тэгэхээр энийг нэг бас тодорхой зүгээр олон нийтэд мэдээлэл өгөөч.

Энэ ажлуудаа санхүү мөнгө босгож чадаагүй байж байтал шахаад баахан орон сууцын хорооллууд барьчихсан. Ер нь энэ орон сууц нийтийн эрх ашгийн төлөө зам барихад бөөн эсэргүүцэлтэй л явж байдаг. Энэ баахан орон сууцын хотхон барихад ямар этгээдүүд нь ийм зөвшөөрөл олгочихсон юм? Хэн гэдэг гар Засаг дарга нарын үед тэр том хотхонуудыг ингээд зөвшөөрлийг нь өгсөн юм бол? Энийг бололцоотой бол мэдээллүүдийг нь хэлмээр байх юм. Тэгээд энэ Туул гол дотор чинь наран шарлагын газар гээд нэг олгочихсон байсан шүү дээ. Тэр наран шарлагын газар жишээ нь энэ Туулын хурдны замын трасс дотор байгаа юу? Тэр наран шарлагын газар ашиглалтад орсон уу үгүй юу энэ чинь нэг хүний Туул гол дотор нэг арал дээр нэг хувийн эдлэн шиг том том байшингууд байсан. Тэр ер нь юу болсон бэ? гэх зэрэг ийм жижиг хувийн эрх ашгуудын хөндсөн юмнууд болсон юм биш биз дээ гэдэг бодлууд байна. Тэгэхээр нэгэнт энэ Туул голыг хамгаалах асуудал яригдаж байгаа бол энэ замын асуудлууд дээр бас ийм асуудал ярьж байсан шигээ тэр орон сууцын хотхоны асуудлууд ер нь яая гэж одоо нийслэл бодож байгаа юм. Энэ дээрээ нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт энэ Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын явцад гэхгүй л дээ. Ер нь 6 дэд төв байгаа. Яг энэ дэд төвийнхөө хувьд агаарын бохирдол түгжрэл ч гэдэг юм уу энэ зүйлүүд дээр яах вэ? Зүгээр түрүүн Д.Энхтүвшин гишүүн л асуугаад бол уг нь тодорхой хариулмаар байна. Жишээ нь түгжрэлээс бид хэд нэг хүн жилд хэчнээн цагийг, хэчнээн өдрийг түгжрэлд алдаж байгаа вэ? Үүнээс үүсэх эдийн засгийн тооцоолол боломж нь хэдэн төгрөг бид нар алдаад байгаа вэ? Энэ зүйлүүдийг бас нэг олон нийтэд маш тодорхой тоонуудыг хэлж өгөөч. Хөрс агаарын бохирдлоос байдаг юм уу? Энэ эрсдэлүүдээс ер нь ямар хэмжээний эрүүл мэндийн

зардал хүн амд гарч байгаа вэ? Энийг бас нэг тодорхой хэлчихмээр байна.

Энэ төслүүдийн нийгэм эдийн засгийн үр дүнг бид нар ярьж байгаа юм чинь нэгэнт л бас хэлэх нь зөв байх. 2 дугаарт энэ Сэлбэ төвийн хувьд өртгөө нөхөх төсөл мөн үү? Өнөөдөр оруулж ирээд байгаа тэр бонд чинь тийм эрсэдчихээд байгаа зүйл байгаа юм уу? Энийг олон нийтэд ингэж мушгиж тайлбарлах тусам энэ том төслүүдийг эрсдэлд оруулахыг л нигууртай уг нь зүгээр хэрэгжээд явж байгаа яг графикийн дагуу хэрэгжээд явбал энэ төсөл чинь ашиглалтад ороод..

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүний микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Нөхөөд явах ийм төсөл мөн биз дээ. Энийг бас нэг тодорхой хариулж өгөөч. 2 дугаарт шинжээчээс асууя. Шинжээч буруу ташаа мэдээлэл өгвөл эрүүгийн хариуцлага хүлээдэг. Дээрээс нь төвийг сахих байр суурьтай байдаг мэргэжлийн байх ёстой 3.Туяа гээд хүнээс асууя. Та нийслэлээс ер нь хэчнээн төсөл хөтөлбөр авсан бэ? Энэ Сэлбэ дэд төвийн зөвлөх үйлчилгээ дээр та Хайдро дизайнер гэдэг компанитай консорциум болж ороод тендерт нь шалгараагүй гэж үнэн үү? Энэ дээр Сэлбэ дэд төвийн та анхны тэр хэсэгчилсэн төлөвлөгөөг та бас хийсэн үү? Өнөөдөр нийслэлд байгаа Эмээлт аж үйлдвэрийн парк гандангийн хэсэгчилсэн төлөвлөгөө бүх энэ зураг төслийн юмыг танд л өгөх ёстой байдаг уу? Та яг бие даасан бүрэн тийм шинжээчээр ажиллах тийм хүн мөн үү? Энийг одоо яг нэг хариулаач таны ашиг сонирхлын хэчнээн компани Нийслэлээс энэ зөвлөх үйлчилгээний тендерүүдийг авсан бэ? Одоо яг хэдэн тендерт хийгээд явж байгаа вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Микрофон нээж өгнө үү? Хариултаа авъя. Б.Одбаяр дарга 6 номер.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн замын хөгжлийн газар Б.Одбаяр. Тэгэхээр Туулын хурдны замын трасс анх 2013 онд Засгийн газрын 8 дугаар сарын 23-ны өдрийн 307 дугаар тогтоолоор бол батлагдсан байгаа. 2014 онд магадлан ерөнхий дүгнэлт хэсэгчилсэн байдлаар Барилга хөгжлийн төвөөр батлагдаж гараад нийтдээ сүүлд 2016 онд эцсийн дүгнэлт бол Зам тээврийн хөгжлийн төвөөр магадлан ерөнхий дүгнэлт батлагдаж гарсан байгаа. Тэгэхээр 2016 онд батлагдсан замын трасс маань 2013 онд батлагдсан 307 дугаар тогтоолоосоо өөрчлөгдсөн зүйл нь гэвэл тухайн хот тосгоны барилгажилт буюу одоо нөхцөл байдалдаа тааруулаад ирэх юм бол 2016 онд батлагдахдаа маршалын гүүрнээс Зайсангийн гүүр хэсэг дээрх голын үерийн далангаар явж байсан бол энийгээ голынхоо голдирол руу оруулж ирсэн байгаа юм. Татам хэсэг рүү. Тэгэхээр энэ дээр л өөрчлөлт гарсан байгаа юм. 2016 онд яг эцсийн байдлаар магадлан ерөнхий дүгнэлт нь гараад бүх зөвшөөрлөө аваад эцсийн байдлаар магадлагдсан зураг дээр 2024 онд бид бүхэн төлөвлөхөд харьцуулаад харах юм бол өөрчлөгдсөн зүйл байхгүй.

Энэ дээр зөвхөн суурьшлын бүс дээр ирж байгаа 2 байршил дээр олон түвшний огтлолцол бий болгож байгаа юм. Тэгээд далангаар байсан зураг төслийг гүүрэн байгууламж болгож өөрчлөгдсөн. Үүнээсээ үүдээд төсөв нэмэгдэх шалтгаан болсон байгаа. Мэдээж 4 эгнээ зам 6 эгнээ болсон. Яагаад гэхээр тухайн үед байсан автомашин авто тээврийн хэрэгслийн тоо хэмжээ өөрчлөгдсөн. 2025 онд 2024 онд тухайн үед байсан нийтдээ 805 мянган тээврийн хэрэгсэлтэй болсон. Энэ тоо хэмжээтэйгээ харьцуулаад үзэх юм бол зайлшгүй 6 эгнээ болох шаардлага бий

болсон. Трассын хувьд гэх юм бол энэ дээр өөрчлөгдсөн зүйл байхгүй. Далангаар байгаа тоо хэмжээг голын татам хэсэг дээр байгаа далангийн хэмжээг бол гүүрэн байгууламж болгож өөрчлөгдсөн л асуудал байгаа юм. Түгжрэлээс үүдээд яг алдагдсан боломжийн өртөг гэх юм бол 2016 онд нийтдээ магадлалын ерөнхий дүгнэлт гарсан нарийвчилсан зураг төсөл батлагдсан байсан.

Энэ хугацаанаас бодох юм бол 2026 онд үзэхэд 2022 онд 2020 оны байдлаар гэхэд бид нар алдагдсан боломжийн өртөг гэхэд ойролцоогоор 2,7 их наяд төгрөг байсан. Сүүлийн жилүүд дээр ирж байх юм бол авто тээврийн хэрэгслийн тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулаад энэ тоо 3 их наядад давсан байгаа. Жил бүр бид нар алдагдсан боломжийн өртгөөр. Тэгэхээр амьдралын чанар эндээс зөвхөн яг түгжрэлээс үүдэж байгаа хохирол шууд ба шууд бус үр нөлөөгөөр маш ихээр гарч байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За дараагийнх нь асуулт шинжээч рүү мөн үү эсвэл болоогүй байна уу? Сэлбээсээ 8 дугаар микрофоныг өгье.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сэлбэ хот зөвхөн санхүүгийн үр өгөөж гэхээсээ илүүтэйгээр нийгэм, эдийн засгийн өгөөжийн өндөр төсөл гэж гарч байгаа юм. Нийгэм, эдийн засгийн өгөөж түрүүн П.Сайнзориг гишүүний асуусан асуултад бас байгаа алдагдсан боломжийн өртөг, түгжрэл, агаарын бохирдол, байгаль орчин, хөрсний бохирдлоос болох эрүүл мэнд гээд. Ингээд үзэхээр бид нарын тооцооллоор эдийн засгийн жилийнх нь өгөөж нь 15-аас дээш гарч байгаа. Энэ олон улсын хувьд сайн гэж дүгнэж байгаа. Санхүүгийн загварчлалын хувьд зөвхөн бид орон сууцаа тойрч ажиллаад байна. Түрүүн бас Р.Батболд гишүүн асуусан байсан. Өртгийн талаар мөн борлуулалтын үнэлгээний талаар өртгөө нөхөх үү талаар би бас тайлбар хэлье. Нийт магадлагдсан төсвөөр төслийн менежмент хэрэгжүүлж байгаа багийн хувьд бол санхүүгийн ашиг гэхээсээ илүү нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр ажиллаж байгаа. Санхүүгийн өгөөжийг хэн хүртэж байна вэ гэвэл эндээс төслийг гүйцэтгэж байгаа барилгын компаниуд хүртэж байгаа. Төсөвт өртөг дээр ногдож байгаа төсвийн нормоороо бол 180 орчим тэрбум төгрөгийн ашиг нь барилгын салбарт өөрсдөө үлдэж байгаа юм. Тэрнээс биш төсөл хэрэгжүүлж байгаа төслийн багт бол үлдэхгүй. Мөн метр квадратын үнэлгээгээ бид нар мэдээж өртөг дээр суурилж гаргаж байгаа. Зах зээлийн дундаж үнэлгээ, өрсөлдөх чадвар, бусад барилгын компаниудын бас бизнесийн орчныг хязгаарлахгүй түвшинд үзэж байгаа. Тэгээд борлуулалтын орлогыг бид нар 2,4 их наядаар нийт хөрөнгө оруулалтын зардлыг 2,2 их наядаар төлөвлөсөн. Бондын эргэн төлөлтөд ямар нэгэн эрсдэл учруулахгүйгээр бид нар ажиллаж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 3 дугаар микрофоныг өгье. Шинжээчийн хариулт.

Шинжээч 3.Туяа: Миний бие Нью Урбанизм компанийн захирал. Хот төлөвлөгч. Энэ ажлынхаа хүрээндээ Улаанбаатар хотод миний хийж гүйцэтгэсэн ажил гэвэл 2015 он хүртэл болохоор зэрэг бүгдийг нь би тоочих уу ямар ажил хийсэн гэдгээ? 2015 он хүртэл бид нар Их засгийн ерөнхий төлөвлөгөө дээр ажилласан. Өөрөөр хэлбэл 2030 он хүртэл үндсэн чиглэлийн хүрээнд боловсруулж байсан нэг толгой хорооллын төлөвлөгөөнүүд дээр ажиллаж байсан. Түрүүний таны дурдсан Эко парк гэдэг болохоор олон улсын төсөл дээр Энэтхэгийн Крисл гэдэг компанитай хамтарч дотоодын туслан гүйцэтгэгчээр ажилласан. Тэгээд дээрээс нь Хайдро гэдэг компанитай бид нар энэ Сэлбийн дэд төвийн төсөл рүү тендерт орсон нь үнэн.

Тэгээд ялагдсан гэдэг үнэн. Маргаан гарсан нь үнэн. Ямар хэмжээгээр ямархуу худалдан авалтын ажиллагаа болж тэмцэлдсэн бэ? гэдгээ хэрвээ тодруулахад хүсэх юм бол би хэлэхэд бэлэн байна. Энэ төсөлд яагаад орсон бэ гэвэл өмнө нь 2014-2015 онд 2014-2017 оны хооронд дээр нь 2019-2020 оны хооронд гэр хороолол...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Сайнзориг гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Ийм л хүн шинжээч хийж байна шүү дээ. Ашиг сонирхлын зөрчилтэй. Тендерт ороод ялагдсан. Тэгээд энэ төслийг шинжээчийг дүгнэлтийг гаргаад хувийн ашиг сонирхлыг хавчуулж байх магадлалтай. Хурал даргалагч ийм шинжээчдийг хаанаас хэн санал болгож ингэж ашиг сонирхлын зөрчилтэй оруулж ирээд байдаг юм бэ? гайхаж байна. Бүхэл бүтэн Улсын Их Хурлын үйл ажиллагааг үр дүнгүй болгож байгаа байхгүй юу. Ийм байдлаараа бид хэд явж болохгүй. Би энэ хүнийг мэргэжлийнх нь хувьд дутуу ч юм уу муу гэж байгаа юм биш. Ийм ашиг сонирхлын зөрчилтэй бол болохгүй л байхгүй юу даа. Би Эмээлт аж үйлдвэрийн паркийг Дэлхийн банкнаас ТЭЗҮ нь хийгээд ирж байхад хүлээж авч байхад энэ З.Туяа архитекторыг мэдэж байна. Бид хэд бас шийдэл гаргах гээд танай муухай ажлыг бид нар Дэлхийн банктэй яаж хүлээж авах гэж байсан. Бөөн юм болж байс ч мэдэж байна. Протокол нь ч байж байгаа.

Тэгэхээр анхнаасаа энэ хэлэлцүүлгийн чинь шинжээчдийн багаас эхлээд ерөөсөө асуудлуудтай байна шүү гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлчихье. 2 дугаарт У.Баатар захирал бас нэг хэлж өгөөч. Тэр нь энэ Сэлбэ дэд төвийг чинь алдагдалтай болоод л бараг зогсоох гэж байгаа юм ярьж байна. Энэ зогсвол ер нь хэчнээн хүн ажлын байргүй болох вэ? Энгийг нэг бас хариулчхаарай. Энэ бол өөрөө өөрийнхөө өртгийг нөхнө. Энд нэг хэсэг залуучууд пи ар хийж байгаа юу? Бондын эргэн төлөлтийг татвар төлөгч төлөх гэж байна гэдэг мессежийг иргэдэд өгөөд байгаа юм. Үгүй ээ энгийг энэ бүтээн байгуулалт нь өөрөө өөрийнхөө өртгийг нөхөх юм байна гэж би ойлгож байгаа. Зөв үү? Энэ дээр тодорхой яг таг хариулаад өгөөч. 2 дугаарт энэ магадлалын асуудал байна. Түрүүн хэн гишүүн бас асуув. Барилга байгууламжийн магадлалыг 3 газар хийж байна. Барилгын хөгжлийн төв, Замын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв ер нь энэ магадлалын байгууллагыг ер нь цаашдаа нэгтгээд Ерөнхий сайдын дор нь өгвөл яадаг юм бэ? Ингээд юмаа хянаад явахгүй бол нэг ийм уялдаагүй ажилладаг ажлаа хийдэг нь ч мэдэгдэхгүй. Тэгээд ер нь чадав нь ямар байдаг юм? Барилгын хөгжлийн төв нь том юм уу эсвэл Замын хөгжил нь том юм уу гээд хэн асуув? Зөрөөд байвал хэний алийг нь барьдаг юм бэ гээд л асуугаад л байна. Тэгэхээр үүнийг хэн хариулах ёстой юм бол? Бодвол ЗГХЭГ-ын дарга уг нь энд хамрагдах ёстой эсвэл Барилгын яамнаас нэг ийм тодорхой байр сууриа хэлээч? Ер нь яах ёстой юм бэ? Энэ зүйлүүдийг чинь магадлаад явж байгаа хүмүүсээ дэмжиж зөв гэж үзэх юм уу? буруу гэж үзэх юм уу. Түрүүчээсээ зарим хүмүүс буруу гээд байгаа байхгүй юу. Ер нь аль институтын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөд цаашдаа явах ёстой юм. Иргэд олон нийтийг төөрөгдүүлээд байгаа энэ зүйлүүд дээр юу гэж бодож байна? Манай барилгын яамны хүмүүс байвал хэлээч. Манай хуульч гээд нэг залуу Усны тухай хууль ярьж байна. Тэгээд одоо энэ Эрдэнэбүрэний цахилгаан станц чинь Усны хууль зөрчөөд баригдаж байгаа гэж ойлгож болох уу? Энэ Завхан гол дээр баригдсан Гэгээн нуур үүсгэгчхээд байгаа төсөл чинь бас усны хууль тогтоомж зөрчсөн гээд баригдах уу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минут нэмж өгье.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Мэдээлэл өгчихье гэж байгаа юм. Тэр зөвшөөрлийг нь Байгаль орчны сайд, Барилгын сайд өгдөг байсныг л хуульд бид нар журмыг нь шигтгэж өгсөн. Тэр онцгой хамгаалалтын бүс дээр чинь гүүр тавьж байгаа чинь одоо усны хууль тогтоомж зөрчиж байгаа юм уу? Энэ сэргээгдэх эрчим хүчний УЦС-ууд барьж байгаа чинь зогсох ёстой юм уу? Тэгэхээр битгий дутуу судалсан юмаа ингэж чанга дуугаар худлаа яриач. Энэ усны хууль тогтоомж чинь одоо ч явж байгаа.

2 сайдын журмаар явдаг энэ зөвшөөрлийг л хуульд нь суулгаж өгч хууль зүйн үндэслэлтэй болгох энэ асуудлыг нь дээшлүүлж өгсөн болохоос биш огтоосоо хийгддэггүй зүйлийг яриагүй. Энэ УЦС бол баригдаж байгаа. Далан шуудуунууд баригдаж байгаа юм. Дээрээс нь энэ зам гүүрнүүд чинь усны онцгой шугамын хөндлөнд ч гэсэн тавигдаад явж байгаа. Тэгэхээр би бас ийм зүйлүүдийг битгий төөрөлдүүлээсэй. Энэ одоо инженерүүд чинь энэ асуудлуудын шийдлийг нь гаргаад явдаг байхгүй юу даа. Ингээд иргэд олон нийтийг буруу мэдээлэл өгөхөөр бас энэ асуудлууд чинь л үүсчихдэг. Тэгэхээр ийм....(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За тэгье. Эхний асуулт бас надтай холбоотой асуусан. Шинжээчдийг бид ажлын хэсгээрээ хэлэлцээд сонгоод гэрээ байгуулаад явсан. П.Сайнзориг гишүүн ажлын хэсгийн гишүүн. Ер нь бол би нэмээд хэлэхэд энэ хүмүүс чинь өөрсдөө мэргэжлийн хүмүүс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлээд тэрийгээ батлаад гарын үсэг зураад үүрэг хүлээгээд явж байгаа.

Малчин хүн малаа мэддэг, мэргэжлийн хүн мэргэжлийнхээ ажлыг мэддэг. Мэргэжлийн чиглэлээр ажиллаж байгаагүй хүн гэх юм бол энийг чинь ойлгох хүн байхгүй. Хуульч хүн хууль ярихаар зэрэг та хуулийн ашиг сонирхолтой гэж хэлж болохгүй. Эрдэмтэд инженерүүд энэ хүмүүсийг нэг бөөгнүүлж байгаад ямар нэгэн юм зөвтгөх болохоороо худлаа нэрийг нь ашигладаг эс үгүй бол эсрэгээрээ ингээд чи тэнд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн хүлэмжийн хийн ялгарлын тооцоог хийж байсан хүн байна. Энэ дэлхийн асуудлыг шийдэхэд оролцож болохгүй. Ингэж ярьж бол болохгүй. Ажлын хэсгийн гишүүний үүднээс үзэж байна. Дараагийн асуулт Сэлбэ дэд төвтэй холбоотойгоор 8 дугаар микрофон нээж өгнө үү.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Төслийн борлуулалтын орлогоороо бондынхоо мөнгийг төлөх бүрэн бололцоотой байгаа. 2 дугаарт мөн дутагдаж байгаа хөрөнгө оруулалтаа бид нар нөхөж байгаа борлуулалтын орлогоороо тийм учраас бол эрсдэлгүй гэж би хэлмээр байна. Яг одоогийн байдлаар 2 мянга гаруй ажиллах хүч төслийн талбай дээр ажиллаж байгаа. Үүн дээр бид нар нэмж тодотгож хэлэхэд гаднын хөрөнгө оруулалттай компанийн гэрээн дээр маш хатуу заалт оруулсан. Хуульдаа 20% хүртэл туслан гүйцэтгэгч авч болно гэдэг байдал бид нар 40% хүртлээ тавьж өгсөн. Өнөөдрийн байдлаар төслийн гүйцэтгэлийн нийт 80-аас дээш хувийг дотоодын ААН-үүд бэлтгэн нийлүүлэгч нар ажиллаж байгаа. Яг өнөөдрийн байдлаар 2100 орчим хүн ажиллаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмэлт хариулт Барилгын яамнаас бодлогын чанартай асуулт асуусан.

ХББОСЯ-ны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Магадлалын үйл ажиллагааг Засгийн газрын 51 дүгээр тогтоол мөн 2019 оны 108 дугаар

тогтоолын хүрээнд магадлалын үйл ажиллагааг Барилгын Хөгжлийн Төв дээр бол хариуцаж явуулж байгаа. Манайх Барилгын хуулийн шинэчилсэн найруулга бодлогын хүрээнд мөн одоо энэ магадлалын үйл ажиллагааг магадлалын нэгдсэн дүгнэлтийг байхгүй болгоод экспертүүд өөр өөрсдийн хүрээнд магадлалынхаа үйл ажиллагааг хариуцдаг зохицуулалтыг оруулж байгаа. Барилгын хөгжлийн төв дээр явж байгаа одоогийн процесс бол Барилгын хөгжлийн төв магадлалын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа. Экспертүүд бол өөр өөрсдийн мэргэжлийн чиглэлээр экспертийн дүгнэлтээ гаргаад явдаг ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр хууль эрх зүйн орчныг шинэчлэх хүрээнд бол би....(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Энэ 3 магадлалын төв нэг байх ёстой юм уу? Хоорондоо яаж уялдаатай итгэл төрүүлэхгүй байна гэж байна. Нэмж хариулъя.

ХББОСЯ-ны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр: Манай Барилгын хөгжлийн төв дээр барилга байгууламж дээр бол магадлалын үйл ажиллагаа явуулна. Замын хөгжлийн төв маань зам гүүрэн байгууламжийн зураг төсөл дээр бол магадлалын үйл ажиллагаа явуулж байгаа. Мөн Эрчим хүчний хөгжлийн төв дээр бол эрчим хүчний шугам сүлжээний зураг төсөл дээр магадлалын үйл ажиллагаа явуулж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За дараагийн Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү.

УИХ-ын гишүүн Ц.Баатархүү: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны түрүүнд хот суурин газрын засаглалыг зайлшгүй эргэж харахгүй бол болохгүй юм байна гэдэг ойлголтыг бүгд авч байна. Энэ сонсгол өөрөө сонсоод өнгөрөх биш үр дүнтэй байх ёстой. Тэгэхээр Улсын Их Хурал бол хот суурин газар тэр дундаа нийслэл Улаанбаатар хотын энэ засаглалыг бол эргэж харах зайлшгүй шаардлага үүссэн байна. Иргэдийн өмнөөс хяналт тавих ёстой иргэдийн хурлын төлөөлөгчид бол Засаг даргын үйл ажиллагааг хянах биш Засаг даргын хармаанд нь орчихсон. Ингээд ажилтан нь болчихоор засаглалын хямрал үүсээд байна. Тэгэхээр бид нэгжийн хууль дээр нэг бол энэ НИТХ-ын төлөөлөгч нарыг давхар ажил хийлгэхгүй байх эсвэл НЗД-ыг нийслэлчүүдээс өөрсдөөр нь сонгуулдаг байх гэсэн хувилбарыг бодохгүй бол Засаг дарга болсон хүн болгон өөрийн гэсэн ийм төслийг лоббиддог.

Бизнесийн ашиг сонирхлын, улс төр бизнесийн бүлэглэлийн ийм лобби болж хувирсан. 2015 онд Улсын Их Хурал дээр Азийн хөгжлийн банкны төсөл зээлийн хэлэлцээр байгуулсан. Тэр бол Монгол Улсын түгжрэлийг бууруулахад, Улаанбаатарын түгжрэлийг бууруулахад бол Би Ар Ти төсөл бол хамгийн оновчтой юм байна гэсэн. Засаг дарга солигдох болгонд түгжрэл нэрээр нэг төсөл гарч ирсэн. Энэ Францын зээлээр дүүжин тээвэр гээд нийтийн тээврийн төрөлд ордоггүй. Аялал жуулчлалын шинжтэй зүйлийг Засаг дарга дараагийн Засаг дарга лоббидсон. Төслийн нэгж байгуулсан. Одоо болтол ашиглалтад ороогүй татвар төлөгчдийн мөнгөөр зээл болон зээлийн хүү төлж байгаа. Одоо нэмээд ерөөсөө энэ түгжрэлийг бууруулна гэдгээр бизнес хийдэг болсон. Хамгийн үр дүнтэй эдийн засгийн ачаалал бага авах Монгол Улсад байж болох шийдэж болох нь бол тусгай замын автобус мөн гээд мэргэжлийн байгууллага дүгнэчхээд байхад 7 янзын төслийг лоббидож оруулж ирсэн.

Энэ төслийнх нь 70% нь зээлээр. Тэгэхээр Монгол Улс бол зээлээр хөгжил худалдаж авдаг, зээлээр хөгждөг энэ сэтгэлгээнээсээ салах хэрэгтэй. 3 дугаарт нь

энэ ТЭЗҮ нь өөрөө үнэхээр шинжлэх ухааны үндэстэй юм уу, үгүй юм уу, мэргэжлийн юм уу, үгүй юм уу гэдгийг нь шалгадаг хянадаг газар байхгүй болсон. ТЭЗҮ гэдэг нэг юм яриад ТЭЗҮ-д өөрчлөлт оруулж байна гэдэг нэг зүйл яриад төсөвт өртгийг нэмдэг болж байна.

Хамгийн сүүлд нь энэ Монгол Улсад Засгийн газар гэж байна уу? Яахаараа энэ Зам, тээврийн яам өөрөө Монгол Улсын авто замыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө батлаад нийслэл Улаанбаатар хотод бол Би Ар Ти эсвэл өөр ямар нэгэн шийдэл хэрэгтэй гээд явахгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ц.Баатархүү гишүүний микрофоныг нэмж өгье.

УИХ-ын гишүүн Ц.Баатархүү: Бодлого байхгүй байгаагийн илрэл юм. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монгол Улсад энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийг ямар зарчмаар явуулах юм бэ гэдэг бодлого байхгүй байна. Нүдэн дээр нь нүүрэн дээр нь алдаатай төслүүд хэрэгжиж байхад дув дуугүй байсан. Өнөөдрийн танилцуулга дээр энэ яамдын ТНБД нар маш бөөрөнхий, тодорхой шийдэлгүй, мэргэжлийн биш дүгнэлтүүдийг уншиж байна. Ийм хариуцлагагүй болохоор энэ улс орон чинь хариуцлага гэдэг зүйлийг бүгд нэхээд байна. Засгийн газрын түвшинд хууль хэрэгжихгүй байна. Худалдан авах ажиллагааны тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бүх хууль зөрчигдөөд байхад хуулийг зөрчөөд байхад ямар ч арга хэмжээ авдаггүй. Тийм учраас Улсын Их Хурлын дэгийн хуульд өөрчлөлт оруулж энэ хяналтын сонсголын дараа үр дүнгийн сонсголыг бол.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүн нийтдээ 15 минут байгаа шүү. Асуулт нь эхлээд асуултад хариу авах уу? Гишүүн нэг микрофон нээж өгье. Ц.Баатархүү гишүүн.

УИХ-ын гишүүн Ц.Баатархүү: Тэгэхээр бид нар нэгжийн хуулийг анхааръя. 2 дугаарт энэ сонсголын араас Хянан шалгах түр хороо үр дүнгийн сонсголыг зохион байгуулъя. Маргааш Улсын Их Хурлаар Улсын Их Хурлын хуулийн нэмэлт өөрчлөлт дээр үүнийг ярих ёстой. Иргэд юу ярьж байна вэ гэхээр энд хэн нэгнийг буруутгаж цоллохоос илүү цаашид хуулийн хулгай, хуулийн цоорхой ашигласан төсвийн хулгай гаргахгүй байх тал дээр Улсын Их Хурлыг илүү анхааралтай илүү хариуцлагатай бай гэдэг ийм шаардлагыг хэлж байна.

3 дугаарт Улаанбаатар хотын энэ засаглалын асуудлыг нэг мөсөн шийдэх ёстой. Бүх улс төрийн намууд Улаанбаатар хотын захирагчийг иргэдээс сонгоно гэж мөрийн хөтөлбөрт орсон. Үүнийгээ бид нар хийх ёстой юм байна. Тэгэхгүй бол тэнд 2016 онд 800 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан Улаанбаатар хот өнөөдөр 11 их наядын төсөвтэй 500 сая ам.долларын хүүтэй бонд авсан, 500 сая ам.долларын бонд гаргасан гадаадаас авсан.

Гадаадад бонд гаргаад нэг ч ажил нь явдаггүй. Тэгээд одоо энэ сонсголын араас болох ажлууд нь юу юм болохгүй ажил нь юу юм эрэмбэлээд ямар ажил дээр ямар хуулийн хариуцлагын алдаа гарч байгаа юм бэ? гэдгийг нэг мөсөн шийдэж үр дүн гаргахгүй бол болохгүй юм байна гэсэн. Ийм дүгнэлтэд хүрч байна.

Тэгээд хамгийн сүүлд энэ яамдууд үнэхээр хариуцлагагүй байна. 7 төслийг 70%-ийг нь зээлээр авчихсан. Дуртай нь орж ирээд түгжрэл бууруулна гээд төсөл санал болгодог мэргэжлийн байгууллага байдаггүй энэ салбарын стратеги

төлөвлөгөө гэж байдаггүй. Тэр дундаа энэ Зам тээврийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам бол “чих нь дүлий нүдээ тагласан” байдлаар явж байгаад ийм байдалд хүрсэн шүү гэдгийг хэлье. Энэ дээр их анхаарах ёстой шүү л гэдэг. Ийм санал хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ц.Баатархүү гишүүн их чухал саналууд хэллээ. Сонсголын үр дүнд санал, дүгнэлт боловсруулна. Санал дүгнэлтээ холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлнэ. Тэгээд шаардлагатай гэж дүгнэвэл Улсын Их Хурал руу орно. Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр.

УИХ-ын гишүүн П.Наранбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн сонсгол бол Монгол Улс ардчилалтай байгааг илэрхийлж байгаа сонсгол гэж харж байгаа. Иргэдийн төлөөлөгч иргэд нь өөрсдөө ирээд суучихсан. Би бүгдийг нь сонслоо. Маш их тийм ойлгомжтой хэлэх санаагаа маш сайн бодож ирсэн. Энэ үгийг бид сонсох ёстой. Нөгөө талдаа Улсын Их Хурлын гишүүд нь нийслэлийн болоод холбогдох улсууд бүгд ирчихсэн байна. Ингээд ярилцаж байгаа нь бол сайн хэрэг гэж харж байна. Энэ бол Монгол Улс ардчиллаа хэрэгжүүлж байгаа, ардчиллаа хэрэглэж байгаа нэг жишээ гэж харж байна. Гэхдээ нөгөө талдаа эзэд нь алга. Нийслэл талаас эзэд нь байхгүй байна шүү дээ. Нэг нь ч алга. Хэрэгжүүлсэн улсууд нь ингээд зогсож байдаг. Үгүй ээ тэр шийдвэрийг гаргасан эзэд нь хаа байна гэдэг асуудал байгаад байгаа юм. Одоо энд байгаа төрийн албан хаагчдыг би бол буруутгах бодол алга.

Яагаад вэ гэвэл энэ хүмүүс бол ажлаа хийсэн байгаа юм. Ерөөсөө л тендерийн асуудлыг ярихад ч гэсэн. Жишээлбэл, Засгийн газар дотроо Сангийн яам бүх тендерийн, бүх үе шат дээр нь бүгдийг нь хянаад л явдаг шүү дээ. Санхүүжилтийг олгох эсэхийг эцсийн шатад тэд шийддэг. Хариуцлага болохоор зугтчихдаг ийм нөхцөл байдал байгааг бол хэлэх ёстой. Гэхдээ нийслэлд асуудал байна. 2-3 асуудлыг би хөндөж ярья гэж бодож байна.

1 дүгээрт ер нь нийслэл яг энэ түгжрэлийг тайлъя, утааг арилгая л гэж явсан шүү дээ. Тэгэхдээ тэрний ард шийдэхдээ дандаа төр өөрөө шийднэ, нийслэл өөрөө шийднэ, утааны байцаагчдыг бий болгоно энэ тэр гээд хувийн хэвшлийн оролцоог бүгдийг нь халж хаясан. Утааг арилгахдаа яасныг Та бүхэн мэдэж байгаа шүү дээ.

Урьд нь янз бүрийн хувилбартай түлшнүүд хийж байсан бүгдийг нь хааж хаяад зөвхөн өөрсдөө үйлдвэрлэнэ гээд. Тэгээд өнөөдөр хашаанд нь хүртэл бараг тэр сайжруулсан түлшийг хүргэж өгдөг. Нийслэл бараг 40 тэрбум төгрөгийг зөвхөн зөөвөрлөхөд, тээвэрлэхэд хэрэглэдэг болсон. Хашаанд нь сайжруулсан түлшийг хүргэж өгч байгаа ийм л нөхцөл байдал руу аваачсан. Түгжрэлийг бууруулъя гээд л явсан. Яг үр дүнд нь өнөөдөр юу харж байна гэхээр түгжрэл нь огт буураагүй дундаж хурд нь 10-хан километр цагийн хурдтай тэгээд энийгээ 12км болговол бүүр их мөнгө хэрэгтэй гээд ингээд сууж байгаа ийм нөхцөл байдалтай тулчхаад байгаа нь үнэн байна. Тэгээд энэнтэй холбоотойгоор би бас ганц 2 зүйлийг бас асууя гэж бодож байгаа. 1 дүгээрт бол энэ их том ийм мега төсөл яриад ирэхээр бид хажуугаар нь жижиг төслүүдийг мартдаг юм байна. Одоо жишээлбэл Ар Эф Ай Ди гэдэг энэ төсөл байна. Радио Фрикюнси Айдентификэйшн гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл радио долгионоор нь тэр машин хаана явж байгааг мэдрээд тэгээд аль жанкшн буюу аль уулзвар дээр нь хэдэн төгрөгийн...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Наранбаяр гишүүний микрофоныг нээе.

УИХ-ын гишүүн П.Наранбаяр: Тэгэхээр Ар Эф Ай Ди буюу радио долгионоор нь Улаанбаатарт зорчиж байгаа бүх машиныг мэдрээд хаанаас нь хэдэн төгрөгөө авах юм бэ гэсэн энэ шийдвэрээ гаргана гээд нийслэл 2023 оноос явсныг би сайн мэдэж байна. Тэнд 22,3 тэрбум төгрөгийг зарцуулсан боловч нэг ч төгрөг яг одоо бодитой бол хэрэгжээгүй байна. Бид Туулын хурдны зам, Сэлбэ дэд хотхон гэж ярьж байх энэ завсарт энд ийм магадгүй хулгай гэж хэлж болохуйц ийм зүйл гарчихсан. 22,3 тэрбум төгрөг салхинд хийсэн хүмүүсийн Та бүхэн санаж байвал урд талын шилэн дээр нь нэг ийм нарийхан ийм мэдрэгч гээд юм зоож байсан нааж байсан юу ч хэрэгжээгүй. Тэр мөнгө хаана байна одоо хэн хэрэгжүүлээд байгаа юм. Тухайн үед бол Батзориг гэдэг одоо НИТХ-д сууж байгаа хүн энэ асуудлыг хариуцаж байгаа гээд л явж байсан. Энэ одоо хаана байна. Ийм байдлаар зувчуулсан, хэрэглэсэн, хэрэгжүүлээгүй хаячихсан ийм санхүүгийн ямар ч утгагүй ажлууд бол зөндөө явсан.

Дараа нь бол НЗД нь гарч ирээд үгүй ээ бид одоо өнөөдөр ухаалаг камераар бүгдийг хянаж байгаа учраас наад нэг Ар Эф Ай Ди чинь хэрэггүй гэж ярьж эхэлсэн. Гэтэл 22,3 тэрбум яваад өгсөн. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь хяналтаас гарлаа шүү гэдэг юм яриад байна. Иргэд яриад байгаа нь бас ийм зүйлийг хэлээд байна шүү дээ. Одоо яамдыг бүгдийг нь боомилсон Хэмнэлтийн хууль гээд байгаа. 5 сарын 31 гэхэд тендерийг нь бүгдийг нь байхгүй болгодог. Орон нутагтай очоод уулзахад үгүй ядахдаа ТЭЗҮ ч юм уу эсвэл зураг төсвийг нь үлдээж болдоггүй юм уу л гэсэн юм ярьж байгаа.

Би сая Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбаттай уулзаад ирсэн. Тэгэхэд тэрийг ярьж байна. Нийслэл дангаараа энэ хэмнэлтийн хуулийг огт хэрэглэхгүйгээр 80 гаран ААН байгуулаад л явж байна. Тэгээд Говь-Алтай аймагт өнөөдөр цахилгаан станцыг нь санхүүжүүлнэ гэсэн ийм юм яриад явж байна. Нөхцөл байдал ийм болтол нь яагаад бид муутгачихсан юм бэ? Үүний ард нь 45 төлөөлөгчийн 40 нь МАН-аас дангаараа гарч ирсэн. Сөрөг хүчний ямар ч хяналт байгаагүй тэр НИТХ дээр 5 гишүүн төлөөлөгч юу хийсэн юм гэдгийг би сайн мэдэхгүй байна. Ийм нөхцөл байдал дунд найрлаж болдог юм байна. Би сая сонгуулийн 2024 оны ирцийг харлаа 42%-тай л байна. 60% нь ирж саналаа өгөөгүй. Ийм нөхцөл байдал дунд мажоритар тогтолцоогоор өнөөдөр энэ бүх нөхцөл байдлыг бий болгосон ийм тогтолцооны шинжтэй бас алдаа байгааг хэлээд байгаа юм. Юутай ч гэсэн тэр Ар Эф Ай Ди-тай холбоотой хариулт....(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За Ар Эф Ай Ди-тай холбоотой хариулт Нийслэлээс өгье. 5 номерын микрофон нээж өгье.

НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар: П.Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар. Дэд бүтэц уншигч буюу төхөөрөмжийн сүлжээ ажиллахад бэлэн болсон. Системийн хөгжүүлэлт нь Зам тээврийн яаман дээр явж байгаа юм байна. Засгийн газрын тогтоолоор систем хөгжүүлэх ажилд оруулахыг Түгжрэлийн сайд, Зам тээврийн сайд нарт даалгасан. Ийм Засгийн газрын тогтоолоор Зам тээврийн яаман дээр систем хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаа юм байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Зам тээврийн яам хариулах боломжтой гэж үзэж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Зам, тээврийн яамнаас 13 номерын микрофон дээр хариулъя.

ЗТЯ-ны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа: Зам тээврийн яам Замын бодлого зохицуулалтын газар Ч.Сугармаа. Яг энэ Ар эф ай ди-ийн наалттай холбоотой асуудал бол манай Тээврийн газар дээр явагдаж байгаа. Авто замын газар дээр бол мэдээлэл байхгүй байна. Тийм болохоор мэдээллийг нягталж эргэж мэдүүлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Наранбаяр гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн П.Наранбаяр: За баярлалаа. Тэгэхээр ийм том, том асуудлын хажуугаар үүнийгээ бид мартаж болохгүй. 22,3 тэрбум төгрөг чинь цаас болоод салхинд хийсчхээд байна. Тэгэхэд бид мэдэхгүй наадах чинь тээврийн газрынх мэднэ, нийслэл нь болохоороо Зам тээврийн яам нь мэднэ гээд. Бид бол энэ хариуцлагыг эцсийн нэг төгрөг хүртэл татвар төлөгчийн мөнгө хаашаага зарцуулагдсан юм бэ гэдгийг мэдэх эрхтэй улсууд. Хариуцлагыг нь бид нэхэх ёстой улсууд энийг нэхэхгүй бол бид энд суугаад яах юм тийм биз? Ийм нөхцөл байдалтай ингэж сууж байгааг харахад бол харамсаж байна. Тэгээд миний бас нэг асуултад хариулсангүй. 80 гаруй ААН-ийг хэмнэлтийн хуулийг зөрчөөд яахаараа байгуулдаг юм янз янзын корпорацууд байгуулаад хаячихсан юу гэсэн үг юм.

Энэ ямар хуулийг нийслэл ашиглаад ийм юм хийчхэж байгаа юм. Өнөөдөр тэр төсвийн тогтвортой байдлын тайланг харахад бол яг хэлээд байна. Монгол Улс нэгдсэн төсөвтэй гэтэл энд чинь ингээд Монгол Улсыг өөрийг нь эрсдэлд оруулах ийм их хэмжээний төсвүүдийг ярьчихсан байна гээд.

Засгийн газар 14 мега төсөл ярьж эхэлсэн нь үнэн. Тоогоор хөөцөлдөж байгаа юм шиг нийслэл 24 мега төсөл болгож оруулж ирсэн шүү дээ. Тэгээд тэр цаана нь бараг Монгол Улсын нийт ДНБ-тэй тэнцэх хэмжээний мөнгийг ярьж эхэлсэн. Эцэст нь юу болсон бэ гэвэл Монгол Улс өнөөдөр Хятадын хойд муж шиг ажиллаж эхэлсэн. Өнөөдөр харин ярьж байна. Тэр Сэлбэ хотхоныхон тэрийг барьж байгаа улсууд нь бол яах вэ? Сүүлд бид эсэргүүцлээ илэрхийлж байж орж ирсэн гээд энэ чинь энэ нутагтаа эзэд нь хэн юм? Энэ асуудлыг хөндөж байгаа олон хүнтэй би бол санал нэг байна.

Тэгэхээр энэ Ар Эф Ай Ди-гийн талаар ер нь тусгайлан Ерөнхий хяналтын сонсгол цааш нь явуулах ёстой. Ингэж нуугдсан төслүүд олон төслүүд бий. Том төслийн хуруун завсар нь хавчуулагдсан ийм олон төсөл бий. Энэ дээр нь бол НИТХ-ын төлөөлөгч нар нь хүртэл оролцчихсон байгаа. Ийм учраас бид НИТХ-ын төлөөлөгч гэдэг хүн иргэдийнхээ төлөөлөгчийг л хийх ёстой. Цалин мөнгөө аваад явж болно. Үйл ажиллагааны зардлыг аваад явж болно. Тэрийгээ яг хууль ёсны дагуу өнөөдөр үйл ажиллагаа явуулах бүх боломжоор хангагдах ёстой. Нөгөө талдаа захиргааны албыг, агентлагийн дарга нарыг хашихгүйгээр захиргааны талын Засаг даргынхаа үйл ажиллагааг хянах иргэдийнхээ дуу хоолой болох ажлыг хийх ёстой гэж бодож байгаа юм. Ийм учраас энэ Ар Эф ай ди дээр ийм үлбэгэр хариултыг би авмааргүй байна. Хариуцсан улсуудыг дуудаж асуулгах ёстой. 22,3 тэрбум төгрөгийг салхинд хийсгэчхээд сууж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэр нийслэлээс олон тооны аж ахуйн нэгж компаниуд нэмж байгуулсан талаараа ер нь ямархуу бодлого юу явж байгаа талаар нийслэлээс хариулах уу? НИТХ-аас үүсгэн байгуулж байгаа байх аа? Хурлын дарга бол байхгүй байгаа. Хэн хариулах вэ? Ямар хуулиар ямар үндэслэлээр 80-аад компани байгуулсан бэ? НИТХ-аас хэн байгаа билээ? М.Халтар

дарга 7 дугаар микрофон.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар: Эрхэм гишүүний асуултад хариулт өгье. НИТХ-аас байгуулсан энэ төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанитай холбоотой мэдээлэл бол яг одоо гар дээр бэлэн биш байна. Тэгэхээр танд эргээд маргааш гэхэд бол энэ мэдээллийг гарган хүргүүлж өгье. Энэ бол бас Нийслэлийн Өмчийн харилцааны газар. НЗДТГ бас холбогдох газруудаас бол бид нар мэдээллийг авах ёстой байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 8 номер дээр нэмж хэлнэ.

НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах: Нийслэлийн өмчит орон нутгийн өмчит ААН-үүдийн тоо бол ОНӨТҮГ бол 26 байна ХК болон ХК бол 17 нийтдээ бол 43 өмчит компани байгаа. Энэ шинжээчид бол 80 гэдэг нь ташаа мэдээлэл гарсан байна. Нэгжийн тухай хууль дээр 18.2-т бол аймаг, нийслэлээс сум, дүүрэг бол хуулиар олгосон чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит этгээд бол байгуулж болно гээд заагаад өгчихсөн байдаг. 2024-2026 он дээр нийслэл хотод бол 5 ААН-үүдийг татан буулгасан. Шинээр нэмэгдсэн орон нутгийн өмчит бол 8 ХХК байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Энэ 80 гэдэг тоог шинжээч биш УБЕГ-аас ирсэн тоо шүү. П.Наранбаяр гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн П.Наранбаяр: Ингээд энд бол гөлөг төөрүүлж байгаа юм шиг тоон дээр ярьж эхэлж байна. Энэ 43, 80 энэ чинь төрийн алба бүгд сонсож байгаа шүү дээ. Энэ бол яг хуультай явах ёстой. Монгол Улсад хуулиас гадуур хэн ч байхгүй. Тэгэхээр зэрэг энэ тоогоо Та бүхэн энд хэлсэн энэ тоон дээрээ хариуцлага хүлээнэ шүү. Бид Улсын бүртгэлээс авсан тоог шинжээч нарын бас дурдсан тоог хэлээд байгаа юм.

2 дугаарт яахаараа нийслэл л нийслэлээсээ даваад үйл ажиллагаагаа явуулаад эхлэв? Орон нутаг руу энд тэнд хөрөнгө оруулаад эхэлсэн хувийн ААН байсан бол ойлгоно. Тэнд байвал цахилгаан станц барихад нь тусалъя ч гэдэг юм уу яахаараа даваад үйл ажиллагаа явуулдаг юм. Улаанбаатар хот чинь өөрийн гэсэн хилийн цэстэй. Орон нутгийн бие даасан байдал гэдэг чинь Үндсэн хуультай яахаараа Та бүхэн давсан үйл ажиллагаа явуулдаг юм энийг би асуугаад байгаа юм юу гэсэн үг юм энэ чинь. Энэ хуультай юм бол энэ хуулиа барь.

Цаашдаа бид ингээд асуудал дэлгэгдээд ирэх тусам олон зүйл байна. Түрүүнд бас зарим гишүүд хэлж байна. Ер нь бол энэ орон нутгийн бие даасан байдал чинь юу юм бэ гэж. Би өөрөө нийслэлд төлөөлөгч байсан хүний хувьд бол орон нутгийн бие даасан байдлын төлөө зогсдог хүн. Гэтэл үүнийг хязгаарлахаас өөр аргагүй байдал руу оруулж байна гэдэг бол аюултай. Монгол Улс бол холбооны улс биш. Монгол Улс бол өнөөдөр унитар улс. Нэгдмэл 1 төсөвтэй төсөв нь ердөө 5 л хуваагддаг. Гэтэл ингээд хөрөнгө оруулалт шийдээд явдаг ийм хачин нөхцөл байдал руу оруулж байдаг энийг бол хүлээн зөвшөөрөхгүй. Таны та харин хэлсэн сая тоондоо хариуцлага хүлээнэ шүү. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Наранбаяр гишүүн түрүүн тэр Ар Эф Ай Ди-ийн талаар асуусан. Тэр бол шаардлагагүй болоод хэрэггүй болчихсон гэж хэлсэн шүү. Засаг дарга хэллээ тийм ээ? Тэгээд оронд нь камер

зөндөө байгаа гэж ярьсан. Камер болоод мэдээллийн технологийн талаар Инновац, цахим бодлогын дэд хороо дээр бид нар сонссон. Одоо эргээд санахад 235 тэрбум төгрөг санагдаж байна. Сүүлийн 4 жилийн хөрөнгө оруулалтын 200 ерөөсөө 90% нь сүүлийн 2 жилд зарцуулагдсан. Үүн дээр тэгээд ихэвчлэн камер болон IT-ийн хөрөнгө оруулалт байгаа. Тэгэхээр яагаад энийг ярьсан бэ гэвэл ерөөсөө Монгол Улс энэ салбарт хэдийг зарцуулаад байгаа юм бэ гэдгийг сүүлийн 2 жил нэхэж байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд нь нийслэл мэдээлэл оруулж ирсэн саяхан бас энэ тусгай байгууллагуудаас мэдээлэл авч байх жишээтэй. Тэгэхээр бид нар ер нь хаана хэдэн төгрөгөөр юу хийгээд хэдийг нь хаяад байна гэдгийг ойлгох хэрэгтэй.

Тэр бол аягүй том бас чухал дүгнэлт хийж байх ёстой ийм асуудал гэдгийг нэмж дурдъя. Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан сайд утсаар ярьсан. Дорноговь аймагт эрчим хүчний ажлаар, ТНБД болохоор Өвөрхангай аймагт чухал ажлаар яаралтай дуудагдаад явцгаасан учраас Зам, тээврийн яамны газрын дарга болон бусад төлөөллүүд оролцож байгаа гэдэг мэдээлэл өглөө. Бидний танилцуулгын үндсэн сэдвийн хүрээнд танилцуулга хийж чадсангүй, бэлдээгүй юм байна гэж ойлголоо. Энэ энэ тал дээр бол ажлын хэсэг дээр бол мэдээлэл өгнө гэсэн байна.

Хамгийн гол нь энэ чинь нөгөө ажлын хэсэг биш үзэж байгаа хүмүүст мэдээлэл өгөх хэрэгтэй байгаа шүү дээ. Тэгэхээр тэрийг одоо дараа нь нөхөж өгөх нь гэж. Оролцогч нартаа анхааруулахад бид нар дэгтэй, соёлтой хоорондоо харьцах хэрэгтэй. Түрүүн бол ингээд асуудлууд гарна, уур бухимдал төрнө, эмоци явна. Тэгэхдээ ямар нэгэн байдлаар хараал ерөөл хэлж ялангуяа Улсын Их Хурлын гишүүд рүү болон оролцогч руу төрийн албаныхан руу хандсан нэг нэгэндээ хараал хэлсэн тийм зүй бус харьцаагаар харьцахгүй байхыг нийтэд нь нэг анхааруулъя. Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: За гээд сонсоод байх тусам улам л маргаантай, улам л асуудалтай. Ер нь энэ нийслэл чинь сүйрчихсэн байсан юм биш үү. Энэ том 2,3 их наядын дүнтэй төсөл нь ийм байгаа юм чинь 200 тэрбум, 2 тэрбум, 200 сая төгрөгийн энэ төслүүд нь юу болж байгаа юм бол гэхээс бүр аймшигтай санагдаж байна. Яг үнэндээ тэр бол ерөөсөө ямар ч хяналтгүй явдаг юм байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Тэгээд Үндэсний Аудитын газраас асууя. Энд жишээлбэл гуравхан сарын дотор 900 гаруй тэрбум төгрөгөө 1,9 их наяд болгочихсон байгаа юм. Тэгээд энд бол ямар ч магадлал хийгдээгүй гээд биччихсэн байгаад байгаа юм. Өчигдрийн танилцуулга дээр гарч байсан. Би буруу санаагүй бол бараг 1,5 их наяд орчим төгрөгийн зураг төсөвгүй магадлал хийлгээгүй 75 орчим төсөл арга хэмжээг эхлүүлсэн байна гэсэн байсан. Аль байгууллагынх дээр байна. Тэгэхээр ийм зураг төсөвгүй, магадлал хийлгээгүй төслүүдийг өмнө нь хэр их хэрэгжүүлдэг байсан юм бол? Тэгээд хэрэгжүүлэх болгонд нь Та бүгдийн зүгээс зөрчилд тооцож тэгээд энийг нь болиулах арга хэмжээ одоо авдаг юм уу? авдаггүй юм уу? Ер нь яах ёстой юм бэ? Энэ Улсын Их Хурал дээр ч гэсэн байнгын ийм явдаг байсан, харин ч бас ч гэж одоо жил ирэх тусам гайгүй болж байна уу гэж харагдаж байгаа. Гэтэл нийслэл бол яг тэр чигээрээ байгаа юм байна. Тэгээд төсөвт өртөг нэмэгдэх асуудал энэ дээр бол бүүр гамшиг юм шиг байна. Үгүй ээ, аргагүй шүү дээ. Зураг төсөвгүй юун дээр үндэслэж дүн тавиад байгаа нь тодорхойгүй магадлал хийлгээгүй байна гэдэг чинь. Тэгэхээр энэ дээр та нэг хариу өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хэн хариулах вэ? 15 дугаар микрофоныг нээж өгнө үү?

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Ж.Баярмаа гишүүний

асуултад хариулъя. Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн. Бид нар сэдвээр гүйцэтгэлийн аудит хийгээд одоо 6 сарын 30-нд эцэслэж тайлангаа бол Төсвийн байнгын хороо холбогдох байгууллагуудад өгнө. За одоо яг бол асуудлын бүртгэлд танилцуулагдаад шийдлүүдийн шийдэл танилцуулагдаад шалгагдагч байгууллагаас санал тайлбараа аваад явж байгаа. Дээр нь бид нар холбогдох асуудлуудыг хууль хяналтын байгууллагатай хамтраад мэдээлэл өгөөд хамтарч ажиллаж байгаа. Саяын магадлалтай холбогдуулаад өмнө нь ч гишүүд бас асуусан юм байна лээ.

Энэ эхний магадлал 2016 оны 5 сарын 18-нд 594,8 тэрбум төгрөгөөр Зам тээврийн хөгжлийн төвөөс магадалсан. Дараа нь 2024 онд 916,3 тэрбум төгрөгөөр мөн одоо тодотгож магадлалыг Зам тээврийн хөгжлийн төвөөс хийсэн. Ингэж явж байгаад 1,9 тэрбум төгрөг болох буюу 2025 онд бол Зам тээврийн хөгжлийн сайд, НЗД-ын хамтарсан энэ нэг шийдвэрээр дээр ийм 1,9 их наяд гэсэн төгрөгийн төсөвт өртөг гарч ирсэн. Энэ бол магадлагдаагүй байсан. Энэ талаар бид нар холбогдогч байгууллагуудаас тайлбар одоогоор аваагүй тайлбар ирүүлээч гээд сууж байгаа. Хамгийн сүүлд 2025 онд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай ийм тушаал гараад 2,3 их наяд төгрөг болгож магадалсан байна лээ.

Магадлахдаа Зам, тээврийн сайдын 2011 оны хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх журам гэж байдаг. Энэ журмыг бариад ТЭЗҮ, урьдчилсан зураг, төсөвт магадлал хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг гэж байгуулсан байна лээ. Тэгэхээр эндээс бид нар юу гэж дүгнэсэн бэ? гэвэл энэ урьдчилсан зураг төсөв гэдэг ойлголт бол зөвхөн төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр байдаг төсөл хэрэгжүүлэхэд тавих шаардлага дээр түншлэлийн төслийн урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ гэсэн ийм томъёолол нэр томъёо байдаг. Энэ хүрээнд концесс түншлэлийн хүрээнд энэ асуудал анх санаачлагдаж явсан юм билээ. Сүүлдээ нийслэлийн төсвөөс шийдэгдэхээр гараад явчихсан. Манай эцэслэсэн дүгнэлт гараагүй ч гэсэн урьдчилсан байдлаар танилцуулагдсан байгаа.

Нэг дүгнэлт хэлэхэд төслийн ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл, төсөвт магадлал хийсэн нь хууль тогтоомжид нийцээгүй чиг үүргийн давхардал ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож салбар хоорондын уялдаа холбоо хангагдаагүй төслийн нарийвчилсан тоо хэмжээнд зөрөө үүсэх төсөвт өртөгт...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гүйцээж хариулъя.

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Төслийн нарийвчилсан тоо хэмжээнд зөрүү үүсэх төсөвт өртөгт өөрчлөлт орох хяналт хариуцлагын тогтолцоо алдсан байна. Бид 2 сайдад урьдчилсан байдлаар 2 зөвлөмж өгөхөөр бэлдсэн. Нэгийг нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад магадлалын ерөнхий дүгнэлт барилгын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоонд туссан зарим ажилд төсвийн эксперт магадлал хийгээгүй байхад баталгаажуулсан хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх гэсэн байдлаар урьдчилсан байдлаар бид нар асуудлын бүртгэлд танилцуулсан байгаа.

Зам тээврийн сайдад төсөл арга хэмжээний ТЭЗҮ зураг төсөлд магадлал хий гэдэг чиглэлийг нь өгөөд хийхдээ салбарын хууль тогтоомж норм стандартад нийцүүлж нарийвчилсан зураг төсөлд магадлал хийх гэдэг ийм урьдчилсан байдлаар бид асуудлыг тавьсан байгаа. Ер нь бол Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зам замын авто замын тухай хуулийн энэ зураг төсөл гэдэг

ойлголтууд зөрөөтэй. Дээр нь ТЭЗҮ-ийн талаар нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс болоод энэ ТЭЗҮ-тэй холбоотой...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Баярмаа гишүүний микрофон өгье.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Та сая магадлал хийлгэсэн дээр хүртэл асуудал байна гэж унших шиг боллоо гэж ойлголоо. Тийм үү? Тоо нь зөрөөтэй. Энэ аль магадлал вэ? Аль дээр хийсэн тэр 2,3 их наяд дээр хийсэн магадлалыг хэлж байна уу үгүй юу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 15 номерын микрофоныг нээе.

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Тодруулаад хариулъя. Хамгийн сүүлд 2025 онд хийсэн энэ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар баталсан орон тооны бус экспертүүдийн ажлын хэсгийн энэ магадлал хийсэн байдал дээр бид нар саяын дүгнэлтийг гаргасан. Өөрөөр хэлбэл төсвийн эксперт магадлал хийгээгүй байхад баталгаажуулжээ гэсэн дүгнэлтийг бид гаргаж тавьсан байгаа. Ер нь бол замын байгууламжтай замтай холбоотой энэ зураг төсөв дээр бол Зам, тээврийн сайд, Зам тээврийн хөгжлийн төв нь магадлал хийх ёстой байсан гэсэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Баярмаа гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Тэгээд хийгдээгүй, хийгдсэн ганц нэгэн тоо нь зөрүүтэй, хийх ёсгүй байгууллага хийчихлээ гэж ойлголоо. Одоо хууль гэж ер нь байгаа юм уу, үгүй юм уу л гэдэг асуулт дахин дахин тавигдаад байна л даа. Нийслэлийн аудитын газар гэж байгаа тиймээ? Ер нь энэ өмнөх нийслэлийн төсөл арга хэмжээнүүдэд энэ зураг төсөвгүй магадлал хийгдээгүй ажлууд хэр их байдаг байсан юм бэ? Байнгын ийм давтагдаад сүүлдээ 2,3 их наядын ийм том төсөл дээр хүртэл хээвнэг зураг төсөвгүй магадлал хийлгээгүй явж байдаг юм уу гэдэг асуултыг асууя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нийслэлийн аудит 3 номерын микрофон.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга Г.Нандинжаргал: 2024 онд бид нийслэлийн төсвийн төсөлд өгсөн санал дээр төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлтийг өгч байсан. 2025 оны төсвийн төсөлд ер нь төсөвлөлтийн шаардлага хангахгүй төслүүдийг баталж болохгүй гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн байгаа. Тэгээд 2025 ондоо гарсан зөрчлүүдийг арилгах ялангуяа аудитаар нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, санхүүжилт, захиалагчийн хяналт, өмнөх аудит болон төсвийн төсөлд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт мөн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон өмч бүртгэлтэй холбоотой нийт 688 тэрбум төгрөгийн дүнтэй давхардсан 1101 төсөл арга хэмжээний хүрээнд 37 төрлийн алдаа зөрчилд 6 дүгнэлт өгсөн. 299 тэрбум төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосон. Зөрчлийг арилгах 1, сахилгын шийтгэл ногдуулах 4 албан шаардлага хүргүүлсэн байгаа. Энийг бол нийслэл хангаж ажиллах ёстой. Нэг байгууллагыг бид нар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. 2025 оны байдлаар Нийслэлийн иргэдийн хурлын даргад

2, НЗД-д бол 5 зөвлөмж хүргүүлсэн байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Төсөв баталж болохгүй гэдэг ийм зөвлөмж өгсөн гэж байна. Бүр төсөвлөлт шаардлага хангахгүй байгаа тул баталж болохгүй гэсэн атал батлаад явж байна гэдэг чинь, бид нар эндээс юуг ойлгож болох вэ гэвэл, нөгөө төсөв баталдаг ИТХ, Засаг дарга 2 хоорондоо бантан болсны л илрэл байна.

Зүй нь Улсын Их Хурал хүртэл аудитын дүгнэлтийг яриад, бариад, тэр дээр чинь засаад залруулаад л явдаг болчихоод байхад, нийслэл дээр тийм юм байхгүй юм байна гэж дүгнэлээ. Энэ чинь засаглалын хямрал, ерөөсөө ялгаа зааг байхгүй болчихсон. Зүй нь гүйцэтгэх байгууллагаа хянаж байх ёстой. Нөгөө хурал нь өөрсдөө тэр дотроо орчихсон, гүйцэтгэгч болчихсон явж байгаагийн илрэл юм уу даа л гэж харж байна.

Дараа нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө байхгүй гэдэг зүйл яригддаг. Тэгээд энэ төлөвлөгөө гараад ерөнхий үнэлгээ хийдэг байгууллага нь хяналт тавьсны үндсэн дээр жилийнх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталдаг гээд байна. Тэгэхээр байгаль орчны төлөвлөгөө, менежментийн төлөвлөгөө байхгүй гээд байгаа нь суурь төлөвлөгөө байхгүй тухай ярьж байна уу? эсвэл жилийн төлөвлөгөө байхгүй тухай ярьж байна уу? Байгаль орчны яамнаас асууя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Байгаль орчны яамнаас хариулъя. Дугаар хэд билээ? 11 номерын микрофоныг нээе.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн дарга А.Алтанзул: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд бол Туулын хурдны замын байгаль орчны менежментийн төлөвлөгөө 5 жилийн хугацаагаар, ТЭЗҮ-д заасан хугацаагаараа орж батлагдсан.

Бид нарын албан шаардлага, ажлыг зогсоосон үндэслэл нь бол тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй үйл ажиллагаа явуулаад эхэлсэн байсан. Энэ нь өөрөө зөрчил болоод ажлыг зогсоох үндэслэл нь болсон. Хуульд зааснаар тухайн жилийн байгаль орчны төлөвлөгөөг батлуулах хуулийн зохицуулалт байдаг. Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/618 тоот тушаалаар батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө хянан боловсруулах, хянан батлах журам дээр бол яг тухайн жил болгон дээр нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулна. Өнгөрсөн жилийнхээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянуулж дүгнүүлнэ гэдэг ийм зохицуулалтууд нь байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Баярмаа гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: 4 тусгай зөвшөөрөл аваагүйгээр эхэлсэн. Нөгөө усан байгууламж, устай холбоотой дүгнэлтүүд гараагүй эхлүүлсэн. Эхлүүлэхэд шаардлагатай тэр хууль зүйн шаардлагуудыг биелүүлээгүй тухай юм байна.

Бас нэг ноцтой юм байна лээ. Геологи хайгуулын явцад өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашигласан химийн бодисын асуудлаар шалгалт хийж байгаа. Тэгэхээр ямар бодис байгаад, яагаад шалгалт хийж байгаа юм? Хортой химийн бодис байсан юм уу, эсвэл юу гэсэн үг юм?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: А.Алтанзул дарга хариулъя. Туул дээр ялангуяа их босож ирсэн асуудал шүү. 11 номерын микрофоныг нээе.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн дарга А.Алтанзул: Гишүүний асуултад хариулъя. Ажлын гүйцэтгэлийн явцад Хао Юань Женерал констракшн компани Дорнын Улзынмандал гэж компанитай гэрээ байгуулсан юм байна лээ. Тэгээд гэрээнийх биш уучлаарай, би андуурсан байна. Голын голдирол дотор барьж байгаа тэр суурь барих зориулалтаар химийн бодис орсон бодисыг хийж ажлаа явуулсан юм байна лээ.

Энэ дээр Экологийн цагдаагийн албанаас хэрэг үүсгээд, тэгээд гомдлын дагуу хэрэг үүсгэчихсэн явж байгаа. Манайхаас холбогдох мэдээллүүдийг аваад явж байгаа. Одоо хэргийн шалгалтын ажил нь явж байгаа учраас нарийн мэдээллийг танд өгөх боломжгүй байна. Ерөнхийдөө бид нар гаргасан зөрчилд нь торгуулийн арга хэмжээ авах шийдвэрийг нь прокурорт...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Баярмаа гишүүн дуусчихсан уу? 30 секунд л байгаа юм байна. Ж.Баярмаа гишүүн үг хэлээд дуусгаж болно.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Сэлбэ дэд төвтэй холбоотой нэг асуулт байна. Уг нь багц 3.1 гээд ажлыг сонгон шалгаруулахдаа асуудал үүсээд Хятадын компанийг шалгаруулчихсан юм байна. Гэтэл цаана нь Монгол компани асуудал үүсгээд шүүхээр яваад байгаа.

Уг нь Монгол компани хямд дүн санал болгосон байгаа юм. Хятад компаниас илүү хямд дүн санал болгосоор атал яагаад, юуны улмаас Хятад компанийг шалгаруулаад байдаг юм бэ? Шүүхийн үйл явц нь ер нь ямар түвшинд явж байгаа юм бол? Энийг мэдэж байгаа хүн байна уу, ямар учиртай Хятад компани шалгаруулаад байгаа гэдэг чинь маш том асуултын тэмдэг шүү.

Авлига аваад шалгаруулаад байгаа юм уу? Уг нь бол Монгол компани чинь улайм цайм хямд үнэ санал болгосон гэж байна шүү дээ. Тэгээд Хятад компаниудад давуу эрх олгоод байгаа тухай асуудал маш их сөхөгддөг. Сүүлдээ Туулын хурдны замын 2,3 их наядын төсөл хүртэл дахиад л маргаантай хятад компани, 2 хятад... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 8 номероос хариулъя.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Нийт 7 багцын нэг болох 3.1 дүгээр багц дээр 11 блокийн барилга угсралтын ажил дээр Хятадын Чайна констракшны 5 дугаар товчоо шалгарсан. Тэгээд Нийслэлийн худалдан авах ажиллагаанаас бид нарт гэрээ байгуулах мэдэгдлийг ирүүлсэн. Гэрээ байгуулах мэдэгдэл ирээд, гэрээ маань хийгдээд явж байтал, гомдол гараад одоогийн

байдлаар 2 шатны шүүхээр орчихсон дээд шатны шүүх рүүгээ явж байгаа. Тэгээд төслийн ажлыг зогсоосон. Бид нар эцсийн шатны шүүхийн шийдвэрийг хүлээж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүн асуултаа асууя.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Та бүхэндээ сонсголын 2 дахь өдрийн мэнд хүргэе. Хоёр өдрийн сонсголд сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод хийгдэж байгаа бүтээн байгуулалт, агаар, орчны бохирдол, авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх төслүүдийнхээ талаар мэдээлэл өгсөн чухал үр дүнтэй хурал болж байна гэж ойлгож байна. Өнөөдрийн сэдэв ч мөн хүрээнд явагдаж байгаа. Өнөөдөр зөвхөн нөгөө Туул хурдны зам, Сэлбэ төвийн хүрээнд асуудлууд яригдаж байна.

Улаанбаатар хот өдөр ирэх тусам хүрээгээ тэлж байгаа, тэлэлтийг зогсоох зөв гарц шийдлийг төр засгийн хүрээнд үргэлж илэрхийлж, мөн нийслэлийн зүгээс ч гэсэн бүх боломж бололцоогоо дайчлан нийгмийн үйлчилгээ зэргээс шалтгаалан хараахан зогсоож чадахгүй байгаа юм. Өнөөдөр Туул хурдны зам дээр яригдаж байгаа асуудлууд бол 2013 онд эхэлсэн, Засгийн газрын 46 дугаар тогтоолоор эхлээд өнөөдрийг хүрсэн. Мөн 2013 оны Засгийн газрын хуралдааны 307 дугаар тогтоолоор Туул хурдны замын чигийг тогтоосон бөгөөд энэхүү тогтоол өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа. 2022 онд Улаанбаатар хотын шинэ тойрог замыг барьж байгуулах тухай УИХ-ын болон Засгийн газрын шийдвэрүүд гарсан. Засгийн газрын 476 дугаар тогтоолоор Туулын хурдны замын гүүрэн байгууламж барьж байгуулахыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасан. Ийм шийдвэрүүд удаа дараа гарч байсан. Энэ хүрээнд бүтээн байгуулалт, ажлууд өрнөж эхэлсэн. Харамсалтай нь өнөөдөр Туулын хурдны замын ТЭЗҮ болон санхүү мөнгө босгох ажил 13 жил үргэлжилж байгаад эхэлсэн. Гэтэл өнөөдөр яг эргээд гацаанд орж байгаа. Энэ юутай холбоотой юм бэ гэхээр өмнө нь эрх зүйн болон санхүүгийн чадамжгүй байсан учраас төслүүд нэг нь ч хөдөлж чадаагүй байсан.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль 2022 онд шинэчлэгдээд тэр татвар, мөнгө санхүү, бонд босгох эрхээ хот авч байж мөнгөө босгоод өнөөдөр эхэлсэн. Тэгээд өнөөдөр ийм гацаанд орсон.

2 дугаар асуудал Сэлбэ дэд төв байгаа юм. Би өөрөө, өөрийн биеэр очсон танилцсан. Тэр гадаад ашиглалтын зээлийн хуулийн төслийн хүрээнд оруулж ирж өргөн барьсан, харамсалтай нь хасагдсан. Гэлээ гэхдээ Сэлбэ дэд төв өнөөдөр зогсолтгүй урагшлах ёстой. Явж байгаа байх гэж би найдаж байна. Хот дээрээ байх юм уу? Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам руу явах юм уу гэсэн ийм шийдлүүд яригдаж байсан. Нэг минут сунгаж авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Сэлбэ дэд төвийн өгөөж нь өөрөө маш их шүү. Маш олон жил яригдсан. Гэр хорооллыг барилгажуулах л гээд яриад байгаа болохоос Улаанбаатар хотдоо доороо инженерийн дахиад Улаанбаатар хот байгаа шүү. Инженерийн барилга байгууламжийнхан бид бүхэн шинэчлэлийг хийж чадаагүй. Хамгийн сүүлд 2024 онд авсан мэдээллээр Улаанбаатар хотын доор

байгаа инженерийн барилга байгууламж, дэд бүтцийн 86% нь шинэчилж чадаагүй зогссон.

Улаанбаатар хот өөрөө газар нутгийн байршлын хувьд Туул голоо даган 2 талд төмөр замаар тусгаарлагдсан босоо шугаман ийм хот. Яалт ч үгүй гэр хорооллын маш их тэлэлттэй байгаа. Энийг зогсоохын тулд дэд төвүүдээ түшиглэн барилгажуулалтыг хийхээс өөр замгүй. Тэгэхээр энэ дээр яригдаад байгаа бодлогын алдаанууд байгаа юм уу?... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Үргэлжлүүлээд ярих уу? асуулт асуух уу? Н.Алтаншагай гишүүний микрофон нээж өгье.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Хууль эрх зүйн хувьд маш олон боломжууд нийслэл дээр нээгдсэн. 70 гаруй хуульд өөрчлөлт оруулсан. Засгийн газрын 10 гаруй тогтоол гарч байсан.

Улаанбаатар хотын дэд бүтцийг дагасан 5-6 дэд төв байгаа. Баянхошуу, Толгойт, Амгалан, Сэлбэ, Шар хад энийг дагаж л орон сууц босгох гэж байгаа хэлбэр нь. Хэдэн асуулт байна.

Сэлбэ төв санхүүжилт зогссон уу, явж байгаа юу? Энэ дээр миний ямар нэгэн хувийн эрх ашиг байхгүй шүү, энийг бүр онцгойлон тэмдэглүүлье протоколд. Ажил нь битгий зогсоосой гэсэндээ энийг би асууж, тодруулж байгаа юм.

Сэлбэ-2 гэсэн төлөвлөлт хийгдсэн гэсэн ийм мэдээлэл байгаа. Сэлбэ-1 төвөөсөө урагшлаад 32-ын тойрог хүртэл явна гэсэн ийм мэдээллийг би олж авсан. Энэ цаашаа үргэлжлэх үү?

Баянхошуу, Толгойт, Шар хад, Амгалан төвүүд рүүгээ. Миний мэдэж байгаа мэдээллээр бол цэвэр бохир, халуун, дулаан нь татагдсан л гэж байгаа юм. 2013 онд эхэлсэн дахин төлөвлөлт юунаас болж зогссон юм бэ гэвэл дэд бүтцээ бид бүхэн ерөөсөө Улаанбаатар хот шийдэж чадаагүй байсан. ААН-үүд бие даан шийдвэрлэх ямар ч боломжгүй юм байна лээ. Тэгээд тэр дахин төлөвлөлт зогссон.

Шинэ давлагаа нь бол 2023 оноос хойш эхэлсэн гэж бодож байгаа. Дэд бүтцүүд татагдсан, дээр нь газар чөлөөлөлт явагдсан. Барилга орон сууц нь эхэлсэн.

Миний ганц хэлж байсан зүйл бол газар чөлөөлөлт дээрээ онцгойлон анхаарахдаа иргэдэд байгаа өмч буюу газрыг нь хамгийн боломжит өндөр үнээр нь үнэлж аваарай гэсэн ийм л зүйлүүдийг Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч байхдаа ч хэлж байсан. Улсын Их Хурлын гишүүн болоод ч хэлж байсан. Хашаандаа аав ээжтэйгээ гэр барьчихсан, байшинд байгаа 3 өрхийг яаж тэрийг хямдхан үнэлж аваад бусдыг нь тэгээд тэр 100 хэдэн саяар аваад 1 өрөө юм уу, 2 өрөө байранд л орно шүү дээ. Хангалттай сайн үнэлж аваарай гэдэг боломжуудыг л эрэлхийлж байсан. Саналаа байнга илэрхийлж байсан.

Тэгэхээр газар чөлөөлөлтүүд дээр дахин цаашаа ямар төлөвлөлт байгаа вэ? цаашаагаа үргэлжлээд явах ёстой? Энийг хууль эрх зүйн хүрээнд нь маш сайн нийцүүлж иргэддээ ойлголт мэдээллээ өгөхгүй бол энэ ажил ерөнхийдөө маш хүндрэлтэй олон бэрхшээлтэй тулж байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хариулт авах уу? 8

дугаар микрофон.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Н.Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Санхүүжилтийг түр хугацаагаар зогсоосон байсан. Тэгээд өнгөрсөн 7 хоногоос үе шаттайгаар 1, 2 гүйцэтгэлүүдийг олгож эхэлж байна. Нөгөө цаанаа шалгалтын, үр дүнтэй холбоотойгоор Төрийн сан руу тийм албан шаардлага ирсэн байсан. Тэгээд цаашдаа хэвийн үргэлжлэх төлөвтэй байгаа.

Сэлбэ-2 гэж зүгээр бид нар Сэлбэ дээрээ тулгуурлаад 2 гэдэг л юм түр ажлын хэсэг гаргах гээд явж байгаа. Юу гэхээр цаашид зөвхөн төр газраа чөлөөлөөд дэд бүтцээ тавьж өгөөд хувийн хэвشلүүдийн хөрөнгө оруулалтаар дараа дараагийн хот төлөвлөлтийн ажлууд явна. Гэхдээ өмнө дутагдаж байгаа буюу ажлын байрыг нэмэгдүүлэх, кластер төв ялангуяа яг тухайн бүс нутагт байх үйлдвэрлэлийн район, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн орчныг бий болгох. Мөн амины сууцыг дэмжсэн ийм бодлогын хүрээнд дараагийн төслийг 150 га дээр хэрэгжүүлбэ гэсэн ийм төлөвлөгөө бол байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүн.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Туул хурдны зам дээр товчхон үг хэлээд өндөрлөө. Туул хурдны зам бол ерөнхийдөө явах ёстой. 13-14 жилийн төлөвлөлт, төлөвлөгөө. Энийг Х.Нямбаатар гэнэт унтаж босож ирээд, сэрээд ТЭЗҮ-г нь хийчихсэн юм биш.

Монгол Улс өөрөө Ази Европыг холбосон олон улсын Эй Эйч-3 гэсэн олон улсын замын трасс дээр байрлаж байгаа. Энэ дээгүүр Ази Европыг холбосон ачаа тээврийн логистикийн төвүүд дамжин өнгөрөх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, олон төв хот руу шилжих дэд бүтэц улам тэлэх ийм боломжууд л нээгдэж байгаа гэж харж байгаа. Өчигдөр хотын дарга хэлж байсан, трассыг нь дахиж судлаад тавина гэж байгаа.

Би бодож байгаа. Энд ирсэн иргэд Сэлбэ дэд төвийг эсэргүүцэж байна гэж би лав ойлгохгүй байгаа. Туул хурдны замыг эсэргүүцэж байна гэж ойлгохгүй байгаа. Гагцхүү байршил дээрээ иргэд болон хот дээр нэг үл ойлголцол үүсчихсэн байгаа. Тэгэхээр энийгээ нэг талд нь гаргаад, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг явуулах хэрэгтэй. Хүссэн хүсээгүй том бүтээн байгуулалтууд явна. Хот өдрөөс өдөрт тэлнэ. Нийгэм эдийн засгийн хамгийн том төвлөрөл үүсчихсэн байгаа, Улаанбаатар хот. Монгол Улсын хүн амын 55% нь байгаа. Тэгэхээр Пүрэвдагва дарга болон хотын удирдлагын баг зөв шийдлүүдээ гаргаад эргээд иргэддээ саналуудыг нь аваад маш өргөн хүрээний хэлэлцүүлэг явуулаад, УИХ, Засгийн газрын болон холбогдох байгууллага олон улсын шинжээч, хөндлөнгийн байгууллагуудаар дүгнэлтүүдээ гаргаад энийг бид бүхэн цаг алдалгүй явуулах хэрэгтэй.

Мэдээж хууль хяналтын байгууллагын асуудал байвал цаг хугацаандаа шалгагдах ёстой газраараа шалгагдаад дүгнэлтүүд нь гараад эцэслэгдээд, мухарлагдаад явах ёстой. Тэгэхгүй бол 2 өдөр ерөнхийдөө нийслэлийг буруутгалаа. Тэгээд нийслэлийг 45 ийм мангастай болчихсон юм шиг өнгө аяс руу орчхож байгаа юм. Та бүхнийг бол ойлгож байна. Хийе бүтээе, хуулийн хүрээнд л зүтгээд ажилласан ийм л байгууллага. Тэгээд би өчигдөр хэлж байсан нутгийн өөрөө удирдах ёс руу хэт их хэлбийж байгаа юм биш үү. Дараа дараачийн аймгуудыг энд орж ирээд сонсгол хийхэд бараг л нээлттэй болчихлоо шүү дээ. Өмнөговийг

авчиръя. Эрдэнэт дээр сонсгол хийе гээд эхэлбэл энэ чинь бүр ийм сонсгол хийдэг газар болоод хувирах магадлалтай шүү.

Тэгээд иргэдийн тавьж байгаа шаардлагыг зүй ёсны хүлээж авч ажилдаа маш олон талын ойлголцолтой явж байж энэ ажил урагшилна гэдгийг төгсгөлд нь хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Н.Алтаншагай гишүүн яг тодорхой дурдлаа. Шийдэгдэхгүй их олон жил болж байгаад, санхүү шийдэгдээд явсан чинь ийм юм болчихлоо гээд.

Би Туулын хурдны зам дээр өмнө нь Ж.Баярмаа гишүүн асуугаад дутуу хариултаа авчихсан дээр нэг юм тодруулчих хэрэгтэй байна. Хурал даргалагчийн хувьд асуултуудад хариултаа авч байх ёстой учраас тодруулъя. Ерөнхий зургийг нь харсан чинь аудитаас асуугаад байна. Эхлээд 916 тэрбум төгрөг байж байгаад, дараа нь 3 сарын дараа 1,9 их наяд болоод, тэр нь бол хүчин чадал нэмэгдсэн. Дараагаар нь нөгөө үер ус гээд гүүрэн байгууламж болоод 2,3 их наяд болсон.

Энэ хооронд зураг төсөл урьдчилсан зураг төсөл магадлан хийгдлээ. Магадлан хийхдээ урьдчилсан зураг төсөл гэдэг юман дээр тулгуурлаж хийлээ, магадлан нь болохоор шаардлага хангахгүй байна гэсэн ийм дүгнэлтийг хэлээд байна. Тэгээд тэр магадлан дээр нь урьдчилсан зураг төсөл дээр нь тулгуурлаад барилга угсралтын И Пи Си гэрээг Фидик хийдэг стандартаар хийчихжээ. Гэрээ хийхдээ 500 тэрбум төгрөгийг шилжүүлчихсэн юм байна. Энэ хооронд мэдээж энэ чинь алхам бүрд төсөв нөгөө 0,9, 1,9, 2,3 гээд батлагддаг. Тэр батлах хурал нь бол НИТХ дээр болдог. Хурлын төсөв тодотгосон шалтгаан үндэслэл гээд хуулийн 3 үндэслэл байгаад байна.

- 1 дүгээрт нь дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас,
- 2 дугаарт нь урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас,
- 3 дугаарт нь үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нэмэгдсэнээс.

Тэгээд алин дээр нь үндэслэж шийдвэрүүд гарсан бэ гэдэг ийм асуулт НИТХ руу уг нь явсан юм. Тэгэхээр энэ дээр бол ер нь нэг хариулт гарах ёстой. Хариулт бол гогцооны чинь нэг тайлах үзүүр гэж хүлээгээд байна.

2 дахь асуулт нь 500 тэрбум урьдчилгаа бол төлчихсөн, явчихсан. Түрүүн тэр сонгон шалгаруулалт нь бол тэнд нэг гарсан ЗГХЭГ-ын ажлын хэсэг бол хуульд нийцээгүй болсон гэж үзэж байгаа юм байна. Тэр нь деталь шалгалт нь явж байна. 500 тэрбумын урьдчилсан төлбөрийн баталгаа нь хуурамч юм уу, жинхэнэ юм уу гээд нэг нээлттэй асуудал байна. Үндэсний Аудитаас хариу хэлэх боломжтой юу? 15 дугаар микрофон.

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Хурал даргалагчийн асуултад хариулъя. Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн.

Бид нар баталгаатай холбоотой асуудлыг 1 дүгээрт СЗХ эрх бүхий байгууллагаас тодруулга авсан. Дээр нь гадна байгаа байгууллагын үйл ажиллагаа чиг үүрэг нь энэ чиглэлийн эрх бүрэн ч зөвшөөрөл эрх байгаа эсэх асуудлаар лавлагаа авахыг гаднын улсын ЭСЯ-аар өөрөөр нь дамжаад авах гэсэн боловч бидэнд боломжгүй байна гэсэн ийм хариу өгчхөөд байгаа юм. Тэгээд бид нар энэ талаар хууль хяналтын байгууллага шалгаж байгаа учраас тэгээд энэ хүрээд үндсэндээ хязгаарлагдсан гэсэн үг. Тэгэхээр энэнээс цаашаа бол бид нар яаж ч

чадахгүй байгаа, одоогийн байдлаар нарийвчилж үзэж чадаагүй байгаа л гэсэн тийм хариулт байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: УИХ-ын гишүүн Б.Жаргалан асуултаа асууя.

УИХ-ын гишүүн Б.Жаргалан: Юуны өмнө нийслэлийн төсөв болон нийслэл дээр хэрэгжүүлж эхэлж байгаа мега төслүүдтэй холбоотой УИХ-ын ерөнхий хяналтын сонсголыг санаачлаад зохион байгуулж байгаа Ж.Золжаргал нарын гишүүдэд талархал илэрхийлмээр байна. Сая зарим хүмүүс сонсгол хэрэггүй ерөөсөө Улсын Их Хурал сонсдог байгууллага боллоо гэж хэлж байх шиг байна. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар ерөнхий хяналтын сонсгол, хянан шалгалтын түр хороо зэрэг байгууллагууд бол иргэдийн мэдэх эрхийг хангаж дээрээс нь парламентын хяналтыг хэрэгжүүлэх маш чухал механизмууд юм. Тэгээд энэ механизмыг бид нар үр дүнтэй ашиглаж чадах юм бол манай ардчилал бэхэжнэ, манай шийдвэр гаргалт бэхэжнэ, тэгээд тэр хэрээрээ иргэдийн ч гэсэндээ сэтгэл ханамж сайжирна гэж харж байгаа.

Тэгээд Туулын хурдны замын асуудал дээр бол УИХ дахь АН-ын бүлэг нэлээн хэдэн 7 хоногийн өмнө өөрсдийнхөө бүлгийн хурал дээр нээлттэй хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулсан. Хатан туулай хамгаалъя хөдөлгөөн тухайн хэлэлцүүлэг дээр их идэвхтэй оролцсоны улмаас яг энэ сэдэв олон нийтийн хүртээл болж анхааралд орж өнөөдрийн түвшинд очоод байгаа.

Тэгээд өчигдөр мега төслүүд гээд 24 мега төслүүд анх танилцуулагдаж байсан. Бид нарыг анх УИХ-д сонгогдсоны дараа нийслэлээс 24 мега төсөл хэрэгжүүлнэ нийлбэр дүн нь болохлоор хөрөнгө оруулалтын өртөг нь 55,4 их наяд төгрөг байна гэсэн зүйл анх ярьж орж ирж байсан. Өчигдөр харахад 24 төсөл нь 16 төсөл болоод 28,9 их наяд төгрөг гэсэн ийм мөнгөн дүнтэй болчихсон байна. Тэгээд нэг асуудал байгаа юм нэг татгалзчихаад байгаа. Хэрэгжүүлэхээ больчихоод байгаа үлдэгдэл 8 төсөл нь ер нь тодорхой мөнгө төгрөг зарцуулсан төслүүд байгаа юм уу? яагаад вэ гэхлээр жишээлбэл тэр Өөдөө тэмүүлэх гүүр гэхэд л тухайн үед төсөвт бол мөнгө тавиад л байсан гэх мэтчилэн яг ийм тодорхой мөнгөн зарцуулалтууд хийгдчихсэн зүйлүүд байгаа юу? 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуудал Туулын хурдны замын асуудал яригдсаны дараа Даваадалай орлогчийн асуудалтай холбоотой хууль зүй, хуулийн байгууллага шалгаж байгаа асуудалтай холбоотой нийслэлийн төсөл хөтөлбөрүүд болон хувь хүмүүсийн 2,6 их наяд төгрөг байгаа данснуудыг царцаасан гэсэн мэдээлэл ер нь олон нийтэд тийм аягүй сонин ойлголт өгчихсөн байгаа. Тэгээд 2,6 их наяд төгрөг нийслэлийн хэдэн дансыг царцаачихсан юм бэ? Тэр дотор ийм хувь хүмүүсийн данс байгаа юм уу, ер нь хаана ийм их мөнгө яваад байгаа юм бэ? гэдэг дээр нэг тодорхой тайлбар холбогдох байгууллагууд нь өгнө үү? гэж хүсье. Тэгээд дахиад тодруулъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүний асуултад 8 дугаар микрофон дээрээс хариулъя.

НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах: НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах.

Энэ 2,6 их наядын үлдэгдэл гэж яриад байна. Үлдэгдэл маань бол арилжааны банканд буюу Сэлбэ 500 сая ам.долларын бондын үлдэгдэл 1,5 их наяд төгрөг нь

бол арилжааны банканд байгаа. Үлдэгдэл 1,1 их наяд нь нийслэлийн төрийн сангийн үлдэгдэл болон нийслэл, дүүрэг, нийслэлийн төрийн сангийн үлдэгдэл дэх дансны үлдэгдэл нь 1,1 их наяд төгрөг. 2,6 их наядын үлдэгдэл гэдэг дүн нь Х.Нямбаатар дарга ажлаа хүлээлгэж өгөөд тухайн үед Төрийн сан дахь болон арилжааны банканд дахь үлдэгдлийн мэдээллийг гаргасан. Тэгэхээр тухайн дансыг мэдээлэлтэй холбоотойгоор АТГ-аас Нийслэлийн ерөнхий зарлагын дансыг царцаасан байгаа. Энэнтэй холбоотойгоор бид тухай бүр нь нийслэлийн цалин гаргах, мөн Сэлбийн гүйцэтгэл сая гарч эхэлж байна гэж байна. Тодорхой хэмжээнд бол бид нар хүсэлтээ хүргүүлээд прокурорын шийдвэрээр гүйцэтгэлийг нь гаргаад явж байгаа. Хэвийн явж байгаа гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Жаргалан гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Б.Жаргалан: Тэгэхээр ийм засаглалын алдаанууд, ер нь үр дүнгүй засаглалын төлөөснүүд чинь наад бүхэн чинь шүү дээ. Одоо нийслэлийн данснууд царцаачихсан байж байгаа. Гүйлгээ гаргах тоолондоо зөвшөөрөл аваад. Тэгээд л бид нар ийм л хүнд суртал ийм үр дүнгүй засаглал руу орчхоод байгаагийн л шинж л дээ. Тэгээд өнөөдөр хэлэлцэж байгаа 2 төсөл Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв 2 бол Улаанбаатар хотын хувьд тулгамдсан маш том 2 асуудлыг цаасан дээр бол шийднэ гэсэн зорилгоор анх төлөвлөгдөж хэрэгжиж эхэлсэн гэж ойлгож байгаа. Тэр нь юу вэ гэхлээр түгжрэл болон утаа. Сүүлийн 20 гаруй жил Улаанбаатарыг зовоосон 2 асуудал байж байгаа. Ерөөсөө шийдэлгүй өдөр ирэх тусам дордоод байгаа. Түгжрэл, утаатай тэмцэхийн тулд бид нар заавал хэдэн их наядаар нь хөрөнгө мөнгө зарцуулаад, олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд метрог нь ч тавиад, хурдны замыг нь ч тавиад, Эл Ар Ти, Би Ар Ти бүгдийг нь нэгэн зэрэг тавиад шийдэх юм шиг ийм бодлогогүй зүйл нийслэл дээр яваад байгаа учраас хүмүүс бухимдаад байгаа юм. УИХ дээр ч гэсэн гишүүд бухимдаж байна. Иргэд бухимдаж байна. Улаанбаатарчууд бүгдээрээ бухимдаад байгаа юм.

Түгжрэл утаатай тэмцэх тодорхой бодлого ерөөсөө алга байна. Яг үнэндээ тэр түгжрэлтэй тэмцье гэж үзэхэд, нийтийн тээврийг хөгжүүлэх хүч, хөгжүүлэх шаардлагатай гэдэгтэй бүгдээрээ л санал нийлж байгаа. Гэхдээ нэгэн зэрэг тэр метрог ч тэр, Эл Ар Ти, Би Ар Ти ч тэр, цанын бааз дээр явдаг дүүжин тээврийг ч тэр нэгэн зэрэг бүгдийг нь эхлүүлдэггүй л байхгүй юу даа. Тэгээд 2,4 их наядаар 32км зам тавихгүй л байхгүй юу даа. Бид нарт хязгаарлагдмал нөөц байгаа. Тэр хязгаарлагдмал нөөцөө ухаалаг ашиглах ёстой талаар л яриад яваад байгаа юм. Түүнээс биш жишээ нь аль нэг даргыг, Х.Нямбаатар гэдэг даргыг Б.Пүрэвдагва гэдэг даргаар солих асуудал биш. Өчигдөр жишээлбэл Хотын шинэ даргын хэлж байгаа ч гэсэндээ бөөрөнхий л байгаад байна.

Би бол Туулын хурдны замыг зогсооно гэж огт хэлэхгүй байна. Тэгэхээр уул нь нийслэлийн удирдлага, хэрэв үнэхээр удирдлага шинэчлэгдэж байгаа бол бодлогоо шинэчилмээр байгаа юм. Ийм бодлогогүй, бодлоготой, баахан мөнгө үрэн таран хийсэн байдлаар явмааргүй байгаа юм. Тэгэхээр нийслэлийн удирдлагаас юу хүсэх байна вэ гэхлээр нэг мөр манлайлал үзүүлээч. Түүнээс биш өнөөдөр хэлэгдээд байгаа зүйлүүд ч тэр, энэ Туулын хурдны зам дээр асуудлуудыг нь бүгдийг нь гоё шалгаад явуулах юм. Үгүй тэр 32км замыг 2,4 их наяд төгрөгөөр тавих чинь өөрөө эдийн засгийн хувьд ч тэр бүх талаар логикийн хувьд ч тэр буруу юм. Нэгэн зэрэг 30, 40, 50 их наядаар бид нар төсөл хэрэгжүүлэх боломж бололцоо ч алга. Битгий татвар төлөгчдийн Монголчуудын, Улаанбаатарчуудын мөнгийг үрэн таран хийгээд байгаач л гэдэг ийм асуудал шүү. Цагаа нэмээд авъя.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Б.Жаргалан гишүүнд цагийг нь нэмж өгье.

УИХ-ын гишүүн Б.Жаргалан: Туулын хурдны зам дээр тодорхой асуултууд байна. 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа олгочихсон гээд байгаа. Энэ урьдчилгааг ямар эрх зүйн үндэслэлээр, тэр баталгаа гээд нэг зүйл яваад байсан юм. Тэр нь ямар баталгаа байсны үндэслэл дээр, ямар эрх зүйн үндэслэлээр олгосон бэ? тэгээд тэр 350 тэрбум төгрөгийг нь аль хэдийнээ зарцуулчихсан гээд нэг жагсаалт гаргаад ирчихсэн тийм мэдээлэл байна. Тэр жагсаалт дотор нэг тодорхой зүйл заалтыг нь онцолмоор байна. Байгаль орчны хамгаалал, археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгаанд 8,4 тэрбум төгрөгийг зарцуулчихсан гэсэн мэдээлэл байгаа юм. Миний хувьд АН-ын бүлэг дээр хийсэн хэлэлцүүлгийн араас Соёлын өвийн үндэсний төв, Соёлын яам руу бичиг явуулаад үнэхээр Туулын хурдны зам төслийн хүрээнд байгаль орчны хамгаалал, нэн ялангуяа археологи палеонтологи, угсаатны зүйн чиглэлийн судалгаа хийгдсэн үү гэсэн чинь огт хийгдээгүй гэсэн тийм албан бичиг хариу ирсэн. Тэгээд Газрын тухай хуулийн 31.4-ийн хүрээнд ч гэсэн хэрэв тийм судалгаа хийгдээгүй бол заавал хийгдэх ёстой юм байна лээ. Тэгэхээр энэ дээр нийслэлийнхэн тодорхой хариулт өгмөөр байна.

Мөн түүнчлэн аудитын газрын удирдлагууд ирсэн байгаатай холбогдуулаад аудитын байгууллагаас асууя. Нийслэлийн өмчит компаниуд гээд өчнөөн олон ашгийн төлөө компаниуд ажиллаж байна гээд өчигдөр танилцуулагдсан. Тэгэхээр төрийн аудитын байгууллагын хүрээнд нийслэлийн төсөв дээр аудит хийснээ ярьсан байгаа. Тэгэхээр нийслэлийн өмчит компаниуд дээр хийгдсэн аудит бүгд дээр нь хийгдсэн үү, ямар зөрчлүүд гарсан бэ, хийгдээгүй компаниуд байна уу? гэдэг ийм тодорхой асуулт байна.

Дүрэмд заагаагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдол байгаа юу? Тухайлах юм бол өчигдөр яригдаад байгаа тэр Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент гэдэг компани болохлоор Улаанбаатар хотын асуудал дээр л ажиллах ёстой гэсэн тийм дүрмийн заалттай юм байна. Гэтэл хаа хамаагүй Говь-Алтайн ЗДТГ-т зөвлөгөө үйлчилгээ үзүүлээд явуулаад байгаа нь өөрийнхөө компанийн анх үүсгэн байгуулсан үндэслэл, дүрмээ зөрчсөн явдал байна уу?

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Хэдэн номер вэ? 7 номерын микрофоныг нээе.

НЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулга: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. НЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулга.

Б.Жаргалан гишүүн урьдчилгаа төлбөрийн талаар эрх зүйн орчны талаар асуулаа. Энэ хүрээнд нийслэлд хэрэгжүүлж байгаа улс, нийслэл, дүүргийн төсөв бүх улсын хэмжээнд хийгдэж байгаа ажлын санхүүжилт нь Төсвийн тухай хууль мөн Төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, ЗГ-ын 278 дугаар тогтоолоор зааж өгсөн байдаг. Эдгээр хууль нь ерөнхийдөө урьдчилгаа төлбөрийн зохицуулалт нь

- 1 дүгээрт тендерийн баримт бичигт тусгасан байх.
- 2 дугаарт гэрээнд тусгагдсан байх.
- 3 дугаарт банкны болон даатгалын баталгаатай байх.
- 4 дүгээрт тухайн жилийн санхүүжих дүнгээсээ хэтрэхгүй байх гэсэн ийм хуулийн зохицуулалтаар явдаг. Энэ хүрээнд Туулын хурдны зам дээр тендерийн баримт бичигт заасан байсан, гэрээнд заасан даатгалын баталгаа ирүүлсэн. Эдгээр

бүрдлийг эрх бүхий албан тушаалтнууд нь хянаж үзээд шийдвэрээ гаргасан байдаг. Тэгээд энд шийдвэр гаргасан албан тушаалтнууд бол байхгүй мөн хууль хяналтын байгууллагаар хянагдаж байгаа учраас үүнээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй байна.

Археологи геологийн асуудал дээр бол Замын хөгжлийн газрын дарга Одбаяр үргэлжлүүлж хариулна.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: 6 номерын микрофоныг нээе.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Замын хөгжлийн газар Б.Одбаяр.

Тэгэхээр ШУА-д гүйцэтгэгч компани маань археологи палеонтологи болон түүх, угсаатан зүйн судалгаа хийх хүсэлтүүдээ 2026 оны 2 дугаар сарын 27-нд археологийн хүсэлтээ хүргүүлсэн байгаа. Палеонтологийн хүсэлтийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлсэн байгаа.

Хурал нь ШУА дээр болохлоор тухайн зөвлөлийн хурлынх нь гишүүд нь ихэнх нь нас өндөр болсон, байхгүй болсон гэсэн шалтгаанаар удаад, 2026 оны 4 дүгээр сард гишүүдээ цуглуулаад албажуулаад, хүсэлтийг нь албажуулаад, гэрээгээ хийж тайлан дүгнэлтээ 2026 оны 5 дугаар сарын 6-ны өдөр албажуулсан гэдэг тайлбарыг ирүүлсэн байгаа.

Төв угсаатан зүйн хүрээлэн дээр 2026 оны 4 дүгээр сард мөн ШУА-аас зөвшөөрөл нь гараад тайлангаа хийгээд явж байгаа. Арай баталгаажиж амжаагүй байна гэдэг тайлбарыг хүргүүлсэн.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Б.Жаргалан гишүүний микрофоныг нээх үү, тодруулж асуух, хэлэх зүйл байгаа юу? Аудитын 3 номерын микрофоныг нээе.

Нийслэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал: Нийслэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал. Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 2025 онд нийслэлд нийтдээ 3 ААН татан буугдсан байна. 12 ААН шинээр байгуулагдсан. 4 байгууллага үйл ажиллагааны статус өөрчлөгдөөд нийт 45 байгууллага, ААН-ийн 7 байгууллага төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргаж байна. Яг өнөөгийн байдлаар. Нийт 52 ААНБ үйл ажиллагаа явуулсан. Бүх санхүүгийн тайлан бол нэгтгэсэн байгаа. ААН-ийн тайлан гаргаж буй 45 байгууллагын 24 нь ОНӨААТҮГ байна. 21 нь ХХК статустай байгаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгах зарим нэгэн акт албан шаардлагуудыг бол хүргүүлсэн. Ялангуяа хүнс хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг 5 байгууллагад. Цаашлаад тайлан тоонд үйл ажиллагаа явуулаагүй 2 байгууллага, нийслэлийн төсвөөс 100 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардалд зарцуулсан санхүүжилт олгохоор батлахгүй байх зарим нэг албан шаардлага, зөвлөмжүүдийг хүргүүлсэн байгаа. Аудитын илрүүлэлтээр бол 2025 онд 10 ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр 18,5 тэрбум төгрөгийг баталсан байсан. Урсгал үйл ажиллагааны зардалд 7,6 тэрбумыг зарцуулсан байсан. Энийг бол өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд тооцоод зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байгаа.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Б.Жаргалан гишүүнд 35 секунд асууя.

УИХ-ын гишүүн Б.Жаргалан: Тэгэхээр саяын тэр археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгааны талаар Соёлын Өвийн Үндэсний Төвөөс 4 сарын 22-нд ирүүлсэн баримт бичиг дээр ямар ч бүртгэл байхгүй байна гээд байгаа юм. Тэгэхээр та хэд юмыг араас нь хийгээд байх юм? бүх судалгаанууд чинь өмнө нь хийх ёстой байсан байхгүй юу. Тэгэнгүүт араас нь нэг цаас бөглөж байгаа юм шиг. Тэгээд ийм хууль бус зүйлүүд хийгээд байгаа юм.

Сэлбэ дэд төв дээр ерөөсөө олигтой юм ярьж чадсангүй. Цаг олдсонгүй. Ер нь бол төр утаатай тэмцэж байгаа нэрийдлээр байшин барьдаг болчихсон явдал чинь л бодлогын алдаа. Яахлаараа төр 12 мянган айлын орон сууцыг бүр мөнгө босгож барилгын компаниуд дунд тендер зарлаж мөнгийг нь гаргаж, тэр болгоныгоо хянаж байшин барих ёстой юм бэ. Манай үндэсний компаниуд тэрийг чинь хийчхэж чадна шүү. Тэгээд Сэлбэ дэд төв дээр тэгээд дараа нь хэнд ... (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: О.Батнайрамдал гишүүн асуултаа асууж, үгээ хэлье.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Сонсголын 2 дахь өдөр бүтэн суулаа. Тавьсан презентациудыг нэлээн нухацтай харлаа. Нэмэлт асуултуудыг өөрсдөөс нь очоод асуулаа.

1 дүгээрт Төсвийн тогтвортой байдлын зөвлөл орж ирж, нэлээн ноцтой, ноцтой юм яриад гарчихлаа. Хэдэн үг хэлэхгүй бол болохгүй нь. Монгол Улсын нэгдсэн төсөвт учирч буй системийн эрсдэлийг нийслэлийн төсвийн бие даасан байдал гээд тодорхойлчихоод гарлаа шүү.

Сүүлийн 30 жил улсын төсвөөсөө бүх хот, аймаг хараат л явж ирсэн. Гэхдээ Монгол Улс чинь хөгжиж байгаа. Нэг хүнд ногдох ДНБ-ээрээ 7 мянга орчим ам.долларт очиж байна гэдэг бол upper middle class буюу дунджаас дээгүүр орлоготой орны тоонд албан ёсоор ороод эхэлчихсэн байгаа. Тэгэхээр нийслэл томорчихсон, өөрөө орлогоо олоод цаашаа зохицуулаад явах нь бол бид нарын хүссэн хүсээгүй цаашаа хөгжлийн шатдаа явж байгаа. Том хот ингээд л явдаг юм.

Өмнөговийос өгсүүлээд өөрсдөө хангалттай орлого олоод бие даагаад эхлэх энэ боломжийг нь бид нар хааж болохгүй. Сүүлийн 30 жил ганцхан улсын төсөв гэсэн зүйлээс бүх юм хамааралтай байсан, тэр 30 жилийн сэтгэхүй чинь өнөөдөр хүрээд хоцорч байгаа шүү. Хуучирч байна.

Тийм учраас Улаанбаатараа аваачаад төсвийн хувьд бие даасан байдал нь систем эрсдэл гээд дүгнэж болохгүй юм. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлтдээ нэмэлт тайлбар өгөх ёстой. Энийгээ цаашаа залруулах хэрэгтэй. Эсвэл та бүхний үзэж байгаа үзэл чинь хоцорч байна шүү, өөрсөдтэй чинь адилхан. 1 дүгээрт.

2 дугаарт өнөөдөр Туулын хурдны замын талаар ерөнхий сонсголыг нэлээн сонслоо. Гэхдээ яг үнэнийг хэлэхэд би 2,3 их наядаар барьж байгаа дээр уул нь харьцуулсан судалгаа хүлээгээд ерөөсөө харсангүй. Яг бусад улсын жишгүүдтэй, 10 жишигтэй харьцуулмаар байгаа юм. Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд бид нар хурдны зам барьж үзээгүй учраас 2,3 нь юм уу, 5 нь юм уу, 1 нь юм уу мэдэхгүй байна. Бид

нар бүгдээрээ эксперт биш. Энэ дотор ийм өндөр хурдны зам барьж байсан нэг ч хүн байхгүй. Монгол Улс нэг ч хурдны замгүй.

Тэгэхээр яах вэ 2 том сэдэв дээр хоёр 7 хоногийн дотор сонсгол хийгээд, 10 шинжээчийг энэ их материал дээр хоёр 7 хоногийн дотор дүгнэлт гарга гэхээр чинь яг үнэнийг хэлэхэд надад бол төсөөлөгдөхгүй л харагдаад байгаа юм. Ж.Золжаргал дарга ахлаад сонсгол хийж байгааг бол би маш зөв гэж бодож байгаа. Хяналт шалгалтын тухай хуулиар олон нийтэд, татвар төлөгчдөд захиран зарцуулалтын талаар мэдээлэл өгөх нь ерөөсөө буруутгаж болохгүй юм. Энэ бол зөв. Гэхдээ энэний ард нь маш... (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: О.Батнайрамдал гишүүнд минут нэмж өгье.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал: Баярлалаа. Нэгэнтээ маш их мэдээлэл өгөөд ингэж байгаа бол 10 шинжээчдээ хангалттай хугацаа өгөх ёстой байсан юм. Үнэхээр улс төржөөгүй бол бид нар зунжингаа ажиллуулж байгаад намар сонсголыг хийсэн бол илүү үр дүнтэй, шинжээчид хангалттай мэдээлэл дээрээ ажиллаад бодитой дүгнэлт хийх боломжтой байх байсан болов уу л гэж бодож байгаа юм. Тэрнээс биш би шинжээчдийг огтхон ч буруутгамааргүй байна.

Харин ашиг сонирхлын зөрчилтэй байх юм бол энэ дээр өөр хэлэх юм юу ч байхгүй. Ашиг сонирхлын зөрчил байх юм бол тэр шинжээчийн гаргасан дүгнэлтийг ерөөсөө хүчингүй болгох хэрэгтэй. Яагаад гэхээр ашиг сонирхлын зөрчил гэдэг зүйлийн ард ямар ч дүгнэлт хүчингүй байх юм. Тэгэхээр энэ дээр бол ажлын хэсэг маш нухацтай хандах ёстой хуулийн цоорхой байгаа юм байна лээ. Хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт УИХ дээр яригдаж байгаа. Энэ дээр бол шинжээч ялангуяа ерөнхий сонсголын шинжээч ашиг сонирхлын зөрчилтэй байх мэдүүлэг... (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Горим нь ингэж таараад байгаа. 3 минут байгаа. Тэгэхээр асуулт. Саяынхаа асуулттай холбоотой хариулт хүсэж байгаа бол. Тэгвэл О.Батнайрамдал гишүүний микрофоныг нээх хэрэгтэй юм байна.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал: За нөгөө бодож байсан бодлоо мартчихлаа шүү бараг.

2 дугаарт, тэрийг хариуцлагатайгаар хэлье. Ер нь цаашдаа ч гэсэн бид нар сонсгол хийхэд, сонсгол зохион байгуулахад бүр нэг номерт тавих ёстой зүйл, ашиг сонирхлын зөрчил дээр хүн болгон дээр, болохгүй бол ард талын background check хийх ёстой. Яагаад гэвэл маш их үр дагавартай.

3 дугаарт, Сэлбэ дэд төв, манай Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг дээр явж байгаа гялтайх ганц том төсөл юм. Би өөрөө Сүхбаатар Чингэлтэйгээс мандат авч сонгогдсон УИХ-ын гишүүний хувьд энэ дээр байр сууриа илэрхийлэх ёстой. Илүү бодит мэдээллийг өгмөөр байна. Яагаад гэвэл Сүхбаатар, Чингэлтэй дээр би сая иргэдтэйгээ уулзаад явахад бол энэ дээр чих тавин хүлээдэг. Сэлбэ дэд төв төсөл өөрөө манай СБД-ийн 14 дүгээр хороо, Чингэлтэйн дүүргийн 14, 18 дугаар хороонууд дээр баригдаж байгаа том төсөл, 158 га газар чөлөөлөлтөд, 2200 айлын чөлөөлөлтийг маш богинохон хугацаанд хийсэн түүхэн газар чөлөөлөлт болсон байдаг. Анх газар чөлөөлөлтийг явна гэж байхад яг үнэнийг хэлэхэд би бол хувьдаа итгэхгүй л байлаа. Тэр 2200 айлтай хэлцэл хийгээд богинохон хугацаанд чадах уу гэж үнэхээр бодож байсан.

158 га газар 12 мянган айлын орон сууц, үйлчилгээний төв барина гэж байгаа юм. Ер нь Монгол Улсын сүүлийн 30 жилийн төсвийн хуваарилалтыг том зургаар нь аваад үзэх юм бол Улаанбаатар хотын нийт иргэдийн 3-ны 2 нь гэр хороололд амьдарч байгаа мөртөө хамаг хөрөнгө оруулалт нь хэдэн байшингаа тойроод л явчихсан. Гэр хороолол нь дандаа мартагдсан, орхигдсон. Тэр хүмүүсийн дуу хоолой хүрдэггүй. Энэ гэр хорооллын бүс дотор явж байгаа хамгийн том төсөл нь өөрөө Сэлбэ дэд төв мөн шүү. Тэгэхээр тэр хүмүүсийн асуудлыг шийдэж байгаа төсөл дээр бид нар анхааралтай хандах ёстой. Харин алдаанууд байвал бид нар засаад явах ёстой. Энэ дээр бол огтхон ч маргахгүй. 3, 4 дүгээр хорооллыг 1974-1982 оны хооронд 149 га газар 9300 айлын орон сууцны том бүтээн байгуулалт явсан байдаг юм байна лээ. Энэ бол бидний яг харьцуулалт байгаа юм.

Тэгэхээр Сэлбэ дэд төв бол яг нэг тиймэрхүү жишгээр явж байна гэсэн үг юм. Анх 2008, 2009 онд АХБ-ны анхны дэд бүтцийн төслийг нь татах ажил яваад, тэгээд нэг ёсондоо 2023 он хүртэл тэр чигээрээ зогсчихсон, гацчихсан, орхигдчихсон байсан. Тэгээд ерөөсөө сүүлийн 2 жил маш идэвхтэйгээр яваад өнөөдөр нийт хөрөнгө оруулалтынхаа 20 орчим хувь нь ороод явж байгаа төсөл юм. Энэ төсөл явахад дулаан, цахилгаан, усан хангамж хэрэгтэй. Саяын тэр дулаан дээр бол шинжээчийн дүгнэлт дээр ч гарч байна л даа. Би нэлээн тодруулж асуулаа. Сэлбэ дэд төв ашиглалтад ороход нийтдээ бүх тэр үйлчилгээний төвтэй нь барихад 93МВт дулааны хангамж хэрэгтэй, гэхдээ эхний ээлжид баригдаж байгаа тэр 8 мянган айл орчим орон сууц барихад нийтдээ 40-44 МВт хэрэгтэй юм байна. Энэ нь бол өнөөдөр баригдчихсан байгаа Сэлбэ дулаан Дамбадаржаа станцаас, 10 сард ашиглалтад орох Дамбадаржаагаасаа бол хангагдчих юм байна. Тэгэхээр 100% хангагдчихна. Үйлчилгээний төв цаашаагаа баригдаад явахад бол нэмэлтээр дахиад 40-50 МВт хэрэгтэй. Энэнийх нь бичиг баримтын ажил нь явж байгаа юм байна.

Цахилгааны хувьд бол 35,10-ын дэд станц ямар ч байсан баригдчихсан эхний тэр 8 мянган айлын орон сууц барихад цахилгааны асуудал нь шийдэгдчихсэн юм байна. 2027 оны төсөв дээр үлдсэн дахиад цахилгааны нэмэгдэл шаардлага, хангамж нь бол 60 тэрбум орчим төгрөгөөр 2027 оны төсөв дээр орж байгаа юм байна. Тэгэхээр иргэд зөв мэдээлэл авах ёстой л доо. Тэр 8 мянган айлын орон сууц баригдахад сургуультай, цэцэрлэгтэйгээ, нийгмийн барилга байгууламжтайгаа, цахилгаан дулааны хувьд бол шийдэгдчихсэн юм байна. Тэгэхгүй бол юу ч шийдэгдээгүй юм шиг буруу ойлголт явж болохгүй. Энийг би шинжээчээс болон яг тэр Сэлбэ дэд төвийг хариуцаж байгаа албан тушаалтнаас баталгаажуулж энэ дээр байр сууриа илэрхийлэхийг хүсэж байна.

2 дугаар асуулт шинжээчийн дүгнэлт дээр хувилбар 1, хувилбар 2-ыг гаргасан байна. Шинжээчийн дүгнэлт болохоороо тэр төсвийн зардлын эх үүсвэрийн хүрээнд хувилбар 2-ыг дэмжиж байгаа нь өөрийнх нь гаргаж байгаа хувилбар 2 дээр бол хувийн хэвшил нийт эх үүсвэрийн 60%-ийг гаргах хэрэгтэй гэж. Үлдсэнийг нь бол орон нутаг болон төсөв, олон улсын байгууллагууд газар чөлөөлөлтөөрөө газрын эзэд нь гээд явчхаж болно гэж. Энэнтэй бол би шинжилгээний дүгнэлтэд санал нэг байна. Хувийн хэвшил нь илүү давамгайлах ёстой 60 орчим хувийн төсвийг нь гаргах хэрэгтэй. Тэгэхээр одоо байгаа хувилбарыг болохоороо хувийн хэвшил 19,4 гээд үнэлчихсэн байна л даа. 19,4%-ийг нь хувийн хэвшил гаргаж байна. Бусдыг нь улсын төсөв, нийслэлийн бонд гээд. Тэгэхээр энийг баталгаажуулах хэрэгтэй юм уу? Үнэхээр хувийн хэвшил 19%-ийг нь л гаргаж байгаа юм уу, эсвэл шинжээчийн дүгнэлт нь өөрөө зөрөөд байгаа юм уу? Тэгэхээр энийг гаргасан шинжээч болон Сэлбэ дэд төв дээрээ хариуцаж байгаа хүмүүс нь энд яг хариуцлагатайгаар надад

хариулж өгөх хэрэгтэй байна. Яг 2 хувилбар дээр асуултынхаа хариултыг аваад нэмж тодруулъя.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Дэгийн тухай хуулиараа 20 хүртэлх минутад асуулт, хариулт зэрэг явах ёстой. О.Батнайрамдал гишүүн маш их минутаа үг хэлэх маягаар авлаа, 4 минут байгаа хариултад. Нэр, албан тушаалаа хэлээд, 1 номерын микрофоныг өгье.

Шинжээч 3.Туяа: О.Батнайрамдал гишүүний асуултад хариулахад, АХБ-ны тавьсан дэвсгэр дэд бүтэц дээр төсөл хэрэгжиж байгаа. Тэгээд түрүүний танилцуулгад болохоор нийт төслийн хөрөнгө оруулалтад АХБ-ны төсвийн хөрөнгө оруулалтыг оруулаагүй. Тэгээд дээрээс нь нэмэлт дэд бүтцийн буюу дулааны эх үүсвэрийг барих өртөг тооцогдоогүй байсан. Бас авто зам тооцогдоогүй байсан нэмж оруулсан. Дээрээс нь хувиараа хөрөнгө оруулах гэж байгаа бүс буюу түрүүний зураг дээр харуулж байсан улаан бүс дээр байх талбайг корпорацын танилцуулга дээр метр квадрат талбай нь байсан. Тэгэхээр зэрэг одоогийн 113 барилгыг магадлалаар оруулаад төсвийг нь нягтлаад, дундаж үнийг нь 2,5 гэж аваад нийт өртгийн гүйцэтгэлийн төслийн нийт дүн гаргасан.

Тэгээд энэ дотроосоо хэлж байгаа нь өөрт чинь танилцуулсны дагуу 35-ын цахилгаан станцын АХБ-ны нэг эх үүсвэр байгаа. Дахиад нэмэлтээр хэрэгтэй. Тэгээд АХБ-ны тавьсан Сэлбэ дулааны станцаас 21 нь, Дамбадаржаагаас 23 нь, үлдэгдэл буюу өөрөөр хэлбэл 91,8МВт -аас тодорхой хувь нь шийдэгдсэн, тодорхой хувь нь шийдэгдээгүй байгаа. Тэр нэмэлт дээр нь асуудал үүссэн байгаа гэдгийг нь тайлбарласан.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Баярлалаа. Дараагийн хариулах хүнд 8 номерын микрофоныг өгье.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, Мэдээж аливаа төсөл арга хэмжээ ялангуяа барилгын том төслүүдийн дэд бүтцийн асуудлыг бол түрүүлж шийдэх хэрэгтэй. 2013 оноос хойш АХБ-аас санхүүжүүлсэн дэд бүтцийн ажлуудыг 100% ашиглаж байгаа.

Хоёрдугаарт, Сүүлийн өсөн нэмэгдсэн ТЭЗҮ-ийн хэрэгцээгээрээ одоогийн байгаа Сэлбэ болон Дамбадаржаагаас ирэх дулаанаараа бол одоогийн төлөвлөчихсөн 100% хангахаар байгаа. Түрүүний хэлсэн дутагдаж байгаа зүйл дээр бол ТЭЗҮ дээр 63МВт-ын шинэ эх үүсвэрийг барьж байгуулна гэдэг ийм төлөвлөгөөтэй. Гэхдээ төслийн баг бол яг нүүрсэн цахилгаан станцаас жоохон татгалзсан. Яагаад гэхээр Улаанбаатар хот газрын шилжилт гэж яригдаж байна. Газрын гүний дулаан гээд манай төсөл дээр явагдаж байгаа судалгаанууд бол зэрэг явж байгаа.

Хэрвээ 63 МВт-ыг барихаар болох юм бол Сэлбэ дэд төв биш ч баригдаж байгаа Дамбадаржаагийн станцыг өргөтгөх бололцоотой гэдэг дүгнэлт гарсан. Энэ дээр бид нар урьдчилсан тооцоог нь гаргаад зохих албаныханд хүргүүлчихсэн байгаа.

Цахилгааны хувьд мөн бүрэн хангагдахаар байгаа. Чингэлтэй талдаа 80МВт -ын шинэ дэд станцын зураг төслийн ажил нь дуусаад ирэх онд баригдана. Гэхдээ бид нарт шаардлагатай нь 28МВт. Гэхдээ цаашид өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг

бодож энийг хангалттай байдлаар цахилгааны эх үүсвэрийг тавьсан. Мөн цэвэр усны хангамж дээр 2 мянган кубын Шинэ Хайлаастын станцыг нэмж хийж байгаа юм. Яагаад гэхээр өмнө нь АХБ-ны нөгөө хүн амын тооцооллоороо харьцангуй бага тооцсон байсан, одоогийн хэрэглээгээ тооцоод бид нар 2 мянган кубийг нэмж тооцож байгаа. Шинжээчийн дүгнэлтээр ахиад 3500-г нэмэх шаардлагатай гэсэн байна.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Нэмэлт байхгүй. Х.Булгантуяа гишүүнд давхар мэдээлье. Ер нь бол нийт 15 минутаар явж байгаа асуулт хариулт нийлээд тэгэхээр өөрөө асуух асуулттайгаа хариулттай нь бодоод.

УИХ-ын гишүүн Х.Булгантуяа: Саяын О.Батнайрамдал гишүүний асуулт дээр 8 номерын микрофоноос нэмээд хариулчхаарай,

1 дүгээрт, Би зүгээр нэг ийм юм хэлэх гэсэн юм. 25 гишүүн гарын үсэг зурж өнөөдрийн сонсголыг зохион байгуулъя гэсэн байна. Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах тухай гээд 2026 оны 5 сарын 1-нд 25 гарын үсэг зурсан гишүүдээс 2 хоногийн сонсголд 7, 8 гишүүн л оролцсон байна. Бараг 60, 70 төрийн албан хаагчдыг суулгаад, иргэдийн төлөөлөл суугаад ийм олуулаа гарын үсэг зурчхаад өөрснөө санаачилсан гишүүд нь ирж суухгүй юм бол, асуулт асуухгүй юм бол энэ олон төрийн албан хаагчдыг 2 хоног иргэдтэй уулзах ёстой албан бичгийн хариу, цаг нарт нь өгөх ёстой хүмүүсийг ажлыг нь хийлгэсэнгүй шүү дээ. Яг ямар асуултад хариулт авах гээд яг ямар зүйлийг тодруулах гээд үүнийг санаачилсан юм. Тэгээд зарим нь бүр ирцдээ ч орохгүй, нөгөө санаачлаад гарын үсэг зурсан гишүүд нь Байнгын хороонд өөрснөө байдаг гишүүд нь ирцдээ ч орохгүй өглөөнөөс авхуулаад 2, 3 цагийн дараагаар арай гэж сонсгол эхэлж байгаа юм. Ийм байсан юм бол энийг яах гэж санаачилсан юм? Эцсийн зорилго нь яг юу байсан юм? Зүгээр улс төр хийх гэж, эсгүй бол олон төрийн албан хаагчдыг 2 хоног цалинг нь өгөөд бид нарыг хүлээж бай гэж дуудсан юм уу?

2 дугаарт мэдээлэл хийх ёстой сайд нараас нь ганцхан Ц.Сандаг-Очир сайд ирж мэдээлэл хийлээ. Хэрвээ нийслэлийн ийм их төсөвтэй холбоотой мэдээлэл хийх сайд олдохгүй байсан юм бол энэ цагаа зохицуулж болохгүй байсан юм уу? Тэгээд газар хэлтсийн дарга нар ирээд, төрийн нарийн ч байхгүй, хэдэн газар хэлтсийн дарга нар ирээд хөөрхий жоохон сандчихаж байгаад л явах шиг боллоо.

3 жилийн өмнө би Төсвийн байнгын хороон дээр 15 жилийн төсвийн дүн шинжилгээ хийгээд танилцуулж байсан юм. Тэр үед би яг хэлж байсан юм. Ер нь орон нутгийн хөгжлийн сан ганцхан нийслэл Улаанбаатар гэлтгүй бүгдээрээ томорсон 2011-2025 оны хооронд тооцоход орон нутгийн төсвийн зарлага 521 тэрбумаас 8,2 их наяд буюу 15,7 бараг 16 дахин өссөн байна. Энэ бол манай бүх аймгууд нэмэгдсэн, тэгэхдээ муу дүн биш. Энэ бол Монгол Улсын эдийн засаг өсөж байна гэсэн үг. Монгол Улсын нийт төсөв нийлээд нийлээд бараг Рио Тинто гэдэг компанийн цалингийн зардал гэдэг ганцхан зарлагын ангилалтай бид нар тэнцэхүйц хэмжээний тийм эдийн засагтай улс. Тийм учраас нэмэгдэж байна гэдэг бол сайн зүйл. Гэхдээ үр дүнтэй зарцуул гэж ярьж байгаа нь зөв зүйтэй, иргэдийн санал бол зөв зүйтэй.

Энд юу ярьж байгаа вэ гэхээр улсын төсөвт төвлөрүүлдэг наймхан аймаг байдаг. Хэдхэн жилийн өмнө дөрөвхөн аймаг байсан одоо 8 аймаг болж байна. Бид нар уг нь бол төвлөрүүлж байгаа аймгуудыг эдийн засгийн хувьд илүү их эрх чөлөөг нь олгоё гэж уриалаад байгаа юм. Дандаа улсын төсвөөс бүгдээрээ авдаг байж

болохгүй. Зарим нь болохоороо аймаг, орон нутгаа ухуулж, ухуулж, иргэд нь бухимдаж, бухимдаж, зарим нь өвөлжөө ч байхгүй гээд, хаваржаа... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Х.Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Х.Булгантуяа: Хэдэн төгрөг олоод тэрүүнийгээ улсын төсөвт төвлөрүүлээд зарим нь болохоороо дуу хуураа дуулсаар байгаад улсын төсвөөс мөнгө аваад сууж байж болохгүй. Гэтэл сүүлийн үед улсын төсөв УИХ дээр юу яригдаж байна гэхээр улсын төсөвт төвлөрүүлж чадахгүй, тэр битгий хэл бүх албан хаагчдынхаа цалинг улсын төсвөөс авч байгаа мөртөө дарга нарынхаа томилгоог бид нар хийнэ. Нөгөө дарга нарынхаа цалинг ч тавьж чадахгүй байгаа. Яг үнэнийг хэлэхэд томилох гээд байгаа дарга нарынхаа цалинг ч тавьж чадахгүй байж томилгоогоо бид нар хийнэ. Харин төсвөө бид нар бүрдүүлж чадахгүй. Тэр бүрдүүлэх хэдэн аймгууд бид нарт бүрдүүлж өгөөрэй. Бид нар дарга нараа томилно гэдэг. Сүүлийн үед манай А.Ариунзаяа гишүүн ядаж хүүхдийн салбараас гараа татаач, савраа татаач гэж хэлж байгаа нь бол бүр аргаа барсан хэрэг.

Тэгэхээр би сонсголын эцсийн зорилго нь бид нар яг юу гэж дүгнэх гээд байгаа юм бэ? Үнэнийг хэлэхэд улсын төсөв дээр бид нар... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гишүүний микрофоныг нэмж өгье.

УИХ-ын гишүүн Х.Булгантуяа: Үнэнийг хэлэхэд. Улсын төсөв дээр нийслэлтэй холбоотой хөрөнгө оруулалтуудыг ерөөсөө тавихаа больсон. Манай БЗД бол 3 ээлжийн сургуультай болж байна. Сургууль цэцэрлэгийн хүртээмж хүнд болж байна гэж хэлэхээр бүгдээрэнг нь нийслэлийн төсөв дээр л шийд, нийслэлийн төсвийг чинь тавьчихсан шүү дээ гэж хэлдэг болсон. Нийслэлтэй холбоотой хот тохижилт, зам гүүр юу ч улсын төсөв дээр тавихаа больсон. Энийг бүгдээрэнг нь шийд гэж байгаа. Тэгсэн мөртөө сумтай холбоотой болохоороо сумын тохижилт, сумын цэцэрлэгжүүлэлт, бараг сумын худаг бүгдээрэнг нь улсын төсөв дээр тавьж байгаа юм. Тэгэхээр Сангийн яам, ЗГ-аас төсвийн реформоо нэг хийхгүй юм уу, яг улсын төсөв дээр юугаа тавих юм. Худгаа тавих юм уу, лифтээ тавих юм уу? тэгсэн мөртөө өнөөдөр 3 мянган хүүхэдтэй болсон сургуулийн өргөтгөлийг тавихгүй юм уу, тэрүүнийг нь болохоороо нийслэл л шийд гээд хаячихдаг. Хэрвээ нийслэлд Монголын хүн амын тал нь амьдарч байгаа нийслэл энэ бүгдийг шийднэ гэвэл төсөв нь том байхаас өөр арга байхгүй.

Орон нутаг нь бүгдээрээ шийднэ гэвэл зарчим бүх орон нутагт адилхан үйлчлэх ёстой. Бид нар НИТХ-ын төлөөлөгчөөс манай дүүрэгт цэцэрлэг бариад өгөөч гээд гуйгаад байх чинь аягүй хэцүү биз дээ. Яагаад гэвэл ард түмэн сонгочихсон юм чинь. Бид нараас ч гэсэн үүнийг шаардаж байна. Манай хүүхэд 3 ээлжийн сургуультай болчихлоо гишүүн минь гээд, манай хороо цэцэрлэггүй болчихлоо гээд шаардахаар би ч тийм эрх мэдэл байхгүй дээ. Дүүргийнхээ төлөөлөгчөөс, нийслэлийн төлөөлөгчөөсөө гуйя даа гэж би хэлэх болчихоод байгаа. Яагаад гэвэл улсын төсөв дээр хоттой холбоотой ямар ч хөрөнгө оруулалт тавихгүй шүү гэж Сангийн яам сүүлийн хэдэн жил шийдсэн. Сүүлдээ манай нийслэлийн төсөв, улсын төсөв ийм болсон.

Зарим аймаг орон нутгаас сумдын сургууль цэцэрлэг бүр сая 2027 оны хөгжлийн төлөвлөгөө дээр дотуур байр, дотуур байрны тохижилт, дээрээс нь нэмээд

дээврийг будах гээд баахан ажил тавьснаа хоттой холбоотой юу ч тавихгүй, хотыг бол хот шийд гэдэг ийм бодлого баримталж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээрээ Сангийн яам, ЗГ нэгдсэн журмаар нэг бодлоготой болохгүй юм уу. Бид нар ямар аймгийнх нь компьютерыг нь тавиад, принтерийг нь тавиад, худгийг нь тавиад, гадна фасадыг нь тавиад, ямрынх нь болохоороо сургуулийг нь ч шийддэггүй, цэцэрлэгийг нь ч шийддэггүй юм. Монгол Улсын иргэд чинь хэнийх нь өврөөс зарим нь гараад, хэнийх нь хойноос зарим нь төрчихсөн юм шиг ийм байх ёстой юм бэ? Гэтэл зарим аймаг орон нутаг болохоороо саяхан Дундговь аймгийн Засаг дарга Мөнхчулуун дарга хэлж байсан. Манай Гурвансайхан сум дээр 9,5 тэрбумаар сумаа гороолох эргэн тойронд нь зам тавьчих юм. Гишүүд нь өөрснөө санаачлаад. Тэгэхээр яг үүн шиг төсөв чинь улсын төсөв хүртэл ийм замбараагүй болчихсон байгаа цаг үед Төсвийн байнгын хороо бүгдийг нь авч хэлэлцэхгүй юм уу? Сая бид нар намар улсын төсөв хэлэлцэхэд 1,2 их наядын шинэ төв... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Уучлаарай. Х.Булгантуяа гишүүний минутыг нийтдээ 15 минутаар явж байгаа. 6 минут 53 байна. Асуулт хариулт гээд хуваачихсан байгаа. Х.Булгантуяа гишүүний микрофон.

УИХ-ын гишүүн Х.Булгантуяа: Тэгэхээр бид нар үүнийгээ цэгцлэх цаг нь болсон л гэж хэлэх гээд байгаа юм. Тэрнээс биш би 2 хоног 60, 70 төрийн албан хаагчид энд ирж суугаад санаачилсан гишүүд нь ч байхгүй. Бүгдээрээ бие биеийнхээ царайг харж байгаад жоохон бухимдлаа илэрхийлж байгаад, сошиалаар зөв буруу мэдээллүүд цацаж байгаад дуусах ёсгүй гэж бодож байна.

Үүний ард ялангуяа хууль тогтоох байгууллага УИХ төсвийн реформоо хийх цаг нь болжээ. Нийгмийн үйлчилгээг үзүүлэх суурь хөрөнгө оруулалтууд гэж нэг ангилалтай. Эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегийн хөрөнгө оруулалт гэж нэг ангилалтай. Европын олон улсууд тийм байдаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах хөрөнгө оруулалт гээд батлан хамгаалах онцгой байдал ч гэдэг юм уу хөрөнгө оруулалтуудтай. Орон нутаг нь аль нь энийгээ авч явах юм. Улсын төсөв маань алийгаа авч явах юм гэдэг ангилалтай, юун дээр хувийн хэвшлийг оруулах юм бэ гэдэг ангилалтай. Энэ бүгдийг бид нар шийдэхгүй бол 5 жилийн дараа ахиад л ийм сонсгол болох байх шүү.

Аймаг орон нутгууд улсад төвлөрүүлж байгаа аймаг орон нутгуудыг бол тодорхой хэмжээний эдийн засгийн эрх чөлөөтэй байх ёстой гэж боддог. Манай Өмнөговь аймаг өнөөдөр төвлөрүүлсээр байгаад, өнөөдөр эрчим хүчээ ч шийдэж чадаагүй аймаг байдаг. Тэгэхээр эрх чөлөөг нь олгох ёстой, тэгэхдээ одоо харахад араас нь манай Өмнөговийнхон маань сайн харж байгаа байх. Сонсгол хийх юм шиг байна шүү. Тэрүүнийг нь хулгайг нь тогтоох байгууллагууд нь тогтоох байлгүй дээ.

Би таныг юм ярьж байхад юу ч яриагүй шүү дээ. Тэгэхээр бие биедээ хүндэтгэлтэй хандъя.

Бид нар бүгдээрээ үүнээс дараагийн гарц гаргалгааг гаргая. Сонсгол даргалагч зөвлөмж байх ёстой гэж би бодож байна. Энэ 2 хоног үр дүнтэй байх ёстой гэж бодож байна. Дараагийн реформуудаа дараагийн хяналтын механизмуудыг бий болгож байж төсвийн томоохон шинэчлэлүүд үр дүнгээ өгнө гэж би бодож байна. Тэгээд түрүүн О.Батнайрамдал гишүүний асуултад 8 номерын микрофон дээрээс нэмээд хариулчхаач тэгэх үү?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 8 дугаар микрофон нээж

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Дэд бүтцийн хувьд түрүүний ярьсанчлан бүрэн хангагдсан гэж би хэлнэ. Дээрээс нь хүний нүдэнд харагдахгүй буюу хөрсний, усны түвшнийг доошлуулах цогц систем хийгдэж байгаа. Энэ ажил нь яг хийгдэж байгаа.

Эдийн засгийн хөрөнгө оруулалтын агуулгаар нь шинжээчийн гаргасан тооцоо, манай тооцоо 2 бол харин энэ дээр мөргөж байгаа. Яагаад гэхээр ер нь том төслүүдийг цаашид хувийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувиар шийдэх хэрэгтэй. Энэ удаад бол бид нарын тооцоогоор 54-60% нь хувийн хөрөнгө оруулалтаар шийдэгдэх юм байна. Том агуулгаар ярихад бид нар орон сууц л яриад байгаа болохоос энэ чинь 20 минутын хот цогцолборын хүрээнд шинэ дэд төвийг бий болгож байгаа. 3 орчим их наяд төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг нь бүрдүүлж байгаа юм. Тэгэхээр хотын эдийн засгийн асуудал яригдана.

Зөвхөн одоогийн хэрэгжиж байгаа 2 орчим их наядын хөрөнгө оруулалт маань барилгын салбарт ямар их дэм болж байгаа билээ. Шууд утгаараа бүх барилгын гүйцэтгэж байгаа болон бэлтгэн нийлүүлж байгаа, үүнээс цалинжиж байгаа бүх хүмүүсийн орлогод шууд нөлөөлж байгаа. Тэгэхээр төсөл өөрөө зөвхөн орон сууц бариад метр квадратаар борлуулах биш өөрөө төсөл хэрэгжих явцдаа хэрэгжсэнээсээ хойшдоо маш олон төрлийн ач холбогдолтой. Энийг бол зүгээр би өмнө нь нэг хариулт дээрээ хэлсэн. Нэг удаа хийчихсэн юм биш, сүүлийн арваад жил ярьж байгаа төлөвлөж байгаа маш олон ТЭЗҮ байгаль орчны үнэлгээ судалгаа бүгд дандаа сайжруулахын тулд явсан. Тэгэхээр өнөөдрийн нөхцөл байдал дээр бол одоогийн хувилбараараа хэрэгжиж байгаа.

Тэгэхээр мэдээж шинжээч маань маш богино хугацаанд, бид нар хүртэл ТЭЗҮ-тэйгээ жил гаран ноцолдож байна. Ард нь гарах гээд л байж байна. Тэгэхээр шинжээч, шинжээчийн баг богино хугацаанд ажилласан гэхэд зарим зүйл дээр бол санал нэгдэхгүй байгаа ч гэсэн би хөрөнгө оруулалтын зардал дээр бол санал нийлж байгаа. Ер нь цаашид иймэрхүү төслүүдийг зөвхөн газар чөлөөлөлт болон дэд бүтцийг нь төр хариуцаад бусад хөрөнгө оруулалтын боломжийг нь хувийн хэвшилд нээж өгөх ёстой гэдэг ийм байр суурьтай байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Х.Булгантуяа гишүүн болсон уу? Баярлалаа.

Би та бүхэндээ нэмж мэдээлэл хийх хэрэгтэй юм шиг байна. Сонсголд мэдээлэл хийх, танилцуулга хийх хүмүүсээс Ерөнхий аудитор С.Магнайсүрэн ирсэн. Ц.Сандаг-Очир сайд танилцуулга хийсэн, Б.Энхбаяр сайд Хэрэг эрхлэх газрын дарга танилцуулга хийсэн. Шинжээч нар танилцуулга хийсэн. Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яамнаас ТНБД М.Баяраа танилцуулга хийсэн. Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан Дорноговь аймагт ажилтай явж байгаа, төлөөлөл ирүүлсэн байна.

Хурал даргалагчийн үүднээс асуултын хэсэг дуусаж байгаа учраас хэдэн тоон дээр дахиад тодруулах шаардлага байна.

Сэлбэ дэд төвөөс би төслийн удирдагчаас хэдэн тоо асуугаадахъя. Төслийн нийт өртөг маань 2,3 их наяд уу, 4,3 их наяд уу, 5,3 их наяд уу, бүгдээрэнг нь нийлсэн тэр тоон дээр. 8 дугаар микрофон.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя. Эхлээд бид нар 113 блок байшингийн төсөвт өртөг дээрээ тойрч ярих хэрэгтэй байх. Үүнтэй холбоотой дэд бүтцийн зардлууд болон барилга угсралтын зардлууд маань 2,3 их наяд болж байгаа. 5,3, 5,7 гэж байж байгаа. Бид нарын тооцоогоор 5 орчим дээр эргэлдэж байгаа. Төсөл бүхэлдээ 58 га дээр хувийн хэвшил болон нийгмийн дэд бүтцүүд бий болсон түүнд зарцуулагдах урьдчилсан тооцоо юм. Нийт эдийн засгийн хувьд тийм тооцоо гарч байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 5,8 их наядаас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай тэр үйлчилгээний хэсэг нь тийм хэдэн төгрөг вэ?

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Энэ дээр бид нарын тооцоогоор 3 орчим их наяд төгрөг гэж тооцоолж байгаа. Мөн нэмж хэлэхэд хувийн хэвшилд санал болгож байгаа 40 орчим гагаас төсөл тодорхой хэмжээний өгөөж хүртэхээр төсөөлөлтэй байгаа. Урьдчилсан байдлаар 416 тэрбум төгрөгийг энэ бүсээс хөрөнгө хэлбэрээр ирээдүйд олох боломж нийслэл дээр байгаа. Энэ бол орлогын тухайд бол сая ерөөсөө дурдагдаагүй нэг ажил байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 1 м.кв талбайн өртөг 3 сая 700 юу, 4 сая 800 юу?

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Магадлагдсан төсвөөр 1 м.кв талбай маань барилгын талбайгаараа 2 сая 460 мянга, үүнд бол НӨАТ болон барьж байгаа компанийн зардал, ашиг, төслийн менежментийн төслийн багийн хэрэгжүүлж байгаа 2%-ийн зардал, магадалшгүй, зохиогчийн хяналт бүх зардлууд орсон. Ашигтай талбай руугаа шилжүүлэхээр 3 сая 460 мянга болж байгаа юм. Нийтийн эзэмшлийн талбайнуудаа хасаж тооцож байгаа юм. Тэгээд дэд бүтцийн гадна тохижилтынхоо зардлыг нь өгвөл 3,8 орчим саяд багтаж байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Борлуулах үнэ нь хэд байх вэ?

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Борлуулах үнэ дээр бид нар 3 хувилбартай байна. Яг одоогоор эцэслээгүй шууд өртгөөрөө борлуулах 3,8-аар боломж байна. Эсвэл 4,10-ны зах зээлийн дундаж ханшаар борлуулах нэг төлөвлөгөө байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 3,8 нийт өртөг дотор нөгөө бонд, зээлийн хүү, санхүүгийн зардлууд багтсан гэж ойлгох уу? 8 номер нээгээд өгнө үү.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Бондын хүүгийн зардал 3,8 дотроо бол багтаагүй байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэгэхээр чинь зүгээр бизнесийнхээ зарчмаар бол 4 сая гаран 4,8-аар зарж байж нөхөх маягийн л тоо байгаа юм. Тэгэхээр явж явж энэ хэмжээний өртөг нэгэнт л хүрч байгаа бол нөгөө хувийн хэвшил ороод хийгээд ашгаа аваад, баяжаад явахад ийм дүн гарчхаад

байна. Тэгэхээр бид нар эргээд бодох хэрэгтэй. Түрүүн яриад байсан ер нь бол хувийн хэвшлийн оролцоо нэлээн илүү байж энэ чинь явах юм биш үү гэж яриад байгаа дүгнэлттэй бол санал нийлээд байх шиг байна.

Бас нэг асуулт байна. 12 мянган орон сууц гээд нөгөө 500 сая доллар бонд босгох үеийн бичиг баримт. Одоо бол 8500 арай хүрэхгүй байна. 490 хэд ч билүү тэгээд 3500 орон сууц хаачсан бэ гэдэг асуулт.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Төслийн нийт 158 га талбайн хүн амыг анх захиалахдаа 50 мянган хүн амтай байхаар ажлын даалгаварт боловсруулж өгсөн. Энэ хүрээнд 12 мянган айлын орон сууц энэ бүс нутагт боломжтой гэдэг ТЭЗҮ байгаа. Үүнээс 3500 нь хувийн хэвшлээр, үйлчилгээтэй орон сууц хэлбэрээр ерөнхий болон хэсэгчилсэн байдлаар тусгасан. 113 блок, 9-өөс 12 давхар орон сууц нь 8575 айлын орон сууц байгаа.

Тендерийн явцад 10 мянган айлын орон сууц гэж яригдсан. Төслийн баг нэг айлын дундаж метр квадратыг зураг төслийн хүрээнд нэмэгдүүлж 61 м² болгосон. Энэ ямар зорилготой вэ гэвэл хот байгуулалтын хүрээнд бүх төрлийн худалдан авагч сегментүүд энд төвлөрөх ёстой гэж үзэж байгаа. 33-89 м²-ын 11 төрлийн орон сууц. 60 м²-ыг яагаад сонгосон бэ гэвэл ипотекийн зээлд хамрагдаж байгаа дийлэнх нь 60 м²-ыг худалдаж авч байгаа. Мөн бид орон сууцны үнэ хэд байх вэ гэдэг нь ипотека дээр өнгөрсөн хугацаанд олгогдсон нийт санхүүжилтийн 70-с дээш хувь нь дунд болон дундаас дээш орлоготой буюу 3,5-аас 4 сая төгрөгийн орлоготой иргэдэд олгогдсон юм байна лээ. Тэгэхээр бид нарын зорилтоо бол зорилтот бүлэг гэж яриад байгаа худалдан авах чадамж бүхий иргэд гэж харж байгаа. Манай дундаж орлого нь 2,5 сая төгрөг байгаа. Ипотекийн өнөөдөр мөрдөгдөж байгаа шаардлагын хүрээнд энийг худалдаж авах чадвартай хүн 30 хувийн урьдчилгаатай, үүнийг 6-аас 8 хувийн хүүтэй, 30 жил хүртэлх зээлээр авахад дундаж орлого нь 2,5 сая төгрөгийн орлоготой байхад дүйцэхүйцээр төлөвлөсөн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэгэхээр орлогодоо тааруулж талбайгаа нэмсэн болохоор 3500 орон сууц байхгүй болсон. Гэхдээ энд хоёр асуудал байгаа. Нэгдүгээрт, анх бонд босгох шийдвэр гаргахдаа 12 мянга гэж байсан. 3500 гэдэг чинь асар том тоо. Тэгэхээр энэ шийдвэр гаргаж байгаа хүмүүс тэр хэмжээний айлын орон сууцыг хангах юм байна гэж шийдвэр гаргаж байгаа.

Дараа нь явцын дунд өөрчлөгдөнө гэдэг бол үндэслэл, тооцоолол өөрчлөгдөж байна гэсэн үг. Том төслүүд дээр өөрчлөгдөх нь өөрчлөгддөг. Гэхдээ ТЭЗҮ, зураг төсөл хоёрыг багцаар хийсэн гэж байгаа. Энэ багц ажил гэдэг юм бол, ТЭЗҮ гэдэг чинь юу хийх гэж байгаа цар хүрээгээ тодорхойлоод, түүн дээрээ тулгуурлаад байшингийнхаа нарийвчилсан зургаа хийдэг. Хоёуланг нь нийлүүлж өгчихөөр явж байх хооронд өөрчлөгдөөд байдаг ийм л асуудал.

Энэ ташрамд хэлэхэд худалдан авалтын хууль дээр бид нар бас ийм юм яриад байгаа. Мега төслийг хурдан явуулахын тулд багцаар нь хийхгүй бол болохгүй гэж. Энэ дээр маш том эрсдэл гардаг, энэ бол төслийн удирдлагын асуудал. Миний 15 минут дуусах дөхөж байгаа тул би дахиад асууна.

Ингээд 500 сая долларын бондыг 2027 оны 10 сараас төлж эхлэх юм байна. Тэгэхээр одоо үүнийг яах вэ? 2027 оны 10 сард орон сууц зарагдахгүй бол Сэлбэ 20 төслийг түрээслээд шилжүүлэх юм байна. Үүн дээр ямар төлөвлөлттэй байна вэ? 8 дугаар микрофон.

НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах: Сэлбийн бондыг бид нар 2,8 жилийн хугацаатай, 7,75 хувийн хүүтэйгээр 500 сая долларын хэмжээтэй гаргасан. Одоо бид нарт бондын үлдэгдэл мөнгө гүйцэтгэлтэйгээ уялдаад 1,5 их наяд төгрөг байгаа. Тэгэхээр бид нар 2027 оны 8 сарын 21-нд Сэлбийн борлуулалттайгаа уялдаад, одоогийн тооцоолж байгаагаар 200 сая долларыг эргэн төлөөд, 300 сая долларыг борлуулалтын гүйцэтгэлтэй уялдуулаад сунгах төлөвлөгөөтэй байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сунгахаар хүү нь хэд байх вэ?

НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах: Одоогийн байдлаар бид нар тооцож үзэхэд 7 орчим хувьтай байна гэж үзэж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Дахиад нэг асуулт байна. Энэ 2 мянган айлын газрыг ойролцоогоор 400 тэрбум төгрөгөөр чөлөөлсөн. 2 мянган айл хаана байгаа талаар судалгаа байна уу? 8 дугаар микрофон.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Богино хугацаанд шууд худалдан авалтаар чөлөөлсөн нэг давуу тал харагдаж байгаа. Нөгөө тал нь энэ иргэд хаачсан бэ гэдэг асуудлыг төслийн багийн хувьд дараа дараагийн газар чөлөөлөлт дээр анхаарах шаардлагатай гэж үзэж байгаа. Урьдчилсан байдлаар 3 хорооны иргэдээс, хорооны бүтцээс авсан мэдээллээр 8-аас 10 орчим хувь нь л орон сууцанд орсон гэдэг мэдээлэл өгсөн. Бусад нь өөр агуулгаар зарцуулсан гэдэг мэдээлэл урьдчилсан байдлаар байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Гэр хороололд энэ байшин барилга, орон сууц үнэхээр хэрэгтэй байгаа. Д.Энхтүвшин гишүүн түрүүн асуугаад байсан. Утааны бодлого хаана байна вэ гээд. Айлуудыг шилжүүлж байгаа бол утаагаа бууруулж байх ёстой. Гэтэл нөгөө иргэд маань 200 сая төгрөг барьж аваад дахиад нэг газар хашаа хатгаад суучихсан байх магадлал өндөр байна. Тийм болохоор бодлогын дүгнэлт хийнэ гэдэг бол сонсголын бас нэг ач холбогдол. Энэ орон сууцны төсөл хэрэгтэй гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхдээ концепц, үзэл санааг нь өөрчилж, олон хүмүүс ажиллаад, олон хүмүүс ашиг хийгээд аль аль нь сэтгэл хангалуун үлдэх ёстой болохоос өндөр үнээр зарагдаж байж эцсийн дүндээ өртгөө, үр ашгаа нөхөх гээд байгаа юм шиг харагдаж байна.

Хаана төрийн үйл ажиллагаа, хаана бизнесийн аж ахуйн үйл ажиллагаа, түүнийг хэн хийх вэ, энэ олон хүмүүс ажлаа хийе гээд л ажиллаж байгаа байх. Гэхдээ тэр дунд эрх мэдэл, боломж гэдэг хажуугаар нь буруу юм явах олон нүхийг бий болгодог л доо. Тийм болохоор хүмүүс орон сууцтай болж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ энэ дээр их анхаарах хэрэгтэй гэдгийг нэмж хэлье.

Надад дахиад хугацаа байгаа. Би өчигдөр асуусан бичгийн талаар НИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга ирсэн байгаа гэсэн. Тэр зөвлөлийн данснаас 70-аад тэрбум төгрөг зарцуулсан гээд мэдээ яваад байна. Авлигатай тэмцэх газарлуу 280 сая төгрөгийн шилжүүлэг хийгдсэн гэсэн. Энэ тал дээр мэдээлэл өгөөч. Ямар хэмжээний төсвийг 2024, 2025, 2026 онуудад ямар зорилгоор зарцуулсан бэ, үр дүн нь ямар байгаа вэ?

7 дугаар микрофон, дараа нь 4 дүгээр микрофон.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар:

Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Энэ нэг жоохон төөрөлдсөн асуудал яригдаад байх шиг байна. Өнөөдөр өглөө хуралдаан даргалагчаас 10 цагт албан тоот хүлээж авсан. Энэ албан тоотын хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл болон Гамшгийн зөвлөлтэй хамааралтай 150 хуудас материал бэлтгэж, цахимаар хүргүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүрэгт ИТХ-ын даргаар ахлуулсан орон тооны зөвлөл зохицуулна гэж хуульчилсан. Энэ хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн зөвлөл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл ажиллаж байгаа. Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн талаарх мэдээллийг хурлын ажлын албаны даргын хувьд та бүхэнд хүргэе. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл ажлын албатай учраас ажлын албаны дарга Б.Оюу-Эрдэнэ энэ талаар мэдээлэл өгнө.

Гамшгаас хамгаалах зөвлөл 2022 онд байгуулагдсан, ажиллах журмаа баталсан. Энэ хүрээнд бол гол зохион байгуулалтын ажлыг бол хийдэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд гамшгийн эрсдэлийг бууруулах онцгой байдлын байгууллага, Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, бусад төрийн чиг үүргийн байгууллагууд, нийслэл, дүүргийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоог хангаж үйл ажиллагаа явуулдаг. Нийслэлийн хэмжээнд 2025–2026 оны байдлаар гал түймрийн дуудлага 7757, түүнчлэн аюултай үзэгдэл, осол... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Микрофоныг нэмж өгье.

Та шилжүүлсэн мөнгөний дүн, зорилгыг нь хэлж өгөөрэй.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар:

Гол нь энэ дуудлага мэдээллийг хэлж байгаа нь улсын хэмжээнд гарч байгаа дуудлагын 55 хувь нь нийслэлд хамаарч байгаа. Ийм учраас нийслэлийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлж ажиллаж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Олон дуудлага ирдэг болохоор үйл ажиллагааных нь зардалд дэмжлэг үзүүлж байгаа гэсэн үг үү?

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийнхөө нэг хувиас доошгүйг зарцуулахаар тооцож төсөвт тусгахаар заасан. 2025 онд 3,5 тэрбум, 2026 онд 6 тэрбум төгрөг төлөвлөсөн. НИТХ дээр буюу гэмт хэргийн зөвлөл дээр 68 тэрбум гэж яригдаад байгаа. Үүний 6 тэрбум нь гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийнх байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэмж цаг өгье.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар:

Дээр нь шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийг байгуулахад гол зарцуулалт явсан. Энэ төвийг байгуулах гол шалтгаан нь шуурхай ажиллагааг зохион байгуулах нэгдсэн хяналтын систем нийслэлд байхгүй, техник тоног төхөөрөмжийн үзүүлэлт

ашиглалтын шаардлага хангахгүй байсан. Өнөөдөр энэ мэдээллийн эрин зуунд тоног төхөөрөмжийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай. Мөн шуурхай удирдлагын төв нь ЦЕГ-ын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс дуудлага, мэдээллээ авдаг. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, нягтралыг тооцох, шуурхай албаны автомашины хөдөлгөөнд хяналт тавих боломжгүй байсан зэрэг олон шалтгааны улмаас энэ төвийг тохижуулах ажил хийгдсэн. Үүний 4,7 буюу бараг 5 тэрбум төгрөг нь шуурхай удирдлагын төвийн программ хангамж, хөдөлгөөний хяналтын программ хангамж дээр зарцуулагдсан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нөгөө 68 тэрбум гэдэг чинь юу юм? Бусад нь юугаар бүрдэж байгаа юм, тоонуудыг нь хэлж өгөөч. 4 дүгээр микрофоныг нээж өгнө үү.

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Оюу-Эрдэнэ: Сайн байцаана уу. Та бүхэнд энэ оройн амар амгаланг айлтгая. Таны явуулсан албан бичиг дээр 280 сая төгрөгийг Авлигатай тэмцэх газарлуу шилжүүлсэн гэсэн байна. Үүнд хариулт өгье.

Манай 2025 оны төсөвт тусгагдсан төлөвлөгөөний хүрээнд яг 280 сая биш, 119 сая төгрөгийг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн гишүүн байгууллага руугаа шилжүүлсэн. Энэ ямар арга хэмжээ байсан бэ гэвэл улсын хэмжээнд иргэд, олон нийтэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулах төлбөрт 119 сая төгрөгийг шилжүүлсэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 2025 оны дүн байна тэ?

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Оюу-Эрдэнэ: Тийм

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 2024 оны дүн танд байгаа юу?

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Оюу-Эрдэнэ: Байхгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 2026 оных?

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Оюу-Эрдэнэ: 2026 онд бол Авлигатай тэмцэх газарлуу...

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Энийг яагаад асуугаад байна вэ гэхээр энэ мэдээлэл гадуур яваад байна. Сэтгүүлч нар санаа зовоод асууж тодруулаад байгаа юм. Цаад санаа нь юу юм бэ гэхээр зорилго нь тодорхойгүйгээр АТГ, онцгой байдал, цагдаагийн газар луу мөнгө шилжүүлээд, үүгээрээ ямар нэгэн юм хаацайлж байгаа юм биш биз дээ гэсэн асуудал ирүүлээд байх юм. Тэгэхээр энэ асуултынх нь хариултыг сонсголоор та бүхэн тайлбараа хэлж, санаа зовж байгаа хүмүүсийг тайвшруулах буюу анхаарал хандуулах шаардлагатай.

Иргэдийн хурлын дэргэдэх зөвлөлөөс АТГ луу 2024 онд 319, 2025 онд 119 сая

төгрөг шилжүүлсэн гэсэн нэмэлт мэдээлэл ирж байна. 2026 онд 242 төлөвлөсөн юм уу, явчихсан юм уу. Нийтдээ сүүлийн 3 жилд 680 сая төгрөг. Онцгой байдал, цагдаа гээд нийлбэр дүн нь 3 жилийн 1,2 тэрбум төгрөг харагдаж байна. Энэ бол төсөв батлаад эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын асуудал. Гэхдээ энэ мэдээлэл яваад байгаа учраас шалгаад тодорхой хариулт өгөх нь зөв. Нэмж хэлэх зүйл байгаа юу? 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Оюу-Эрдэнэ: Энэ дээр юу байгаа юм? ХЗДХЯ-ны 17 дугаар тогтоол байгаа. Тээврийн цагдаа буюу олон нийтийн цагдаагаас нийт 319 албан хаагчийг 2025 оны 4 сарын 8-ны өдөр ЦЕГ-ын дарга Сүхболд болон Нийслэлийн иргэдийн хурлын дарга Баяр нар хоорондоо 2 жилийн хугацаатай гэрээ хийгдээд явж байна. Түгжрэл бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс эдгээр албан хаагчийн цалин хөлс, нийгмийн даатгал, байрны ашиглалтын зардлыг нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс гаргаж байгаа... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Д.Үүрийнтуяа гишүүн түрүүн асуулт асуугаад хангалттай хариулт аваагүй гэсэн. Зам тээврийн хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төвийн 2 магадлалын зөрүү гэдэг асуудал ярьсан. Аль аль нь өөрийнхөө мэргэшсэн чиглэлээр үе шаттайгаар хийдэг гэсэн ерөнхий хариулт авсан. Энэ дээр нэмж тодруулъя. Д.Үүрийнтуяа гишүүн асуултаа гүйцээж асууя.

УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа: Хуралдаан даргалагчид баярлалаа. Ерөнхий аудитор бас ирсэн байгаа дээр тодруулах асуултуудаа дахин тодруулъя. 2 янзын газар дүгнэлт, магадлал хийгээд байна. Зам тээврийн хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв. Энэ хоёр өөр дүнтэй, нэг жил хүрэхгүй хугацаанд их наядаараа зөрөөтэй магадлал хийгээд байна. Туулын хурдны зам дээр аль магадлалыг нь барих ёстой байсан юм бэ? Аудитын дүгнэлтээр юу гэж гарсан бэ? 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар магадлал нь хийгдээгүй 1,9 их наяд төгрөг ороод тусгагдчихжээ гэдэг асуудал шалгалтаар гараагүй юм уу? 2025 онд нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийгдээгүй юм уу гэдгийг тодруулж байна.

Нөгөө 2 магадлалын төвөөс ч энэ дээр тодруулж хариулж өгөөч. Дээр нь Зам тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга хоёр хамтарсан шийдвэрээр гэж байгаа. Аудитор тайлбарлахдаа үүнийг урьдчилсан дүгнэлт байсан юм шиг яриад байгаа. Энэ үнэхээр хүчин төгөлдөр, эрх зүйн акт мөн юм уу, биш юм уу? Энийг тодорхой болгож өгөөч. Мөн Худалдан авах ажиллагааны газраас асуусан асуултад хариулт аваагүй. Нийслэл бас үүн дээр хариулж өгөөрэй. Тэр нь юу вэ гэхээр Худалдан авах ажиллагааны газраас оруулж ирсэн тайлан дээр шалгарсан компани 6 төрлийн зөрчилтэй байхад ялчихсан байна гэдэг дүгнэлт гаргасан. Оролцогч бусад компаниудаас гомдол гаргаагүй юм уу? НЗДТГ энэ дүгнэлтийг юу гэж үзэж байгааг хариулж өгөөч гэдэг асуултуудад гүйцээж хариулт авъя. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 15 дугаар микрофон.

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад тодруулж хариулъя. Анх 2016 онд Зам тээврийн хөгжлийн төвөөс 594,8 тэрбум төгрөгөөр магадлан, дараа нь 2024 онд 916,3 тэрбумаар магадлал хийсэн байдаг. 2024 оны магадлалаар баталгаажсан 916,3 тэрбум төгрөг нь 2025 оны төсөв батлах тухай Нийслэлийн иргэдийн хурлын тогтоолд ороод 538,6 тэрбум төгрөгөөр

санхүүжих дүнг тавьсан байдаг.

Сүүлд Зам, тээврийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан шийдвэрээр төсөвт өртөг 1,9 их наяд болсон. Энэ бол тендерийн баримт бичигт туссан дүн бөгөөд магадлал хийгдээгүй, баталгаажаагүй байсан. Энэ төсөвт өртгөөр сонгон шалгаруулалт яваад амжилтгүй болсон. Ийм дүн манай нотлох баримтад авагдсан. 2025 онд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 27 дугаар тушаалаар орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулагдаж, ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөвт магадлал хийх агуулгаар ажиллаад 2,3 их наяд төгрөгөөр магадалсан байдаг. Энэ төсөвт өртөг нь Нийслэлийн 2026 оны төсөв батлах тухай тогтоолд ороод санхүүжих дүн нь 800 тэрбум төгрөг гэж суусан байдаг.

2025 онд 401 тэрбум, 2026 онд үлдэгдэл 99 тэрбум төгрөг санхүүжсэн. Үүнээс гадна 7,8 тэрбум төгрөг бусад ажилд санхүүжсэн гэдгийг танилцуулгадаа хэлсэн. Манай дүгнэлтээр одоогийн байдлаар дүгнэлт эцэслээгүй ч урьдчилсан дүгнэлтийг агуулгаар хэлсэн. Нэгдүгээрт ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөвт магадлал хийсэн нь хууль тогтоомжид нийцээгүй, чиг үүргийн давхардал, ойлгомжгүй нөхцөл байдал бий болгож, салбар хоорондын уялдаа холбоо хангагдаагүй байна. Төслийн нарийвчилсан тоо хэмжээнд зөрүү үүсэх, цаашид төсөвт өртөгт өөрчлөлт орох асуудал байна гэсэн байдлаар дүгнэлтээ гаргаж байгаа. Удахгүй албажна. Манай аудитын дүгнэлтээс үндэслээд хоёр сайдад зөвлөмж, шийдэл гаргасан... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нэг минут сунгая.

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Зам тээврийн сайдад зөвлөмж өгсөн. Зам тээврийн сайдад төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөлд магадлал хийхдээ салбарын хууль тогтоомж, норм стандартад нийцүүлэн нарийвчилсан зураг төсөлд магадлал хий гэж хэлсэн. Бидний үзэж байгаагаар Зам тээврийн хөгжлийн төв магадлал хийх ёстой, ийм чиг үүрэгтэй. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад өмнө нь магадлал хийсэн асуудал дээр жишээлбэл төсвийн эксперт магадлал хийгээгүй байхад баталгаажуулсан дутагдлууд байна. 15 хэсэгтэй магадлалын 3 дээр нь огт холбогдох мэргэжлийн эксперт байхгүй байхад гараад явчихсан зэрэг дутагдал байна. Мөрдөж ажиллаагүй, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооц гэсэн. Энэ урьдчилсан дүгнэлтийг асуудлыг танилцуулаад удахгүй албажуулахаар явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Нөгөө 2 төвөөс та бүхэн тус тус нэг минутад багтааж хэлж өгнө үү. Барилгын хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, тэгээд Худалдан авах ажиллагаа, нийслэл мөн үү? 1 дүгээр микрофон.

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Д.Оюунболд: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. 2024 оны 11 сарын магадлал болон 2025 оны 2 магадлал манайд байгаа. Энэ нь зураг зохиогч өөрчлөгдсөнтэй холбоотой, мөн 2025 онд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2025 онд дахиж магадлал хийсэн. Тэр нь ТЭЗҮ-ийн урьдчилсан зураг төсөл буюу техникийн зураг төсөл дээрх магадлал хийсэн байдаг. Авто замын байгууламжийн зураг төслийн магадлалын журмаар 2 үе шаттайгаар магадлалыг хийнэ гэж заасан. Техникийн зураг төсөл болон нарийвчилсан зураг төсөл хоёр дээр нь магадлал хийхээр зохицуулсан. Инженерийн

нарийвчилсан зураг төслийн магадлал нь 2026 онд дахиж хэсэгчилсэн байдлаар манай байгууллагад ирээд дахиад магадлал хийх үйл ажиллагаа явж байгаа. Нийт 33 км авто замаас 5 км авто замыг хэсэгчилсэн байдлаар магадлалыг хийсэн. Мөн журмаараа томоохон хэмжээний... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За дараагийнх нь 3 дугаар микрофон.

Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер З.Энх-Оргил: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Туулын хурдны замын ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөв гэсэн ажил магадлалаар манайхаар орсон. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 27 дугаар тушаалаар 2025 онд салбар дундын экспертүүдийн ажлын хэсэг байгуулагдсан. Энэ экспертүүд чиглэл бүрийн 14 хүний бүрэлдэхүүнтэй. Хот төлөвлөлт, ус хангамж, дулаан хангамж, цахилгаан хангамж, холбоо, авто зам, гүүр, геодези гээд бүх чиглэлийн эксперт оролцсон. ТЭЗҮ-г ажлын даалгаврын дагуу урьдчилсан байдлаар боловсруулсан. Тэр төсөв дээр урьдчилсан томсгосон нормоор урьдчилсан хөрөнгө оруулалтын тооцоог хийсэн нь 2,3 их наяд гарсан... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Худалдан авах ажиллагааны газрын 16 дугаар микрофон.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Ажлын хэсгээс хүссэн мэдээллийн дагуу Туулын хурдны зам гэсэн тендер шалгаруулалтыг 2025 оны 4 сарын 23-ны өдөр зарласан. 2025 оны 7 сарын 4-ний өдрийн 15 цаг 58 минутад үр дүнгээ оруулсан. Төрийн худалдан авах ажиллагааны систем дээр ямар нэгэн гомдол гарсан гэж бүртгэгдээгүй байна. Хуулиар Төрийн худалдан авах ажиллагааны газар зөвлөмж, тайлбар өгөхгүй учраас танилцуулагдсан зөвлөмж, тайлбартай холбоотой мэдээлэл надад алга байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. О.Батнайрамдал гишүүнээр үг хэлэх гишүүдийн нэрсийг тасаллаа. Ирцийн дарааллаар Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл үг хэлнэ.

УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл: Бүгдэд нь тэвчээр гаргаж өглөөнөөс орой хүртэл сууж, идэвхтэй оролцож байгаад хувь хүний зүгээс талархал илэрхийлье.

Энд улс төржилт биш, мэдээллийн ил тод байдлыг бий болгох, сайн засаглалыг бий болгох, нэгэнт ужгирсан, бугширсан асуудлын шийдлийг олох үүднээс энэ сонсгол зохион байгуулагдаж байна гэж ойлгож байгаа. Гэтэл зарим ашиг сонирхлын зөрчилтэй байсан гэх үү? ямар гэх үү? гишүүд маань орж ирээд өөрсдөө улс төржүүлж байгаа нь харамсалтай. Иргэд ерөөсөө тэнэг биш. Бараг дуугай байсан бол илүү сайн байх байсан байна лээ шүү дээ, яаж байгаа юм бэ, аягүй буруу байлаа.

За эхнээс нь ярья. Тэр мега төслүүд, хурдны зам, Сэлбэ дэд төвийн дэргэдэх орон сууцжуулах хөтөлбөр гээд 2 өдөр бүрэн чадлаараа ярилцлаа. 100 хувь мундаг мэтгэлцээн өрнөөгүй ч зорилго нь зөв, бие биетэйгээ танилцаж, мэдээлэл солилцож

тодорхой түвшинд асуудлыг шийдэхийг зорьцгоолоо гэж бодож байна.

Олон улсын түвшинд Олон улсын төсвийн түншлэл (International Budget Partnership) гэж байгууллага байдаг. Энэ байгууллага нээлттэй төсвийн индекс (Open Budget Index) гаргаж, улс орнуудыг 2 жилд нэг удаа эрэмбэлж жагсаадаг. Ийм судалгааны үр дүн байдаг. Монгол Улс харьцангуй, хангалттай байранд эрэмбэлэгдэхгүй байгаа юм. Үүн дээр бидний төсвийн сахилга бат алдагдаж байгаа, аливаа шийдвэр гаргах үйл явцдаа иргэдээ хангалттай оролцуулахгүй байгаа байдал нөлөөлж байгаа.

Энэ түншлэлийн дэргэд гол хийгддэг олон улсын хурлуудын гол уриалга нь юу байдаг вэ гэхээр төсвийн ил тод байдал, хариуцлагатай байдал, иргэдийн оролцоо юм. Тэгэхээр олон улсын түвшинд угаасаа төсөв батлах үйл явцад иргэдээ оролцуулдаг. Зөвхөн Монголын асуудал биш. Зөвхөн бүгдээрээ бие биенийгээ хэцүүдүүлэх гээд энэ ярилцлага, сонсгол, уулзалтуудыг хийгдэхгүй байгаа юм. Бүгдээрээ нэг эх оронтой гээд хэлээд байгаа шүү дээ. Бүгдээрээ тал талаасаа санаа зовж, асуудлаа ярилцъя, хариуцлага тооцдог байя. Найзан дундаа явсаар байгаад Монгол маань хэцүүдээд байна. Зарим иргэд маань хэцүү амьдралтай байгааг бүгд мэдэж байгаа. Тэгээд энэ асуудлаа ярихаар улс төржиж байна гээд байгаа нь буруу шүү дээ. Бүгдээрээ хамтдаа залуучуудаа зөв замд оруулмаар байна. Тэгэхгүй бол эрсдэлтэй амьдарч байна шүү дээ. Гар үсэг зурлаа маргааш нь тэр залууст юу ч тохиолдож байж магад.

Буруу улс төрчид, ах, эгч нарын гайгаар Бурууг дагавал могойн хорлол гэж байна шүү дээ. Олон улсын түвшний юм яриад байгаа юм шүү. Тэгээд нээлтийн ил тод байдал чинь хууль эрх зүйн орчноор баталгаажихсан байх ёстой. Энийг хөндөж байгаа. Үүний хажуугаар үг хэлэх, үзэл бодлоо эрх чөлөө илэрхийлэх эрх чөлөө бас хумигдах гээд байна. Үгээ зорилго нь зөв илэрхийлэхэд л улс төржүүлээд л манипуляци хийгээд байна. Монголын залуучуудын эвслийн Т.Амарзаяа өглөө ирээд энд оролцлоо шүү дээ. Ингэж хэлж байна. 2 жил дараалаад нийслэл хэвлэл мэдээллийнхэнд мөнгө зарсан нь нийлээд 3,41 тэрбум төгрөг гэж байна шүү дээ. Энэ чинь асар их мөнгө мөн үү? Энэ залуучууд өөрсдөө ингээд судалгаа хийгээд хэлээд байна шүү дээ. Тэр нь хаалттай хэвлэлийн гэрээ байж магадгүй. Далимд нь бид хэдийг нийгмийн төлөө, иргэдийнхээ сайн сайхны төлөө, ямар ч улс төржилтгүйгээр санаа зовоод дуугарсны төлөө, манипуляци хийгээд сошиалаар нүдээд байна шүү дээ.

Орилоо, чарлаа, эмгэн шуламс гэнэ. Юу юу ч гэнэ вэ? Боль л доо ич л дээ. Ингэлээ гээд хуучин нийслэлийн удирдлагууд өөрсдийгөө улам харлуулаад, иргэдийн зэвүүцлийг төрүүлээд байна шүү дээ. Яагаад ийм юм бэ? Бүгд нэг эх оронтой энийгээ ухаараач ээ. Эх орон, нийгэм сайжирвал бүгд жаргана шүү дээ. Зөвхөн бид хэд жаргах гээгүй шүү дээ. Энэ эгнээнд сууж байгаа хэд. Тэгээд ичиж амьдаръя, хариуцлага тооцдог байя. Энэ сошиал медиа арай буруу болчихлоо шүү.

Ганчимэг сэтгүүлчийн бичсэнийг хараарай, уншаарай. Тэр аягүй сайн бичсэн байна лээ. Тэрийг уг нь би уншиж өгмөөр байна. Нэмэлт нэг минутаа авъя... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа.

УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа: Хоёр өдрийн турш нийслэлийн төсөв,

хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар сонсгол хийж, олон нийт, иргэдийг мэдээллээр хангах үүргээ УИХ-ын хяналтын чиг үүргийнхээ хүрээнд Төсвийн байнгын хороо хэрэгжүүлж ажиллаж байна. Гэхдээ ерөнхий хяналтын сонсголыг хийхэд Улсын Их Хурлын түвшинд ч, гүйцэтгэх удирдлага, Засгийн газрын харьяа байгууллагуудаас орж ирж байгаа мэдээлэл дээр ч анхаарах асуудлууд байна.

Ил тод байдлыг хангах үүднээс бид нар мэдээллийн чанар, бодит байдал гэдэг зүйл дээр хаа хаанаа анхаарахгүй бол болохоо больсон байна. Яамдын өгч байгаа мэдээлэл яг энэ хяналтын сонсголын бай болж, мэдээллээ онож өгч чадахгүй байна. Дээр нь бид Улсын Их Хурлын байнгын хороон дээр ч анхаарах асуудал байна. Шинжээчдийг сонгож томилох асуудалд цаашид анхаарах хэрэгтэй юм байна. Шинжээчид Байнгын хороонд бид ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлээд орж ирж байгаа. Гэтэл асуулт, хариулт дээр асуудлууд үүсэж байна. Шинжээчдийн мэдлэг ур чадвар нь энэхүү нөхцөл байдлыг судлаад дүгнэлтээ хараат бусаар гаргаж, бусдад танилцуулж ойлгуулах чадварыг харж сонгохгүй бол болохгүй байна.

Би ганц хоёрхон жишээн дээр хэлэхийг хүсэж байгаа юм. Үндэсний аудитын газар сая хариулт өглөө. Зам тээврийн яамны Зам тээврийн хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв гээд 2 хөгжлийн төвөөр магадлал хийлгээд орж ирээд байгаа юм. Энэ хоёр төвийн магадлалыг магадлах шаардлагатай болчихож байгаа юм. Хууль эрх зүйн орчныг нь бид нар бүрдүүлж өгөхгүй бол хүссэн хүсээгүй энэ систем нь өөрөө ийм нөхцөл байдлыг үүсгэж байна. Уг нь бол магадлалаар батлагдсан дүн эцсийн дүн байх ёстой. Гэтэл шинжээчийн дүгнэлт дээр сүүлийн 2,3 их наядыг Барилга хөгжлийн төвийн магадлал гэж шинжээчийн дүгнэлт орж ирээд байдаг. Үндэсний аудитын газрын Ерөнхий аудитор ирж байж л энэ бол хамтарсан ажлын хэсэг, комисс гарсан гэдэг зүйлийг хэллээ шүү дээ. Барилга хөгжлийн төвөөс ч өмнөх хариулт дээрээ Барилга хөгжлийн төв 2,3 их наядыг гаргасан нь урьдчилсан дүгнэлт, ерөнхий байдлаар гаргасан гэжээ. Хэзээ ч магадлагдсан дүн урьдчилсан байдлаар хөдлөх боломжтой дүн байх ёсгүй. Энэ бол магадлалаар баталгаажуулна гэдэг бол эцсийн төсөв байх ёстой. Гэтэл өнөөдөр ийм юм яриад сууж байна гэдэг бол бас нэг талдаа харамсалтай. Тийм учраас бид нар энэ барилга хөгжлийн төв, зам тээврийн хөгжлийн төв хараат бусаар магадлал гээд баахан дүн нэмээд байгаа энэ нөхдүүдийн эрх зүйн орчныг өөрчилж системийг нь зохицуулж өгөхгүй бол өөрөө энэ чинь магадлагдах, хяналтад орох шаардлагатай ийм субъектийг бид нар бий болгочоод сууж байгаа юм биш үү. Энэндээ итгэж чадахгүй, итгэл үнэмшил авч чадахгүй байна. Үндэсний аудитын газрын ачааллыг нэмээд дахиж хянаад сууж байдаг ийм л тогтолцоо руу орчихжээ. Энэ бол одоо нэг л ажил дээр гарч байгаа жишээ. Зөвхөн энэ одоо нийслэлийн төсвийг ярьж байгаатай холбоотой л гарч байгаа жишээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа маш олон ажлууд энэ хэдэн хөгжлийн төвүүдээр магадлагдаад явж байгаа. Энэ асуудлуудыг бид нар ярих цаг болчихсон байна гэдэг нь өнөөдрийн сонсголоос бас харагдлаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Нөгөө талдаа би нийслэлийн Иргэдийн хурлыг бүүр гайхаад байгаа юм. Яагаад төсвийн хуулийн шаардлага хангахгүй байгаа төсвийг, магадлал нь эцэслэж гарч ирээгүй байгаа төсвүүдийг батлаад яваад байдаг юм. Энэ чинь хуулийн хүрээнд ажлын алба оруулах уу? үгүй юу? гэдгээ шийдээд гүйцэтгэх удирдлагын зүгээс оруулж ирж байгаа асуудал нь болохгүй байна гээд буцаадаггүй юм уу? Тэгээд энэ хууль тогтоомжийн хэрэгжилт гэдэг зүйл ер нь шат шатандаа хаана явна вэ? гэдэг зүйл харагдаж байгаа юм. Дээр нь энэ эрх үүргийн, чиг үүргийн холилдчихсон, давхардчихсан яам, нийслэл энд тэнд гарын үсэг зураад явдгаа ер нь хэзээ болих

юм. Яахаараа Зам тээврийн сайд Нийслэлийн Засаг даргатай хамтраад урьдчилсан төсөв гаргаад гарын үсэг зураад явж байгааг яг үнэндээ ойлгохгүй байна.

Үүн дээр Үндэсний аудитын газрын дүгнэлтүүд тодорхой албажиж гарч ирэх байх гэж бодож байна. Гэхдээ өнөөдөр энэ сонсголын дүнгээр бид нар хэт улс төржиж нэг талыг барьж улс төрийн өнгө аястай асуудлыг дэврэхээс илүүтэй, аль нэг нам улс төр лүү чихэхээс илүүтэй, өнөөдөр байгаа бодит үнэтэйгээ одоо нүүр тулж, шийдэх ёстой гарц гаргалгаагаа гаргаж ажил хэрэг болгоосой л гэж хүсэж байна. Хаа хаанаа асуудлууд бол олон байна. Иргэдийг, олон нийтийг мэдээллээр хангах үүргээ бид нар ямар ч байсан тодорхой түвшинд биелүүллээ. Гэхдээ хангалттай бодит мэдээ, мэдээллүүд эцэслэж орж ирж чадсангүй гэж харж байна.

Мэдээж хууль хяналтын байгууллагууд ажиллаж байгаа зүйл дээр хуулийн дагуу байсан уу? үгүй юу? гэдгийг гаргах байх. Харин цаашдаа хяналтын сонсголоор орж байгаа мэдээ, мэдээллийн үнэн бодит байдлыг нягталж байж сонсгол дээр танилцуулдаг тогтолцоо бидэнд хэрэгтэй юм байна. Чуулганаар яг энэ УИХ-ын хяналт шалгалтын болон дэгийн тухай хуулиуд орж байгаа энэ цаг хугацаанд бид бас анхаарах ёстой юм байна. Баярлалаа

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Сонсгол маань тодорхой хэмжээнд өөрийнхөө зорилгыг тавьсан. Иргэдийн мэдэх эрхийг хангах, иргэд сонсъё гэсэн учраас энэ чиглэл рүү сонсголыг зохион байгуулсан нь тодорхой хэмжээнд үр дүнд хүрсэн гэж бодож байна. Зарим гишүүд маань бас дургүй байх шиг байна лээ. Үр дүнгүй болчихлоо гэж ярьж байх шиг байна. Би бол иргэдийн мэдэх эрхийг л хангаж байгаа болохоос тодорхой үр дүнд хүрэх гэж байгаа асуудал биш, Үндсэн хуулиар олгосон эрхийг нь хангаж байгаа юм. Өнөөдөр сонсгол хийж байгаа нь олон болохгүй асуудлуудыг гаргаж байна. Уг нь бид нар энэ Улсын Их Хурал дээр энэ асуудлыг ярьж байх ёсгүй байгаа юм. Олон гишүүн өнөөдөр нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх хэрэгтэй гэж ярьж байна. Гэхдээ та хэд нутгийн өөрөө удирдах байгууллага биш. Засгийн газар Ерөнхий сайд томилдог байгууллага, бүтцүүд маань нутгийн өөрөө удирдах байгууллагыг дарангуйлаад, иргэдийн Нийтийн хурлын төлөөлөгчдөө тодорхой байдлаар нөлөөндөө оруулаад иргэдийг төлөөлөх чадваргүй болчихсон.

Засаг даргатайгаа нийлээд иргэдийнхээ эсрэг жагсаал хийгээд явж байна гэдэг чинь байр нь орвонгоороо эргэхээд байна шүү дээ. Уул нь иргэдийн төлөөлөгч иргэдээ төлөөлөөд ЗГ-аас томилсон Засаг даргатайгаа бодлогын талаар мэтгэлцээд, өөрсдийнхөө ажиллаж амьдрах орчныхоо талаар ярьж байх ёстой байтал төлөөлөгчид нь Засаг даргатайгаа нийлээд иргэдийнхээ эсрэг жагсаж байдаг.

Одоо энэ олон асуудлууд үүсчихсэн. Хууль хяналтын байгууллага дээр ч гэсэн асуудлууд үүсчихсэн байна. Тэгэхээр энэ жишиг өөрөө зөв тогтохгүй бол нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц чинь ерөөсөө тогтож чадахгүй байна. Бид нарын нутгийн өөрөө удирдах байгууллагыг сайжруулна гэдэг чинь Засаг дарга болон түүнийг тойрсон албан тушаалтнуудын асуудал биш. Засгийн газар талаас харахаар Орон нутгийн байгууллага юм шиг. Иргэдийн хурал талаас харахаар шал өөр тусдаа иргэдийнхээ эсрэг бүтэц болчихоод байна.

Тэгэхээр нутгийн өөрөө удирдах байгууллагыг сайжруулна гэдэг нь иргэдийн

нийтийн хурлын төлөөлөх чадварыг сайжруулна гэсэн үг.

Сонгууль дээр ч асуудал байна. Энэ төлөөлөх чадвар, ашиг сонирхлын зөрчил гэж бас ярьж байна. Хамгийн том ашиг сонирхлын зөрчил бол УИХ-ын гишүүн нийт иргэд, нийтийн эрх ашгийг төлөөлөх ёстой байдагтай адилхан нийтийн иргэдийн хурлын төлөөлөгч ч гэсэн тухайн орон нутгийнхаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах ёстой. Яг энэн дээр л асуудал үүсээд байна. Тэгэхээр үүнийг цаашид хууль тогтоомжийн хүрээнд сайжруулах зүйлс байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын дүр эсгэж хийдүүлж байгаа, тусдаа вант улс шиг иймэрхүү дүр зураг бий болсон нь нууц биш. Бүгд л мэдэж байгаа. Төсвийн зарцуулалтыг харахад тодорхой байна. Хууль тогтоомжийг ч гэсэн Ерөнхий сайд, сайд нарт чиглэл өгөөд л парламент дээр хүссэнээрээ батлаад л явдаг байсан. Тэгээд одоо яг нутгийн өөрөө удирдах ёс гэдэг юм чинь байхгүй болчихоод байна. Үүнийг сайжруулах чиглэлээр хийх зүйлс их байна.

Өнөөдрийн сонсгол дээр шинжээчид маш цөөхөн 7 хоног орчим ажилласан. Цаг хугацааны хувьд бол нэлээн шахуу ажилласан. Дээр нь нийслэлийг буруу, зөрүү дутуу мэдээлэл өгөхгүйгээр мэдээллээ сайн өгөөрэй гэсэн. Зарим мэдээллүүдийг хангалттай өгөөгүйгээс болоод санал нийлэхгүй байгаа асуудал ярьж байна лээ. Тэгэхээр яг хаа хаанаа хариуцлагатай ажиллах хэрэгцээ шаардлагууд байгаа. Нэмээд сонсголыг хийхэд тийм амар байгаагүй. Жишээлбэл төсөв мөнгөө ч хүртэл яаж санхүүжүүлэх талаар дэмжлэг байхгүй. Байнгын хороон дээр бид нар шинжээчдийн цалинг өгөх талаар Байнгын хороо дэмжлэг үзүүлэхгүй гэсэн. Хурал зохион байгуулж байгаа Золжаргал бид хоёр төлнө. Тодорхой хэмжээний сорилтуудыг давж хийж байгаа юм. Хоёр гурван шатанд дэмжихгүй гэдэг санал авч байсан. Ашгүй өнөөдөр шийдсэн юм шиг байна.

Сонсгол бол мэдэх эрхийг хангах байгаа юм. Зүй нь бол орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь хангалттай сайн ажилладаг байсан бол бид нар ийм сонсгол хийх шаардлагагүй. Үүнийгээ сайжруулах хэрэгтэй юм байна. Цаашдаа хууль тогтоомжоо энэ чиглэлээр сайжруулах хэрэгтэй юм байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал: Өнөөдөр нийслэлтэй холбоотой асуудлаар 2 өдрийн сонсгол явж дуусаж байна. Татвар төлөгчдийн мөнгө, өмч хэрхэн захиран зарцуулагдаж байгаа талаар иргэдийг мэдээллээр болон мэдэх эрхээр хангах оролдлого болгон зөв. Хянан шалгах түр хороо, ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулж байгаа нь зөв. Гэхдээ нөгөө талаасаа маш том хариуцлага дагуулдаг. Энэхүү ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсан гишүүдийн зөв. Үүнийг хэнд ч буруу гээгүй. Зарим гишүүд над руу хараад яриад байх шиг байна. Үгүй ээ, би өөрөө Хянан шалгах түр хорооны сонсгол хийсэн хүн. Урдах сонсгол шиг улс төржиж, олон нийтийг хуваагаад байна гэж яриад байх шиг байна. Бас л Оюу толгойн сонсголыг яриад байх шиг байна. Үүнд ард түмэн өөрсдөө дүгнэлт хийсэн байх. Ялангуяа маш их дата, мэдээлэл дээр шинжээчид ажиллаж байгаа бол тэр шинжээчдэд боломжийг нь олгох ёстой. 16 мега төслийн ТЭЗҮ гээд маш их бичиг баримт, 30 гигабайт дата ирж байгаа гэж шинжээчид өөрсдөө хэлсэн.

Тэгэхээр хангалттай хугацаа өгөөд, судалгаанд үндэслэсэн дүгнэлт гаргах боломжийг нь бид нар олгох ёстой. Цаашид ерөнхий хяналтын сонсгол зохион

байгуулахдаа ч энэ дээр бодох ёстой. Шинжээч нь өөрөө хангалттай цаг байгаагүй гэж микрофон дээр хэлсэн. Тэр хүмүүстээ боломжийг нь олгох ёстой. Энэ зун ажиллачихсан бол илүү сайн дүгнэлт гарах байсан гэдгийг хэлсэн. Энэ ерөнхий хяналтын сонсголд иргэд идэвхтэй ирж үзэл бодлоо илэрхийлсэнд баяртай байна. Үүнийг хүндэтгэлтэйгээр хүлээж авч байна. Сая Д.Энхтүвшин гишүүний хэлж байгаа зөв. Эхлээд ИТХ нь энэ асуудлаа ярилцаад, үнэхээр болохгүй бол бид нар татаж авч ярих хэрэгтэй. Үүн дээр хуулийн цоорхой харагдлаа. ИТХ олон нийтийг төлөөлж нийслэлийнхээ захиран зарцуулалтыг хянах үүрэгтэй, яг л нийслэл дэх Улсын Их Хурал гэсэн үг. Гэтэл нийслэлийнхээ албан тушаалыг аваад явах нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж байна.

Тэгэхээр энэ дээр хууль тогтоомжийн хувьд, энэ ерөнхий сонсголоос нэг дүгнэлтэд хүрээсэй гэж бодож байна. Эдгээр асуудлаа шийдээд явах хэрэгтэй. Үүнээс болоод, жишээлбэл Сэлбэ дэд төв дээр явж байгаа том бүтээн байгуулалтууд 10 хэдэн жил гацаж байгаад сүүлийн 2-3 жил урагшилсан төслийг татаж унагаах ёсгүй. Яагаад гэдгийг дахиад хэлье. Яг үнэнийг хэлэхэд 30 жилийн турш улсын төсвийн хуваарилалт хийхдээ нийслэлийн хүн амын гуравны нэг нь байдаг хэдэн байшингаа тойрч сайжруулаад л хөрөнгө оруулалт хийсэн. Гэр хороолол руу хөрөнгө оруулалт маш дутагдалтай явсан. Тийм учраас гэр хорооллыг цогцоор нь өөрчлөх төслүүдийг дэмжих ёстой, түүний жишиг нь Сэлбэ дэд төв болоосой гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Сэлбэ дэд төв амжилттай хэрэгжвэл цаашид Сүхбаатар, Чингэлтэйгээс гадна Сонгинохайрхан, Баянзүрх гээд гэр хорооллыг орон сууцжуулах боломж гарна. Эдийн засаг өөрөө томрох тусам энэ шаардлага, нөхцөл бүрдэнэ. Ингэж жишиг болж яваасай гэж бодож байна. Гэхдээ явж байгаа асуудлуудыг нээлттэй ярилцаж, засахыг нь засаад улам сайжруулж явах ёстой. Тийм учраас энэ нь ч дүгнэлтэд ороосой гэж бодож байна. Цаашид сонсголууд зохион байгуулагдах байх, иргэдийг мэдэх эрхээр нь хангаж явах ёстой. Цаг хугацааны хувьд сая Д.Үүрийнтуяа гишүүний хэлсэнтэй санал нэг байна. Яамдууд өөрсдөө ирж танилцуулгаа бэлдэж орж ирэх ёстой. Сонсгол гэдэг бол олон нийтийг мэдээллээр хангаж байгаа учраас яамдууд ч үүрэгтэй, хариуцлага хүлээсэн хүмүүс... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Хоёр өдөр иргэдийн үүсгэл санаачилгаар зохион байгуулагдсан гэж хэлж болохуйц энэ сонсголд маш идэвхтэй оролцсон иргэний нийгмийн төлөөлөл, мөн төр, засгийн байгууллагын албан тушаалтнуудад талархлаа илэрхийлье.

Ярих юм зөндөө байна. Тэгэхдээ бидний үг бүх л түвшиндээ маш их мөргөлдөж байна. Буруу, зөрүү мэдээлэл энэ сонсголын үеэр гарсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ энэ нь хуультай учраас түрүүн Ж.Золжаргал дарга сануулсан. Хэн ямар буруу мэдээлэл өгснийг түүгээр нь хянаж, шалгадаг байх. Бүхэлдээ нэг буруу мэдээлэл цацагдаж иргэдийн толгойг эргүүлсэн зүйл гараагүй гэж бодож байна. Би төрийн албан тушаалтнуудад итгэж байна.

Засаглалын хямралтай холбоотой асуудлыг гишүүн болгон дурдаж байна. Нутгийн өөрөө удирдах ёс руу халдаж, төвлөрүүлэх гэж байна гэж. Энэ хоёр өдрийн сонсголыг нийслэлийн болон орон нутгийн ажлыг Улсын Их Хурал татаж аваад байгаа юм шиг ойлголт төрчих вий гэж жоохон санаа зовж байна. Тийм юм хэзээ ч байхгүй. Нутгийн удирдах ёс хөгжөөд явбал сайн. Гэхдээ сахил хүртээд шал дордов

гэдэг шиг, өөрсдөө удирддаг баатар болоод, хулгай нь гаарчхаад явж болохгүй. Хамгийн гол нь тэр л байгаа. Бид аагаа барж, аргаа барсандаа энд 2 өдөр суугаагүй. Ямар сайндаа л энэ 2,3 их наядын төсөл ямар байдалд орчхоод байгааг бид мэдэж байгаа. 8 хүн нь эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдаж, 3 хүн нь цагдан хоригдсон байдалтай байна. Энэ ноцтой асуудал биш юм уу? Үүнийг ярихгүй, чихээ бөглөж, нүдээ аниад өнгөрөх юм уу? Түүгээрээ асуудал шийдэгдээд өнгөрөх байх гэсэн асуудал нь шийдэгдэхгүй байсан. Огт шийдэгдэхгүй байсан. Сүүлдээ 3 байгууллагын хамтарсан ажлын хэсэг гарч байж энэ ажил зогсонги байдалд оров. 30-аад дансны 6 их наяд төгрөгийн гүйлгээг төр зогсоосон гэж байгаа. Ийм ноцтой асуудал үүссэн учраас л өнөөдөр бид сонсгол хийж байгаа юм.

Монгол Улс бол нэгдмэл төрийн байгуулалтай улс. Мужуудаас бүрддэг улс биш. Тэгэхээр аль нэг аймагт асуудал үүсээд, тэндээ шийдэж чадахгүй, хулгайдаа баригдчихаад байвал энэ Их Хурал дээр авч хэлэлцэнэ. Өмнөговь, Дорноговь, Төв аймаг хамаагүй, асуудлаа шийдэж чадахаа болиод наашаа иргэд хандах юм бол бид сонсгол хийсээр байх болно. Гагцхүү тэндээ хуулийнхаа дагуу зөв зохистой үйл ажиллагаа явуулбал наашаа татаж авах шаардлага байхгүй гэдгийг бүгд мэдэж байгаа.

Дээр нь нэг зүйл нэмж хэлье. Сүүлийн 36 жилийн турш Монгол Ардын Нам энэ нийслэлд засагласан. Ардчилсан нам бол 1996-2000 онд 4 жил, дараа нь 2012-2018 онд 2 жил, нийтэд нь аваад үзвэл 16 хувьд нь засагласан бол Монгол Ардын Нам 84 хувьд нь засаглажээ. 36 жилийн 30 жилд нь Монгол Ардын Нам засагласан байна. Тэгээд нэг талаасаа улс төржиж болохгүй гэж байх юм. Энэ чинь улс төржиж байгаа асуудал биш, улс төрийн хариуцлага ярьж байна. Улс төрийн намууд сонгуульд орж ийм ажил хийнэ гэж амлалт өгч байж сонгогддог. Тэгэхээр бид улс төрийн хариуцлагыг ярихаас өөр замгүй. Э.Бат-Үүл даргын үед нийслэлд их ажил хийгдсэнийг бид бүгд мэднэ, алдаа оноо байсныг үгүйсгэхгүй. Тэгэхээр өнөөдрийн нөхцөл байдлыг дүгнэхэд нийслэл асар их мөнгөтэй, мөнгөгүйн зовлон огт байхгүй. Одоо мөнгөө яаж зарцуулах вэ гэдэг зовлонтой харагдаж байна. Мөнгийг хэр их үрснээр биш, хэр хариуцлагатай, хяналттай, үр ашигтай зарцуулсан бэ гэдгээр нь дүгнэнэ. Тэнд хүүхэд 3 ээлжээр хичээллэж байхад энд бид 2.3 километрийн зам... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Сонсгол хоёр өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Иргэдийн мэдэх эрхэд нээлттэй хандсан гэдэгт эргэлзэхгүй байна. Хотын удирдлагуудад улам том шалгуур ирж байгааг тал талаас нь ухамсарлах ёстой. Эдийн засгийн тэлэлт, өсөлт, том төслүүд улам их хардлага дагуулна. Энэ ойлгомжтой. Энэ нийгмийн шахалт, улс төрчдийн олон эрх ашгийн уулзвар энэ дээр байгаа. Сүүлдээ энэ ажлыг хийдэг хүн байх уу, үгүй юу? Залуучууд халширч магадгүй. Гэхдээ төрд тангараг өргөсөн бол хийх ёстой. Дарга ирж болно, явж болно, солигдож болно.

УИХ-ын гишүүд, нийслэлийн төлөөлөгч нар ч сонгуулийн үр дүнгээр солигддог. Иргэдийн эрх ашиг эрэмбийн хамгийн нэгдүгээрт байх ёстой. Сүүлийн 36 жилийн 32 жил нь хот ямар ч санхүүгийн эх үүсвэргүй, чадамжгүй байсан. 2022 онд эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдэж, эдийн засгийн чадамжтай болж, олон хуримтлагдсан асуудлуудыг эрэмбэд нь оруулж галт тэрэг хөдөлсөн. Энд улс төрчид болон иргэд маш олон талын байр суурь илэрхийлсэн.

Улсын Их Хурлын гишүүний хувьд, тойрог дээрээ хотоос сонгогдсон гишүүн хөрөнгө оруулалт тавихаар нийслэл дээрээ яриад шийд гэдэг. Зам тавихгүй, сургуулийг улсын төсөв дээр тавихгүй, нийслэл, дүүрэгтэйгээ яриад шийд гэдэг. Хотын дарга хүсэлтээ тавихдаа дүүргээс магадлал хийлгэсэн, зураг төсөв нь батлагдсан төслийг бариад л явдаг. Би ч хөөцөлдөөд явсан. Тэнд ямар нэгэн хувийн эрх ашиг байхгүй. Иргэдтэй уулзахад гарсан саналуудыг эрэмбэлээд л өгдөг. Сангийн яаманд хүсэлт өгөхөөр хотын гишүүд хотдоо ханд гэдэг. Иргэдтэй уулзахаар хүссэн хүсээгүй зам, талбай, гэрэлтүүлэг, дэд бүтэц, цалин тэтгэврээ нэхдэг, эрэмбэд нь оруулж шийднэ. Өөр гарц байхгүй.

Нийслэлийн иргэдийн хурал руу олон талаас, олон өнцгөөс шахалт ирж байна. Хууль эрх зүйн хувьд нэг шинэчлэгдэх цаг нь болсон юм уу гэсэн бодол төрж байна. 2022 оны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар байсан нэг жоохон урамшууллыг аваад хаячихсан. Зовлонгоо л хэлж байна. Бид Улсын Их Хурал дээрээс бүх юмыг нь хаасан. Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч нар цалин урамшуулалтай байя, төрийн болон орон нутгийн өмчийг удирддаггүй байя, зөвхөн төлөөлөгчийнхөө үүргийг гүйцэтгэе, аж ахуйн ажилд оролцохгүй байя гэсэн саналууд гарч байсан ч дэмжигдээгүй. Тэр үед ажлын хэсэгт дүүргийн удирдлагууд, нийслэлийн төлөөлөгчид санал хүргүүлж байсан ч нэг ч өгүүлбэр нэмж аваагүй. Бүгдийг нь хэрчиж, өөрсдөө хийсэн юмаа эргээд шүүмжилж байна. 70-80 албан хаагч хоёр өдрийн сонсголд оролцож, 5-6 хүн л хариуллаа, бусад нь энд сандал халаагаад сууж байлаа. Хотын ажил мундаагүй маш их, аж ахуйн ажил. Иргэдийн эрх ашгийг бид сонгууль болгоны мөрийн хөтөлбөрөөр бүх улс төрийн намууд уралдаж, ам хуурайгүй ярьдаг. Гэтэл өөрсөд дээр нь тулаад зарим нь хэрэгжүүлэхээр болохоо байчихдаг, эрх баригч нам хийхээр сөрөг хүчин нь бүр жадлан эсэргүүцдэг ийм л дүр зурагтай байна. Хотын удирдлагуудад амжилт хүсье. Хүссэн хүсээгүй энэ хуулиараа л явж байгаа. Хууль шинэчлэгдвэл өөрчлөгдөх байх. Эрэмбэлсэн ажлуудаа цаг тухайд нь хийж, иргэдийн хүлээснийг тайлмаар байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Ямар ч байсан иргэдийнхээ тодорхой мэдэх эрхийг хангах зорилгоор энэ ерөнхий сонсголыг явуулж, тодорхой түвшинд зарим асуудлыг хүргэж чадсан. Тэгэхдээ түрүүн О.Батнайрамдал гишүүний саналтай адил байна. Шинжээчдээ зөв сонгож, ажиллах хугацаа өгөх ёстой байсан. Ажлын хэсгийн даргад үүнийг нэг удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгах эрх байдаг. Үнэхээр шинжээчдийн зарим дүгнэлтийг харахад хиймэл оюун ухаанаар боловсруулчихсан юм шиг зүйл байна. Үүнийг олон нийтэд үзүүлээд төр ингэтлээ чадахгүй болчихсон юм гэж харуулалтай биш. Ийм л онигоотой байна бид нар. 1992 онд Улаанбаатар хот 600 мянган хүнтэй байсан бол үүнээс хойш хүн ам 3 дахин, суурьшлын бүс 6 дахин өссөн. Бүтээн байгуулалт ч тодорхой хэмжээнд явсан. Энэ 30 жилийн хугацаанд шинэ Үндсэн хуулийн тогтолцоонд Улаанбаатар хотын улсын төсөвт цуглуулсан орлогын ердөө 7 хувийг буцааж зарцуулах эрхтэй байсан нь урсгал зардлаа л дийлдэг байв. 2022 онд 43 хувийг үлдээсэн, аймгууд нийтээрээ үлдсэн. Аж ахуйн нэгжийн орлогын 40 орчим хувийг үлдээсэн. Тэгэхдээ хоёрхон жил явсан

Нийслэл Улаанбаатар хот асуудлаа шийдэх хүртэл бараг авахгүй гэж байсан. Сүүлдээ асуудлууд үүсээд 176-г төвлөрүүл, 225-ыг төвлөрүүл гэж байсан бол одоо 400 руу явж байгаа. Энэ бол Улаанбаатарын хуримтлагдсан асуудал. Эрт шийдсэн бол ийм хэмжээнд хүрэхгүй байсан. Нийтийн тээврийн асуудлыг хүртэл

Улаанбаатар хот мэддэггүй байсан. Өмнө нь С.Баяр гуайн Засгийн газрын үед нийтийн тээврийг шинэчлэхдээ Зам тээврийн яам автобуснуудыг хувийн хэвшлийн нэр дээр шууд өгчихсөн, тэр төлбөрийг буцааж аваагүй, нэхэхээр шүүх нь автобуснууд хувийн компани дээр байгаа учраас нийслэлд нэхэмжлэх эрхгүй гэсэн. Бүх юм ийм байсан. Автобус нь шатаж, утаандаа баригдаж, давс машин дээрээс цацаад зогсож байсан ийм хот байсан. Ямар сайндаа л төлөөлөгч нар нэг сургууль, нэг тоглоомын талбай, нэг байшингийн дээвэр янзлахаараа л нийслэлийн төлөөлөгч нар болчихлоо гэдэг байсан. Эдгээр арга замыг олж, мөнгийг босгож, зөв төслүүдийг эхлүүлэе. Сэлбэ бол эхний раундыг л нийслэл хийнэ, 2 дахь раунд нь Дэнжийн мянга, Гандангаас наашаа, 32-ын тойргийн хүмүүс энэ байр луу газраараа нүүж ороод, газар чөлөөлж, дэд бүтэцжүүлээд блок блокоор нь зарна гэсэн концепцтой.

Үүнийг өнөөдөр бид хэлж мэдүүлсэнгүй. Энэ асуудлуудыг бодитой ярих ёстой. Яг үнэндээ нийслэлийг сүүлийн хоёрхон жил цуглуулж ирсэн төсвийнх нь 40 хувиар дэмжихэд ийм хэмжээний боломжийг гаргаж урагшлуулах гэж оролдож байна. Дээр нь мега төслүүдийн 2-3 нь л төсвөөс байгаа. Бусад нь олон улсын санхүүжилт буюу EPC+F-ээр бусдаас мөнгийг нь олж ирээд барьж байгуулаад, бид нар бага багаар үе шаттайгаар төлдөг нөхцөлтэй. Метро дээр ТЭЗҮ-г хийчихвэл барих юмыг үе шаттайгаар төлнө. ТЭЦ-5-ын 20 хувийг нийслэл, 80 хувийг хувийн хэвшил гаргана. Ийм байдлаар энд байгаа 2 сая гаруй иргэдийн асуудлыг шийдэх гээд байгаа шүү.

Нийслэл энэ бүтээн байгуулалтын явцад боловсрол, нийгмийн хатуу, зөөлөн дэд бүтцийг хаяагүй. Сүүлийн 3 жилд боловсролын салбарт 200 тэрбум төгрөг зарцуулсан. Би хүртэл орлогч байхдаа аж ахуйн нэгжүүдтэй хэрэлдэж байж газаргүй гэж байсан газруудад сургууль, цэцэрлэггүй 9 хороонд барьж байгуулсан. Боловсролын яамны царцаагаад зогссон бүх төслүүдийг нийслэл дуусгаж өгсөн. Ингэж боломжуудаа ашигласан. Хот гэдэг бол Монголын нүүр царай, энэ бол тосгон биш. Тосгон шиг байлгахыг хүсээд байгаа гэж би ойлгож байна. Энэ мэдээллийн зөрөөнөөс л болж улс төрийн тоглолт явж байна. Тийм учраас олон гишүүний хэлж байгаа засаглалаа янзалъя гэдэгтэй санал нэг байна. 2022 онд болохгүй гэж байхад л урамшууллыг нь аваад хаясан. Намайг тэр үед төрийн нарийн бичгийн дарга байхад тэнэгээрээ дуудуулж байсан. Чи орон нутгийн юм мэдэхгүй байж... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. (алх цохив)

Сонсгол хаахаас өмнө оролцогчдоос 2 хүсэлт ирсэн байгаа. Нэг нь шаардлага, нөгөө нь хүсэлт. Сонсгол даргалагчийн зүгээс хүлээж авлаа. Тамгын газар болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцаж, яаж шийдвэрлэх талаар арга хэмжээ авна. Нэг нь нийслэлийн хуучин болон одоо байгаа удирдлагуудтай хариуцлага тооцох асуудлаар иргэн Гүррагчаа, Гэрэлт-Од, Мөнхсайхан нарын гарын үсэгтэй шаардах бичиг байна. Нөгөө нь эрх нь зөрчигдөж байгаа тусгай хэрэгцээт иргэдийн талаарх тулгамдсан асуудлын хүсэлт буюу иргэн П.Нямдэлгэрийн хүсэлт байна. Энэ 2 хүсэлтийг холбогдох журмаар нь хэлэлцэнэ.

Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 2 дугаар тогтоолоор “Нийслэлийн 2024–2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголыг энэ хоёр өдөр хийлээ. 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн сонсголд төрийн байгууллагаас 61, иргэн, хуулийн этгээдээс 19 хүн оролцсон бол 6 дугаар сарын 16-ны буюу өнөөдрийн сонсголд төрийн байгууллагаас

61, иргэн, хуулийн этгээд, ТББ-аас 41 хүн оролцлоо. Сонсголыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн MNB суваг болон Улсын Их Хурлын Parliament.mn цахим платформоор шууд дамжуулж, мэдээллийг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор дохионы хэлний орчуулгыг зэрэг хүргэж ажиллаа.

Сонсгол хийх үндсэн шаардлага бол иргэдийн хүсэл, хэрэгцээ, шаардлага. Иргэд сонсохыг хүссэн төрийн байгууллага иргэдийн сонсох, мэдэх эрхийг хангаж байх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулиар засгийн бүх эрх гагцхүү ард түмний мэдэлд байна, Монгол Улсын иргэн төрийн үйл хэрэгт шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжиж оролцдог. Тэгэхээр төлөөллийн байгууллага иргэдийн хүсэл шаардлагад нийцүүлж хэрэгтэй мэдээллийг нь өгөх үүрэгтэй. Үүнийг нарийн нягталж ажиллах хангах нь зүйн хэрэг. Гэхдээ хамгийн чухал нь шуурхай, түргэн, нээлттэй байх явдал. Энэ үүднээс хэрэгцээ шаардлага гарсан. Энэхүү хэрэгцээ шаардлагыг төлөөлөл болоод сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд мэдэрч хуулийн дагуу хүсэлт гаргаж, гарын үсэг цуглуулаад Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгууллаа.

Нийслэлийн мега төслүүд 16 ч бай, 24 ч бай энэ бол маш том ажил. Мөнгөн дүн нь ч хүний ой тоонд ороход хэцүү. Энэ бүхнийг нарийвчлан ярих юм бол хэзээ ч дуусахгүй. Түүний бэлтгэл ажил бол бараг хэзээ ч дуусахгүй. Гэхдээ цаг хугацааны хувьд яг одоо шийдэх, анхаарах нь тулчихсан байгаа. Янз бүрийн маргаан, төлбөр тооцооны асуудлууд намар болтол хүлээгээд байх боломжгүй. Тэгэхээр асуудлыг хэлэлцэх шаардлагатай үед нь хэлэлцэх нь зүйтэй. Бодлогын зарим өөрчлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлуудыг хийх хэрэгтэй байна. Энэ үүднээс Хаврын чуулган завсарлахаас өмнө энэ ажлыг зохион байгуулах шаардлагатай гэдэг үндэслэлийг УИХ-ын гишүүд гаргаж тавьсан. Төсвийн байнгын хороо энэ асуудлыг хэлэлцэж дэмжээд, товоо тогтоож, ажлын хэсгээ байгуулсан. Ажлын хэсэг маш богино хугацаанд өндөр ачаалалтай ажиллалаа. Шинжээчдийг богино хугацаанд их шахаж олон мэдээлэл дунд ажиллууллаа. Нөгөө талаараа мэдээлэл бүрдүүлэхэд богино хугацаа учраас нийслэлийн болон төрийн бусад байгууллагыг их шахаж ажилласан. Энэ хугацаанд амжаагүй, ойлголт зөрсөн, мэдээлэл дээр зөрөө гарсан зүйлс бас бий. Тэгэхдээ Монгол Улс хуультай, хууль тогтоомжид зааснаар шаардлагатай гэж үзвэл хариуцлага тооцох асуудлыг ярина. Энэ тал дээр магадлах ажлууд хийгдээд явна.

Ажлын зохион байгуулалтын хувьд УИХ-ын Тамгын газар маш сайн ажилласан. Хугацаа богино, олон ажил давхцаж, байнгын хороод хуралдаж, орон нутгийн сонгууль болж байгаа энэ үед ур чадвар гарган, координаци хийж ажилласныг зориуд тэмдэглэе. Хоёр өдрийн хуралдаан цагтаа эхлээгүйд хүлцэл өчье. Орон нутгийн сонгууль, байнгын хороодтой холбоотойгоор зөвхөн сонсгол хүлээгээд байнга гэж байхгүй. Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын ажилтай хүмүүс учраас өглөө нэлээн хоцорч эхэлсэнд сонсголд оролцогчид болон нийт иргэдээсээ хүлцэл өчье.

Цаашид хэд хэдэн санаа гарч байгаагийн нэг нь бол сонсголыг эхлүүлэхэд шийдвэрийг нь гаргасан бол ирц хүлээхгүй байх, хоёрдугаарт нь сонсголд тухайн асуудлыг хариуцаж байсан шинэ, хуучин хүмүүсийг ирүүлдэг байх. Үр дүнгийн хяналтын сонсгол байгуулдаг байя гэж зарим гишүүд санал болгож байна. Нийслэлийн болоод төсвийн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хууль зэрэг эрх зүйн орчныг сайжруулах талаар олон саналууд гарлаа. Үүнийг сонсгол даргалагчийн зүгээс эдгээрт байр суурь илэрхийлэх нь оновчтой биш. Ажлын хэсэг дээр сонсгол санаачлагч гишүүдтэй хэлэлцэж санал, дүгнэлт

боловсруулна. Санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороо дээр хэлэлцэж, шаардлагатай бол УИХ-ын тогтоолын төсөл гаргаж нэгдсэн чуулганаар хэлэлцэх дарааллаар явна. Тамгын газраас сонсголын тайлан, мэдээллийг хуулийн хугацаанд буюу 5 хоногийн дотор гаргаж нийтэлнэ, дээр нь цугларсан мэдээллийг ангилж, шаардлагатай мэдээллийг гаргаж өгдөг байя гэсэн асуудлыг бид албан бичгээр тавьсан. Урьд өмнө техникийн хувьд төвөгтэй учраас хэрэгжилт нь тааруу явдаг байсан ажил байгаа юм билээ.

Сонсголд идэвхтэй оролцсон иргэд, оролцогч та бүхэнд баярлалаа. Хоёр өдөр тэвчээртэйгээр сууж мэдээлэл өгсөн төрийн байгууллагын албан хаагчид, нийслэлийнхэнд баярлалаа. Бид нэг нэгнээ буруутгаж байгаа юм биш. Маш их ажил, маш том мөнгөний, маш их ачаалалтай, улс төрийн хэл амтай, стресстэй ажил хийж байгаа хүмүүсийг ойлгож байна. Цаг үе нь ийнхүү шаардаж, иргэд сонсох хэрэгтэй байгаа учраас та бүхнийг ч их шахаж ажилласан. Мэдээлэл өгч идэвхтэй хамтран ажилласан та бүгдэд баярлалаа. Бүх зүйлс муу байна гэж юу байх вэ. Сайжруулах зүйлээ бид сайжруулаад л явна. Нийслэлийн нөр их ажил хийж яваа хүмүүстээ амжилт хүсье.

Ингээд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос зохион байгуулсан “Нийслэлийн 2024–2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголыг хаасныг мэдэгдье. (алх цохив)

Тэмдэглэлтэй танилцсан:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ


Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР